

**МЯНГАНЫ ХӨГЖЛИЙН ЗОРИЛТОД СУУРИЛСАН ҮНДЭСНИЙ
ХӨГЖЛИЙН ЦОГЦ БОДЛОГЫН ХЭРЭГЖИЛТИЙН МЭДЭЭ**

/2010 оны жилийн эцсийн байдлаар /

2011. 02. 15

Орхон аймаг

	Зорилт	Хэрэгжилт
МОНГОЛ УЛСЫН ХҮНИЙ ХИЙГЭЭД НИЙГМИЙН ХӨГЖИЛ		
4.1. Ядуурал, ажилгүйдлийг бууруулах бодлого: Нэгдүгээр үе шат (2007-2015 он):		
<i>Стратегийн зорилт 1. Ядууст чиглэсэн, харьцангуй чинээлэг дунд давхаргыг төлөвшүүлэх эдийн засгийн бодлого хэрэгжүүлж, орлогын өсөлтийг хангах замаар ядуурлыг хоёр дахин бууруулна.</i>		
	<ul style="list-style-type: none"> • эдийн засгийн өсөлт, хөрөнгө оруулалтын арга хэмжээтэй нягт уялдуулан ажлын байрыг нэмэгдүүлж, ажилгүйдлийн түвшинг 3 хувиас ихгүй байлгах; 	<p>Ажилгүйдлийн түвшинг ажил идэвхитэй хайж байгаа иргэдийн эдийн засгийн идэвхтэй хүн амд эзлэх хувийн жингээр тооцож байна. Ажил идэвхитэй хайж байгаа ажилгүй иргэдийн тоо 1.7 мянга, ажилгүйдлийн түвшин 5.1 хувьтай байна. Орхон аймгийн нийт хүн амын 66.9 хувийг хөдөлмөрийн насны хүн ам эзэлж байгаа боловч нийт хүн амын 36.3 хувь, хөдөлмөрийн насны хүн амын 54.1 хувь нь хөдөлмөр эрхэлж байгаа нь ажиллах хүчний нөөц хангалттай байна. Бүртгэлтэй ажилгүйчүүдийн тоо өмнөх оноос 3.1 хувиар буурсан байна.</p> <p>Сургалт, бизнесийн жижиг зээл, нийтийг хамарсан ажил, ажил олгогчийн дэмжлэг, ажилгүйдлийн тэтгэмж, нөхөн олговор болон хууль тогтоомжинд заасан бусад үйлчилгээг давхардсан тоогоор 7431 иргэнд үзүүлэв. 2010 онд аймгийн хэмжээнд 3206 ажлын байр бий болсныг бүртгэлээ. Үүнээс 1727 нь шинээр байр бий болсон ажлын байр байна. Ажил олгогч нараас 3220 ажлын байрны захиалга хүлээн авч, 1997 иргэнийг ажилд зуучилж орууллаа. Шинээр байгуулагдсан компани, нөхөрлөл зэрэг аж ахуйн нэгжүүд, Дэлгэрэх худалдааны төв, SKY супермаркет, Хөх гангын үйлдвэр, Анаг ХХК, Хоолны газар, Мандал шанд хамгаалалтын алба, дэлгүүр, үсчин, салон, дэн буудал, Эра төв, Фитнис клуб, Жижиг зээл ЖДҮ-ийн зээл, ХБИ-ийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төсөл зэрэг нийт 3206 ажлын байр бий болсон байна.</p>

		Хэрэгжиж байна 90%
	• өрх, хүн ам, амьжиргааны түвшний талаархи үндэсний хэмжээний мэдээллийн сан байгуулна.	Хүн ам өрхийн бүртгэлийн мэдээллийн санг баг, сум, аймгийн түвшинд байгуулж, жил бүр хөдөлгөөнийг хийж баяжуулан мэдээлэл, судалгаа, шинжилгээнд ашиглан ажиллаж байна. Санг жилийн эцсийн байдлаар хаалт хийж 32 төрлийн үзүүлэлтийг гаргаж ажилласан байна. Хүн ам, орон сууцны тооллогын бэлтгэл ажлын хүрээнд санд давхардаж орсон 10.0 мянган орчим хүний давхардлыг арилгаж, тооллогын хяналтанд суурь хяналт болгон ашиглав. Хэрэгжиж байна 90%
	Ажилгүй, ядуу, нэн ядуу иргэдэд мэргэжил, ажлын дадлага туршлага эзэмшүүлэн, ажлын байртай болгох, хөгжлийн зээл, тусламжид хамруулах зэргээр амьжиргааны эх үүсвэртэй болох, орлогоо нэмэгдүүлэхэд нь дэмжлэг үзүүлэх;	Ш.Отгонбилэгийн нэрэмжит Технологийн сургууль, Эрдэнэт ХЭСТ, Албан бус боловсрол төв, “ТОДГ” сургалтын төв, “Футур”, “Залуу техникч”, “Дэлгэрхангай”, “Солонго”, “Хүүхэд, залуучууд эмэгтэйчүүд” ТББ-ын мэргэжил сургалтын төв зэрэг 9 сургалтын байгууллагатай гэрээ байгуулан мэргэжлийн 15 төрлөөр 18 удаагийн сургалтыг зохион байгууллаа. Аж ахуй эрхлэх, төслийн сургалтыг Эрдэнэт Бизнес инкубатор төвтэй 12 удаа зохион байгуулж 278 иргэнийг хамруулан аж ахуй эрхлэх төрөл бүрийн ур чадвар олгов. “Оюу толгой” компаниас тус үйлдвэрт ажилд орж ажиллах хүсэлтэй иргэдийг сургалтанд хамруулах бүртгэл хийгдэж шалгалтанд тэнцсэн 120 иргэнийг Технологийн сургууль дээр белазийн жолооч, баяжуулагч, цахилгаанчин зэрэг мэргэжлээр 1 жилийн хугацаатай суралцаж байна. “Оюутолгой” компаний хөрөнгө оруулалтаар мэргэжилтэй ажиллах хүч бэлтгэх зорилгоор манай аймагт олгогдсон квотын дагуу иргэдийг журмын дагуу бүртгэн шалгалт авч 111 иргэнд 17 мэргэжлээр 9-21 сарын хугацаатай мэргэжил эзэмшүүлэхээс манай аймагт 4-н төрлийн мэргэжлээр, бусад мэргэжлүүдийг Улаанбаатар болон хөдөө орон нутгуудад эзэмшүүлэхээр сургалтын бүртгэл явагдаж, 856 хүнээс шалгалт авч 111 хүнийг сонгон сургаж байна. “Хас” банкаар дамжуулан 136 иргэн, аж ахуй нэгжид 474.8 сая төгрөгийн зээл олгож 541 ажлын байр бий болсон. Хэрэгжиж байна. 90%
	• ажлын байр шинээр бий болгосон аж ахуйн нэгж, байгууллагад эдийн засгийн урамшуулал олгох.	Ажил олгогчийг дэмжих арга хэмжээний зардлаас бүртгэлтэй ажилгүй иргэнийг байнгын ажлын байраар хангаж ажиллуулж байгаа 11 ахуйн нэгж байгууллагын 25 иргэний цалингийн нөхөн олговорын урамшуулалд 30.8 сая төгрөг зарцууллаа. Хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг 24 сараас дээш хугацаагаар авч ажиллуулж

		байгаа Хот тохижуулах газар, Эрдэнэт ДЦС, Эрдэнэт хивс ХХК, Эрдэнэт-ус ОНӨХК, Монголиан катеринг ХХК зэрэг 5 аж ахуйн нэгжид ажил олгогчийг дэмжих зардлын урамшуулал 1800.0 мянган төгрөгийн дэмжлэг үзүүлсэн байна. Хэрэгжиж байна. 90 %
4.2. Жендэрийн тэгш байдлыг хангах бодлого Бүх үе шат (2007-2021 он):		
<i>Стратегийн зорилт 1.</i> Жендэрийн тэгш байдлын үзэл баримтлалыг үндэсний соёлын дэвшилтэт уламжлал, хүн төрөлхтөний соёл иргэншлийн ололттой хослуулан төлөвшүүлнэ:		
• бүх шатны боловсролын хөтөлбөрийн агуулгыг жендэрийн мэдрэмжтэй болгох;		Эцэг эхийн зөвлөлийн даргын сонгуульд алба хашдаг 50 гаруй эцэг, эхэд “Эцэг эхийн үүрэг, хариуцлага”, “Хүүхдийн хүмүүжил төлөвшил” сэдвүүдээр сургалт явуулсан. Мөн Наран цогцолбор сургууль дээр “Эцэг-эх-сургууль” сургалтыг 2 анги сонгон авч туршилтын журмаар ажиллуулж байна. БСГ-ын дэргэдэх “FM-107.6”-ын зайны сургалтын “Боловсролын цаг” хөтөлбөрийн хүрээнд 5 сарын турш “Гэр бүлд өгөх эм шиг зөвлөгөөнүүд”, “Гэр бүлийн тухай хууль”, “Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх” хуулийг сурталчилсан байна. Иргэний боловсрол хичээлийн хүрээнд 9-р ангийн сурагчдад “Би гэр бүлийн нэг гишүүн” сэдвээр 10 цагийн хичээл заасан байна. Наран цогцолбор сургууль дээр “Гэрлэлт ба гэр бүлийн амьдрал” сургалт явуулж 200 хүн, Албан бус боловсрол төвийн багш нарт “Гэр бүлийн боловсрол” сургалт, 8-р сургуулийн 144 сурагч, 17 багшид “Гэр бүлийн тухай хууль, гэр бүл төлөвлөлт” сэдэвт сургалт, хувийн хэвшлийн “Ийгл” сургуулийн 20 эцэг эхэд “Гэр бүлийн хүчирхийлэл гэж юу вэ” сэдэвт, 7-р сургуулийн 300 гаруй эцэг, эхчүүдэд “Хүүхдийн хүмүүжил, төлөвшил” сургалтыг тус тус явууллаа. Гэр бүлийн ордноос бэлтгэн гаргасан гэр бүлийн талаархи цуврал лекцүүдийг албан бус боловсрол төвийн багш нарт гарын авлага болгон бэлтгэж өгөв. ЕБС-ийн нийгмийн ажилтнуудыг “Гэр бүлд зөвлөн туслагч бэлтгэх” сургалтанд бүрэн хамрууллаа. Анги удирдсан багш, нийгмийн ажилтнууд эцэг эхчүүдийн судалгааг дэлгэрэнгүй байдлаар гаргаж гэр бүлд чиглэсэн сургалт сурталчилгаа, сурган хүмүүжүүлэх хичээлийг боловсролын түвшин, хэрэгцээ шаардлагад нийцүүлэн хэсэгчлэн зохион байгуулах ажлыг эрчимжүүлэх чиглэлээр арга зүйн зөвлөгөөг өгч, хичээлийн хөтөлбөр боловсруулан хэрэгжүүлж байна. Хэрэгжиж байна 70%
• өмчийн болон хөдөлмөрийн харилцаанд эрэгтэй, эмэгтэйчүүдийг адил,		Гэр бүлийн ордон, “Гал голомт” үндэсний хөдөлгөөний Орхон аймгийн салбар хүрээ, Хөгжлийн бэрхшээлтэй эмэгтэйчүүдийн холбооны Орхон аймгийн

	тэгш оролцуулах соёлыг хэвшүүлэх;	<p>салбар зэрэг байгууллагуудтай хамтран ажиллаж байна. Эмэгтэйчүүдийн эрхийг хамгаалах өдрийг угтан Ахмадын хороо, эмэгтэйчүүдийн ТББ-уудаас “Буянтай ээж”, “Мянган ээжийн баяр” зэрэг арга хэмжээнүүдийг зохион байгуулсан. Монгол улсын Ерөнхийлөгчийн ивээл дор зохион байгуулагдаж буй “Монгол тэмүүлэл-эмэгтэйчүүд” сарын аяны хүрээнд аймагт идэвхитэй үйл ажиллагаа явуулж буй эмэгтэйчүүдийн 10 гаруй төрийн бус байгууллагын удирдлагуудын уулзалт зохион байгуулж, хамтран ажиллах талаар санал солилцлоо.</p> <p>Гэр бүлийн ордон, “Гал голомт” үндэсний хөдөлгөөний Орхон аймгийн салбар хүрээ, Хөгжлийн бэрхшээлтэй эмэгтэйчүүдийн холбооны Орхон аймгийн салбар зэрэг байгууллагуудтай хамтран ажиллаж байна. Эмэгтэйчүүдийн эрхийг хамгаалах өдрийг угтан Ахмадын хороо, эмэгтэйчүүдийн ТББ-уудаас “Буянтай ээж”, “Мянган ээжийн баяр” зэрэг арга хэмжээнүүдийг зохион байгуулсан. Олон улсын гэр бүлийн өдрийг угтан “Гал голомт” ҮХ-ний ОАСХ-тэй хамтран “Буянт аав”, Аймгийн гэр бүлийн баяр, Гэр бүл, жендэрийн талаар цуврал лекц, гэр бүлийн аялал, ЕБС-ийн сурагчдийг Гэр бүлийн ордонтой танилцуулах, Гэр бүлүүдийн караоке тэмцээн, шилдэг гэр бүлүүд оролцсон теле кафе гэх мэт олон нийтийг хамарсан арга хэмжээнүүдийг зохион байгуулж орон нутгийн төсвөөс 500,0 мянган төгрөг зарцууллаа.Тус-дэм төрийн бус байгууллагатай хамтран жендэрийн болон хүн худалдаалах, хүүхэд эмэгтэйчүүдэд нөхөн үржихүйн мэдлэг олгох чиглэлээр сургалтууд явуулж 3 удаагийн сургалтанд 150 гаруй өсвөр насны хүүхдүүд болон насанд хүрэгчдийг хамруулсан байна.</p> <p>Хэрэгжиж байна 90%</p>
	<ul style="list-style-type: none"> • удирдах, шийдвэр гаргах түвшинд жендэрийн тэгш байдлыг хангах нөхцөлийг бүрдүүлэх. 	<p>“Гал голомт” Үндэсний хөдөлгөөний Орхон аймгийн салбар хүрээтэй хамтран “Шийдвэр гаргах түвшний эмэгтэйчүүдийн чадавхийг дээшлүүлэх, жендэрийн сургалт явуулж 20 удирдагч эмэгтэйчүүдийг хамрууллаа.</p> <p>Хэрэгжиж байна 90%</p>
4.3. Гэр бүлийн хөгжил, хүн ам зүйн бодлого Бүх үе шат (2007-2021он):		
<i>Стратегийн зорилт 1. Гэр бүлийг хүний аж төрөх таатай орчин болгоход чиглэсэн цогц бодлого хэрэгжүүлнэ:</i>		
	<ul style="list-style-type: none"> • гэр бүлийг уламжлалт соёл, ёс заншлын өвийг хадгалан хөгжүүлэх орчин болгох; 	<p>Гэр бүлийн ордон, “Гал голомт” үндэсний хөдөлгөөний Орхон аймгийн салбар хүрээтэй хамтран гэр бүл, жендэрийн асуудлаар 6 удаагийн сургалт зохион байгуулж 58 хүн хамрагдлаа. Өрх гэр бүл, ялангуяа шинээр гэр бүл болж байгаа залуучуудад жендэрийн талаар ойлголт өгч гэр бүлийн гишүүдийн эрхийг зөрчихгүй байхтай холбогдсон мэдээлэл сургалтыг шинээр гэр бүл болсон 218</p>

		<p>хосыг хамруулан зохион байгуулж гарын авлага түгээлээ. Гэр бүлийн баярын өдрийг тохиолдуулан Цагдаагийн газраас зохион байгуулсан ажлын хүрээнд цагдаагийн 200 гаруй албан хаагчдад “Гал голомт-гэр бүл” сэдвээр 2 цагийн сургалт хийлээ. 13 багийн 60 гаруй гэр бүл оролцуулж “Гэр бүлийн үнэ цэнэ”, “Гэр бүлийн болон гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль”, “Гэр бүлийн төсөв, эдийн засаг” сэдвүүдээр хичээл зааж ярилцлага зохион байгууллаа.</p> <p style="text-align: center;">Хэрэгжиж байна 90%</p>
	<ul style="list-style-type: none"> • ядууралд орсон болон эмзэг бүлэгт хамрагдаж буй гэр бүлийн онцлогт тохирсон “Өрхийн хөгжлийн төлөвлөгөө”-г тэдний өөрсдийн оролцоотойгоор боловсруулж, түүнд Үндэслэн амьжиргааг дээшлүүлэх ажлыг тасралтгүй хэрэгжүүлэх; 	<p>Аймгийн хэмжээнд ядуу өрхийн талаарх мэдээллийн сан бүрдүүлэх, сонгогдсон өрхүүдийн “Өрхийн хөгжлийн төлөвлөгөө” боловсруулж, нийгмийн халамж, хөдөлмөр эрхлэлт, орлого нэмэгдүүлэх үйлчилгээнд хамруулах зорилгоор Баян-Өндөр сумын 19 багийн 407 өрх, Жаргалант сумын 3 багийн 30 өрх, нийт 437 өрхийн судалгааг бэлтгэгдсэн асуулгын маягтын дагуу гарган Өрхийн хөгжлийн дэвтрийг шинээр хэвлүүлж судалгаанд хамрагдсан өрх бүр дээр нээлээ. Бүлгийн зохион байгуулалтанд яаж орж, цаашид хамтарч ажиллах талаар зөвлөгөө өгч мөн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас олгогдож буй жижиг зээл, мэргэжил олгох сургалт, нийтийг хамарсан ажил, ДЗОУБ-тай хамтран ажиллаж гэр бүл, эрүүл мэнд, боловсролын талаар сургалтанд хамруулах талаар мэдээ мэдээллийг нийт 11350 гаруй иргэдэд мэдээлэл сурталчилгаа хийж ажилласан. Мөн Баян-Өндөр, Жаргалант сумдын 437 өрхийг амьжиргааг дээшлүүлэх зорилгоор Баян-Өндөр, Жаргалант сумдын 18 багийн Амьжиргааг дэмжих зөвлөлийн нийт 55 гишүүнд ДЗОУБ-тай хамтран өрх гэрүүдийг ямар замаар бүлгийн зохион байгуулалтанд оруулж болох талаарх сургалтыг зохион байгуулж явуулсан. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих 5 төрлийн үйлчилгээнд 315 өрхийн 541 иргэн хамрагдаж 180772.0 мянган төгрөг, Нийгмийн халамжийн 7 төрлийн үйлчилгээнд 720 өрхийн 2176 иргэн 159557.4 мянган төгрөг, төрийн болон ТББ-тай хамтарч 8 төрлийн ажил үйлчилгээнд 238 өрхийн 598 иргэнд 61106.0 мянган төгрөгийг тус тус зарцууллаа.</p> <p style="text-align: center;">Хэрэгжиж байна 90%</p>
	<ul style="list-style-type: none"> • бүтэн өнчин, хаягдмал, гэр бүлээсээ дайжсан, хараа хяналтгүй хүүхдийг гэр бүлд, эсхүл гэр бүлтэй нь дүйцэхүйц халамжийн таатай орчинд өсгөж хүмүүжүүлэх нөхцөлийг 	<p>Манай аймагт бүтэн өнчин 243 хүүхэд байна Үүнээс Энэрэл асрамжийн төвд 3-18 насны 31 ,19-24 насны 27 хүүхэд амьдарч сурч хүмүүжиж байна .Бусад 185 нь ах эгч эмээ өвөө хамаатан садныдаа байдаг . 2010 он гарсаар бүтэн өнчин хүүхдүүдээс 25 хүүхэдтэй биечлэн уулзаж санал бодлыг сонсож ярилцлага</p>

<p>бүрдүүлэх;</p>	<p>хийв. Энэрэл төвийн бүтэн өнчин хүүхдийн 83 хувь нь ямар нэгэн дугуйлан секцэнд хамрагдаж байна. Шүрэн урлал, наамал урлал баримал, зураг , оёдол хатгамал , бүжиг, үлээвр хөгжим гэх мэт дугуйлангууд Энэрэл төв дээрээ хичээллэж байна.</p> <p>Эцэг эхийн хараа хяналт сул хүүхдийн талаар:</p> <p>Аймгийн ИТХ, ГХУС зөвлөлөөс 2010 оныг “Тэнэмэл хүүхэдгүй аймаг болох” зорилт дэвшүүлэн ажилласан. Үүний хүрээнд Эцэг эхийн хараа хяналт сул тэнэмэл 12 хүүхдийг хүлээн авч уулзаж зөвлөгөө өгч иргэний үнэмлэхгүй байсан 4 хүүхдэд ХТХ-ээс иргэний үнэмлэхний олгож өгөв. ИТХ-ын дарга ГХУС салбар зөвлөлийн хүрээнд хүүхдийг гэр бүлд нь нийгэмшүүлэх зорилгоор Христийн сүмүүдийн удирдлагуудтай тохиролцон 20 хүүхдийн гэр бүлд туслах хүсэлт тавин ажилласан байна. ГХУССЗ-ын хуралд “ Эцэг эхийн хараа хяналт сул хүүхэдтэй хэрхэн ажиллаж байгаа талаар сонсгол оруулж хэлэлцүүлэв. Салбар зөвлөлөөс өгсөн үүрэг даалгаварын дагуу ажил зохион байгуулан ажилласан байна</p> <p>Эцэг эхийн хараа хяналт сул тэнэмэл болон хөдөлмөр эрхэлдэг хүүхдийг нийгэмшүүлэх бичил төслийг иргэн Онол-Эрдэнэ санаачлан 17 хүүхдийг өдрийн үйлчилгээ хөтөлбөрт хамруулан ажиллаж байна. Энэхүү төсөлд хамрагдсан хүүхдүүдээс сургуульгүй байсан 11 хүүхэд АББ-ын 1-3 –р ангид 5 хүүхэд 4-5 –р ангид 6 хүүхэд сурч байна. Энэхүү төсөл нь хүүхдийн сөрөг зан үйлийг засах сургуульд хамруулах, эцэг эхийн буруу дадалд анхаарч ажиллаж байна</p> <p style="text-align: right;">Хэрэгжиж байна 90%</p>
<p>• “Гэр бүл, хүүхдийн цогц хөгжил” хөтөлбөрийг боловсруулж хэрэгжүүлэх;</p>	<p>Гэр бүл цогц хөгжлийн хөтөлбөрийн хүрээнд шинэ мэдээ сонинд гэр бүл булан гаргаж гэр бүлд зориулсан зөвлөмжийг 10 удаа гаргасан байна.</p> <p>“Гэр бүлдээ үүнийг л хүсдэг” сэдэвт зураг зохион бичлэгийн уралдаанд 700 гаруй хүүхэд оролцож улсын хэмжээнд 9 хүүхэд эхний байруудад шалгарсан байна.</p> <p>Баян-Өндөр Жаргалан сумын нэн ядуу өрхөд амьдардаг зайлшгүй тусламж үйлчилгээ шаардлагатай 260 хүүхдийн судалгаа гаргаж ажиллаж байна.</p> <p>Бүтэн өнчин болон хөдөлмөр эрхэлдэг хүнд нөхцөлд амьдардаг 60 гаруй хүүхдэд хувцас болон эд материалын нэг удаагийн тусламж өгсөн байна.</p>

		<p>ЕБС-ийн дунд “Хариу нэхээгүй тус “аян зохион байгуулж аянд 46 анги хамт олны 3500 гаруй хүүхэд багш оролцож амьдралын хүнд нөхцөлд байгаа 32 хүүхдэд тусламж дэмжлэг үзүүлсэн байна.</p> <p style="text-align: right;">Хэрэгжиж байна 90%</p>
	<ul style="list-style-type: none"> • өрх бүр угийн бичгээ хөтөлж, удамшлын доголдол, оюун ухааны хомсдолоос хамгаалах бодлого хэрэгжүүлэх. 	<p>Ургийн баяр нэгдсэн арга хэмжээг зохион байгуулж халх, казах, дөрвөд, буриад үндэстэн ястаны гэр бүлүүд оролцож өөр өөрийн онцлогтой ургийн бичиг хөтлөлтийг сурталчилсан арга хэмжээг Номин, ЛХА телевизээр олон нийтэд сурталчилан таниулах арга хэмжээг зохион байгуулсан. ЕБС-ийн ахлах, дунд ангийн сурагчдын дунд ургийн бичиг хөтлөлтийн ач холбогдол сэдвээр ярилцлага зохион байгуулсан байна. Одоогоор 5800 өрх ургийн бичгийн хөтлөлтийг хийж хэвшээд байна.</p> <p style="text-align: right;">Хэрэгжиж байна 50%</p>
<p><i>Стратегийн зорилт 2. Хүн амын эмзэг бүлгийн хөгжлийг дэмжих хүний эрхэд суурилсан гэр бүл төвтэй төрийн цоги бодлого хэрэгжүүлнэ:</i></p>		
	<ul style="list-style-type: none"> • хүн амын тодорхой бүлгийн онцлог хэрэгцээнд тохирсон урьдчилан сэргийлэх, хөгжүүлэх, хамгаалах, зуучлах нийгмийн үйлчилгээг өргөжүүлэн хөгжүүлэх; 	<p>2007 оноос 2 суманд нийгмийн ажилтнуудыг орон тоогоор ажиллуулж байгаа ба нийгмийн ажилтнууд нь Ахмад настны нийгмийн хамгаалал, Нийгмийн халамжийн, Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн, Гэр бүлийн тухай зэрэг болон бусад холбогдох хууль тогтоомжийг хэрэгжүүлэн ажиллаж байна. Сумд бүрд 7 хүний бүрэлдэхүүнтэй Амьжиргааг дэмжих зөвлөл ажиллаж байна. Мөн ХХҮХ-т хүн амын хөгжил, гэр бүлийн асуудал хариуцсан ажилтны орон тоо нэмэгдсэн болно. Нийгмийн ажилтнуудыг мэргэшүүлж, тогтвор суурьшилтай ажиллуулах зорилгоор нийгмийн ажилтны 3 үе шаттай сургалтанд 30 гаруй нийгмийн ажилтныг хамруулсан. Баян-Өндөр, Жаргалант сумын нийгмийн ажилтан болон багуудад халамжийн хууль, холбогдох журам зааврын эмхэтгэл ном, гарын авлага хүргэлээ. Нийгмийн халамжийн үйлчилгээг хууль тогтоомжийн дагуу хүргэх, хөрөнгийг үр ашигтай зарцуулахад хяналт тавих чиглэлээр сар бүр сумын болон бүх багуудын амьжиргааг дэмжих зөвлөлийн гишүүдийн хурлын ирц, хариуцлагатай ажиллаж, үнэн зөв санал, шийдвэр гаргаж ажилласан байдал, ажлын оролцоо, айл өрхөөр явж нөхцөл байдлыг нь судалж судалгаа гаргасан байдал зэрэгт хяналт тавьж, дүгнэн 144 гишүүнд 14,7 сая төгрөгийн урамшуулал олголоо.</p> <p style="text-align: right;">Хэрэгжиж байна 90%</p>

	<ul style="list-style-type: none"> • өсвөр үе, залуучуудад ардчилсан, эх оронч үзэл, үндэсний уламжлал, хэл соёл, зан заншлыг төлөвшүүлэх; 	<p>Хүүхдийг эх орон, түүх соёл, заншлаа мэдэхийг хүсдэг, түүгээр бахархдаг байх үзлийг төлөвшүүлэхэд чиглэсэн олон талт үйл ажиллагааг өрнүүлэн, ажиллах, хүүхдийн оролцоог хүүхэд багачуудын дунд дэлгэрүүлэн хөгжүүлж, нийгэм дэх өөрчлөлт, шинэчлэл, хөгжил дэвшилд тэдний хувь нэмрийг хөхүүлэн дэмжиж ажиллах зорилтыг дэвшүүлэн хэрэгжүүлж ажиллалаа</p> <p>Хүүхдийн байгууллагын 85 жилийн ойн хүрээнд ЕБС-иудын дунд хүүхдэд эх оронч үзэл төлөвшүүлэх чиглэлээр Үндсэн хуулийн өдрөөр АХА, тэргүүний жагсаалч салаа шалгаруулах, миний Монголын түүх, Үндэсний эрх чөлөөний хувьсгалын мөн чанар, үр дүн, ардын өв уламжлалаас суралцъя, Монгол бичиг-бидний бичиг зэрэг тэмцээн, уралдаан, аяныг зохион байгуулж, давхардсан тоогоор 9800 гаруй хүүхдийг хамрууллаа.</p> <p style="text-align: right;">Хэрэгжиж байна 90%</p>
	<ul style="list-style-type: none"> • хүн амын бүтцэд гарах өөрчлөлт, наслалтын асуудлыг нийгмийн бодлого, хөтөлбөр, хөгжлийн төлөвлөлтөд тусгах орчныг бүрдүүлэх; 	<p>Монгол Улсын хүн амын настжилтын асуудлаархи үндэсний стратеги батлагдсантай холбогдуулан аймгийн БТСГ, ЭМГ, Ахмадын хороотой хамтран “Ахмадын биеийн тамирыг дэмжих” сарын аян зохион байгууллаа. Ахмадын хорооноос “Ахмад үе чөлөөт цаг” цэнгүүнийг 7 хоног бүр тогтмол зохион байгуулж давхардсан тоогоор 1800 гаруй ахмадыг хамрууллаа. Эрүүл мэндийн газар, Ахмадын хороо хамтран “Эрүүл агаар эм” сэдэвт өдөрлөгийг жил бүр зохион байгуулж хэвшлээ. Хүн амын үндсэн үзүүлэлтүүдийг жил бүр тооцож дүн шинжилгээ хийж холбогдох бодлого хөтөлбөрүүдэд бодлогыг тусган ажиллаж байна. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар жилдээ 750-800 ахмад настанг хүлээн авч эрүүл ахуйн шаардлага хангасан орчинд стандартад тохирсон тоног төхөөрөмж, тав тухтай орчинд эмийн бус эмчилгээгээр эмчлэн сувилж, бие бялдрын болон сэтгэл санааны дэмжлэг үзүүлэх зорилгоор “Ахмадын амралт сувилал”-ын барилгын ажил хийгдэж байгаа ба гүйцэтгэл 90%-тай байна. Хөдөлмөрийн 3 талт салбарыг оролцуулсан “Хөдөлмөрийн бага чуулган” хийж 80 гаруй хүн, “Иргэдийн санаачлага-Төрийн дэмжлэг” сэдэвт хөдөлмөр эрхлээгүй иргэдийн зөвлөгөөн хийж 400 гаруй хүнийг оролцуулж зөвлөмж гарган 2011 оныг “Өрхийн амьжиргааг дэмжих жил” болгон зарласан.</p> <p style="text-align: right;">Хэрэгжиж байна 90%</p>
	<ul style="list-style-type: none"> • хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрхийг хамгаалах, нийгмийн амьдралд идэвхтэй оролцох таатай орчныг бүрдүүлэх. 	<p>Орон даяар зохион байгуулагдсан “Хүртээмжтэй орчин” аяны хүрээнд хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн дунд гар бөмбөг, сагсан бөмбөгийн тэмцээн, хүүхдүүдийн дунд дуу, шүлэг, бүжиг, гар урлал, тэргэнцэртэй хүүхдүүдийн</p>

	<p>уралдаан, урлагийн их наадам, хуулийн мэдлэг олгох сургалт, нарийн мэргэжлийн эмч нарын урьдчилан сэргийлэх үзлэг зэрэг ажлуудыг зохион байгуулж, 300 гаруй иргэдийг хамрууллаа. Нээлттэй хаалганы өдрийг зохион байгуулж, иргэдийн хийсэн бүтээгдэхүүнээр үзэсгэлэн худалдааг зохион байгуулж, 30 иргэн оролцож, амжилттай оролцсон 2 иргэнд нийт 50,0 мянган төгрөгийн урамшуулал олгов. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн ОУ-ын өдрийг аймгийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж байгаа нийт төрийн бус байгууллагууд болон холбогдох газруудтай хамтран хийж олон нийтийг хамарсан арга хэмжээнүүдийг зохион байгуулсан байна. Үүнд: Цагаан таягтны өдрийг тэмдэглэн өнгөрүүлэхэд зориулж орон нутгийн төсвөөс 237.0. мянган төгрөг, Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн талаар орон нутагт хэрэгжүүлж байгаа үйл ажиллагааг сурталчилсан Улаанбаатар хотын хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн “Тулга-5” телевизийн хамт олонд дэмжлэг үзүүлж 300.0 мянган төгрөг, Монголын хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн байгууллагуудын үндэсний холбоо Орхон аймгийн зөвлөл байгуулагдсаны 25 жилийн ойн арга хэмжээ болон ХБИ-ын олон улсын өдрийг угтаж үзэсгэлэн худалдаа, уулзалт, сургалт, уралдаан тэмцээний зардалд орон нутгийн төсвөөс 500,0 мянган төгрөг, “Уулын баяжуулах Эрдэнэт үйлдвэр” ХХК-аас 1,0 сая төгрөгийн дэмжлэг тусламж үзүүллээ. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрх ашгийг хамгаалах Олон улсын өдрөөр Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй эцэг эхийн холбооны Орхон аймгийн салбар, Тэгш дүүрэн хөтөлбөр, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг дэмжих чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг төрийн бус байгууллагууд хамтран “Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн өдөрлөг” зохион байгууллаа.</p> <p>Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн олон улсын өдрийг угтаж хөгжлийн бэрхшээлтэй иргэд бүлэг болон ажиллаж өөрсдийн үйлдвэрлэсэн бүтээгдэхүүний үзэсгэлэн худалдаа гаргаж 10 гаруй бүлэг иргэдийн бүтээлүүд оролцсоноос шилдэг бүтээлийг шалгаруулж урамшууллаа. Мөн хүүхдүүдийн дунд гар зургийн уралдаан, томчуудын дунд шатар, даамын тэмцээн, зэргийг зохион байгуулж, байгууллагууд өөрсдийн үйл ажиллагааг сурталчлах, бүлэг болон ажиллаж хамтдаа үр дүнд хүрэхийн чухлыг сурталчлан таниулж, ХБИ-ын төлөө үлгэр жишээ ажиллаж байгаа Баян-Өндөр сумын “Мөнх сүндрэл-2” өрхийн эмнэлгийн үйл ажиллагааг хэвлэл мэдээллийн хэрэгсэлээр нийтэд сурталчлан, Хөгжлийн бэрхшээлтэй иргэний нийгмийн хамгааллын тухай хуулийн сурталчилгаа хийх, төр захиргааны зүгээс хийгдэж байгаа ажлуудыг тайлагнах,</p>
--	---

	<p>өөрөө өөртөө үйлчлэх чадваргүй иргэдэд өөрөө өөртөө туслах баг байгуулах сургалтыг 30 хүнд, өөрөө өөртөө үйлчлэх чадваргүй ганц бие болон хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн асран хамгаалагч нарын уулзалт зэрэг ажлуудыг хийж гүйцэтгэсэн ба нийтдээ 100 гаруй иргэд уг өдөрлөгт оролцлоо.</p> <p>Хэрэгжиж байна 90%</p>
<p><i>Стратегийн зорилт 3. Эцэг, эх үр хүүхдээ эрүүл, саруул өсгөн бойжуулж, боловсрол хүмүүжлийн зөв төлөвшилтэй болгон хөгжүүлэхэд чиглэсэн гэр бүлийн таатай орчныг бүрдүүлэхийг төрөөс дэмжинэ. Төрөлтийг дэмжих замаар хүн амын жилийн дундаж өсөлтийг нэмэгдүүлж, улмаар хүн амаа өсгөх бодлого баримтална:</i></p>	
<ul style="list-style-type: none"> • эхийн эрүүл мэндийг жирэмслэлтийн эхэн үеэс хамгаалах, ургийн бойжилтыг оношлох, хянах, хүүхдийг нэг нас хүртэлх хугацаанд шаардлагатай тохиолдолд нэмэлт тусгай хоол, хүнсээр үнэ төлбөргүй хангадаг үндэсний жишиг боловсруулан тогтоож хэрэгжүүлэх 	<p>Нэмэлт тусгай хоол, хүнсээр үнэ төлбөргүй хангадаг үндэсний жишиг боловсруулагдаагүй боловч зуны чийрэгжүүлэлтийн үйл ажиллагааг ДЗОУБ-ын санхүүжилтээр 9 дэх жилдээ зохион байгуулж байгаа ба 2010 оны зуны чийрэгжүүлэлтийн хүрээнд өрхийн эмнэлгийн сувилал, цэцэрлэгийн эмч нийт 40 хүнд Нар, ус, агаараар хэрхэн хүүхдийг чийрэгжүүлэх, иллэгийг хэрхэн хийх талаарх 2 сургалтыг ДЗОУБ-ын санхүүжилтээр, УБ хотын хүүхдийн сувилалтай хамтран явуулав. Зуны чийрэгжүүлэлтийн хүрээнд 0-5 насны 20 хүүхэд нийт 200 хүүхэд хамрагдаж, хүүхдүүдийн бие бялдын түвшин дээшилж чийрэгжсэнээр биеийн жин дунджаар 150-300 гр, түүнээс дээш 1500 гр хүртэл нэмэгдсэн үр дүн гарсан байна. Орон нутгийн төсвөөс 2 сая төгрөгний санхүүжилтээр сум өрхийн эмнэлэг, БОЭТ-д эмзэг бүлгийн 360 жирэмсэн эхчүүдэд төмөр агуулсан аминдэм эмийг 10800 ширхэгийг олгон, эмчилгээний үр дүн 98,2 хувьтай байна. Жирэмсэн эхчүүдэд Нөхөн үржихүйн эрүүл мэнд хөтөлбөрийн дагуу 56000 төмрийн бэлдмэл олгогдсон байна. Эдгээр үйл ажиллагааны үр дүнд жил тутам цус багадалтай жирэмсэн эхчүүдийн тоо буурч байна.</p> <p>Хэрэгжиж байна 90%</p>
<ul style="list-style-type: none"> • амаржсан эхчүүдийн хүүхэд асарсны тэтгэмжийг сарын дундаж цалингаас багагүй байлгаж, нийгмийн болон эрүүл мэндийн даатгалын шимтгэлийг төрөөс хариуцан төлөх; 	<p>Дээд шатны байгууллагын шийдвэр гараагүй байна.</p> <p>Хугацаа болоогүй.</p>
<ul style="list-style-type: none"> • 0-18 насны дөрөв ба түүнээс олон хүүхэдтэй гэр бүлийн эх /эцэг/-д олгох цалингийн, нийгмийн болон эрүүл мэндийн 	<p>Дээд шатны байгууллагын шийдвэр гараагүй байна.</p> <p>Хугацаа болоогүй.</p>

даатгалын урамшууллын тогтолцоог хуульчлан хэрэгжүүлэх;	
<ul style="list-style-type: none"> • 0-18 насны дөрөв болон түүнээс дээш хүүхэдтэй өрхийг орон сууцны байраар хөнгөлөлттэй үнээр хангах бодлого хэрэгжүүлэх. 	Дээд шатны байгууллагын шийдвэр гараагүй байна. Хугацаа болоогүй.
<i>Стратегийн зорилт 4. Хүүхэд эхээс төрсөн цагаасаа зургаан нас хүртэл гэр бүл, эсхүл түүнтэй дүйцэх орчинд өсөж торних, зөв хүмүүжил, ёс суртахуунтай болох, сургуулийн өмнөх боловсрол олгоход төрөөс онцгой анхаарна:</i>	
<ul style="list-style-type: none"> • хүүхдийг хөхөөр хооллох, зургаан нас хүртэл нь эрүүл мэндийн тусгай хяналтанд байлгах нөхцөл бүрдүүлэх; 	<p>Зуны чийрэгжүүлэлтийн хүрээнд ДЗОУБ ЭНХХ, Эрүүл мэндийн газар, өрхийн эмнэлгүүдийн хооронд үйл ажиллагааны хамтын гэрээ байгуулж, 8 өрхийн эмнэлэг, Есүсийн чуулган, Найдвар төв нийт 10 цэгт нийт 5,9 сая төгрөгийн санхүүжилтийг олгон, 0-5 насны нийт 200 хүүхэд хамрагдаж, хүүхдүүдийн бие бялдрын түвшин дээшилж чийрэгжсэнээр биеийн жин дунджаар 150-300 гр, түүнээс дээш 1500 гр хүртэл нэмэгдсэн үр дүн гарсан байна.</p> <p>Орон нутгийн төсвөөс 2,0 сая төгрөгийн дэмжлэгтэйгээр 20-р цэцэрлэгийн зуны сувиллын ангид 0-2 насны суурь өвчтэй, эмзэг бүлгийн өдөрт дунджаар 20-23 хүүхэд, давхардсан тоогоор 760 хүүхэд хамрагдсан байна.</p> <p>Эрүүлжүүлэх чийрэгжүүлэх төлөвлөгөөний дагуу айргаар шавших, шар сүүнд оруулах, усаар чийрэгжүүлэх, иллэг массаж хийх, ясны шөлөнд оруулах, давсан замаар явах, элсэн талбайд тоглох зэргээр чийрэгжүүллээ. Мөн чийрэгжүүлэлтэнд айраг, шар сүү, загасан тос, давс зэргийг ашиглан сүү таргийг 7 хоногийн цэсэнд өдөр бүр өгч, эцэг эхчүүдэд “Хүүхдийг нар ус агаараар чийрэгжүүлэхийн ач тус” сэдвээр зөвлөгөө өгч, гарын авлага тараасан байна.</p> <p>Дэлхийн зөн олон улсын байгууллагаас өрхийн эмнэлэг болон сумын эмнэлэгт “Ээжүүдийн клуб”-ыг 15-ийг байгуулан, 21.0 сая төгрөг зарцуулж, 3 төрлийн 3200 ном, 300 плакат, жигнүүр, савны ком, өлгий, банн, хүүхэдтэй зэргийг хүлээлгэж өгчээ.</p> <p>“Ээжүүдийн клуб”-ын хүрээнд Жаргалант сум, 11 өрхийн эмнэлгийн сургалтанд 946 жирэмсэн эх, 874 хөхүүл эх, 2256 бага насны хүүхэдтэй эх, хүүхдийн нэмэгдэл хоолны сургалтанд 748 эцэг эх хамрагдсан байна. Энэ ажилд сайн</p>

		<p>дурын 78 ээжийг бэлтгэж сургалтыг хамтран явуулж байна.</p> <p>Хэрэгжиж байна 90%</p>
	<ul style="list-style-type: none"> • амьжиргааны доод түвшнээс доогуур орлоготой өрхийн хүүхдийг зургаан нас хүртэл нь насны онцлогт тохирсон эрүүл хоол хүнсээр хөнгөлөлттэй үнээр хангах; 	<p>Дээд шатны байгууллагын шийдвэр гараагүй байна.</p> <p>Хугацаа болоогүй.</p>
	<ul style="list-style-type: none"> • хүүхдийг бие бялдар, эрүүл мэнд, оюун ухаан, сэтгэцийн зөв хөгжилтэй, үндэсний хэл, сэтгэлгээтэй болгон хүмүүжүүлэхэд эцэг, эх, эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын байгууллагын үүргийг өндөржүүлэх. 	<p>Аймгийн хэмжээнд хараа хяналтгүй, эмзэг бүлгийн хүүхдүүдийг байршил, хаягийн дагуу дахин бүртгэл явуулж, ар гэрийн амьдрал байдалтай танилцав. Говил баг дахь хогийн цэгт амьдардаг нэг өрхийн 2 бага насны хүүхэд татаж унадаг, амьсгалын замын өвчтэй байсныг илрүүлэн ЭМГ-т мэдэгдэн эрүүл мэндийн үзлэгт оруулж, эмнэлгийн үйлчилгээнд хамруулав.</p> <p>БСГ, ЭМГ, ДЗОУБ-тай хамтран ЕБСургуулийн 9-11-р ангийн сурагчдын дунд Нөхөн үржихүйн эрүүл мэндийн аймгийн IV олимпиадыг зохион байгуулж 11 сургуулийн 251 хүүхэд оролцсон байна. БСГ, ЭМГ-тай хамтран ЕБС-ийн эрүүл мэндийн хичээлийн багш нарын дунд ур чадварын олимпиадыг 5 дахь жилдээ зохион байгуулж дүнг гаргав. Өсвөрийн эмч нарыг бэлтгэх зорилгоор ЭМГ-ын сургалтын танхимд сургууль бүрээс 4 - 5 хүүхэд нийт 40 гаруй сурагчдыг 14 хоногийн сургалтанд хамруулан сургаж, “Сургагч багш” сертификат олгож, гарын авлага материалаар хангав.</p> <p>Сургууль, цэцэрлэгүүдэд хүүхдийн сурч хүмүүжих, орчны аюулгүй байдлын хангалт, осол гэмтлээс урьдчилан сэргийлэх чиглэлээр үзлэгийг явцын дунд хийсэн бөгөөд цэцэрлэг, сургуулийн үүд, орчинд хальтиргаа гулгаагүй байлгах, автомашины замын ойролцоо байгууллагууд анхааруулах, таних тэмдэг тавих, хогийг зориулалтын саванд хийж тээвэрлүүлэх, багш нарын хувцас өлгөх зориулалтын өрөөтэй болох зэрэг шаардлагуудыг тавьж хэрэгжилтэнд хяналт тавиж ажиллав.</p> <p>Аймгийн ЭМГ-тай хамтран ЕБС-ийн 5 сургуулийн 8-9-р ангийн сурагчдын дунд “Эмнэлгийн анхны тусламж хэрхэн үзүүлэх вэ” сэдэвт үзүүлэх сургууль зохион байгуулж анхан шатны дадлага олгосон бөгөөд үйл ажиллагааг Номин, Лха ТВ-ээр сурталчлав. Сургуулиудын оролцоо, идэвхийг үнэлж 1,2,3 байр эзлүүлэн мөнгөн шагнал гардуулж, сургуулийн эмч, багш нарт эрүүл мэндийн боловсролын сэдэвт ном олгосон байна.</p> <p>ЕБС-иудад хөгжимт дасгал, гимнастикийн цагтай болгох тухай аймгийн Засаг</p>

	<p>даргын захирамж гарч нийт сургууль, цэцэрлэгүүдэд үлгэрчилсэн дасгалын CD олгож ажилласан байна.</p> <p>СӨББ-ын хүүхдүүдийн дунд явган аялал, “Хөгжөөнт буухиа” тэмцээнийг зохион байгуулав. Тэмцээнд нийт 16 цэцэрлэгийн 160 хүүхэд, 32 багш оролцож, 3 төрөл, 13 үе шатлалаар хурд, хүч авхаалж самбааг сорьсон байна.</p> <p>Хэрэгжиж байна 90%</p>
<p>4.4. Боловсролын хөгжлийн бодлого Нэгдүгээр үе шат (2007-2015 он):</p>	
<p><i>Стратегийн зорилт 1. Суралцагчдад хүртээмжтэй, чанартай, хэрэгцээнд нь нийцсэн боловсрол эзэмших тэгш боломж бүрдүүлнэ:</i></p>	
<p>• бага насны хүүхдийг сургуулийн өмнөх боловсролд бүрэн хамрагдах боломж нөхцөлийг бүрдүүлэх</p>	<p>Сургуулийн өмнөх боловсролд хамрагдах хүүхдийн тоо, хүчин чадлыг нэмэгдүүлэх зорилгоор Их залуу багт 140 хүүхдийн хүчин чадал бүхий эцэцрлэг барьж ашиглалтанд орууллаа. Мөн Баянцагаан багт 120 хүүхдийн хүчин чадал бүхий цэцэрлэгийн барилгыг барьж эхлүүлсэн ба 2011 онд Эрдэнэ багт мөн цэцэрлэг барихаар улсын төсөвт туссан болно. Мөн 60 хүүхдийн хүчин чадал бүхий хувийн өмчийн “Анжелс” цэцэрлэг шинээр байгуулагдсан.</p> <p>2, 3, 7 дугаар цэцэрлэгт ашиглагдахгүй байсан анги танхимыг засварлан 5 бүлгийг нээн, тохижуулж, сургалт хүмүүжлийн үйл ажиллагаа явуулж, сургуулийн өмнөх боловсролын хамран сургалт 89,4 хувьд хүрсэн.</p> <p>Энэ хичээлийн жилд төрийн өмчийн 18, төрийн бус өмчийн 3 цэцэрлэгийн үндсэн сургалтанд 4036, хувилбарт сургалтад 498 бүгд 4534 хүүхэд сургуулийн өмнөх боловсролд хамрагдаж, сурч, хүмүүжиж байгаагаас төрийн бус өмчийн “Хөөрхөн гүнж”, “Миний гэр”, “Солонго” цэцэрлэгүүдэд 150 хүүхэд хүмүүжиж байна.</p> <p>Сургуулийн өмнөх боловсролд хамрагдсан хүүхдийн тоо 432-оор үүнээс цэцэрлэгийн үндсэн сургалтанд хамрагдагсад 233-аар, хувилбарт сургалтанд хамрагдагсад 199-ээр нэмэгдсэн байна.</p> <p>Сургуулийн өмнөх боловсролын хамран сургалт өнгөрсөн хичээлийн жилд 80.0 хувь байсан бол энэ жил 85.2 хувьтай болж, 5.2 хувиар өссөн байна.</p> <p>Хэрэгжиж байна 90%</p>
<p>• бүх шатны боловсролын байгууллагын суралцагчид болон багшийн хүйсийн харьцааг тэнцвэртэй болгох;</p>	<p>Энэ хичээлийн жилд төрийн болон төрийн бус өмчийн сургуульд 974 багш ажиллаж байгаагаас эмэгтэй багш 816 буюу 83.7 хувь, эрэгтэй багш 158 буюу 16.2 хувийг эзэлж байна.</p> <p>Мөн 18139 сурагчид суралцаж байгаагаас бага ангид суралцагчдын 48.5,</p>

		<p>дунд ангид 50.2, ахлах ангид 53.0 хувийг тус тус эмэгтэй сурагчид эзэлж байна. Дээрх дүнгээс үзэхэд суралцагчдын хүйсийн харьцааны тэнцвэр хэвийн харьцаатай байна.</p> <p style="text-align: center;">Хэрэгжиж байна 70%</p>
	• боловсрол нөхөн олгоход дэмжлэг үзүүлэх;	<p>Албан бус боловсрол төвд 129, Говилд 18, Баянцагаан 16, Рашаант 10, Шанд 24, Жаргалант суманд 18 хүүхэд, залуучуудыг бичиг үсгийн болон боловсрол нөхөн олгох сургалтанд хамруулсан. Үүнээс бичиг үсгийн сургалтанд 52, бичиг үсгийн дараах сургалтанд 82, боловсрол нөхөн олгох танхимаар 65, цугларалтаар 40, эчнээгээр 18 хүүхэд, залуучууд суралцсан байна.</p> <p>Их залуу багийн байранд сургуульд огт суугаагүй 6, сургууль завсардсан, бичиг үсэг бага мэдэх 8 хүүхдийг бичиг үсгийн зуны сургалтанд хамруулсан.</p> <p style="text-align: center;">Хэрэгжиж байна 90%</p>
	• хөдөөгийн малчин өрхийн 0-6 насны хүүхдэд сургуулийн өмнөх боловсрол олгох үйл ажиллагааг нүүдлийн аж байдалд нь тохируулан зохион байгуулах;	<p>Жаргалант сумын цэцэрлэг нь зориулалтын гэр цэцэрлэгтэй бөгөөд 6-8-р сард нүүдлийн гэр цэцэрлэгийг 3 цэгт ажлуулан, малчин өрхийн 42 хүүхдийг сургуулийн өмнөх боловсролд хамруулсан байна. Мөн нүүдлийн цэцэрлэгийг 1 цэгээр нэмэгдүүлэн өмнөх оноос 16 хүүхдэд сургуулийн өмнөх боловсрол илүү олгосон байна.</p> <p>ХХ цэцэрлэг нь “Бүх нийтийн боловсролын үр дүнд түргэн хүрэх санаачилгын түншлэл” хөтөлбөрийн хүрээнд 6,7 сая төгрөгийн гэр цэцэрлэг хүлээн авч, зуны сувилалын бүлэг хичээллүүлэн, 23 хүүхдийг хамруулж, орон нутгийн төсвөөс 2,0 сая төгрөгийн дэмжлэг үзүүлсэн.</p> <p style="text-align: center;">Хэрэгжиж байна 90%</p>
	• 6 настай хүүхдийг сургуульд бүрэн хамруулах	<p>Ерөнхий боловсролын сургууль 12 жилийн тогтолцоонд шилжиж 6 настай хүүхдийг сургуульд элсүүлэн сургах бэлтгэл ажлыг ханган сургуулиуд өөрийн хамран сургах тойргийн багтай хамтран айл өрхүүдээр явж 6 настай хүүхдийн тоог гаргаж зохион байгуулалтыг хийсэн.</p> <p>Аймгийн хэмжээнд 6 настай 1327 хүүхэд сурч байгаагаас 1-р ангид шинээр 1297 хүүхэд элсэн орсон байна. Хүн амын жилийн эцсийн тооллогоор 1299 хүүхэд байсан тул 6 настай сурагчид бүрэн хамрагдсан.</p> <p style="text-align: center;">Биелсэн 100%</p>
	• хөвгүүдийн боловсролын түвшинг дээшлүүлэхэд чиглэсэн хөтөлбөр хэрэгжүүлэх;	<p>“Жендерийн тэгш байдлыг хангах” үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх орон нутгийн дэд хөтөлбөр боловсруулан ажиллаж байна.</p> <p>Энэ хөтөлбөрийн хүрээнд хөвгүүд боловсролтой байхын ач тус, өрх гэр, эх</p>

		<p>орны өмнө хүлээх үүрэг хариуцлагын талаар эцэг, эхчүүд, сурагчдын дунд төрөл бүрийн ажил зохион байгуулж байна.</p> <p>Үүний үр дүнд эх эцгийн зүгээс хөвгүүдэд хандах хандлага өөрчлөгдөж бага, суурь боловсролын боловсрол эзэмшигчдийн хүйсийн харьцаа тогтвортой хадгалагдан хөвгүүд сургалтын явцад ажил үйлдвэрлэлд шилжих явдал багассан.</p> <p>Харин суурь боловсрол төгсөгчдөөс зах зээлийн эрэлт хэрэгцээ, амьдралын нөхцлөөс шалтгаалан МСҮТ болон ажил үйлдвэрлэлд хөвгүүдээс шилжин суралцаж ажиллах нь их байгаа тул ахлах ангид охидын эзлэх хувь илүү байна.</p> <p>Хэрэгжиж байна 70%</p>
	<ul style="list-style-type: none"> • ерөнхий боловсролын сургуулийн дотуур байрны тохилог орчинг бүрдүүлж, дотуур байранд суух хүүхдийн тоог 2.1 дахин нэмэгдүүлэх; 	<p>Жаргалант сумын сургууль 96, Мон-Туркийн сургууль 85, “Ирээдүйн одод” 50 хүүхэд дотуур байранд байрлуулж байгаа ба цэвэр, бохир усанд холбогдсон байртай болно. Өнгөрсөн онд “Ирээдүйн одод” сургуулийн дотуур байранд Дэлхийн банкны санхүүжилтээр бэлтгэгдсэн хөнжил, гудас, цагаан хэрэглэл болон гал тогооны тоног төхөөрөмж зэрэг 18.8 сая төгрөгийн эд хогшлийг өгсөн. Мөн “Үр дүнд түргэн хүрэх санаачлага төсөл”-өөс Жаргалант сумын сургуулийн дотуур байрны иж бүрэн засварыг 94.0 сая төгрөгөөр хийж, гэрийн нөхцөлд ойртуулж тохижуулсан.</p> <p>Хэрэгжиж байна 90%</p>
	<ul style="list-style-type: none"> • ерөнхий боловсролын сургуулийн суралцагчдын “Үдийн цай” хөтөлбөрийг үргэлжлүүлэх; 	<p>Аймгийн хэмжээнд 1-5 дугаар ангийн 262 бүлгийн 8476 сурагч “Үдийн цай” хөтөлбөрт хамрагдаж байна. Хөтөлбөрийн өдөр тутмын хяналтыг сургуулийн эмч, эмчгүй сургуулиудад бага ангийн сургалтын менежерүүд хариуцан ажиллаж байна. Мөн Боловсрол, соёлын газрын дэргэд хяналт тавих орон тооны бус зөвлөлийг байгуулан, тайлангийн хугацаанд 8 удаагийн хяналт шалгалт хийгдсэн байна.</p> <p>“Үдийн цай” хөтөлбөрийн хэрэгжилтийн талаар судалгаа авч үзэхэд ерөнхий боловсролын сургуулиудын 87.5 хувь нь өөрийн байран дахь цайны газрыг түшиглэн долоо хоногийн 3-5 өдөрт нь сурагчдад халуун хоол олгож байна. Нийтдээ 8-15 нэр төрлийн хүнсний бүтээгдэхүүн, халуун хоолыг 7-14 хоногийн давтамжтайгаар өгч үйлчилж, эцэг, эхчүүдэд хоол, бүтээгдэхүүний чанар, хүртээмжийн талаар сурталчилгаа хийж, санал, гомдол авч, барагдуулж ажиллаж байгаа бөгөөд хөтөлбөрийн санхүүжилтэнд 574,7 сая төгрөг зарцуулсан байна.</p>

		Хэрэгжиж байна 90%
<ul style="list-style-type: none"> • 2010 он гэхэд хүн амын бичиг үсэг тайлагдалтын түвшинг 99.0 хувьд хүргэх 	<p>Албан бус боловсрол төвд 129, Говилд 18, Баянцагаан 16, Рашаант 10, Шанд 24, Жаргалант суманд 18 хүүхэд, залуучуудыг бичиг үсгийн болон боловсрол нөхөн олгох сургалтанд хамруулсан. Үүнээс бичиг үсгийн сургалтанд 52, бичиг үсгийн дараах сургалтанд 82, боловсрол нөхөн олгох танхимаар 65, цугларалтаар 40, эчнээгээр 18 хүүхэд, залуучууд суралцсан байна.</p> <p>Бичиг үсгийн тайлагдалт аймгийн хэмжээнд 99.3 хувьтай байна.</p>	Биелсэн 100%
<i>Стратегийн зорилт 2. Боловсролын бүх түвшний стандарт сургалтын хөтөлбөрийг тухайн үеийн суралцагчийн хэрэгцээ, нийгмийн шаардлагад нийцүүлэн боловсронгуй болгон</i>		
<ul style="list-style-type: none"> • шинжлэх ухаан, технологийн ололтод тулгуурлан боловсролын стандартын шалгууруудыг нарийвчлан тогтоох; 	<p>БСШУЯамнаас боловсролын стандартын шалгууруудыг нарийвчлан тогтоож хэрэгжүүлж байна.</p>	Хэрэгжиж байна 90%
<ul style="list-style-type: none"> • бүх түвшний боловсролын агуулгыг үндэсний ухамсар, мэдрэмж, түүх, соёлоороо бахархах үзлийг төлөвшүүлэх, өөрийн соёлыг дээдлэхийн хамт бусдын соёлд хүндэтгэлтэй хандах, оюун ухааныг эрхэмлэх, бүтээлчээр сэтгэх чадвар, мэдлэг, хүмүүжил олгоход чиглүүлж, суралцагчдын сонгох боломжийг өргөжүүлэх; 	<p>Хүүхдэд эх оронч үзэл төлөвшүүлэх чиглэлээр цуврал арга хэмжээний төлөвлөгөө боловсруулан хэрэгжүүлж байна. Хөтөлбөрийн хүрээнд эх оронч үзэл төлөвшүүлэх чиглэлээр цуврал лекц 9, урлаг, спортын уралдаан, тэмцээн 12, бусад арга хэмжээ 11-г зохион байгуулж, 13210 хүүхэд хамрууллаа.</p> <p>Мөн хичээлийн нээлт, аливаа томоохон арга хэмжээг төрийн дуулалаар эхлүүлэх, хүүхэд бүрт төрийн дуулалыг цээжлүүлэх, ардын урлагыг дэмжих олон талт арга хэмжээ зохион байгуулж хэвшсэн.</p>	Хэрэгжиж байна 90%
<ul style="list-style-type: none"> • сургуулиудыг олон улсын боловсролын стандартад нийцсэн сургалтын хөтөлбөр, төлөвлөгөөтэй болгох; 	<p>12 жилийн сургалтын төлөвлөгөөнд дүн шинжилгээ хийж, сургуулийн удирдлага, мэргэжлийн багш нарын хүрээнд сургалтыг зохион байгуулсан. ЕБС-ийн 16 сургуулиас 8–н сургууль сургалтын төлөвлөгөө 1–ийг, 11 сургууль сургалтын нэмэлт төлөвлөгөөг сонгож сургалтын үйл ажиллагааг явуулсан. Тухайн мэргэжлийн боловсролын стандартад нийцүүлэн сургалтын хөтөлбөрийг жирийн, гүнзгийрүүлсэн сургалттай ангийн, сонгон судлах ангийн хүрээнд анги тус бүрээр хичээлийн, бүлэг сэдвийн, нэгж хичээлийн, жилийн гэхээрэг түвшин бүрт хөтөлбөрийг боловсруулан сургалтанд ашиглаж байна</p> <p>ЕБС-д сургалтын хувибарт хөтөлбөрүүдийг өөрийн сургуулийн онцлогт тохируулан сонгож сургалтанд ашиглаж байна. Энэ хичээлийн жилд гүнзгий ангид гадаад хэл 735, математик 805, хими 198, физик 207, бусад чиглэлээр 30</p>	

		сурагч хичээллэж байна. Хэрэгжиж байна 90%
• боловсролын шинэчлэл-өөрчлөлтийг эхлэн туршиж зүгшрүүлдэг “Туршилтын бааз сургуулиудын лаборатор бүтэц”-ийг буй болгоно. Үүнд: Улаанбаатар хотод 10 хүртэл, аймаг бүрт 2 хүртэл тооны сургуулийг сонгох буюу шинээр байгуулах замаар хамруулж, боловсролын шинэчлэлийн санаачилгыг дэмжих;	Боловсрол соёлын газарт Байгалийн ухаан, техник хөдөлмөр, дуу хөгжим, гадаад хэл, бага боловсролын сургалт аргазүйн төвүүдийг тохижуулж нээсэн. “Баян-Өндөр” цогцолбор сургуулийн 6-р бага сургуулийг БСГ-ын харьяа түшиц сургууль болгон ажиллаж байна. 6-р сургуулийн багш сурагчид дээрх чиглэлийн сургалт арга зүйн төвүүдтэй сургалт болон арга зүйн чиглэлээр багш сурагчид хамтран ажиллаж байна. Хэрэгжиж байна 50%	
• бүх нийтийн монгол хэл, бичгийн боловсролыг тасралтгүй дээшлүүлж, бүх шатны сургуульд эх хэлээ төгс эзэмшиж ашиглах, бичих, илтгэх ур чадварыг хөгжүүлэх нөхцөл боломжийг нэмэгдүүлэх;	Энэ хичээлийн жилд ерөнхий боловсролын сургуулийн 4-9-р ангийн 10418 сурагч монгол бичгийн хичээл судаллаа. Багш, сурагчдын монгол бичгийн чадварыг нэмэгдүүлэх, идэвхжүүлэх зорилгоор монгол бичгийн бага олимпиадыг 8 төрлөөр зохион байгуулж, нийт сурагч, мэргэжлийн болон бага ангийн багш нарын 20 орчим хувь нь хамрагдсан байна. Мөн “Орхон” цогцолбор сургууль санаачлан байгууллага, анги, тэнхимийнхээ хаягийг монгол бичгээр бичиж, байрлууллаа. Аймгийн нийт багш, сурагчид “Хүмүүн бичиг” сонинг сургалтад ашиглах хөдөлгөөн өрнүүлснээр энэ жил захиалгын тоо өмнөх жилээс 120-оор нэмэгдсэн. 17-р сургуулиас “Би монгол хүн” сэдвийн дор намтар, түүхээ монгол бичгээр бичих хөдөлгөөн өрнүүлж, сургуулийн нийт багш, сурагчдыг хамруулсан. Монгол хэл, бичгийн багш нарт 3-р сарын 25-29-ний хугацаанд МУИС-ийн багш Монгол хэл, соёлын сургуультай хамтран заах арга зүйн чиглэлээр сургалт, нийт монгол хэлний багш нар монгол бичгийн холбох ёс, түүнийг заах аргазүй, монгол бичгээр хичээнгүй бичих аргазүй, үсгийн тэг хэлбэрийн тухай ойлголтыг гүнзгийрүүлэх, харилцан туршлага солилцох сургалт явуулсан. Монгол бичгийн гайхамшиг, онцлог, бичлэгийн олон хэлбэрийг таниулах зорилгоор багш, сурагчдын дунд уран бичлэгийн уралдаан зохион байгуулж, эцэг, эхчүүдэд сурталчлан нийт 340 орчим эцэг, эх үзэж, сонирхлоо. Монгол бичгийн хавсарсан болон бие даасан кабинет байгуулж, шинээр 6 кабинет гэрчилгээ авсан байна. Монгол бичгийн тэргүүний уншигч шалгаруулах “Үндэсний бичиг мину” улсын 5-р уралдаанд манай аймгаас 10 сурагч оролцож, 3 сурагч хүрэл медаль,	

		тусгай байрын шагнал хүртлээ. Хэрэгжиж байна 90%
	• 2015 онд багтаан англи хэлийг бүх нийтийн голлох гадаад хэл болгох;	2006-2008 оны хичээлийн жилээс эхлэн 4-р ангиас эхлэн англи хэлний сургалт хичээлээр орж эхэлсэн. Аймгийн хэмжээнд нийт 13113 сурагч албан ёсоор англи хэлийг судалж, 611 сурагч гүнзгийрүүлэн судалж байна Хэрэгжиж байна 70%
	• 2015 он хүртэлх хугацаанд бүх нийтийн англи хэлний сургалтын чанарыг дээшлүүлж, дээд боловсрол эзэмшигчид ажил, мэргэжлээрээ шаардлагатай мэдээллийг англи хэлээр ашиглах чадвартай болгох. 2021 он гэхэд төрийн захиргааны төв байгууллагын ажилтнууд албан ажлаа англи хэлээр явуулах чадамжтай болох;	Англи хэлний үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэн ажиллаж, аймгийн Засаг даргын зөвлөлийн хурлаар хөтөлбөрийг хэрэгжилтийг хэлэлцүүлэн, цаашид анхаарах асуудлыг тодорхойлон хэлэлцлээ. Боловсрол, соёлын газрын мэргэжилтнүүд хичээлийн жилд 2-с доошгүй удаа нийт ерөнхий боловсролын сургууль дээр ажиллаж, англи хэлний бүх багш нартай уулзалт хийж, ээлжит хичээлийн хөтөлбөр, төлөвлөгөө, стандартын биелэлтийг хэрэгжүүлж байгаатай танилцан, сургалтын хөтөлбөрийг сургуулийн хэмжээнд боловсруулж мөрдөхөд шаардагдах мэргэжлийн санал, зөвлөгөөг өгч ажиллаж байна. Ерөнхий боловсролын сургуулиуд дээр англи хэлний 31 кабинет байгуулан, сургалтанд хэрэглэж байна. Мөн АНУ-ын Элчин сайдын яамнаас 500 ам доллар, Олон улсын Койка байгууллагаас 14.0 мянган ам долларын төсөл хэрэгжүүлэн, сургалтын хэрэглэгдэхүүн, ном гарын авлага, CD зэргээр хангаж, БСГ-т хүмүүнлэгийн ухааны багш нарын мэргэжил дээшлүүлэх сургалтын төвийг байгууллаа. Багш, суралцагчдын дунд англи хэлний баяр, олимпиад, уралдаан тэмцээнийг олон хэлбэрээр зохион байгуулж, англи хэл сурах идэвхийг өрнүүлэн ажиллаж, улсын олимпиадаас 22 медаль авсан ба алт 10, мөнгө 4, хүрэл 8 хүртсэн байна. Гадаад хэлний гүнзгийрүүлсэн сургалттай 36 дэд бүлэг 538 хүүхдээс түвшин тогтоох шалгалт авахад аймгийн дундаж стандарт 80.3, АВ-ийн эзлэх хувь 34,2, гүйцэтгэл 67,4 хувьтай дүгнэгдсэн байна. Хэрэгжиж байна 70%
	• боловсролын хөгжлийн бодлогод дүн шинжилгээ хийх, шинэчлэлийн онол-арга зүйн үндсийг боловсруулах судалгааны чадавхийг бэхжүүлж, төрөөс санхүүжүүлэх.	БСШУЯам, Боловсролын хүрээлэн, судалгааны байгууллагуудын төвшинд хийгдэж байгаа Хугацаа болоогүй

<i>Стратегийн зорилт 3. Багшийн мэргэжил, арга зүйн хөгжил болон цалин хөлс, урамшуулал, нийгмийн асуудлыг цогцоор нь шийдвэрлэж, энэ чиглэлд хөрөнгө оруулалтыг эрс нэмэгдүүлнэ:</i>	
<ul style="list-style-type: none"> • багш, удирдах ажилтан бэлтгэх, мэргэжил дээшлүүлэх тогтолцоог шинэчлэн сайжруулж, энэ чиглэлд мэргэжлийн төрийн бус байгууллагын оролцоог нэмэгдүүлэх; 	<p>“Боловсролын салбарын шинэчлэл” төсөл, “Эмзэг бүлгийн хүмүүсийн боловсрол-Санхүүгийн хямралын эсрэг” төслийн хүрээнд багш сурагчдын ажиллах таатай орчин бүрдүүлэх, ном гарын авлагаар хангахад 34.8 сая төгрөг зарцууллаа. Багш нарын арга зүйн хөгжилд зориулж Боловсрол, соёл шинжлэх ухааны яам, "ЖАЙКА" олон улсын байгууллагаас 191.0 мянган төгрөгийн ном, хичээлийн CD-г нийлүүллээ.</p> <p>Дэлхийн банкны санхүүжилтээр хэрэгждэг “Үр дүнд түргэн хүрэх санаачилгын төсөл”-өөс Жаргалант, 7-р сургуулиудад Багшийн хөгжлийн төв, сургалтын 30 компьютер, 8 принтер, 2 канон нийт 19,7 сая төгрөгийн тоног, төхөөрөмж, 21 ангийн 62,0 сая төгрөгийн багшийн ширээ, сандал, самбар нийлүүлсэн. Мөн 8 сургуульд Боловсрол, соёл шинжлэх ухааны яамны “Үр дүнд түргэн хүрэх санаачилга” төсөл хөтөлбөрийн хүрээнд 47,5 сая төгрөгийн үнэ бүхий багш, сурагч ширээ сандал, 7, 14-р сургуульд 26,0 сая төгрөгийн үнэ бүхий Цахим номын сан, мэдээлэл харилцааны технологийн төв нийлүүлсэн байна.</p> <p>Энэ онд сургуулиуд өөрийн боломжиндоо тулгуурлан сургалт зохион байгуулж, 2610 багш, БСГ-аас явуулсан сургалтанд 3052 багшийг хамруулжээ.</p> <p style="text-align: right;">Хэрэгжиж байна 90%</p>
<ul style="list-style-type: none"> • багш, боловсролын байгууллагын удирдах ажилтны ур чадварыг хөгжүүлж, ажлын чанар, хөдөлмөрийн үр бүтээлийг үнэлэх шалгууруудыг зөв тогтоож, цалин хөлс нэмэгдүүлэх, урамшуулал олгох зэргээр нийгмийн хамгааллыг сайжруулах; 	<p>Багш нартай байгуулсан үр дүнгийн гэрээний үнэлгээг харгалзан 2009 оноос эхлэн 15 хүртэл хувиар урамшуулал олгож, мөнгөн урамшуулалд энэ онд ерөнхий боловсролын сургуулийн багш нарт 394,3 сая, СӨБ-ийн багш нарт 153,3 сая буюу нийт 547,6 сая төгрөг олгосон байна.</p> <p>Багш нарыг сурч, мэргэжлээ дээшлүүлэх, ном сурах бичиг хэвлүүлэхэд дэмжлэг болох зорилгоор “Нийгмийн дэмжлэгийн сан”-г байгуулан, жил 5-10,0 сая төгрөгөөр хөрөнгийг нэмэгдүүлэн, энэ онд 155 хүнд 3,3 сая төгрөгийн сургалтын тэтгэлэг, 7 хүнд 1,5 сая төгрөгийн хөнгөлөлттэй зээл олгосон</p> <p style="text-align: right;">Хэрэгжиж байна 90%</p>
<ul style="list-style-type: none"> • газар нутгийн алслагдалт, цаг уурын онцгой нөхцөлийн нэмэгдэл олгох; 	<p>Хөдөө орон нутагт ажиллаж байгаа багш нарын 5 жил тутамт нэг удаа олгодог 6 сарын нэмэгдэл цалинг тогтмол олгож ирсэн. Энэ онд 90,4 сая төгрөгийн нэмэгдэл олгосон байна</p> <p style="text-align: right;">Хэрэгжиж байна 90%</p>
<ul style="list-style-type: none"> • дотооддоо мэргэжил дээшлүүлэх нийт 	<p style="text-align: center;">2004 онд хичээл практик, мэргэжил дээшлүүлэх зардал 65,3 сая, 2007 онд</p>

<p>зардлыг 2004 онтой харьцуулан 2007 оноос эхлэн ойролцоогоор 6 дахин нэмэгдүүлж, цаашид жил бүр 10 хувиас доошгүй өсгөх.</p>	<p>66,4 сая байсан бол 2010 онд 178,3 сая төгрөг болж, 2004 онтой харьцуулахад 36,6 хувь буюу 2,7 дахин өссөн байна. Энэхүү хөрөнгийг багш нарын бага хурал, мэргэшил дээшлүүлэх, олимпиадын зардал, мэргэшил дээшлүүлэх томилолтын зардалд тус тус зарцуулагдсан байна. Хэрэгжиж байна 90%</p>
<p>4.5. Эрүүл мэндийн хөгжлийн бодлого Нэгдүгээр үе шат (2007-2015 он):</p>	
<p><i>Стратегийн зорилт 1. Сум, өрхийн эмнэлгийн анхан шатны тусламж хүргэх, шинжилгээ, оношилгоо, эмчилгээ, дархлаажуулалт хийх, шүдний өвчин эмчлэх, бэлгийн замаар дамжих халдвар, хүний дархлал хомсдолын вирус, дархлалын олдмол хомсдол, сүрьеэгээс сэргийлэх, эх, нялхсын эрүүл мэндийг хамгаалах чадамжийг цогц байдлаар хөгжүүлнэ:</i></p>	
<ul style="list-style-type: none"> • эх, нялхсыг хамгаалах тогтолцоог боловсронгуй болгох; 	<p>Эх нялхсыг хамгаалах тогтолцоог боловсронгуй болгох зорилгоор холбогдох эмч, мэргэжилтнүүд, сум, өрхийн эмч оролцсон “Аймгийн хэмжээнд жирэмсэн эхэд үзүүлж буй тусламж үйлчилгээний өнөөгийн байдал, тулгамдсан асуудал, цаашид тавих санал, зорилт” зөвлөгөөн, “Эх хүүхдийн өвчлөл эндэгдэл, тулгамдаж буй асуудлыг бууруулахад шийдвэрлэх арга зам” сэдэвт хэлэлцүүлэг, жирэмсний хяналтыг сайжруулах зорилгоор “Халаадгүй уулзалт”-ыг зохион байгуулан, “Орхон аймгийн эх нярайн үзүүлэлт” -ийг сүүлийн 3 жилийн байдлаар улс, аймгийн дундажтай харьцуулан дүгнэлт хийж, зөвлөмж гарган ажиллалаа. Аймгийн эхийн эндэгдлийг магадлан тогтоох, хэлэлцэх зөвлөлийн хурлыг 2 удаа хийж, аймгийн ерөнхий мэргэжилтнүүдийг шинээр томилон, ажиллах журам, цагийн хуваарийг батлаж, өрхийн эмч нартай 2 удаа уулзалт зохион байгуулж, зөвлөмж өгч ажиллалаа. НҮБ-ийн хүн амын сангийн санхүүжилтээр нийт өрхийн 30 эмч оролцсон жирэмсний хяналтын сургалт, мөн “Жирэмсэн эхийн хөтөч”-ийг хөтлөх талаар сургалт зохион байгуулав. Жирэмсний хяналтыг сайжруулахаар зорилгоор Бүсийн оношлогоо эмчилгээний төвийн төрөх тасгийн MNS5095:2001 стандартын хэрэгжилтэнд улирал бүр үнэлгээ хийж, өрхийн эмч нарын жирэмсний хяналтанд хяналт хийж өрхийн эмч нарт зөвлөмж өгч, өрхийн эмнэлгийн 4 эмчийг төрөх, хүүхдийн тасагт 1 сарын хугацаатай дадлагажууллаа. Эмчилгээ чанарын албаны хурлыг 12 удаа хийж, гэрийн төрөлт, амьгүй төрөлт, нярайн эндэгдлийн тохиолдлуудыг хэлэлцэж, хурлаас гарсан шийдвэрийн хэрэгжилтэнд хяналт тавин ажиллалаа. Эх нялхсыг хамгаалах, эсэн мэнд амаржихуйн тусламж үйлчилгээ үзүүлж буй удирдамжийн дагуу аймгийн 8 хувийн хэвшлийн эмэгтэйчүүдийн эмнэлэг, Бүсийн оношлогоо эмчилгээний төвийн төрөх тасаг, сум, 11 өрхийн эмнэлгийн үйл</p>

	<p>ажиллагаанд зөвөлөмж өгч, хэвийн явуулах нөхцлөөр хангах зорилгоор жирэмслэлтээс хамгаалах хэрэгсэл, эх барихын яаралтай тусламжийн эм тариаг НҮЭМ-ийн цогц тусламж үйлчилгээний төв, төрөх тасаг, сум, өрхийн эмнэлгүүдэд захиалгын дагуу хувиарлан түгээж, хяналт тавин ажиллаж байна. Жирэмслэлтээс хамгаалах хэрэгслийг 16231 эмэгтэйчүүд олгосон байна. Үүнээс эм бэлдмэл 55.6 хувь, Тариа 11.1 хувь, Норплант 0.2 хувь, Бэлгэвч 34.2 хувь, ерөндөг 29.4 хувьтай байна. Жирэмсний хяналтанд орсон жирэмсэн эхчүүдийг төмөр фолийн хүчлээр урьдчилан сэргийлэх, эмчлэх тунд хамруулсан ба цус багадалттай эмзэг бүлгийн 220 жирэмсэн эмэгтэйчүүдэд цус багадалтаас сэргийлэх зорилгоор 660 ширхэг төмрийн бэлдмэлээр хангасан байна. НҮБ-ын ХАС-аас хэрэгжүүлж буй Люксембургийн “Хөдөө алслагдсан сумдын жирэмсэн эхэд үзүүлэх тусламжийг сайжруулах оношлох алсын зайны оношлогоо” төслийн шугамаар Бүсийн оношлогоо эмчилгээний төвийн эх барих эмэгтэйчүүдийн 1 эмчийг ургийн оношлогооны чиглэлээр чанд авианы шинжилгээний сургалтанд хамруулав. БОЭТ-ийн эмэгтэйчүүдийн кабинетаар 16 байгууллагын 412 эмэгтэйчүүдэд урьдчилан сэргийлэх үзлэг хийж, нийт 122 өвчлөл /умайн хоргүй хавдар 10, үргүйдэл 4, өндгөвчний уйланхай 4, үрэвсэлт өвчнүүд 104/-ийг илрүүлж, эмчилгээнд хамрууллаа. “Үр хөндөлт хийх журам”-ын дагуу НҮЭМ-ийн төв дээр нийт 195 үр хөндөлт хийгдэж, төрөх тасгийн эмчилгээ үйлчилгээнд хожуу болон эрт үеийн зулбалт, дутуу төрөлтөөс сэргийлэх зорилгоор нифедипины цохилтын тунг ашиглах, В.Lynch аргыг хэрэглэн умайд оёдол тавих, кесерв хагалгааны зүслэгийг Мисгав Ладахын аргаар хийх, дутуу төрөлт ба токолитик эмчилгээ, вакуум хэрэглэх аргачлал зэргийг нэвтрүүлэн нярайн эмгэгийн зайны оношлогооны Люксембургийн төслийг хэрэгжүүлж хүнд болон эмчилгээтэй нярайд телемедицины сүлжээгээр эмчилгээ оношлогооны зөвлөгөөг авч нярайн тусламжийг үзүүлж 15 удаа зөвлөгөө авсан байна. Төрсний дараахь бүтэлттэй болон хүнд нярайн цусан дахь сахарын хэмжээг тодорхойлдог болсноор нярайн цусны чихэр багадалт болон цаашид гарах хүндрэлүүдээс сэргийлдэг болов. “Жирэмсэн эмэгтэйчүүд болон тэдний бэлгийн хавьтагчдад чиглэсэн төрөлхийн тэмбүү өвчнөөс сэргийлэх нэг цэгийн үйлчилгээ” төслийн хүрээнд жирэмсний хяналтанд орсон эхчүүдэд тэмбүүгийн хурдавчилсан сорилыг анхан шатны эмнэлгүүдэд хийж байгаа ба хурдавчилсан сорилоор 64 эх оношлогдож, ийлдэс судлалын шинжилгээгээр баталгаажиж, стандарт эмчилгээ хийгдэн эмчлэгдсэн ба нийт тэмбүүгийн өвчлөл дотроос</p>
--	--

		<p>жирэмсэн үе дэх тэмбүү өвчин 2010 оны байдлаар гараагүй байна.</p> <p>Орон нутгийн телевизээр НҮЭМ, гэр бүл төлөвлөлт, хүсээгүй жирэмслэлт, жирэмсний хяналтын ач холбогдол сэдвээр 2 нэвтрүүлэг бэлтгэн гаргаж, шууд ярилцлагад 1 удаа, “Гэрийн төрөлтөөс сэргийлье” зөвлөмжийг “Шинэ мэдээ” сонинд нийтлүүлэв. Жирэмсэн, хөхүүл эх, 0-5 насны хүүхдийн эцэг эх асран хамгаалагчдын мэдлэг хандлагыг нэмэгдүүлэх зорилгоор 15 өрхийн эмнэлэгүүдэд тулгуурлан “Ээжүүдийн клуб”-ыг байгуулж сургалтанд ашиглагдах заавар бүхий хавтас, жигнүүр, плитка, савны ком, өлгий, банн, хүүхэлдэй зэрэг нийт 5.248 мянга, эхчүүдэд зориулсан 3 төрлийн ном 3200 ширхэг, плакат 300 ширхэг, хаяг, танилцуулга зэрэг 2.363 мянган төгрөгийн хөрөнгө оруулалтыг өрхийн эмнэлгүүдэд хуваарилан клубуудыг тохижуулсан. “Ээжүүдийн клуб”-ын хүрээнд Жаргалант сум, 11 өрхийн эмнэлгийн сургалтын мэдээг авч нэгтгэхэд жирэмсэн 1345, хөхүүл 1125 эх хамрагдаж, хүүхдийн сургалтанд 0-5 насны эцэг эх 2654, хүүхдийн нэмэгдэл хоолны сургалтанд 896 эцэг эх хамрагдсан байна. Жирэмсэн, хөхүүл эх, хүүхдийн нэмэгдэл хоолны чиглэлээр сайн дурын 85 ээжийг бэлтгэн нийт телевиз мэдээллийн хэрэгслээр 9 нэвтрүүлгийг бэлтгэн нэвтрүүлэв.</p> <p style="text-align: right;">Хэрэгжиж байна 90%</p>
	<ul style="list-style-type: none"> • шүд эмчлэх, эрхтэн тогтолцооны өвчний оношилгоо, эмчилгээний арга технологийг сумын түвшинд нэвтрүүлэх; 	<p>Хүүхэд өсвөр үеийнхний амны хөндийн үзлэг, оношлогоо эмчилгээг хийхэд нийт 86,5 сая төгрөг зарцуулж 14678 үзлэг хийснээс өвчлөлтэй 4191 хүний 53,3 хувийг эмчилсэн байна. “Эрүүл шүд – Сайхан инээмсэглэл” аяны үйл ажиллагааг ЭМГ, БОЭТ, ДЗОУБ-ЭНХХ-тэй хамтран зохион явуулж, бага, дунд ангийн нийт 200 хүүхдийг амны хөндийн урьдчилан сэргийлэх үзлэгт оруулж, эрүүл шүдтэй хүүхдүүдийг урамшуулж “Сайхан-инээмсэглэл” гэрчилгээг гардуулж, 74 хүүхдийг эмчилгээнд бүрэн хамруулж эрүүлжүүллээ. Мөн 211 бүлгийн 9600 сурагчдад “Шүдээ яаж хамгаалах вэ?” сэдвээр “шүдний модель” дээр үзүүлэн сургалт, сурталчилгааг хийлээ. Хувийн хэвшлийн шүдний эмнэлгийн эмч нартай хамтран эмзэг бүлгийн 170 сурагчийг эмчлэн эрүүлжүүллээ. Аймгийн Засаг даргын Тамгын газар, “Хамтдаа инээмсэглэл” төрийн бус байгууллагатай хамтран БОЭТөв дээр БНСУ-ын эмч нарын баг нийт 430 хүнд үзлэг хийснээс 132 хүнд эмчилгээ хийж, уруул тагнайн сэтэрхийтэй 6 хүнд мэс засал эмчилгээг хийлээ. ЭМШУИС-НАСС оюутны холбоо, Эрдэнэт сувилал, Ододонт хувийн шүдний эмнэлэг хамтран “Найрамдлын Эрдэнэс” зусланд амарч байгаа нийт 1580 хүүхдэд үзлэг хийж, фтортой гелийн түрхлэг эмчилгээ хийж, сургалт</p>

		<p>зохион байгуулсан байна.</p> <p style="text-align: center;">Хэрэгжиж байна 90%</p>
	<ul style="list-style-type: none"> • бэлгийн замаар дамжих халдвар, хүний дархлал хомсдолын вирус, дархлалын олдмол хомсдол, сүрьеэтэй тэмцэх чадвартай болгох; 	<p>Аймгийн 4 их дээд сургуулийн 748 оюутанг БЗДХ-ын урьдчилан сэргийлэх үзлэг шинжилгээнд хамруулж, өвчтэй илэрсэн 301 оюутанг эмчилгээнд хамруулав.</p> <p>НҮЭМ болон БЗДХ-ын тусламж үйлчилгээний уялдаа холбоог сайжруулах замаар “ДОХ/ХДХВ-ийн халдварын эрсдлийг бууруулах” төслийн хүрээнд сум, өрхийн эмнэлгүүд, Бүсийн оношлогоо эмчилгээний төвийн төрөх тасагт 1235 жирэмсэн эхчүүдийг тэмбүү илрүүлэх нэг удаагийн сорилын шинжилгээнд хамруулж, шинжилгээнд эерэг гарсан 62 жирэмсэн эхийн оношийг баталгаажуулан хавьтагчтай нь эмчилгээнд хамрууллаа. Сайн дурын зөвлөлгөө шинжилгээний төвөөр сайн дураар ирж 707 хүн үйлчлүүлсэний 302 нь зөвлөлгөө авч, 405 хүн ХДХВ-ийн болон тэмбүүгийн шинжилгээг хийлгэн өвчтэй илэрсэнийг БЗДХ-ийн кабинетэд илгээн эмчлүүлсэн байна. Өрхийн эмнэлгүүд, БОЭТ, Сувилал, Хувийн хэвшлийн эмнэлгүүд, сургуулиудад суртчилгааны материал түгээн өсвөр насныхан их дээд сургуулийн оюутнуудад сургалт сурталчилгааг “ABC-ийн зарчмууд” болон “Өөрөөр амьдарцгаая-Бэлгийн замаар дамжих халдварыг эмчилье”, “Өөрөөр амьдрацгаая-ХДХВ-ийн халдвартай эсэхээ мэдье”, “Өөрөөр амьдарцгаая-Үнэнч байя” зэргийг сурталчлан 1800 гаруй сурагчдыг хамруулан, залуу гэр бүлийн дунд ХДХВ-ийн болон бэлгийн замын халдвар эцэг эхээс хүүхдэд дамжихаас урьдчилан сэргийлэх сургалт сурталчилгааг хэвлэл мэдээллийн байгууллагатай хамтран 2 удаа, хөдөлгөөнт бүлгийн хүн амд зориулсан бэлгийн замаар дамжих халдвараас урьдчилан сэргийлэх суртчилгааг хэвлэл мэдээллийн хэрэгслээр дамжуулан 2 удаа хийсэн байна. 2010 оны 12 сарын байдлаар нийт шинэ илэрсэн сүрьеэ 105 буюу 10000 хүн амд 11.5 тохиолдол байгаа нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 0.2 промилээр нэмэгдсэн байна. БЗДХ-ын кабинетын нийт үзлэг 8080 байгаагаас урьдчилан сэргийлэх үзлэг 6312 буюу 78,1хувьтай байна. Цусны шинжилгээ 5669, мазокийн шинжилгээ 2626, ХДХВ/ДОХ-ын</p>

		<p>шинжилгээ 4506 хийж, жирэмсний урьдчилан сэргийлэх үзлэг 2324, цусны шинжилгээ 2294, 96 хүнд давхардсан тоогоор 288 удаа тэмбүүгийн эмчилгээ хийлээ. СДЗШ-ний төвийн үйл ажиллагаа тогтмолжиж үйлчлүүлэгчдийн тоо нэмэгдэн 2010 онд сайн дурын зөвлөлгөө шинжилгээний төвөөр сайн дураараа ирж 707 хүн үйлчлүүлсний 302 нь зөвлөлгөө авч, 405 хүн ХДХВ-ийн болон тэмбүүгийн шинжилгээг хийлгэсэн байна. БЗДХ тэмбүү 77 тохиолдол буюу 8,8 промилиэр, заг хүйтэн 12 тохиолдол буюу 1.5 промилиэр тус тус буурч, трихоманаз, мөөгөнцөр 87 тохиолдолоор буюу өмнөх оны мөн үеэс 9.2 промилиэр нэмэгдсэн байна.</p> <p style="text-align: right;">Хэрэгжиж байна 90%</p>
	<ul style="list-style-type: none"> • малчдад нүүдлийн өрхийн эмнэлгээр үйлчлэх тогтолцоог бүрдүүлэх; 	<p>Малчин баг болон эмзэг бүлгийн иргэдэд урьдчилан сэргийлэх үзлэгийг жилд 2 удаа зохион байгуулж шаардлагатай тусламж үйлчилгээг үзүүлж, хяналтанд авч эмчилж хэвшсэн. Явуулын үйлчилгээний авто машиныг стандартын дагуу тоноглон улирал тутам малчдад үйлчилж байна. Өрхийн эмнэлэг малчдад үзүүлэх нэн шаардлагатай тусламж үйлчилгээг бүрэн үзүүлэх чадавхийг сайжруулах зорилгоор “Мөнхсүндрэл” өрхийн эмнэлгийн 1 сувилагчийг зүрх судасны чиглэлээр сургалтанд хамруулж, иргэдэд зүрхний цахилгаан бичлэг хийж 1798 хүн шинжилгээнд хамрагдсанаас амжиргааны баталгаажих түвшингээс доогуур 131, хөдөө орон нутгаас ирсэн 25, түр оршин суугаа 10, отроор яваа 5 ,эрүүл мэндийн даатгалд хамрагдаагүй 181 хүн хамрагджээ. Амьжиргааны баталгаажих түвшингээс доогуур орлоготой 160 хүнийг аминдэмд хамруулсан байна.</p> <p style="text-align: right;">Хэрэгжиж байна 90%</p>
<p><i>Стратегийн зорилт 2. Аймаг, дүүргийн болон улсын клиникийн нэгдсэн эмнэлэг, мэргэжлийн төвүүдийн үйл ажиллагааны чадамжийг хөгжүүлнэ:</i></p>		
	<ul style="list-style-type: none"> • хорт хавдарыг эрт оношилох, эмчлэх боломжоор аймаг, дүүргийн эмнэлгийг хангах; 	<p>Орон нутгийн орлогоос “Хорт хавдартай иргэдийн эмийн зардалд дэмжлэг үзүүлэх зөвлөлийг байгуулах, журам батлах тухай” аймгийн Засаг даргын захирамжийн дагуу амьжиргааны баталгаажих түвшингээс доогуур орлого бүхий 49 хүнд 6.0 сая төгрөгний буцалтгүй туслалцааг үзүүлсэн байна. Аймгийн хэмжээнд нийт 4274 хавдартай хүн байгаа бөгөөд үүнээс урьдчилан сэргийлэх үзлэгт 1952 буюу 45,7 хувь, өвчний учир 873 буюу 20,4 хувь, диспансерийн</p>

		<p>хяналтын үзлэгт 1372 буюу 32,1 хувь байна. Хөнгөвчлөх эмчилгээний өдрийн стационарт 50 хүнд түүх нээж 218879 төгрөгийн эмчилгээ хийсэн. Мөн хөнгөвчлөх эмчилгээний ороор үйлчлүүлж өдрийн эм тариагаа хийлгэх 141 хүн, гэрээр 50 хүн хөнгөвчлөх тусламж үйлчилгээ авсан байна.</p> <p>Хөхний болон умайн хүзүүний хорт хавдрыг илрүүлэх чанд авиан шинжилгээг 2010 оны 10-р сараас хийж эхэлсэн байна. Хорт хавдрын үеийн хими эмчилгээг орон нутагтаа давхардсан тоогоор 11 хүнд 27 курс химийн эмчилгээ хийлээ. Эдгээрээс 11 хүнд истори нээж, химийн тарианаас бусад дусал болон яаралтай тусламжийн ба хүндрэлээс сэргийлэх 357 мянган төгрөгний эмчилгээг хийсэн байна.</p> <p style="text-align: center;">Хэрэгжиж байна 90%</p>
	<ul style="list-style-type: none"> дэлхийн тухайн цаг үеийн стандартад нийцүүлэн эрүүл мэндийн байгууллагын шатлал бүрийн үйлчилгээний арга технологи, холбогдох тоног төхөөрөмжийг байнга шинэчлэх, засвар үйлчилгээг хангах тогтолцоог бүрдүүлэх; 	<p>Хүлээн авах тасгийг сэхээний тасагтай нэгтгэн “Хүлээн авах- эрчимт эмчилгээ мэдээгүйжүүлгийн тасаг болгон өөрчилж үйл ажиллагааг өргөтгөн Дэнж багт байрлах 40 ортой эмнэлгийг хүлээн авснаар хүлээн авахын сувилагч 4, сэхээний сувилагч 4, асрагч 2 орон тоог нэмэгдүүлж, жирэмсний онцгой хяналтын эмчийн орон тоог нэмэгдүүлж 3 эмч ажиллуулж Дэнж, Эрдэнэ, Согоот багийн ахмадууд болон иргэдэд нарийн мэргэжлийн тусламж үйлчилгээг үзүүлж байна. Нярайн эмч 3, нярайн сувилагч 8 ажиллуулах болсноор эмгэг нярайд хүргэх тусламж үйлчилгээний хүртээмж сайжирч төрөх тасагт НҮЭМ-ийн цогц тусламж үйлчилгээний төвийг байгуулснаар үр хөндөлтийг стандартын дагуу хийж, гэр бүл төлөвлөлт, жирэмсэн, төрсний дараах болон нөхөн үржихүйн чиглэлээр иргэдэд зөвлөмж өгч ажиллаж байна.</p> <p>Дэлхийн банкны санхүүжилттэй “Шувууны томуу, хүний томууны цар тахлын чадавхийг сайжруулах” төслөөс өвчтөний монитор дагалдах хэрэгслийн хамт, зөөврийн болон суурин автоклав, ариутгагч, 56538,8 долларын хөрөнгө бүхий тоног төхөөрөмжтэй вируслогийн лабораторийг ашиглалтанд оруулснаар орон нутагт анх удаа томуугийн А, В хүрээний вирус илрүүлэх шинжилгээнээс гадна элэгний В,С вирус, бүх төрлийн халдварт өвчнийг молекул биологийн түвшинд оношлох боломжтой болсон байна. Хиймэл бөөрний /гемодиализ/ аппаратыг суурилуулан эмчилгээг 2009 оны 11 сараас эхлэн орон нутагтаа хийж, 4 хүн тогтмол эмчлүүлж нийт 241 шүүлт хийгдсэн байна. Цаашид бөөр шилжүүлэн суулгах мэс засал хийх төсөлд хамрагдах боломжтой болсон. ЭМСайдын тушаал болон өөрсдийн хөрөнгөөр 207,3 сая төгрөгийн машин, тоног төхөөрөмж, “Ар Ти Эм” ХХК-аас эмнэлгийн хог хаягдал шатаах зуух буюу хорт</p>

		<p>утаа ялгаруулдаггүй хог шатаах зуухыг хүлээн авч суурилуулах ажлыг хийж байна. Швейцарийн мэс заслын эмч нарын багаас 75.0 сая төгрөгний өртөг бүхий хүнд өвчтний 30 цахилгаан удирдлагатай ор, мэс заслын багаж хэрэгслийг хүлээлгэн өгсөн байна.</p> <p>ЭМЯ-ны хөрөнгө оруулалтаар 23,8 сая төгрөгийн өртөгтэй эмнэлгийн түргэн тусламжийн зориулалтын автомашин, яаралтай тусламжийн ба оношлогооны үйл ажиллагаанд хэрэглэгдэх 14.0 сая төгрөгийн өртөгтэй ЭХО аппарат , түргэн тусламжийн үйлчилгээ үзүүлэх туулах чадвартай 23.0 сая төгрөгийн өртөгтэй автомашинг сонгомол эмчилгээний тасгийн орлогоос авсан. БОЭТ-ийн төрөх тасагт 2ш пульсоксиметр, 4 хайрцаг бээлий, 2 флакон жавелеон, 50ш санитол, нэг удаагийн халат 10ш , хүүхдийн тасагт 3 хайрцаг бээлий, 300 таблетка жавелион, 2 пульсоксиметр, хангалт хийсэн.</p> <p>Хэрэгжиж байна 90%</p>
	<ul style="list-style-type: none"> алсын зайны оношилгоо, эмчилгээний аргуудыг эмнэлэгт нэвтрүүлэх; 	<p>Зүрх судасны чиглэлээр нийт үзлэг 11840 хүнд хийж Люксембургийн Вант улсын буцалтгүй тусламжаар хэрэгжиж байгаа “Телемедицин ба Зүрх судасны өвчин МОН 003” төслийн хүрээнд алсын зайн холбооны тусламжтайгаар өндөр нарийн мэргэжлийн эмч нараас 15 хүний талаар зөвлөгөө авч, зүрхний ЭХО шинжилгээнд нийт 969 хүн хамрагдсан ба ЭКГ шинжилгээг 7586 үйлчлүүлэгчдэд, холтер 15 хүнд хийсэн байна. Нийт 6350 иргэнд сурталчилгааг хийж, санамж, зөвлөмжөөр хангалаа.</p> <p>Хэрэгжиж байна 70%</p>
	<ul style="list-style-type: none"> өвчний түүхийг цахим картын тогтолцоонд оруулах. 	<p>Мэдээллийн технологи зайн оношлогоо хариуцсан мэргэжилтэнг сонгон шалгаруулж 5 сарын 12-ны өдрөөс эхлэн ажиллуулж байгаа бөгөөд аймгийн хэмжээнд цахим эрүүл мэндийн тогтолцоотой загвар аймаг болгох ажлын хүрээнд ажиллалаа. ЭМЯ-наас явуулж байгаа “Салбарын нэгдсэн сүлжээг зохион байгуулах” ажлын хүрээнд "Монкабель" компаны шилэн кабелийг тавьж "Citynet" компаний интернетийг ашиглаж байна. Мэдээлэл солилцох үйл ажиллагааг сайжруулах ажлын хүрээнд ЭМГ-ын компьютеруудыг дотоод сүлжээнд холбож статистик болон бусад мэдээллийн санг үүсгэн ажиллаж байна. Мэдээллийн сан үүсгэх чиглэлээр холбогдох мэргэжилтэнг сургалтанд хамруулан , программд иргэдийн бүртгэлийг хэрхэн бүртгэх талаар сургалтыг өрхийн 14 сувилагчид явуулж цахим мэдээллийн сангийн программыг өрхийн</p>

		<p>эмнэлгийн компьютерүүдэд суулган иргэдийн бүртгэл мэдээллийг мэдээллийн санд оруулж байна.</p> <p>Өрхийн эмнэлгүүдийн H-info програмаар хүн амын мэдээллийн сан 85 хувьтай, 15-с дээш насны хүн амын мэдээллийн сан 95 хувьтай байна. БОЭТ-ийн бүх тасаг, кабинетүүд компьютерээр бүрэн хангагдан, компьютер сүлжээний ажилтантай болсон ба нийт 73 компьютер дотоод сүлжээ, интернэтэд холбогдож сүлжээгээ ашиглан хоорондоо мэдээлэл солилцох, мэдээлэл өгөх, авах зэрэг үйл ажиллагаа хэвшлээ. Эмнэлгээс гарагчийн хуудсаа Health-Info программ дээр шивж архивлан, амбулаторийн эмч нар үзлэгийн мэдээгээ Health-Info программ дээр шивдэг болсноор үйлчлүүлэгчдэд түргэн шуурхай үйлчлэх нөхцлийг бүрдүүлж байна.</p> <p>ХӨСҮТ-ийн захирлын “Интернэтэд суурилсан томуугийн мэдээллийн систем нэвтрүүлэх тухай” А/67 тушаалын дагуу ЭМГ, БОЭТ, өрхийн эмнэлгүүд томуугийн мэдээг интернэтээр дамжуулан эргэх холбоотой ажиллаж байна. ЭМС-ын 2008 оны 186 дугаар тушаалыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд хэрэглэгчийн эзэмшиж байгаа техник хэрэгсэлд үзүүлэх үйлчилгээний жагсаалтыг гаргаж засвар үйлчилгээний талаар тайлан мэдээний тогтолцоотой болов.</p> <p style="text-align: right;">Хэрэгжиж байна 90%</p>
<i>Стратегийн зорилт 3. Эрүүл мэндийн байгууллагыг мэргэжлийн өндөр мэдлэг, ур чадвартай боловсон хүчнээр хангана:</i>		
	<ul style="list-style-type: none"> • эрүүл мэндийн байгууллагыг үйлчлүүлэгчээ дээдэлсэн үйл ажиллагааны зарчимтай болгох; 	<p>БОЭТ, Эрдэнэт Үйлдвэрийн Эмнэлэг сувилалд лавлагааны хэсэг ажиллуулж дугаар олгох, утсаар үзлэгийн цаг товлох үйлчилгээг үзүүлж байгаа ба өрхийн эмнэлэг, хувийн хэвшлийн эмнэлгүүдийн үүдэнд лавлаганы самбар, сувилагчийн ПОСТ ажиллуулж байна.</p> <p>БОЭТ-ийн поликлиникийн хүлээлгийн зааланд лавлагааны самбарыг шинэчлэн, давхаруудад өнгөөр ялгасан дуугүй хөтөчийн тэмдэглэгээг сэргээн шинэчилсэн байна. Лавлагааны дэргэд үйлчилүүлэгчдэд зориулсан самбар гаргаж үйлчилүүлэгчдийн эрх үүрэг, лавлагаат тусламж үзүүлэх журам, ЭМД-аар үйлчлүүлэх заавар зэргийг байршуулж сурталчилгаа хийж байна. Лавлагааны хэсэгт 95357001 95357002, 95357003 дугааруудыг тогтмол ажиллуулж иргэдэд цаг товлох үйлчилгээг нэвтрүүлж байна. БОЭТ-ийн</p>

		<p>лавлагааны хэсэгт 3 хүн ажиллаж, үйлчлүүлэгчдийг чиглүүлж дугаар тарааж ахмад настан, тахир дутуу иргэдэд 2 тэргэнцэрээр үйлчилж байна. БОЭТ нарийн мэргэжлийн эмчийн цаг товллын үзлэгийн дугаарыг 12071 хүнд олгож утсаар 112 захиалга хүлээн авч үйлчилсэн. Лавлагаат тусламжийн булангаар 8201 хүнд эрүүл мэндийн боловсрол олгосон байна.</p> <p>Эмнэлэг сувилалын лавлагааны хэсэгт тохижилт хийж ТВ байршуулсан сурталчилгааны материал байршуулах тавиуртай, 1 ажилтан тогтмол ажиллан лавлагааны самбарт төлбөртэй тусламж үйлчилгээний тухай мэдээлэл байршуулсан. Лавлагааны хэсгийн ажилтан үйлчлүүлэгчдийг хүлээн авч кабинетуудад хуваарилан компьютерт байршуулж, эмч нар дотоод сүлжээгээр үйлчилүүлэгчдийг дарааллын дагуу үзэж үйлчилдэг. Лавлагааны хэсэг дээр 73692, 73693 дугаарын утас ажиллуулж иргэдэд мэдээлэл өгөх, цаг товлон үйлчилгээг үзүүлж байна. Мөн цех тасгууд амбулаторийн үйлчилгээтэй сүлжээгээр танилцаж эмчийн хяналт үзлэгт хамрагдаж байгаа байдалд хяналт хийх боломтой болсон байна. Кабинетуудын хаягийг бүрэн хийж дуусгасан. 7090 хүн лавлагааны хэсгээр үйлчлүүлж 200 хүнд дугаар захиалах үйлчилгээ үзүүлж цаг товлон үйлчилсэн. 4 төрлийн сургалтын сэдвээр ТВ сургалт хийж байна.</p> <p>Өрхийн эмнэлгүүдийн лавлагааны хэсэгт сувилагч нар ээлжээр ажиллаж байна.</p> <p>Хувийн хэвшлийн ортой эмнэлгүүд лавлагааны самбар гаргаж сувилагчийн постоор угтах үйлчилгээг үзүүлдэг. “Эмч эмнэлгийн мэргэжилтнүүдийн ёс зүй харилцаа хандлагыг дээшлүүлье” 1 сарын аяныг зохион байгуулж, аяны хүрээнд БОЭТөв дээр иргэдээс санал хүсэлт авах нээлттэй утас ажиллуулж байна. Мөн Бүсийн оношлогоо эмчилгээний төв, өрхийн эмнэлгийн холбоо, хувийн хэвшлийн эмнэлгүүдийн “Чандмань-Эрдэнэ” холбоо, УБҮ-ийн эмнэлэг сувилал зэрэг газруудад ёс зүйн салбар хороо байгуулан ажиллах байна.</p> <p style="text-align: right;">Хэрэгжиж байна 90%</p>
	<ul style="list-style-type: none"> • хүний нөөц, мэргэжлийн ур чадварын сургалтыг олон улсын жишигт хүргэх; 	<p>2010 онд ажлын байран дээрх 30 удаагийн сургалтанд 938 эмнэлгийн мэргэжилтэн давхардсан тоогоор хамрагдан, зайн сургалтанд 309 эмнэлгийн мэргэжилтэн оролцож, мэдлэг мэргэжилээ дээшлүүлэн 0,1-1,5 кредит авсан байна. Эрүүл мэндийн яам, Геронтологийн төв, ЭМШУИС, Хадварт өвчин судлалын үндэсний төв, Байгалийн голомтот халдварт өвчин судлалын үндэсний төв, Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төв, Эх нялхасын эрдэм</p>

		<p>шинжилгээний төв, Эмгэг судлаачдын нийгэмлэг, Уушиг судлалын нийгэмлэг, Мэдээгүйжүүлэгч эмч нарын нийгэмлэг зэрэг газруудаас зохион байгуулсан богино хугацааны сургалт, семинаруудад нийт 79 эмнэлгийн мэргэжилтэн давхардсан тоогоор хамрагдсан байна. Эрүүл мэндийн яам болон ЗГХА-ЭМГ-тай хамтран зохион байгуулсан “Хүүхдийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээ, нярайн яаралтай тусламж, зүрх судасны зонхилон тохиолдох эмгэгүүд” сургалтанд 171 эмч хамрагдаж 2 багц цагийн кредит авсан. Эмчийн мэргэжил эзэмшүүлэхээр 1, мэргэжил дээшлүүлэх 1, дунд мэргэжилтний мэргэжил эзэмшүүлэх 9, мэргэжил дээшлүүлэхээр суралцах 4, резиденсийн сургалтанд 3 нийт 18 эмнэлгийн мэргэжилтэн төрийн сангийн зардлаар суралцууллаа</p> <p style="text-align: right;">Хэрэгжиж байна 90%</p>
	<ul style="list-style-type: none"> эмч мэргэжилтнүүдийн цалин, шагнал, урамшуулал, нэмэгдлүүдийн боловсронгуй тогтолцоог хэрэгжүүлэх. 	<p>Эмч мэргэжилтнүүдийн цалин, шагнал, урамшуулал, нэмэгдлүүдийн боловсронгуй болгох саналыг ЭМЯ-нд хүргүүлэв. Зарим албан тушаалын ажиллагсдын үндсэн цалинг нэмэгдүүлэн олгох тухай ЭМС-ын 2010 оны 123 дугаар тушаалын дагуу эмгэг судлаач эмч, эмгэг судлаач эмчийн туслах, эмгэг судлалын лаборант, хүүхэд, нярайн эмч, сувилагч, сүрьеэгийн эмч, сувилагч, яаралтай тусламжийн эмч, сувилагч, мэдээгүйжүүлэлт, эрчимт эмчилгээний эмч, сувилагч, эх барих эмэгтэйчүүдийн эмч, эх баригч нарын үндсэн цалинг 10 хувиар нэмэгдүүлж 2010 оны 07 дугаар сарын 01–ний өдрөөс тооцож олгож байна. Нийгмийн дэмжлэгийн сангийн гишүүдийн хурлын шийдвэрээр 58 эмч, эмнэлгийн мэргэжилтэнд 1.6 сая төгрөгийн буцалтгүй тусламж, 1 хүнд 360.0 мянган төгрөгийн зээл олгосон байна. Монгол улсын Засгийн газрын 2009 оны 368 дугаар тогтоолоор батдагдсан “Төрийн албан хаагчдыг орон сууцны зээлд хамруулах” журмын зээлийн шалгуур, болзлыг хангасан 6 ажилтан орон сууцны санхүүжилтийн корпорацийн зээлд хамрагдсан байна.</p> <p style="text-align: right;">Хэрэгжиж байна 70%</p>
<p><i>Стратегийн зорилт 4. Хүн амын өвчлөл, цаг бусын нас баралтыг бууруулж, дундаж наслалтыг ахиулна. Эрүүл аж төрөх хэв маяг, эрүүл мэндээ хамгаалах зөв зан үйлийг төлөвшүүлнэ:</i></p>		
	<ul style="list-style-type: none"> хүн амд амьдралын зөв зохистой хэвшил, бие бялдраа чийрэгжүүлэх орчин бүрдүүлэх; 	<p>Бие бялдрын хөгжлийн түвшин тогтоох сорилд албан 61 байгууллагын 27032 хүн хамрагдлаа. Аймгийн хэмжээгээр сорилд хамрагсадын 6955 хүн буюу 25,7</p>

		<p>хувь нь Д,Ф үнэлгээ авсан нь цаашид идэвхтэй дасгал хөдөлгөөнөөр хичээллэж бие бялдраа чийрэгжүүлэх шаардлагатайг харуулж байна. БТСГазрын арга зүйч, дасгалжуулагч нар сорил авсан байгууллагын ажилчдын сорилын дүгнэлтийг гарган тухайн хүн ямар чанар нь хангалтгүй дүн үзүүлсэнг тодорхойлж тэр чанараар хичээллэх дасгал хөдөлгөөнийг санал болгон хүргүүлэн ажиллаж байна.Нийт спортын тэмцээн уралдаан, өдөрлөг, цасны баярын арга хэмжээг аймгийн хэмжээнд 221 удаа зохион явуулж давхардсан тоогоор 43042 хүн хамрагдсан байна. Иргэдийн эрүүл мэндийг дэмжих, хөдөлгөөний идэвхи, зөв хооллолтыг дэмжих, хорт зуршлаас сэргийлэх, эрүүл зан үйлийг төлөвшүүлэх чиглэлээр Эрүүл мэндийн байгууллагууд болон бусад байгууллагуудтай хамтран орон нутагтаа нийт 76 удаагийн сургалтыг зохион байгуулж нийт 6631 хүнийг оролцуулсан байна. Үүнд: Эмч мэргэжилтнүүдэд 4 удаа-91, Албан байгууллагуудын ажиллагсдад 35 удаа -5374, Иргэдэд 37 удаа сургалт зохион байгуулж 1166 иргэнийг тус тус хамруулсан байна. Санамж, зөвлөмж, гарын авлага материал 8105 ширхэгийг түгээсэн байна.</p> <p>Хэвлэл мэдээллийн хэрэгслээр 12 удаа нэвтрүүлэг, 12 удаа сэрэмжлүүлгийг цацсан ба мэдээллийг цаг тухай бүр өгч ажилласан байна.</p> <p>Хэрэгжиж байна 90%</p>
	<ul style="list-style-type: none"> • хүн амын дунд эрүүл аж төрөх, уур амьсгалын дарамт, удамшлын аливаа доголдлоос эрүүл мэндээ хамгаалахад чиглэсэн сургалт, сурталчилгааг өргөжүүлэх; 	<p>Нийгмийн эрүүл мэндийн үйл ажиллагаанд халдварт өвчин, халдварын бус өвчин, БЗДХ, ХДХВ/ДОХ-ын чиглэлээр хүн амын дунд эрсдэлт зан үйл, өвчлөл, нас баралтын түвшин, тэргүүлэх шалтгааныг тогтоон тэдгээрийг бууруулахад чиглэсэн урьдчилан сэргийлэх, эрүүл мэндийн боловсрол олгох, эрт илрүүлэх, ажлыг үе шаттай зохион байгуулж, тэмцээн, мэтгэлцээн, уралдаан, уулзалт ярилцлага үзүүлэх сургууль 14 удаа , албан бус сургалт 825 удаа, салбар нэгжүүд болон боловсролын байгууллагуудад цаг үеийн байдалтай холбогдуулан 173 сурталчилгааны самбар ажиллууллаа. Хэвлэл мэдээллийн байгууллагатай хамтран ажиллаж нийт орон нутгийн телевизээр 91 удаа , FM радиогоор 5 удаа эмчийн зөвлөмж, мэдээлэл иргэдэд хүргэж, сонинд 32 удаа зөвлөмж, мэдээлэл нийтлүүлсэн байна. Нийгмийн эрүүл мэндийн чиглэлээр хэрэгжиж буй хөтөлбөрүүдийн хүрээнд нийт давхардсан тоогоор сургалтанд 43413 хүн /нийт хүн амын 47,6%/, давхардсан тоогоор сурталчилгаанд 61788 /нийт хүн амын 67,7%/ нийт сургалт сурталчилгаанд давхардсан тоогоор 104881 хүн /115%/ хамруулсан байна.</p> <p>Хэрэгжиж байна 90%</p>

<ul style="list-style-type: none"> • нөхөн сэргээх, асаргаа, сувилгааны төрлүүдийг хөгжүүлэх; 	<p>“Эрдэнэт үйлдвэр”-ийн Эмнэлэг сувилал нь бүсийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж байгаа бөгөөд нийт үзлэг 22547 хийснээс урьдчилан сэргийлэх үзлэг 7958 буюу 35,2 хувьтай байна. Үйлчлэх хүрээний 22171, харъяалалын бус 1065 хүнд үйлчилсэн байна.</p> <p>Сувилуулагчийн эмчийн үзлэг 4736 үүнээс анхны 2229, давтан үзлэг 2626 хүнд хийсэн байна. Сувилалд хэвтсэн 1469 хүн нийт 14656 ор хоног сувилуулсан байна. Нөхөн сэргээх эмчилгээний тасагт 40 нэр төрлийн эмчилгээг 3240 хүнд давхардсан тоогоор 16221 удаа хийж 99.8 хувь нь эдгэрсэн байна. Эмчилгээний хоолонд элэг цөс, хоол боловсруулах замын 191, зүрх судас, цусны эргэлтийн 81, бөөрний 29, чихрийн шижингийн 103, ердийн 1035 хүнд хийж үйлчилсэн байна.</p> <p style="text-align: right;">Хэрэгжиж байна 90%</p>
<ul style="list-style-type: none"> • уламжлалт анагаах ухааны шилдэг аргыг эрүүл мэндийн үйлчилгээнд нэвтрүүлэх; 	<p>Дотрын өвчний чиглэлийн ортой эмнэлэг 6, уламжлалтын чиглэлийн эмнэлэг 5, шүдний үүдэн эмнэлэг 9, эмэгтэйчүүдийн үүдэн эмнэлэг 9 байгуулагдан ажиллаж байна. Хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагууд дотрын өвчний 7.1-10.1 хувь, уламжлалт эмчилгээний 84.7-100 хувь, шүдний 82.0-90.0 хувь, эмэгтэйчүүдийн өвчний 56.4-84.8 хувийг үзэж эмнэлгийн тусламж үйлчилгээ үзүүлж байна. Хувийн хэвшлийн нэгдсэн эмнэлгийн уламжлалт эмчилгээний салбар “Мажаа” эмнэлэг нь ОХУ-ын Москва, Улаан-Үд хотод ажиллах гэрээ хийж сүүлийн 4 жил амжилттай ажиллаж байна.</p> <p style="text-align: right;">Хэрэгжиж байна 90%</p>
<ul style="list-style-type: none"> • эм, эмнэлгийн хэрэгсэл, багаж, тоноглолын үйлдвэрлэлийн тэргүүлэгч технологийг хөгжүүлэх; 	<p>НҮБ-ийн хүүхдийн сангийн санхүүжилтээр хэрэгжүүлсэн жирэмсний хяналтанд байгаа эмэгтэйчүүдийн дунд БЗДХ-ын тархвар зүйн судалгааны хүрээнд аймгийн сайн дурын зөвлөгөө шинжилгээний төвд нийт 2255.0 мянган төгрөгний сургалтын тоног төхөөрөмж, Глобаль сангийн дэмжлэгтэй ДОХ, сүрьеэгийн төслийн хүрээнд 2706.3 мянган долларын оношлуур нийлүүлснийг ашиглаж байна. Дэлхийн банкны санхүүжилттэй “Шувууны томуу, хүний томууны цар тахлын чадавхийг сайжруулах” төслөөс өвчтөний монитор дагалдах хэрэгслийн хамт, зөөврийн болон суурин автоклав, ариутгагч, 56538,8 долларын хөрөнгөөр вируслогийн лабораторийг ашиглалтанд оруулж орон нутагт анх удаа томуугийн А, В хүрээний вирус илрүүлэх шинжилгээнээс гадна элэгний В,С вирус, бүх төрлийн халдварт өвчнийг молекул биологийн түвшинд оношлон, хиймэл бөөрний /гемодиализ/ аппаратыг суурилуулан эмчилгээг 2009 оны 11 сараас</p>

		<p>эхлэн орон нутагтаа хийж, 4 хүн тогтмол эмчлүүлж нийт 241 шүүлт хийгдсэн байна. Цаашид бөөр шилжүүлэн суулгах мэс засал хийх төсөлд хамрагдах боломжтой болсон. ЭМСайдын тушаал болон өөрсдийн үйл ажиллагааны орлого нийт 207,3 сая төгрөгийн машин, тоног төхөөрөмж, “Ар Ти Эм” ХХК-аас эмнэлгийн хог хаягдал шатаах зуух буюу хорт утаа ялгаруулдаггүй хог шатаах зуухыг хүлээн авч суурилуулсан байна.</p> <p style="text-align: center;">Хэрэгжиж байна 90%</p>
	<ul style="list-style-type: none"> • эрүүл мэндийн салбарт хувийн хэвшлийн үйл ажиллагааг өргөжүүлэх; 	<p>Энэ онд төр хувийн хэвшлийн түншлэл хариуцсан мэргэжилтэнг орон тоогоор ажиллуулан улс болон хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагуудын үйл ажиллагааг дэмжиж, мэргэжлийн удирдлага, нэгдсэн бодлогоор хангаж ажилласан байна. Аймгийн хэмжээнд эрүүл мэндийн 105 байгууллага ажиллаж байгаагаас хувийн хэвшлийн ор бүхий 6 эмнэлэг, 41 үүдэн эмнэлэг, 33 эмийн сан, 8 эм хангамжийн байгууллага үйл ажиллагаагаа явуулж байгаа бөгөөд нийт 49 эрүүл мэндийн байгууллагуудтай хамтран ажиллах гэрээ байгуулан ажиллаж байна. Хувийн хэвшлийн 6 ортой эмнэлэг, 13 эмийн сантай даатгалаас санхүүжих 3 талт гэрээг байгуулан, эрүүл мэндийн даатгалын сангаас 2011 онд санхүүжилт авах ор бүхий хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагуудыг сонгон шалгаруулах үйл ажиллагаанд 6 эмнэлэг хамрагдаж тэнцсэн байна. Эрүүл мэндийн даатгалын хуулийн дагуу эмийн хөнгөлөлтийг 13 эмийн сангаар дамжуулан үзүүлсэн ба нийт 103,5 сая төгрөгний эмийн хөнгөлөлт үзүүлжээ. Эрүүл мэндийн байгууллагуудад түр зөвшөөрөл олгох комиссын хурлаар 3 эм ханган нийлүүлэх байгууллага, 4 эмийн сан, шавьж халдваргүйтгэлийн 1 болон хиймэл шүд, арьс гоо заслын чиглэлээр 2 үүдэн эмнэлгийг ажиллуулахаар зөвшөөрөл олгов. Хувийн хэвшлийн эмнэлгүүдэд 2010 оны байдлаар 3215 хүн 27634 ор хоног хэвтэн эмчлүүлж, амбулаториор нийт 61951 үзлэг хийгдснээс урьдчилан сэргийлэх үзлэг 18472 буюу 29,8 хувьтай байна.</p> <p>Хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагуудтай хамтран аймгийн хэмжээнд иргэдэд эрүүл мэндийн тусламж үйлчилгээг олон талаар үзүүлж байна. Тухайлбал шүдний хувийн хэвшлийн 9 эмнэлэгтэй хамтран эмзэг бүлгийн</p>

		<p>170 сурагчийг эмчлүүлсэн байна. МХГ, ЭМГ-ын даргын хамтарсан удирдамжийн дагуу аймгийн 8 хувийн хэвшлийн эмэгтэйчүүдийн эмнэлэгт нөхөн үржихүйн эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанарт хяналт үнэлгээг хийн, дүгнэлт өгөн хамтран ажиллав. “Тус дэм”- төрийн бус байгууллага болон “Ирээдүй” эмнэлгийг нөхөн үржихүйн эрүүл мэндийн эм хэрэгсэлээр ханган, үнэ төлбөргүй үйлчилгээг иргэдэд үзүүлэх боломжоор хангаж хамтран ажиллаж байгаа ба өсвөр үеийн сургагч багш бэлтгэх ажлыг хувийн хэвшлийн “Ирээдүй” эмнэлэгтэй хамтран гэрээгээр гүйцэтгэж байна. МУИС, ТИС, ХААИС, Маргад дээд сургуулийн оюутнуудад урьдчилан сэргийлэх үзлэгийг Бүсийн оношлогоо эмчилгээний төвийн болон хувийн хэвшлийн эмэгтэйчүүдийн эмч нартай хамтран зохион байгуулж 665 оюутнуудыг үзсэнээс 45 хувь нь эмэгтэйчүүдийн үрэвсэлтэй, тэмбүүгийн хурдавчилсан сорилоор 6 оюутан сэжигтэй гарч баталгаажуулах шинжилгээ авч эмчилгээнд хамруулсан байна.</p> <p style="text-align: right;">Хэрэгжиж байна 90%</p>
	<ul style="list-style-type: none"> байгалийн гамшиг, нийтийг хамарсан өвчлөл, гэнэтийн аюул ослын асуудлыг шийдвэрлэх эрсдэлийн менежментийн чадавхийг бэхжүүлэх; 	<p>Шувууны томуу, хүний томуу өвчний бэлэн байдлыг хангах чадавхийг сайжруулах чиглэлээр “Шувууны томуу, хүний томуугийн өвчлөлийн үе дэхь шуурхай хариу арга хэмжээ” сэдэвт 2 өдрийн сургалтыг зохион байгуулан бүх шатны эрүүл мэндийн байгууллагын эмч, эмнэлгийн мэргэжилтэн нийт 103 хүн хамрагдсан. Сум, өрхийн эмнэлгүүдээр дамжуулан боом, тарваган тахал өвчнөөс урьдчилан сэргийлэх сургалтыг байгалийн голомтот халдварт өвчний улиралчлалыг угтан хүн амд тогтмол хүргэж байна. Малчин багийн иргэд, эрсдэл ажил үйлчилгээ эрхэлдэг, бруцеллөз өвчнөөр эмчлэгдэж, хянагдаж буй хүн амд Газар дор “шар тос” гэвч аюул, Боом өвчнөөс сэргийлье, Хачигт халдвараас сэргийлье зурагт хуудас, гарын авлага, зөвлөмж тарааж, ТВ10 телевизээр 2 удаа зөвлөмж өгсөн. Бруцеллөз өвчний тандалтыг боловсронгуй болгох зорилгоор “Эрдэнэт хивс” болон мах боловсруулах үйлдвэрийн ажилчдад бруцеллөзийн урьдчилан сэргийлэх үзлэг 212 хүнд хийж, 3 ажилтныг хяналтанд авч, эмчилсэн байна. БОЭТ-ийн халдвартын диспансерт бруцеллөз өвчтэй 105 хүн хяналтанд байж эмчлэгдэж байна. Төрийн ба төрийн бус байгууллага, сум, өрхийн эмнэлгийн хамтын ажиллагааг сайжруулах, голомтот мал, амьтнаас хүнд халдварладаг халдварт өвчнөөс сэргийлэх ажлыг боловсронгуй болгох зорилгоор ХХААЖДҮГ-тай хүн малын бруцеллөз өвчний мэдээллийг</p>

		<p>улирал бүр солилцон, тандалт судалгаа хийн ажилласан байна. Малчин багийн иргэд, эрсдэл ажил үйлчилгээ эрхэлдэг, бруцеллёз өвчнөөр эмчлэгдэж, хянагдаж буй хүн амд 550ш зөвлөмж тарааж, Боом өвчнөөс сэргийлэх зөвлөмжийг мэдээллийн хэрэгсэлээр иргэдэд өгсөн. Томуу томуу төст өвчний дэгдэлтийг бууруулах, ариутгал халдваргүйтгэлийг сайжруулах зорилгоор хүүхдийн байгууллагад 860 ширхэг жавелиныг хүргүүллээ.</p> <p style="text-align: center;">Хэрэгжиж байна 90%</p>
	<ul style="list-style-type: none"> олон нийтийн оролцоо, салбар дундын хамтын ажиллагааг сайжруулах замаар хувь хүн, хамт олон эрүүл мэндээ хамгаалах санал, санаачилгыг дэмжин өрнүүлэх; 	<p>Аймгийн хэмжээнд нийгмийн эрүүл мэндээр тулгамдаж асуудлыг тодорхойлон эрүүл аж төрөх хэв маяг, эрүүл мэндээ хамгаалах зөв зан үйлийг төлөвшүүлэх, хамт олон эрүүл мэндээ хамгаалах санал, санаачилгыг дэмжин өрнүүлэх зорилгоор “Эрүүл мэнд бүх нийтийн үйлс” 8 сарын аяныг зохион байгуулан 40 байгууллагад 63 удаагийн сургалтыг 2153 хүнд явуулсан. Эрүүл мэнд бүх нийтийн үйлс 3 сарын аяны удирдамжинд бүх нийтийн хөдөлгөөний идэвхийг дэмжих зорилгоор явган аялалын тэмцээн зохион байгуулж 29 багийн 232 тамирчин, хөгжөөн дэмжигчид нийт 300 хүний оролцоог ханган ажиллалаа. ЕБС, цэцэрлэгийн соёл хүмүүжлийн ажлын нэгдсэн төлөвлөгөөнд эрүүл мэндийн сургалт, сурталчилгааны чиглэлээр тусгах 18 саналыг албан тоотой хүргүүлж, төрийн 53 байгууллага, үйлдвэр аж ахуй ХХК 5, төрийн бус байгууллага 8, олон улсын байгууллага 7, хэвлэл мэдээллийн 12 байгууллагатай хамтран ажиллалаа. Сургалтын танхимыг өөрсдийн нөөц бололцоогоор тохижуулан, хөшиг, сургалтын жижиг ширээгээр ханган 1 компьютерийг тогтмол сургалтанд ашиглахаар байрлууллаа. Эрүүл мэндийн сургалт сурталчилгааны орон нутагт хэрэгжүүлэх стратегийг боловсруулан, хэрэгжих төлөвлөгөөг гарган 39 байгууллагуудад хүргүүлэн, эмийн зохистой хэрэглээний мэдээлэл, уулзалт, сургалт 4 удаа зохион байгуулж 64 хүнийг хамрууллаа.</p> <p>Эрүүл мэндийн боловсрол олгох ажлын хүрээнд 3 төрлийн судалгааг хийлээ. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> Хөдөө орон нутагт ашиглаж буй эрүүл мэндийн мэдээлэл сургалт сурталчилгааны хүртээмж, хэрэгцээний судалгааг хийж мянганы сорилын санд хүргүүллээ. Эрүүл мэндийн ур чадвар”- ын олимпиадын дүнд үнэлгээ хийж, зөвлөмж танилцуулахад нийт 33 багш оролцоноос 20 багш нь эрүүл мэндийн хичээл заадаг багш нар оролцон, эрүүл мэндийн багш нарын онооны

		<p>дундаж нь 7.7 оноо буюу 24.4 хувьтай байна. Энэ дүнгээс харахад ЕБС-д эрүүл мэндийн хичээл зааж байгаа багш нарын эрүүл мэндийн мэдлэгийн түвшин хангалтгүй, мэдлэгийн дундаж үнэлгээ 25.8 хувь /8.1/ буюу F байгаагаас харахад эрүүл мэндийн хичээлийн чанар /эрүүл зан үйлийн талаарх сургалт/ хангалтгүй байгаа нь харагдаж байлаа. Хэрэгжиж байна 90%</p>
	<ul style="list-style-type: none"> • сум, дүүрэг, хот суурин газар болон гэр бүл, ажлын байранд эрүүл мэндийг дэмжих орчныг бүрдүүлэх; 	<p>ЭМД байгууллагын болзол шалгуур шинэчлэгдсэнтэй холбоотой ЗД-ын 2009 оны 228 тоот захирамж, ЭМС-ын 2009 оны 184 тоот тушаалыг ЭМДК-ын даргын албан тоотын дагуу 62 байгууллагад хүргүүлж хүргүүлэн эрүүл мэндийг дэмжих хөдөлгөөн өрнүүлэн зөвлөмжийг өглөө. Аймгийн хэмжээнд эрүүл мэндийг дэмжигч 37 байгууллага байна. Үүнээс 41.3 хувь нь хүүхдийн байгууллага байна. Нийт зөвлөгөө авахаар ирсэн 9 байгууллагад зөвлөмж өгч, 2010 онд шинээр 4 байгууллага ЭМДБайгууллага болсон байна. Хэрэгжиж байна 90%</p>
	<ul style="list-style-type: none"> • хүн амыг баталгаат ундны усаар хангах, эрүүл ахуйг сайжруулах, химийн болон бусад үйлдвэр, ахуйн хог хаягдлын менежментийг багтаасан амьдралын эрүүл орчин бий болгох замаар эрүүл, аюулгүй орчныг бүрдүүлэх. 	<p>ЭМБ-уудын үйл ажиллагааны явцад ялгарсан аюултай хог хаягдлын бүтэц, ялгарсан хэмжээ устгалын ажлын тайланг нэгтгэж, дүгнэлт гарган Аймгийн Байгаль орчны газарт хүргүүлсэн байна. Ойрын ундны усны нөөцийг тогтоон, усны эх үүсвэрээр хангах , ус түгээх цэг, гүний худгийн тоог нэмэгдүүлэх замаар усны хангамжийг сайжруулах чиглэлээр 2010 онд Азийн хөгжлийн банкны 7.5 тэрбум төгрөгний хөрөнгө оруулалтаар Чех улсын “Мон- 2301” төслийн хүрээнд гэр хороололд 26 ус түгээх байр барих, 34 км цэвэр усны шугам, 5.8 км бохир усны шугам тавихаар ажил эхлээд байна. Гэр хорооллын хүн амд зөөврийн усаар хангах нь тээвэрлэх, хадгалах явцад бохирдох магадлал өндөр тул Азийн банкны санхүүжилтээр МОН-3 төслийн хүрээнд төвлөрсөн усан хангамжинд холбох төсөл хэрэгжиж байна. Цэвэр орчин бүрдүүлэх чиглэлээр тодорхой ажлыг зохион байгуулж байгаа аж ахуйн нэгж, байгууллага, гудамж, айл өрхийг орон нутгийн телевиз болон сонин хэвлэлээр жилийн турш сурталчилан нийтийн цэвэрлэгээний хуваарийг гарган, дүүргийн болон эзэнгүй хог хаягдлын цэвэрлэгээний ажлыг 6 удаа зохион байгуулж цэвэрлэсэн талбайг тухайн багуудад нь хүлээлгэн өгснөөр эзэнгүй хог хаягдалгүй хот болох зорилт амжилттай хэрэгжиж байна.</p>

		<p>Орон нутгийн телевизээр “Халдварт өвчний гаралтанд нөлөөлж байгаа нийгэм орчны сөрөг нөлөөлөл, бохирдлын хүчин зүйл”, “Орчны эрүүл мэндийг сайжруулах үйл ажиллагааны чиглэл” сэдвээр мэдээлэл хийсэн байна. “Эрүүл мэнд бүх нийтийн үйлс” 8 сарын аяны хүрээнд Их цэвэрлэгээний өдөрт 357 аж ахуйн нэгж, 4573 хүн оролцож 19869 м.кв талбайг цэвэрлэж, 362 м.куб хог ачуулсан байна. ЭМГ-аас эмч мэргэжилтнүүдийн 2 баг албан байгууллагуудаар халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх, орчны эрүүл мэнд, осол гэмтлийн үед үзүүлэх анхны тусламжийн сэдвээр 58 байгууллагын 700-аад хүнд сургалт зохион байгуулав.</p> <p>Хог хаягдлын менежментийг сайжруулж дахин ашиглах боломжтой хаягдал түүхий эдийг худалдан авах , боловсруулах жижиг үйлдвэрлэлийг бий болгох, эрүүл ахуйн шаардлага хангасан инженерийн байгууламж бүхий хог хаягдлын цэг байгуулах, хог тээвэрлэлтийн тогтолцоог боловсрогуй болгон, машин механизмын паркыг шинэчлэх, түр цэгт байрлуулах талбайг стандартын шаардлагад шилжүүлэн тохижуулах, хогийн сав /контейнер бункер/-г орчин үеийн технологид нийлүүлэн төрөлжүүлэн шинэчлэх, хог хаягдал цуглуулах зориулалтын савны тоог нэмэгдүүлэх, богино хугацаанд авч, зөөвөрлөх чиглэлээр хөтөлбөр боловсруулан аймгийн ИТХ-аар батлуулж хийх ажлын төлөвлөгөөг аймгийн Засаг даргын зөвлөлөөр батлуулан хэрэгжүүлж байна.</p> <p>ЭМЯ-ны харъяа НЭМХүрээлэнгийн 4 мэргэжилтэнтэй хамтран ЭМБ-ууд болон хотын ахуйн хог хаягдлын ангилал, устгалын байдалд асуумж судалгаа, хөрс, агаарын дээж шинжилгээг авсан байна.</p> <p style="text-align: right;">Хэрэгжиж байна 90%</p>
4.6. Соёл, урлагийн хөгжлийн бодлого Бүх үе шат (2007-2021 он):		
<i>Стратегийн зорилт 1. Үндэсний соёлыг эрчимтэй хөгжүүлэх эдийн засаг, зохион байгуулалтын тааламжтай орчинг бүрдүүлнэ:</i>		
соёлын удирдлага, зохион байгуулалт, санхүүжилт зах зээлийн эдийн засгийн горимд шилжих үйл явцыг түргэтгэж, салбарын бүх шатанд мэргэжлийн ба	<p>Соёлын удирдлага зохион байгуулалт, санхүүжилт, зах зээлийн эдийн засгийн горимд шилжих үйл ажиллагаа нь улсын хэмжээнд нэгдсэн бодлогоор зохицуулагдана.</p> <p>Боловсрол, соёлын газрын дэргэд аймгийн Засаг даргын захирамжаар</p>	

<p>удирдлагын ур чадварыг дээшлүүлэх;</p>	<p>байгуулагдсан аймгийн “Соёлын зөвлөл” –ийн үйл ажиллагаа тогтмолжсон ба үүний үр дүнд соёл, урлагийн байгууллагын ажилтан, уран бүтээлчдэд мэргэжил, арга зүйн зөвлөгөө, туслалцаа үзүүлэх ажил нэлээд үр дүнтэй явагдаж байна. Аймгийн соёлын зөвлөл нь соёл, урлагийн байгууллагуудын үйл ажиллагаатай жилд 2 удаа газар дээр нь очиж танилцан шаардлагатай зөвлөгөөг холбогдох ажилтнуудад өгч, шинэ уран бүтээлүүдийг үзэн чанаржуулах асуудлаар санал бодлоо уран бүтээлчидтэй солилцдог байна.</p> <p>Аймгийн соёл, урлагийн байгууллагуудын нийт ажиллагаасаас БСГ-ын зүгээс хууль, эрх зүйн шалгалт авах ажил үргэлжлэн явагдаж байгаагаас гадна уран бүтээлчдийн мэргэжлийн ур чадварын шалгалтыг байгууллагын удирдлагуудтай хамтран авч дүгнэдэг.</p> <p>2010 оны хувьд аймгийн Засаг даргын зөвлөлөөр БСГ-ын болон Хүүхэлдэйн театраас зохион байгуулж байгаа ажил, ардын урлагийг хөгжүүлэх чиглэлээр хэрэгжиж буй үндэсний хөтөлбөрүүдийн биелэлт зэргийг авч хэлэлцлээ.</p> <p>Аймгийн Соёлын зөвлөл нь улиралд 1 удаа хуралдаж, тулгамдаж байгаа болон цаг үеийн асуудлыг авч хэлэлцэн цаашид хэрхэн шийдвэрлэх талаар тэмдэглэлд үндэслэн зөвлөмж гаргаж ирсэн.Удирдлагын ур чадварыг дээшлүүлэхийн тулд тэдэнтэй байгуулдаг үр дүнгийн гэрээнд салбар, байгууллагын үйл ажиллагаатай холбоотой нэмэлт заалт оруулж тайлангийн үеэр үр дүнг тооцон ажиллаж хэвшээд байна.Мэргэжлийн урлагийн 2 байгууллагад /Хүүхэлдэйн театр, “Эрдэнэт” чуулга/ жилд 2 удаа мэргэжлийн ур чадварын шалгалт авч түүний үр дүнг хөдөлмөрийн гэрээ дүгнэх, сунгахад харгалзаж байна.</p> <p style="text-align: right;">Хэрэгжиж байна 90%</p>
<ul style="list-style-type: none"> • үндэсний болон олон улсын хэмжээнд томоохон ач холбогдолтой бүтээл, туурвил, арга хэмжээг хөгжлийн сангуудаас тодорхой хувиар санхүүжүүлэх эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгож хэрэгжүүлэх 	<p>Холбогдох зарим тогтоол, журмуудыг улсын хэмжээнд мөрдөж байна. Монгол улсын Засгийн газрын 1998 оны 2 дугаар сарын 4-ний өдрийн 10 дугаар тогтоол “Хөгжмийн том хэлбэрийн болон дүрслэх урлагийн шилдэг бүтээл худалдан авах тухай”, 2003 оны 6 дугаар сарын 4-ны өдрийн 140 дүгээр тогтоол “Ном, хэвлэлийн шилдэг бүтээлийг худалдан авах журам”, 2007 оны 10 дугаар сарын 31-ний өдрийн 280 дугаар тогтоол “Хүүхдэд зориулсан уран бүтээл</p>

		<p>туурвихад төрөөс санхүүгийн дэмжлэг үзүүлэх журам” зэргээс гадна “Морин хуур-Уртын дуу”, “Монгол хөөмий”, “Монголын уламжлалт бий биелгээ”, “Түүх соёлын дурсгалт зүйлсийг хадгалж, хамгаалах” үндэсний хөтөлбөрүүд хэрэгжиж байна.</p> <p>”Ном хэвлэлийн шилдэг бүтээл худалдан авах” журмын дагуу зохиолч яруу найрагч Д.Дашдондовын “Бөлхөөхийн явдал” “Хүүхэд зориулсан уран бүтээлийг санхүүжүүлэх журам”-ын дагуу аймгийн Хүүхэлдэйн театрт “Огторгуйг эзэмдэгч сөөсгөр” хүүхдийн драм зэрэг уран бүтээлийг санхүүжүүлсэн.</p> <p style="text-align: center;">Хэрэгжиж байна 90%</p>
<p><i>Стратегийн зорилт 2. Хүн амд соёл, урлагийн үйлчилгээг хүртээмжтэй, чанартай хүргэж, иргэдийн оюуны хэрэгцээг хангах талаар дорвитой ахиц гаргана:</i></p>		
	<ul style="list-style-type: none"> • Монгол Улсын үндэстэн, ястан, үндэсний цөөнхийн болон хүн ам зүйн янз бүрийн давхрагуудын оюуны хэрэгцээг үе шаттай судлан тодорхойлж, тэдгээрт тохирсон соёл, урлагийн үйлчилгээний төрөл үр ашигтай арга хэлбэрийг сонгож хэрэглэх 	<p>Орхон аймгийн хувьд олон аймгаас ирж суурьшсан олон ястнууд амьдардаг нутаг. Энэ утгаараа олон ястныг хамарсан үйл ажиллагаа, тэдэнд чиглэсэн ажил арга хэмжээ тасралтгүй зохион байгуулагддаг. Тухайлбал: Үндэсний их баяр наадмын өдрүүдээр наадамчин олонд зориулан аймаг бүрийн гэр барин зан үйлийн хотхон байгуулж, Монголын олон ястаны зан үйл, аж амьдрал, ахуйн хэрэглэгдэхүүн, дуу хуур, бүжиг наадмыг толилуулдаг.</p> <p>Мөн уран бүтээлээ энэ чиглэлээр туурвидаг. Тухайлбал: “Эрдэнэт” дуу бүжгийн чуулга “Бид нэг гэр бүлийнхэн” олон үндэстэн ястны дуу хуурын бүрэн хэмжээний концерт, “Бүргэд” мюзикл бэлтгэн аймгийн хөдөлмөрчиддөө өргөн барьсны дээр Улаанбаатар хот, ОХУ-ын Буриад Улсын Улаан-Үд хотод амжилттай тоглосон ба Жаргалант суманд соёлын өдөр зохион байгуулж хөдөлмөрчид, хүүхэд багачуудад үнэ төлбөргүй үйлчилсэн байна. Түүнчлэн соёлын ордон, төвүүдийн дэргэд “Баруун монгол бий биелгээ”, “Урайнхайн дуу хуур” зэрэг хамтлаг, клуб байгуулахаар бэлтгэж байна.</p> <p>Орхон аймгийн соёлын өдрүүдийг БНХАУ-ын Бугат хотод 2010 онд XI сард зохион байгуулж, ардын уламжлалт болон хүүхэлдэйн урлагаа сурталчилсан.</p> <p style="text-align: center;">Хэрэгжиж байна 90%</p>
	<ul style="list-style-type: none"> • үндэсний монгол бичгээ өвлүүлэн 	<p style="text-align: center;">Энэ хичээлийн жилд ерөнхий боловсролын сургуулийн 4-9-р ангийн 10418</p>

<p>хөгжүүлэх орчин нөхцөлийг бүрдүүлэх;</p>	<p>сурагч монгол бичгийн хичээл судалсан байна.</p> <p>Багш, сурагчдын Монгол бичгийн чадварыг нэмэгдүүлэх, идэвхжүүлэх зорилгоор Монгол бичгийн бага олимпиадыг 8 төрлөөр зохион байгуулж, нийт сурагч, мэргэжлийн болон бага ангийн багш нарын 20 орчим хувь нь хамрагдсан байна. Мөн “Орхон” цогцолбор сургууль санаачлан байгууллага, анги, тэнхимийнхээ хаягийг монгол бичгээр бичиж, байрлуулав. Аймгийн нийт багш, сурагчид “Хүмүүн бичиг” сонинг сургалтад ашиглах хөдөлгөөн өрнүүлснээр энэ жил захиалгын тоо өмнөх жилээс 120-оор нэмэгдсэн байна. 17-р сургуулиас “Би Монгол хүн” сэдвийн дор намтар, түүхээ монгол бичгээр бичих хөдөлгөөн өрнүүлж, сургуулийн нийт багш, сурагчдыг хамруулсан.</p> <p>Монгол хэл, бичгийн багш нарт 3-р сарын 25-29-ний хугацаанд МУИС-ийн багш Монгол хэл, соёлын сургуультай хамтран заах арга зүйн чиглэлээр сургалт, мөн нийт монгол хэлний багш нар монгол бичгийн холбох ёс, түүнийг заах аргазүй, монгол бичгээр хичээнгүй бичих аргазүй, үсгийн тиг хэлбэрийн тухай ойлголтыг гүнзгийрүүлэх, харилцан туршлага солилцох сургалт явуулсан.</p> <p>Монгол бичгийн гайхамшиг, онцлог, бичлэгийн олон хэлбэрийг таниулах зорилгоор багш, сурагчдын дунд уран бичлэгийн уралдаан зохион байгуулж, эцэг, эхчүүдэд сурталчлан нийт 340 орчим эцэг, эх үзэж, сонирхлоо.</p> <p>Монгол бичгийн хавсарсан болон бие даасан кабинет байгуулж, шинээр 6 кабинет гэрчилгээ авсан.</p> <p>Монгол бичгийн тэргүүний уншигч шалгаруулах “Үндэсний бичиг мину” улсын 5-р уралдаанд манай аймгаас 10 сурагч оролцож, 3 сурагч хүрэл медаль, тусгай байрын шагнал хүртлээ.</p> <p style="text-align: right;">Хэрэгжиж байна 90%</p>
<ul style="list-style-type: none"> монголчуудын уламжлалт соёлын биет болон биет бус өвийг хадгалах, хамгаалах, сэргээх, үндэсний хийгээд дэлхий дахины танин мэдэхүй, боловсролын нийтлэг хүртээл болгон дэлгэрүүлэн хөгжүүлэх үйл ажиллагааг төрийн бодлогоор дэмжих; 	<p>“Уртын дуугаа өвлөн дэлгэрүүлэх тухай”, “Морин хуураа дээдлэн хөгжүүлэх тухай” Монгол улсын ерөнхийлөгчийн зарлигууд, Морин хуур, уртын дууг дэлхийн соёлын өвд бүртгүүлсэн явдал нь үндэсний уламжлалт соёлын өвийг дэлхий дахинаа таниулах, ард түмэн, нийт олноороо уламжлалт урлагийн өвөөрөө бахархах, өвлөх үйлст чухал ач холбогдол өгсөн. Мөн энэ чиглэлээр</p>

		<p>Монгол улсын Засгийн газраас баталсан “Ардын урлагийг дэмжих үндэсний хөтөлбөр”, “Үндэсний соёлын өвийн мэдээллийг тоон системд оруулан хадгалах” үндэсний хөтөлбөрүүдийг амжилттай хэрэгжүүлсэн ба одоо “Морин хуур-Уртын дуу”, “Монгол хөөмий”, “Монголын уламжлалт бий биелгээ”, “Түүх соёлын дурсгалт зүйлсийг хадгалж, хамгаалах” үндэсний хөтөлбөрүүд хэрэгжиж байна.</p> <p>Түүх соёлын дурсгалт зүйлсийн тооллого ,байрлалыг GPS-аар тодорхойлж ажил хийгдэн нийт 264 дурсгалыг бүртгэлжүүлсэн.Биет бус өвийн болон тээгчийн судалгааг соёлын төв, үндэсний хөтөлбөрүүдийн ажлын багуудтай хамтран зохион байгуулж байна.Эдгээрийн БМС-г аймгийн Музей дээр төвлөрүүлэн ажиллаж байна.МУИС-тай хамтран хотын гэр хороололд 1,5 сая төгрөгийн зардал бүхий малтлага хийлгэсэн.</p> <p style="text-align: right;">Хэрэгжиж байна 90%</p>
	<ul style="list-style-type: none"> • үндэсний уламжлалт болон сонгодог урлаг, хүүхдэд зориулсан урлагийн төрлийг төрөөс дэмжих үндэсний хөтөлбөр, төсөл боловсруулж хэрэгжүүлэх; 	<p>Монгол улсын Засгийн газраас баталсан “Ардын урлагийг дэмжих үндэсний хөтөлбөр”, “Сонгодог урлаг” үндэсний хөтөлбөрүүдийг амжилттай хэрэгжүүлсэн ба одоо “Морин хуур-Уртын дуу”, “Монгол хөөмий”, “Монголын уламжлалт бий биелгээ”, үндэсний хөтөлбөрүүд хэрэгжиж байна. Мөн Монгол улсын Засгийн газрын 280 дугаар тогтоолоор “Хүүхдэд зориулсан уран бүтээл туурвихад төрөөс санхүүгийн дэмжлэг үзүүлэх журам”-ыг батлан мөрдөж байна.</p> <p>Эдгээр хөтөлбөр, төслийг хэрэгжүүлэх зорилгоор соёлын үйл ажиллагаанд зориулж Орхон аймгийн Засаг дарга 340 гаруй сая төгрөг зарцуулсан.</p> <p style="text-align: right;">Хэрэгжиж байна 90%</p>
	<ul style="list-style-type: none"> • соёл, урлагийн байгууллагуудын материаллаг бааз, барилга байгууламжийн зориулалт, эрүүл ахуй, гоо зүй, техникийн болон үйлчилгээний чанарт тавигдах орчин үеийн хэрэгцээ шаардлагыг тусгасан стандартыг боловсруулж мөрдөх. 	<p>Дээд шатны байгууллагын шийдвэр гараагүй байна</p> <p style="text-align: right;">Хугацаа болоогүй</p>
<p>4.8. Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн бодлого Бүх үе шат (2007-2021 он):</p>		

<p><i>Стратегийн зорилт 1. Гэр бүл, нийгэм, хамт олонд тулгуурласан халамжийн тогтолцоог төлөвшүүлж, халамжийн үйлчилгээг олон улсын жишигт хүргэж хөгжүүлнэ:</i></p>	
<ul style="list-style-type: none"> • нийгмийн халамжийн дэмжлэг туслалцаа зайлшгүй шаардлагатай өрх, иргэдийн хэрэгцээ, сонголтод түшиглэсэн халамжийн олон талт үйлчилгээг бий болгож, үйлчилгээг хувийн хэвшил, иргэний нийгмийн байгууллагуудын оролцоотойгоор хүргэх тогтолцоог бүрдүүлэх; 	<p>Амьдрах ухааны зөвлөгөө өгөх сургалт зохион байгуулж 180 иргэнийг хамруулж 8303,0 мянган төгрөг, хөдөлмөр эрхэлж орлогын эх үүсвэртэй болгоход нь туслаж 182 иргэнд 29854,0 мянган төгрөг, сэргээн засах үйлчилгээнд 75 иргэнийг хамруулж 3342,5 мянган төгрөг, түр байршуулан асрамжлахад 24 иргэнийг хамруулж 2867,2 мянган төгрөг, гэрийн асрамж халамжийн үйлчилгээний зардалд 3 иргэнийг хамруулж 432,0 мянган төгрөг тус тус зарцууллаа.</p> <p style="text-align: right;">Хэрэгжиж байна 90%</p>
<ul style="list-style-type: none"> • хөдөөгийн хүн амд зориулсан нийгмийн явуулын үйлчилгээг хөгжүүлэх. 	<p>Малчин баг болон эмзэг бүлгийн иргэдэд урьдчилан сэргийлэх үзлэгийг 2 удаа зохион байгуулж шаардлагатай тусламж үйлчилгээг үзүүлж, хяналтанд авч эмчилж хэвшлээ. ЭМС-ын 2008 оны 80 тоот тушаалыг хэрэгжүүлж эмзэг бүлгийн хүн амд үнэ төлбөргүй тусламж үзүүлэх зорилгоор тусламж үйлчилгээг зохион байгуулах хуваарь , сургалт сурталчилгааны төлөвлөгөөг гарган 12 удаа зохион байгуулж давхардсан тоогоор нийт 121 байгууллагыг хамрууллаа. Урьдчилан сэргийлэх үзлэгт нийт 7020 хүн хамрагдсанаас амьжиргааны баталгаажих түвшингээс доогуур 1670, хөдөө орон нутгаас ирсэн 207, түр оршин суугаа 326, отроор яваа 57 , эрүүл мэндийн даатгалд хамрагдаагүй 1617 хүн үзлэгт хамрагджээ. Нийт 1798 хүн шинжилгээнд хамрагдсанаас амьжиргааны баталгаажих түвшингээс доогуур 131, хөдөө орон нутгаас ирсэн 25, түр оршин суугаа 10, отроор яваа 5 ,эрүүл мэндийн даатгалд хамрагдаагүй 181 хүн хамрагджээ. Амьжиргааны баталгаажих түвшингээс доогуур орлоготой 160 хүнийг аминдэмжүүлэлтэнд хамрууллаа.</p> <p style="text-align: right;">Хэрэгжиж байна 90%</p>
<p><i>Стратегийн зорилт 2. Иргэний хөдөлмөрлөх эрхийг хамгаалах, бүтээмж, ур чадварыг хөгжүүлэх үндсэн дээр цалин хөлсийг нэмэгдүүлэх, бизнесийн орчин, ажлын байрны тогтвортой байдлыг дэмжих, нийгмийн түншлэлийг төлөвшүүлэхэд чиглэсэн хөдөлмөр эрхлэлтийн бодлогоор дамжуулан хөдөлмөрийн зах зээлийн зохицуулалтыг оновчтой, үр ашигтай</i></p>	

<i>болгож, иргэдийн амьдралын түвшинг дээшлүүлэхэд дэмжлэг үзүүлнэ:</i>	
<ul style="list-style-type: none"> • хөдөлмөрийн зах зээлийн эрэлт, нийлүүлэлтийн судалгааг өргөжүүлж, ажил олгогч, ажил хайгчид, мэргэжлийн сургалтын байгууллагуудын уялдаа холбоог сайжруулах; 	<p>Тайлант хугацаанд Ш.Отгонбилэгийн нэрэмжит Технологийн сургууль, Эрдэнэт ХЭСТ, Албан бус боловсрол төв, “ТОД-Г” сургалтын төв, “Футур”, “Залуу техникч”, “Дэлгэрхангай”, “Солонго”, Хүүхэд залуучууд эмэгтэйчүүд ТББ-ын мэргэжил сургалтын төв зэрэг 9 сургалтын байгууллагатай гэрээ байгуулан мэргэжлийн 15 төрлөөр 18 удаагийн мэргэжил олгох, давтан сургалтанд 609 хүнийг хамруулан сургалаа. Сургалтанд ХЭДС-гаас 38502.0 мян/төг, хоол унааны зардалд 15472.7 мян/төг, Хөдөлмөр эрхлэлтийн дэмжлэгийн зардалд 760.0 мян/төг, нийтдээ 54735.1 мян/төг зарцууллаа./Үүнд аж ахуй эрхлэлтийн сургалт ороогүй болно/</p> <p style="text-align: right;">Хэрэгжиж байна 90%</p>
<ul style="list-style-type: none"> • хөдөлмөрийн гадаад болон дотоод зах зээлийн эрэлт хэрэгцээнд нийцүүлэх замаар гадаадад ажиллах хүч гаргах бодлогыг тодорхойлж хэрэгжүүлэх; 	<p>Улаанбаатар хотын “Их монгол Майнинг” ХХК нь ажилчин авах захиалга ирүүлсний дагуу 33 иргэнийг бүртгэж, танилцуулгыг хүргүүлсэн байна. Тавантолгой, Оюунтолгойн уул уурхайн орд газруудад хамтран ажиллах талаар саналыг хүргүүлээд байна. “Оюу толгой” компаниас тус үйлдвэрт ажилд орж ажиллах хүсэлтэй иргэдийг сургалтанд хамруулах бүртгэл хийгдэж шалгалтанд тэнцсэн 120 иргэнийг Технологийн сургууль дээр белазийн жолооч, баяжуулагч, цахилгаанчин зэрэг мэргэжлээр 1 жилийн хугацаатай суралцаж байна. “Оюутолгой” компаний хөрөнгө оруулалтаар мэргэжилтэй ажиллах хүч бэлтгэх зорилгоор манай аймагт олгогдсон квотын дагуу иргэдийг журмын дагуу бүртгэн шалгалт авч 111 иргэнд 17 мэргэжлээр 9-21 сарын хугацаатай мэргэжил эзэмшүүлэхээс манай аймагт 4 төрлийн мэргэжлээр, бусад мэргэжлүүдийг Улаанбаатар болон хөдөө орон нутгуудад эзэмшүүлэхээр сургалтын бүртгэл явагдаж, 856 хүнээс шалгалт авч 111 хүнийг сонгосон байна. Хөдөлмөрийн 3 талт салбарыг оролцуулсан “Хөдөлмөрийн бага чуулган” хийж 80 гаруй хүн, “Иргэдийн санаачлага-Төрийн дэмжлэг” сэдэвт хөдөлмөр эрхлээгүй иргэдийн зөвлөгөөн хийж 400 гаруй хүнийг оролцуулж зөвлөмж гаргаж ажиллаж байна.</p> <p style="text-align: right;">Хэрэгжиж байна 90%</p>
<ul style="list-style-type: none"> • хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн орчинг сайжруулах, олон улсын хэм хэмжээнд нийцүүлэх замаар эрх зүйн орчныг боловсронгуй болгох; 	<p>Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн орчны тухай ОУХБ-ын 155-р конвенц, хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн тухай хууль болон тэдгээртэй уялдан гарсан НХХС 2008 оны 126, 127-р тушаал болон нийгмийн хамгаалал хөдөлмөрийн харилцааны талаар гарсан хууль эрх зүйн актуудаар</p>

		<p>100-аас дээш ажиллагсадтай байгууллагуудад сургалт сурталчилгааг жил бүр хийж жилдээ 1500 гаруй хүнийг тогтмол хамрууллаа. Эрдэнэт үйлдвэр нь шинээр мөрдөгдөж буй хуулийн дагуу бүх ажиллагсадаа шат дараалалтайгаар ХАБЭА-н сургалтанд хамруулж ТИС-ийг түшиглэн сургалтын баазтай болсон. Ингэснээр бусад аймаг, сум болон орон нутгийн үйлдвэрийн ажиллагсад сургалтанд хамрагдаж мэдлэг мэргэжлээ дээшлүүлэх бололцоо бүрдсэн. Тус үйлдвэр нь өөрийн үйлдвэрийн дэргэд телевизтэй болж Хөдөлмөр хамгаалал, эрүүл ахуйн талаар үйлдвэрийн хэмжээнд зохион байгуулж буй ажлаа аймгийн хэмжээнд сурталчилж байна. Эрдэнэт үйлдвэрийн Хөдөлмөр хамгаалал, байгаль орчны хэлтэс нь орчин үеийн багаж тоног төхөөрөмжөөр тоноглогдсон хөдөлмөрийн нөхцлийн лабораторитой болж мэргэжлийн байгууллагын итгэмжлэл авсан. Ингэснээр төрийн байгууллагын лабораторийн чадамж дутмаг, багаж тоног төхөөрөмжийн хүрэлцээгүй байдалд туслалцаа үзүүлэх нөхцөл бүрдсэн. Өмчийн бүх хэлбэрийн 1118 аж ахуй нэгжийн 120 цех хэсгийн 45200 хүнийг хамруулан хяналт, шалгалт хийж 980 гаруй зөрчил илрүүлэн, зөрчлийн 30,0 хувийг газар дээр арилгуулж, илэрсэн зөрчилтэй холбогдуулан 30 байгууллагын үйл ажиллагааг зөрчлөө арилгах хүртэл түр хугацаагаар хэсэгчлэн буюу бүрэн зогсоож 780 заалт бүхий 119 албан шаардлага өгч биелэлтийг хангуулсан. Илэрсэн зөрчилтэй холбогдуулан 7 байгууллагад 4,9 сая төгрөг, 61 албан тушаалтанд 2,7 сая төгрөгийн торгууль ногдуулж захиргааны хариуцлага тооцсон. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйг хангуулах зорилтыг хэрэгжүүлэхийн тулд хөдөлмөр нийгмийн зөвшлийн 3 талт гэрээ байгуулан хамтран тогтмол томоохон ажлуудыг хийж гүйцэтгэж байна. Тухайлбал: Жил бүр Хөдөлмөрийн хуулийн хэрэгжилтийн үзлэг шалгалт хийж хэвшсэн.</p> <p style="text-align: right;">Хэрэгжиж байна 90%</p>
	<ul style="list-style-type: none"> • Жижиг, дунд үйлдвэрийн тухай хуулийг хэрэгжүүлэх бодлого, арга хэмжээний хүрээнд төрөлжсөн бизнес инкубаторыг байгуулан ажиллуулж, жижиг зээл, ажлын 	<p>Аж ахуй эрхлэх, төслийн сургалтыг Эрдэнэт Бизнес инкубатор төвтэй 12 удаа зохион байгуулж 278 иргэнийг хамруулан аж ахуй эрхлэх төрөл бүрийн үр чадвар олгов. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> • Бизнесээ эхэл-бизнесээ хөгжүүл сургалтанд 4 удаа- 63

<p>байран дахь болон шавь сургалтыг өргөтгөх замаар хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх;</p>	<ul style="list-style-type: none"> • Эдийн засгийн анхан шатны мэдлэг олгох сургалт-10 • Төсөл хөтөлбөр боловсруулах арга зүйн зөвлөгөө өгөх үйлчилгээнд жижиг зээлийн төсөл боловсруулах сургалтаар- 48 • Хоршооны сургалт-18 • Бүлгээр ажиллах чадварын сургалт-15 • Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн сургалт-32 • Шинэ эхлэл ажил хайх чиг баримжаа олгох сургалт-92 иргэн тус тус хамрагдлаа. <p style="text-align: center;">Хэрэгжиж байна 90%</p>
<p>• мэргэжлийн боловсрол, сургалтын талаар төрөөс баримтлах бодлогыг тодорхойлж, хувийн хэвшлийн оролцоог дэмжих замаар бэлтгэгдэж байгаа боловсон хүчний чадавхийг хөдөлмөрийн зах зээлийн хэрэгцээ, шаардлагад нийцүүлэх.</p>	<p>Тайлант хугацаанд мэргэжил олгох сургалтанд 419, аж ахуй эрхлэлтийн сургалтанд 278, нийт 697 хүнийг хамруулан сургалаа.Сургалтанд ХЭДС-гаас 38502,5.0 мян/төг, хоол унааны зардалд 14719,5 мян/төг нийтдээ 53222,0 мян/төг зарцуулсан байна.</p> <p>Ш.Отгонбилэгийн нэрэмжит Технологийн сургууль, Эрдэнэт ХЭСТ, Албан бус боловсрол төв, “ТОДГ” сургалтын төв, “Футур”, “Залуу техникч”, “Дэлгэрхангай”, “Солонго”, “Хүүхэд, залуучууд эмэгтэйчүүд” ТББ-ын мэргэжил сургалтын төв зэрэг 9 сургалтын байгууллагатай гэрээ байгуулан мэргэжлийн 15 төрлөөр 18 удаагийн сургалтыг зохион байгуулав.</p> <p>2010 онд сургалтанд хамрагдсан иргэдийн 240 нь буюу 57,2 хувь нь эмэгтэйчүүд байлаа. Суралцсан шалтгаанаар авч үзвэл, 273 нь буюу 65.2 хувь нь мэргэжилгүй, 130 буюу 31.0 хувь нь мэргэжлээ өөрчлөх шаардлагатай, 15 буюу 3,6 хувь нь 9.11-р анги төгссөн, цэргээс халагдсан залуучууд, 1 буюу 0,2 хувь нь мэргэжлээс шалтгаалах өвчний улмаас мэргэжлээ өөрчлөх шаардлагатай ажилгүй иргэн байна.</p> <p>Насны ангиллаар авч үзэхэд хамгийн олон 182 буюу 43.4 хувийг 18-24 насныхан, 25-34 насныхан 141 буюу 33.7 хувь, 35-44 насныхан 66 хүн буюу 15.8 хувь, хамгийн цөөн 30 буюу 7.1 хувь нь 45-60 хүртэлх насны хүмүүс сургалтанд хамрагдсан.</p> <p>Өрх толгойлсон 30 эмэгтэй үсчин, гар утас засварчин, шүрэн урлал, гэр</p>

		<p>ахуйн цахилгаан хэрэглийн засварчин, барилгын засал чимэглэл, цахилгаанчин, оёдол, тогооч, талх нарийн боов зэрэг мэргэжлээр суралцаж төгссөн байна</p> <p>Хөгжлийн бэрхшээлтэй 16 иргэнийг гагнуурчин-1, гэр ахуйн цахилгаан хэрэгслийн засвар-2, шүрэн урлал-4, цахилгаан-1, гэр ахуйн цахилгаан хэрэгслийн засварчин-2, оёдолчин-1, гар утас засвар-2, үсчин-2, талх нарийн боов-1 зэрэг сургалтанд хамруулсан байна.</p> <p>Хэрэгжиж байна 90%</p>
<p><i>Стратегийн зорилт 3. Хүн амын бүлгүүдийн зохистой хөдөлмөр эрхлэлт, түүний дотор нийгмийн эмзэг бүлгийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих бодлого, хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлнэ:</i></p>		
	<ul style="list-style-type: none"> эмэгтэйчүүд, ахмад настан, малчид, хөгжлийн бэрхшээлтэй иргэд зэрэг хүн амын болон нийгмийн бүлгүүдийн хөдөлмөр эрхлэлтийн хэрэгцээг тодорхойлж, дэмжлэг үзүүлэхэд чиглэсэн хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлэх; 	<p>Иргэдийг түр ажлын байраар хангаж орлогын эх үүсвэртэй болгох, хөдөлмөрийн дадлага олгох, ажиллах урам зоригийг нэмэгдүүлэхэд нийтийг хамарсан ажил их үүрэг гүйцэтгэдэг. Нийтийг хамарсан ажил зохион байгуулахдаа купон олгож хөдөлмөрийн хөлсийг тооцох замаар хөдөлмөр эрхлээгүй эмзэг бүлгийн иргэдийг оролцуулах боломжийг илүүтэй дэмжиж байна. Нийтийг хамарсан ажлыг Орхон аймгийн хэмжээнд “Цэвэр хот бий болгох жил” болгон зарласаны дагуу нийтийг хамарсан ажлуудыг зохион байгуулж баг хороо сумын хэмжээнд хот тохижилт ногоон байгууламжийг нэмэгдүүлэх арчлах тордох, хайс хашлага хийх, хүүхдийн тоглоомын талбайг тохижуулах, ойг нөхөн сэргээх, авто машины зогсоолыг өргөтгөх, булаг ус хамгаалах, малын сэг зэм цэвэрлэх, туслах малчин ажиллуулах, багийн нутаг дэвсгэрт байгаа эзэнгүй хог хаягдлыг цэвэрлэх, зөөж тээвэрлэх зэрэг ажлуудыг 26 аж ахуйн нэгж сум, хороо, баг, СӨХ-үүд зохион байгуулан, тэдгээрт ажилгүй эмзэг бүлгийн 1018 иргэнийг ажиллуулж нийтийг хамарсан ажлын хөлсөнд 90497.0 мян/төгрөг зарцуулсан. Өрх толгойлсон 30 эмэгтэй үсчин, гар утас засварчин, шүрэн урлал, гэр ахуйн цахилгаан хэрэглийн засварчин, барилгын засал чимэглэл, цахилгаанчин, оёдол, тогооч, талх нарийн боов зэрэг мэргэжлээр суралцаж төгссөн байна</p> <p>Хөгжлийн бэрхшээлтэй 16 иргэнийг гагнуурчин-1, гэр ахуйн цахилгаан хэрэгслийн засвар-2, шүрэн урлал-4, цахилгаан-1, гэр ахуйн цахилгаан</p>

		хэрэгслийн засварчин-2, оёдолчин-1, гар утас засвар-2, үсчин-2, талх нарийн боов-1 зэрэг сургалтанд хамрууллаа. Хэрэгжиж байна 90%
	• гадаадад ажиллаж, амьдарч байгаа, өндөр боловсрол, мэргэжил эзэмшсэн монгол иргэдийг эх орондоо буцаж ирж ажиллах сонирхлыг төрүүлэхүйц эрх зүй, эдийн засгийн таатай орчныг бүрдүүлж, өөрийн мэргэшсэн чиглэлээрээ ажлын байр бий болгох санал санаачилгыг хөхиүлэн дэмжих;	2010 онд болсон Хүн ам, орон сууцны тооллогын урьдчилсан байдлаар аймгийн хэмжээнд 2600 хүн гадаадын улс орнуудад сурч амьдарч байгаа судалгааны дүн гарсан байна. Хэрэгжиж байна 50%
	• албан бус хөдөлмөр эрхлэгчдийн бүртгэл, мэдээлэл, зохион байгуулалтыг сайжруулж, төр, иргэний нийгмийн байгууллага, мэргэжлийн холбоодын оролцоотойгоор нийгмийн үйлчилгээнд хамрагдах боломжийг нэмэгдүүлэх;	Албан бус хөдөлмөр эрхлэгчдийн бүртгэл судалгааг явуулж мэдээллийн нэгдсэн сүлжээнд хамруулж үнэмлэхжүүлж байна. Энэ салбарын гол хөдөлмөр нь хот хоорондын нийтийн тээврийн үйлчилгээнд явах, нийтийн тээврээр хот дотор үйлчилгээнд явах, бэлэн хувцас болон хүнсний бүтээгдэхүүн зарж борлуулах, хүнсний бүтээгдэхүүн үйлдвэрлэх, кино прокат ажиллуулах, модон эдлэл хийх, гоо сайхны бүтээгдэхүүн худалдаалах, газар тариалан эрхлэх гутал завсар, үсчин ажиллуулах зэрэг үйлдвэрлэл үйлчилгээг ард иргэдэд хүргэн ажиллаж байна. Албан бус хөдөлмөр эрхэлж байгаа иргэдийг дэмжих зорилгоор зээлд хамрагдах хүсэлт гаргасан иргэн, аж ахуйн нэгжийн төслийг хүлээн авч “Хас” банкаар дамжуулан 136 иргэн, аж ахуй нэгжид 474.8 сая төгрөгийн зээл олгож 547 ажлын байр бий болгосон байна. Хэрэгжиж байна 70%
	• албан бус хөдөлмөр эрхлэгчдийн зах зээлд өрсөлдөх чадварыг дээшлүүлэхэд чиглэсэн эдийн засаг, бизнесийн дэмжлэгийг өргөжүүлэх;	Албан бус салбарт хөдөлмөр эрхлэгчдийн судалгааг мэдээллийн сүлжээнд оруулж www.labor.mn веб сайтанд бүртгэлээ. Албан бус хөдөлмөр эрхлэгчид ихэвчлэн такси нийтийн тээвэр, хувцас, хүнс, гоо сайхны бүтээгдэхүүний худалдаа, үйлдвэрлэл, кино прокат, модон эдлэл, газар тариалан, гутал засвар, үсчин зэрэг үйлдвэрлэл, үйлчилгээнүүдийг эрхэлж байна. Албан бус хөдөлмөр эрхэлж байгаа иргэдийг дэмжих зорилгоор жижиг зээлд хамрагдах хүсэлт гаргасан иргэн, аж ахуй нэгжийн төслийг хүлээн авч “Хас” банкаар дамжуулан 115 иргэн, аж ахуй нэгжид 403,0 сая төгрөгийн зээл

		<p>олгогдсон байна.</p> <p>Хувийн хөдөлмөр зуучлалын алба байгуулах санал, санаачилгыг дэмжиж 2 иргэнд зөвлөгөө, мэдээлэл өгсөн байна. 8-р сард батлагдан гарсан хувийн хөдөлмөр зуучлалын алба байгуулах журмыг сумдад хүргүүлж 150 гаруй иргэн, аж ахуй нэгжид сурталчлах ажил зохион байгууллаа.</p> <p style="text-align: right;">Хэрэгжиж байна 90%</p>
	<ul style="list-style-type: none"> • хөдөлмөр эрхэлж буй хүүхдүүдийг боловсрол, мэргэжлийн сургалт, эрүүл мэндийн үйлчилгээнд хамруулах, эцэг, эх, гэр бүлийн гишүүдийг нь ажлын байраар хангах зэргээр залуучуудын ажил эрхлэлттэй уялдуулан цогц байдлаар хэрэгжүүлэх. 	<p>2010 онд сургууль завсардсан 21 хүүхэд байсны 7-г нь ерөнхий боловсролын сургуульд буцаан суулгаж, 14-ийг нь АББТ-д сургаж, нөхөн боловсрол олгож байна.</p> <p>Албан бус боловсрол төвд 129, Говилд 18, Баянцагаан 16, Рашаант 10, Шанд 24, Жаргалант суманд 18 хүүхэд, залуучуудыг бичиг үсгийн болон боловсрол нөхөн олгох сургалтанд хамруулсан. Үүнээс бичиг үсгийн сургалтанд 52, бичиг үсгийн дараах сургалтанд 82, боловсрол нөхөн олгох танхимаар 65, цугларалтаар 40, эчнээгээр 18 хүүхэд, залуучууд суралцсан байна.</p> <p>Их залуу багийн байранд сургуульд огт суугаагүй 6, сургууль завсардсан, бичиг үсэг бага мэдэх 8 хүүхдийг бичиг үсгийн зуны сургалтанд хамруулсан.</p> <p>“Дезерт” олон улсын байгууллагатай хамтран эмзэг бүлгийн хүүхдийг англи хэлд сургах төсөл, “Хүнд нөхцөлд байгаа хүүхдийн хамгааллын төв”-тэй хамтран хөдөлмөр эрхэлж байгаа хүүхдүүдийг ерөнхий боловсролын сургуульд хамрах төсөл тус тус багтаж байна. Хэлний сургалтын төсөлд ядуу 80 өрхийн 131 хүүхэд, сургуульд хамруулах төсөлд хөдөлмөр эрхэлж байсан 12 хүүхдийг татан оролцуулсан байна.</p> <p style="text-align: right;">Хэрэгжиж байна 70%</p>
ТАВ. ЭДИЙН ЗАСГИЙН ӨСӨЛТ, ХӨГЖЛИЙН БОДЛОГО		
5.1.1. Улсын төсвийн бодлого -Бүх үе шат (2007-2021 он):		
	<p><i>Стратегийн зорилт 1. Төсвийн төлөвлөлтийг Монгол Улсын Мянганы хөгжлийн зорилтод суурилсан Үндэсний хөгжлийн цогц бодлогыг хэрэгжүүлэхэд нийцүүлэн боловсронгуй болгоно:</i></p>	
	<ul style="list-style-type: none"> • орон нутгийн төсвийн удирдлага, санхүүжилтийн эрх хэмжээг нэмэгдүүлж, 	<p>Улсын болон орон нутгийн төсвийн төлөвлөлтийг боловсронгуй болгох, хоорондын уялдаа холбоог сайжруулах үүднээс хөрөнгө оруулалтын бодлого</p>

	хариуцлагын тогтолцоог боловсронгуй болгон улсын болон орон нутгийн төсвийн төлөвлөлтийн уялдаа холбоог сайжруулах;	чиглэлд нэлээд анхаарч ажилласнаар хөрөнгө оруулалтын ажлыг төлөвлөхдөө зураг төсөвгүй ажлыг төлөвлөхгүй байх зарчмыг мөрдөж, мөн ач холбогдол болон чиглэлээр нь эрэмбэлж, дугаарлан хөтөлбөрүүдэд тусган батлуулж байна. Шаардлагатай байгаа хөрөнгө оруулалт, их засваруудын санхүүжилтийг төсөл, хөтөлбөр, улсын төсөв, болон бусад эх үүсвэрүүдэд хамруулахыг зорьж байна. Хэрэгжиж байна 90%
	• төсвийг төсвийн байгууллагуудын бодит хэрэгцээнд нь нийцүүлэн төлөвлөж, санхүүжүүлэх;	Төсвийн байгууллагуудын төсвийн төлөвлөлтийг боловсронгуй болгох чиглэлээр тэдний бодит хэрэгцээ шаардлагыг үнэн зөв тодорхойлж түүний дагуу хөтөлбөр боловсруулж, хөтөлбөрт суурилсан төлөвлөлтөнд шилжин ажиллаж байгаа ба бодит гүйцэтгэлээр нь санхүүжүүлэх, гарсан үр дүнг тооцож урамшуулалын системийг богино хугацаанд шийдвэрлэж ажиллах чиглэл баримталж байна. Мөн үргүй зардлыг бууруулах, шаардлага багатай элдэв зардлыг төлөвлөхгүй байх зэрэгт анхаарч ажиллаж байна. Хэрэгжиж байна 90%
	• төсвийн ил тод байдлыг хангах.	Аймгийн ИТХ-аар 2010 оны төсөв, төсвийн тодотгол хийх, 2011 оны төсвийг батлах үед түүний хэлэлцүүлгийн талаар орон нутгийн радио телевизээр шууд дамжуулан нээлттэй хүргүүлж аймгийн ЗДТГ, ИТХ-ын ажлын албанд иргэд олон нийтээс санал асуулга авах утас ажиллуулж байгаагаас гадна төсвийн орлого зарлагын гүйцэтгэлийн талаар 7 хоног бүрийн шуурхай, сар бүрийн удирдлагуудын нэгдсэн шуурхай зөвлөлгөөнд тогтмол мэдээлж байна. Хөрөнгө оруулалтын явцын талаар Аймгийн Засаг даргын зөвлөлийн хуралд 2 удаа асуудал хэлэлцэв. Цаашид хөрөнгө оруулалтын ажлын явц чанар байдал тендер түүний гүйцэтгэлийн талаар орон нутгийн радио телевиз, хэвлэлүүд, мөн аймгийн вэб сайтад тогтмол мэдээлж хэрэгжилтийг ханган ажиллах болно. Хэрэгжиж байна 90%
<i>Стратегийн зорилт 2. Төсвийн хөрөнгө оруулалтыг Мянганы хөгжлийн зорилтуудтай оновчтой уялдуулан нэмэгдүүлж, урт, дунд хугацааны хөгжлийн хөтөлбөр, төслүүдэд суурилан хэрэгжүүлнэ:</i>		
	• төсвийн хөрөнгө оруулалтыг зорилтот	Хөрөнгө оруулалтын төлөвлөлтийг хийхдээ, нийгэм эдийн засгийг хөгжүүлэх

<p>хөтөлбөрүүд, эдийн засаг, нийгмийн салбарын хөгжлийн мастер төлөвлөгөө, төслүүдэд тулгуурлан хуваарилах;</p>		<p>үндсэн чиглэл, Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр, бусад төсөл хөтөлбөрүүдтэй уялдуулан төлөвлөх чиглэл барьж ажиллаж байна. Үүний үр дүнд манай аймгийн хөрөнгө оруулалтын хэмжээ жилээс жилд өсч 2010 онд улсын болон орон нутгийн хөрөнгөөр 10444,9 сая төгрөгний, Гэр хороололийн усан хангамжийг сайжруулах ажлын хүрээнд 2008-2012 онд 7.3 тэрбум төгрөгийн “ МОН-2301” төслийг Азийн хөгжилийн банкны хөрөнгөөр хэрэгжүүлж байна. Одоогоор зураг төсөв, байгаль орчны нарийвчласан үнэлгээ судалгаа, гэрийн хороололд гүний цооног өрөмдөх ажил эхлээд байна. Мөн “Гэр хороололыг олон нийтийн оролцоотой хөгжүүлэх МОН-9106” төсөл хэрэгжүүлэх нэгжтэй хамтран ажиллаж Баян-Өндөр сумын Цагаанчулуут багийн 14-26,27-47,42-48 дугаар гудамжны гэрэл,Баян-Өндөр сумын Наран багийн 2-13,16-20,38-40,54-69 дугаар гудамжны гэрэлтүүлэгийн ажилд оролцож орон нутгийн төсвөөс 12,0 сая төгрөгийг зарцуулаад байна. 2011 онд улс, орон нутгийн төсвийн хөрөнгөөр 11681,9 сая төгрөгний хөрөнгө оруулалт хийхээр батлагдаад байна. Хэрэгжиж байна 90%</p>
<ul style="list-style-type: none"> • дэд бүтцийн хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх; 		<p>Хотын доторхи болон шинээр байгуулагдсан гэр хороолалуудыг асфальтан замаар холбоход улсын төсвөөс 1700.0 сая төгрөг ,орон нутгийн хөрөнгөөр 435.2 сая төгрөг, гэр хороололын цахилгаанжуулалтанд улсын төсвөөс 500.0 сая төгрөг, орон нутгийн төсвөөс 465,1 сая төгрөг, Дулааны цахилгаан станцын зуухны шинэчлэлд 500,0 сая төгрөг тус тус зарцуулж нийт 3600,3 сая төгрөг, нийт төсөвлөсөн хөрөнгийн 34,3 хувийг эзэлж байна. Улсын төсвийн хөрөнгөөр: 2010 онд он дамжин баригдсан Дэнж,Эрдэнэ багийн 3.55 км авто зам, Дэнж багийн 40 ортой эмнэлэгийн барилга зэрэг 1607,0 сая төгрөгийн зам барилга, Их залуу багийн 120 хүүхдийн цэцэрлэгийн барилгыг ашиглалтанд бүрэн өгч, Ахмадын сувилалын барилга, Хүүхдийн ордны барилга зэрэг объектийн ажил 90-98 хувьтай явагдаж байна. Хэрэгжиж байна 90%</p>
<p>5.1.2. Татварын бодлого Бүх үе шат (2007-2021 он):</p>		
<p>Стратегийн зорилт 2. Экологийн татварыг бий болгож, татварын суурийг өргөтгөн татвар хураалтыг сайжруулж, төсвийн орлогыг зохистой нэмэгдүүлнэ:</p>		

	<ul style="list-style-type: none"> • татварын илүү төлөлтийг буцаан олгох тогтолцоог нэвтрүүлэх: 	<p>2010 оны орон нутгийн төсвийн төлөвлөгөөгөөр Хувь хүний орлогын албан татварын буцаан олголтонд 801643,3 төгрөг олгогдохоор тусгагдсан бөгөөд дараа оны 1-р улиралдаа багтаан олгогдохоор хуульчлагдсан байдаг. 2011 оны төсөвт 1100,000 төгрөг батлагдсан байна.</p> <p style="text-align: right;">Хэрэгжиж байна 90%</p>
5.1.6. Гадаад худалдааны бодлогын стратегийн зорилтууд Бүх үе шат (2007-2021 он):		
<i>Стратегийн зорилт 1. Экспортын бүтээгдэхүүний нэр төрөл, хэмжээг зохистой өсгөнө:</i>		
	<ul style="list-style-type: none"> • эрдсийн болон мал аж ахуйн гаралтай түүхий эдийн экспортыг үе шаттай бууруулж, эцсийн бэлэн бүтээгдэхүүний экспортыг нэмэгдүүлэх; 	<p>. Аймгийн хэмжээнд гадаад худалдаагаар 1.3 триллион төгрөг буюу 980.7 сая ам долларын бараа эргэлт хийжээ. Өнгөрсөн оны мөн үеэс нийт эргэлт 44.5 хувиар, үүнээс импорт 80.4 хувиар, экспорт 40.0 хувиар өсчээ.</p> <p>Гадаад худалдаагаар гол нэрийн бүтээгдэхүүнээс 563.2 мян.тн зэсийн баяжмал, 4.5 мян.тн молибдений баяжмал, 2.8 мян.тн катодын зэс, 61.5 мян.м2 хивс, 2.5 мян.тн малын мах зэрэг 1.1 триллион төгрөгийн бараа экспортлож, хүнсний 1-р гурил 1.4 мян.тн, хүнсний дээд гурил 65.9 тн, хүхэрт натри 5.6 мян.тн, дизелийн түлш 23.2 мян.тн, тээрмийн ган бөмбөлөг 12.6 мян.тн, бензин 20.3 мян.тн зэрэг 183.3 тэрбум төгрөгийн бараа бүтээгдэхүүн импортоор авчээ.</p> <p>Өнгөрсөн оны мөн үеэс экспортод гаргасан хивс 13.5 хувиар, катодын зэс 21.7 хувиар өсч, зэсийн баяжмал 2.9 хувиар, молибдений баяжмал 22.4 хувиар, малын мах 30.8 хувиар буурч, импортоор авсан тоосго, хүнсний дээд гурил 78.9-98.9 хувиар буурч, аммиакийн бордоо 7.8 хувиар, дизелийн түлш 7.9 хувиар, бензин 16.7 хувиар, хэвний элс 31.1 хувиар, хүнсний 1-р гурил 35.9 хувиар, тээрмийн ган бөмбөлөг 2.2 дахин, хүхэрт натри 2.9 дахин, хөдөлгүүрийн тос 6.4 дахин өссөн байна.</p> <p style="text-align: right;">Хэрэгжиж байна 90%</p>
Стратегийн зорилт 2. Импортын бүтээгдэхүүний нэр төрөл, хэмжээг эдийн засгийн хөгжлийн хэтийн чиг хандлагатай оновчтой уялдуулан сайжруулна:		
	<ul style="list-style-type: none"> • импорт орлох зарим 	Шинээр Эрдэнэт хивс ХХК нь ноосон хөнжил, Мөнх тэнгэрийн ташуур ХХК

<p>бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг дэмжих;</p>	<p>хаягдал резинэн бүтээгдэхүүнийг дахин боловсруулан резинен шал жийргэвчүүд, спортын болон сургууль цэцэрлэгийн биеийн тамирын зам талбайн хавтан, Орхон сэтгэмж ХХК нь байгалийн цэвэр модыг үйлдвэрлэлийн аргаар хатааж модны ярыг шүүж сам заалдлаар заасан яргүй зүймэл модон хавтан, модон вакум хаалга цонхны үйлдвэрлэлийг шинээр явуулж байна. Мөн Супер матрас ХХК нь Солонгос улсын үйлдвэрийн технологийг нэвтрүүлэн хэрэглэгчдийн хүссэн загвар хэмжээгээр матрас, модон орыг, Инкрасс ХХК нь шингэн саван/туршилт эхэлсэн/ үйлдвэрлэж байна.</p> <p>2010 онд үйлдвэрлэлийг дэмжих жилийн хүрээнд Монгол Улсын Засгийн Газрын 2009 оны 178 дугаар тогтоолоор баталсан “Орон нутагт үйлдвэр хөгжүүлэх чиглэл”, аймгийн Засаг даргын 2009 оны 159 дүгээр захирамжаар баталсан “Орхон аймагт хөгжүүлэх жижиг дунд үйлдвэрийн тэргүүлэх чиглэл”-д тусгагдсан үйлдвэрүүдийг санхүү зээлийн бодлогоор түлхүү дэмжин ажилласан. Үүний үр дүнд жилд 3000 тн яс боловсруулах био бордооны үйлдвэр, 165.2 мянган м2 хавтан үйлдвэрлэх барилгын сендвичин хавтангийн үйлдвэр, жааз, бэлэг дурсгалын бүтээгдэхүүний үйлдвэр, жинсэн өмд, гэрийн цагаан бүрээсний үйлдвэр, хагас боловсруулсан махан бүтээгдэхүүн, мах ангилан савлаж худалдаалах үйлдвэр, 300 гахайны аж ахуй шинээр байгуулагдаж байна. Мөн талх, нарийн боов, сүү боловсруулах үйлдвэрүүдэд техник, технологи, хөргөлтийн тоног төхөөрөмжийн шинэчлэл хийснээр бүтээгдэхүүний чанар сайжирч, нэр төрөл нэмэгдэх боломж бүрдсэн байна. Тухайлбал “Эрдэнэт өег” ХХК 50.0 сая төгрөгний хөнгөлөлттэй зээл авч, 8 төрлийн шинэ тоног төхөөрөмж нэмж, үйлдвэрлэлийн байраа 66 м2-аар өргөтгөснөөр бүтээгдэхүүний нэр төрлийг 5 нэмэгдүүлж нийт 22-24 нэр төрлийн бүтээгдэхүүн үйлдвэрлэн, үйлдвэрлэлийн хэмжээгээ 2 дахин нэмэгдүүлэв. “Орда заан хошуу” ХХК тоног төхөөрөмжийн шинэчлэл хийсэн байна. Мөн 2010 онд дэмжигдсэн томоохон төслүүдээс “Натураль альфа” ХХК үйлдвэрийн байр худалдан авч засварлан өөрийн ажлын байртай болов. “Эрдэнэт прогресс” ХХК 600 тонны хөргүүлтэй агуулах барьж ашиглалтанд оруулаад байна. “Суу ариг” ХХК гутлын үйлдвэрийн тоног төхөөрөмж авч суурилуулан үйлдвэрлэлээ эхлээд байна. Мөн “Адамас” ХХК нь шингэн шил, “Гелкал” ХХК нь угаалгын шингэн, антивирусыг үйлдвэрлэн дотооддоо нийлүүлж байна.</p>
---	---

		Хэрэгжиж байна 90%
	5.1.7. Хувийн хэвшлийн хөгжил Бүх үе шат (2007-2021 он):	
	<i>Стратегийн зорилт 2. Бизнесийн үйл ажиллагааны эрх зүйн орчинг боловсронгуй болгож, хувийн хэвшлийн үйл ажиллагаанд оролцох Засгийн газрын оролцоог зохистой түвшинд хүртэл хязгаарлана:</i>	
	<ul style="list-style-type: none"> • төрийн зохицуулалтын бүтэц, тогтолцоог хянан үзэж, шуурхай болгох; 	<p>Бизнес эрхлэх үйл ажиллагааны талаархи мэдээллийг иргэдэд нэг цэгээс үзүүлэх зорилгоор НЦҮ-ний зааланд Бизнес ширээг ажиллуулах концепц, үзүүлэх үйлчилгээний зураглал, түүнтэй холбоотой мэдээлийн хуудсуудыг хамтран ажиллах байгууллагуудаас авч бэлтгэн “Бизнес ширээ”-нээс үзүүлэх журмыг боловсруулан гаргаж “Бизнесийн орчны шинэтгэлийн жил”-ийн ажлын хүрээнд “Бизнес ширээ” үйлчилгээг 2010 оны 5-р сарын 17-ний өдрөөс эхлэн НЦҮ-ний танхимд нээн ажиллуулж байна. “Бизнес ширээ” үйлчилгээгээр дараах зуучлах үйлчилгээг үзүүлж байна.</p> <ol style="list-style-type: none"> 1.МХГ-ын “Улсын байцаагчийн ажлын байрны нэгдсэн дүгнэлт 2.БОАЖГ-ын “Байгаль орчинд үзүүлэх нөлөөллийн ерөнхий үнэлгээ” гаргах үйлчилгээ 3.ОБГ-ын “Ажлын байрны галын аюулгүй байдлын дүгнэлт” гаргах үйлчилгээ 4.АЗДТГ-аас олгодог “Согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх тусгай зөвшөөрлийн хүсэлт хүлээн авах үйлчилгээ 5.БӨСумын ЗДТГ-аас олгодог “Тамхи худалдах зөвшөөрөл”-ийн хүсэлт хүлээн авах үйлчилгээ 6.ХАҮТ-аас олгодог “Монгол улсад үйлдвэрлэснийг гэрчлэх гарал үүслийн гэрчилгээ” авах үйлчилгээ 7.ХАҮТ-аас олгодог “Бараа бүтээгдэхүүнд зураасан код олгох” үйлчилгээ <p>“Бизнес ширээ”-ний үйлчилгээний талаар шторк бэлтгэн орон нутгийн Номин ТВ-ээр тодорхой давтамжтайгаар цацаж, сурталчлах ажлыг хийж байгаа ба зааланд урсдаг самбар, гарын авлага, материалуудыг байрлуулан сурталчилгааны зорилгоор 600 ширхэг сонин, болон тараах материал хэвлүүлж үйлчилж байна</p>
	<ul style="list-style-type: none"> • хувийн бизнес эхлэх, эрхлэх, бизнесээ орхих болон бусад үйл ажиллагааг зохицуулсан эрх зүйн актуудыг дахин хянаж, чанаржуулах, цөөрүүлэх, хялбаршуулах замаар оновчтой болгох. 	<p style="text-align: right;">Хэрэгжиж байна 70%</p>

5.2.1. Аж үйлдвэрийн хөгжлийн бодлого		
5.2.1.1. Геологи, уул уурхай, эрдэс баялаг, хүнд үйлдвэрийн хөгжлийн бодлого Нэгдүгээр үе шат (2007-2015 он):		
<i>Стратегийн зорилт 1. Стратегийн орд газруудыг ашиглана. Улсын зардлаар геологийн хайгуул хийж, нөөцийг нь тогтоосон стратегийн орд газруудад төрийн мэдлийн хувийг 51-ээс дээш байлгах бодлогыг баримтална:</i>		
<ul style="list-style-type: none"> • Эрдэнэтийн уулын баяжуулах үйлдвэрийн хүчин чадлыг нэмэгдүүлж, бүтээгдэхүүний боловсруулалтыг гүнзгийрүүлэх; 	<p>Монгол улсад зэс хайлуулах, боловсруулах стратегийн зорилтыг хэрэгжүүлэх үйл ажиллагааны хүрээнд “Эрдэнэт үйлдвэр” ХХК-ыг түшиглэн зэсийн баяжмал боловсруулах, эцсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэн үр ашгийг дээшлүүлэх чиглэлээр тус компаний удирдлага нь ЭБЭХЯ, ҮХШХ-ны ажлын хэсэгтэй хамтран ажиллаж дараах ажлуудыг хийж гүйцэтгэсэн байна. Үүнд: зэс хайлуулах, боловсруулах үйлдвэр байгуулах технологийн оновчтой хувилбарын тооцоо, үйлдвэрийг барьж ашиглалтанд оруулахад шаардагдах хөрөнгийн хэмжээ, байршил, хүчин чадал, хүхрийн хүчлийг хэрэглэх зарцуулалтын судалгаа тооцоог гаргаж зэс хайлах үйлдвэрийн технологи болон техник эдийн засгийн үндсэн үзүүлэлтийг боловсруулан Эрдэс баялаг, эрчим хүчний сайдын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн дэмжигдэж Засгийн газарт танилцуулахаар болсон байна.</p> <p style="text-align: right;">Хэрэгжиж байна. 90%</p>	
<ul style="list-style-type: none"> • катодын зэс, гангийн үйлдвэрлэлийг эрс өсгөх; 	<p>Катодын зэс үйлдвэрлэх хүчин чадлыг нэмэгдүүлж жилд 3.0 мянган тн зэс үйлдвэрлэж 8мм-ын голчтой зэс утас үйлдвэрлэх “Эрдмин” үйлдвэрийн технологийн шинэчлэл өргөтгөлийг хийсэн бөгөөд кабелийн утас үйлдвэрлэж байна. Мөн жилд 50.0 мянган тн 8мм-ын зэс утасны бэлдмэл үйлдвэрлэх хүчин чадал бүхий үйлдвэрийг Финлянд улсын “Outkompu” компанитай хамтран барьж байгуулахаар техник эдийн засгийн үндэслэлийг тооцов.</p> <p>Аймгийн хэмжээнд металл боловсруулах, ган хайлуулах чиглэлээр “Хөх ган”, “ОРА-металл”, “Металл индустрал”, “Бүтээл”, “Эрдмаш”, “Бат Монгол хийц” зэрэг компаниуд үйл ажиллагаа явуулж байна.</p> <p>2010 онд аж үйлдвэрийн салбарт 1.2 триллион төгрөгийн бүтээгдэхүүн үйлдвэрлэн, борлуулсан нь өмнөх оны мөн үеийнхээс үйлдвэрлэлт 40,8 хувиар, борлуулалт 39,3 хувиар өссөн байна.</p>	

		<p>Нийт бүтээгдэхүүний 96,9 хувийг уул уурхайн олборлох салбарт, 2,1 хувийг боловсруулах салбарт, 0,9 хувийг цахилгаан, дулааны эрчим хүч үйлдвэрлэлийн салбарт үйлдвэрлэж байна. Боловсруулах салбарын үйлдвэрлэлтийн 41,1 хувийг төмрийн үйлдвэрлэл, 5,2 хувийг машин тоног төхөөрөмжөөс бусад төмөр эдлэл үйлдвэрлэл эзэлж байна. 2010 онд 2746,2 тн катодын зэс үйлдвэрлэсэн нь өмнөх оноос 111,2 хувиар өсч, ган төмөр хийц 3162,8 тн-ыг үйлдвэрлэсэн нь өмнөх онтой харьцуулахад 90,8 хувьтай байна. “Ора металл” ХХК нь үйлдвэрлэлийн тоног төхөөрөмжийн шинэчлэл хийж өргөтгөн хүчин чадлыг 1500 тн-оор /50 хувиар/ нэмэгдүүлж жилд 4500 тн ган бөмбөлөг үйлдвэрлэх хүчин чадалтай үйлдвэрийг 2010 оны 10-р сард ашиглалтанд орууллаа.</p> <p style="text-align: right;">Хэрэгжиж байна. 90%</p>
<p><i>Стратегийн зорилт 2. Уул уурхайн салбарт байгаль орчныг хамгаалж, экологийн тэнцвэрт байдлыг хадгална:</i></p>		
	<p>• уул, уурхайн ашиглалтанд өртсөн талбайн нөхөн сэргээлтийг сайжруулах;</p>	<p>Ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй аж ахуйн нэгж, байгууллагуудад хяналт шалгалтын ажлыг МХГ-тай хамтран зохион байгууллаа. Шалгалтаар “Очир төв” ХХК, “Үйлс констракшин” ХХК, “Отгонтэнгэр-Оргил” ХХК, “Сид-Со” ХХК-ийн хариуцлага алдсанаас ашигт малтмалын талбайн цэг тэмдэгтийн бүрэн бүтэн байдал алдагдсан, цэг тэмдэгтүүд нь хогонд дарагдсан, алдагдаж устсан, хөндөгдөж байрнаасаа хөдөлсөн, “Зунрун” ХХК-ний биологийн нөхөн сэргээлтээр таригдсан олон наст ургамал ургаагүй “Чингэл-Бөөнцагаан” ХХК-ний БОНБНУ-нь хийгдэж дуусаагүй, “Очир төв” ХХК 5 дугаар сарын 11-нээс эхлэн ямарч төлөвлөгөө, гэрээ, баримт бичгүүдийг батлуулалгүйгээр олборлолт эхэлсэн, техникийн болон биологийн нөхөн сэргээлт хийгдээгүй зэрэг зөрчлүүд илэрсэн. Мөн “Үйлс констракшин” ХХК, “Сид-Со” ХХК-иуд нь ашиглалтын талбайдаа нөхөн сэргээлтийн ажлыг огт хийгээгүй байна. “Отгонтэнгэр-Оргил” ХХК-ний ашиглалт явуулж байгаа талбай нь тус компаний ашигт малтмал олборлох тусгай зөвшөөрлийн цэгүүдтэй нь зөрүүтэй, уг зөрчилтэй талбайдаа 2009 онд олборлолт явуулсан, тус компаний манаач тусгай зөвшөөрөлгүй ашиглалтын бус талбайгаас элс хайргийг бусдад 1м³-ийг нь 3300 төгрөгөөр</p>

		<p>үнэлэн зарж байсан зөрчлүүдийг илрүүлсэн. “Отгонтэнгэр-Оргил” ХХК-ний манаачд дахин зөрчил гаргаж болохгүй талаар сайтар ухуулан таниулж зөрчлийг давтан гаргавал хууль журмын дагуу хариуцлага тооцогдох болохыг хатуу чанга сануулан тус компаний захирал Ванданд ашиглалт явуулахгүй байх талаар албан шаардлага, заавар зөвлөмжийг өгсөн. Шалгалтанд хамрагдсан аж ахуйн нэгж байгууллагуудад ашиглалт явуулж дууссан, олборлолт явагдахгүй талбайнууддаа техникийн болон биологийн нөхөн сэргээлтийг заавар зөвлөмж стандартын дагуу хийж гүйцэтгэх талаар МХГ-ын Улсын байцаагчийн албан шаардлагыг хүргүүлсэн.</p> <p style="text-align: center;">Хэрэгжиж байна 90%</p>
	<ul style="list-style-type: none"> • эдэлбэр газрын экологи, эдийн засгийн үнэлгээ хийж, экологийн хохирлын болон нөхөн төлбөр, хураамжийг тооцох, хариуцуулах, төлүүлэх механизмыг боловсронгуй болгох; 	<p>Монгол улсын Байгаль орчныг хамгаалах тухай, Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуулиудын дагуу Тогтвортой амьжиргаа – 2 төслийн шинээр хэрэгжих 11 төсөлд Байгаль орчинд нөлөөлөх байдлын ерөнхий үнэлгээний дүгнэлтийг, 10 аж ахуйн нэгж, иргэдийн төсөлд байгаль орчинд нөлөөлөх байдлын ерөнхий үнэлгээг тус тус хийж, биелэлтэнд нь хяналт тавин ажиллаж байна.</p> <p>Аймгийн хэмжээнд байгаль орчны чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг 7 Төрийн бус байгууллага байдаг бөгөөд байгаль хамгаалах үйлсэд тэдгээрийн оролцоог нэмэгдүүлэх, мэдээлэл солилцох, мэргэжил арга зүйн туслалцаа үзүүлэх хэлбэрээр хамтран ажиллаж байна.</p> <p style="text-align: center;">Хэрэгжиж байна 90%</p>
	<ul style="list-style-type: none"> • уурхайн хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн нөхцөлийг сайжруулах, ашигт малтмалыг далд аргаар олборлох, газрын гүнд боловсруулалт хийхийг дэмжин өргөжүүлэх; 	<p>Хяналт шалгалтын үр нөлөө ажил олгогч эздийн хууль эрх зүйн мэдлэгийг дээшлүүлэн, үйлдвэрийн осол, мэргэжлээс шалтгаалах өвчнийг бууруулах зорилгоор Монгол улсын “Хөдөлмөрийн тухай”, “Хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн тухай”-иуд тэдгээртэй уялдан гарсан эрх зүйн актаар 27 байгууллагын 990 хүнд 33 цагийн сургалтын зохион байгууллаа.</p> <p>МХГ-ын даргын баталсан удирдамжаар 2010 оны хяналт шалгалтын төлөвлөгөөний дагуу “Эрдэнэт үйлдвэр” ХХК-ний Баяжуулах фабрик, Авто</p>

		<p>тээврийн байгууллага, Барилга угсралтын цех, Засвар угсралтын цех, Хөдөлмөр хамгаалал, байгаль орчны хэлтсүүдэд хамтарсан хяналт шалгалтыг хийлээ.</p> <p>Шалгалтын явцад дээрх цехүүдийн бүх нэгж хэсгүүдийн ажлын байр, ажиллагсадын хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн нөхцөлтэй танилцаж ажиллагсадтай ажлын байран дээр уулзалт ярилцлага зохион байгуулж, санал, хүсэлтийг нь хүлээн авч, хуулийн хугацаанд шийдвэрлэсэн. Илэрсэн зөрчилтэй холбогдуулан үйлдвэрийн захиргаанд 11 заалт бүхий хугацаатай албан шаардлага өгч шалгалтын тухай дүнгийн хурлыг цехүүдийн дарга нарын түвшинд зохион байгуулж танилцууллаа.</p> <p>Хөдөлмөрийн чадвараа 70 хувиас дээш хувиар алдсан иргэд уул уурхайн салбарт ажил хөдөлмөр эрхэлж байгаа нь үйлдвэрийн үйл ажиллагаанд доголдол үүсгэх, үйлдвэрийн осол эндэгдэл гарч болзошгүй гэдэгт УБЭҮ-т дүгнэлт гарган өгсөнөөр бүх цех хэсгүүдэд эмнэлгийн үзлэг зохион байгуулж урьдчилан сэргийлэх арга хэмжээ авагдсан.</p> <p style="text-align: center;">Хэрэгжиж байна 90%</p>
5.2.1.2. Боловсруулах аж үйлдвэрийн хөгжлийн бодлого Нэгдүгээр үе шат (2007-2015 он):		
<i>Стратегийн зорилт 1. Гадаад зах зээлд өрсөлдөх чадвартай эцсийн бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг нэмэгдүүлнэ:</i>		
	<ul style="list-style-type: none"> • экспортын баримжаатай, оюуны шингэц бүхий өрсөлдөх чадвартай, бага оврын бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг хөгжүүлэх; 	<p>Эрдэнэт хивс ХХК нь ноосон хөнжил, Мөнх тэнгэрийн ташуур ХХК хаягдал резинэн бүтээгдэхүүнийг дахин боловсруулан резинен шал жийргэвчүүд, спортын болон сургууль цэцэрлэгийн биеийн тамирын зам талбайн хавтан, Орхон сэтгэмж ХХК нь байгалийн цэвэр модыг үйлдвэрлэлийн аргаар хатааж модны ярыг шүүж сам заалдлаар заасан яргүй зүймэл модон хавтан, модон вакум хаалга цонхны үйлдвэрлэлийг тус тус шинээр явуулж байна. Мөн Супер матрас ХХК нь Солонгос улсын үйлдвэрийн технологийг нэвтрүүлэн хэрэглэгчдийн хүссэн загвар хэмжээгээр матрас, модон орыг, Инкрасс ХХК нь шингэн саван үйлдвэрлэж байна. Эрдэнэт үйлдвэрийн Засвар механикийн заводад хөдөө аж ахуйн тракторыг угсарч байна Аймгийн хэмжээнд гадаад</p>

		<p>худалдаагаар 1.3 трилион төгрөг буюу 980.7 сая.ам долларын бараа эргэлт хийжээ. Өнгөрсөн оны мөн үеэс нийт эргэлт 44.5 хувиар, үүнээс импорт 80.4 хувиар, экспорт 40.0 хувиар өсчээ.</p> <p>Өнгөрсөн оны мөн үеэс экспортод гаргасан гол нэрийн бүтээгдэхүүнээс хивс 13.5 хувиар, катодын зэс 21.7 хувиар өсч, зэсийн баяжмал 2.9 хувиар, молибдений баяжмал 22.4 хувиар, малын мах 30.8 хувиар буурсан байна. Эрдэнэт хивс ХХК нь захиалгын дагуу 108701,9м2 хивс, 5378 хос эсгий шаахай, хөнжил 2046 ш дэр, 76 ширхэгийг Хятад, Шинжан, Казакстан, Киргиз, Япон, Орос, Укриан, Итали улсад, Натураль альфа ХХК нь 6000 ширхэг сарлагын хөөврөн сүлжмэл бүтээгдэхүүнээ Орос, Хятад улсад тус тус гаргасан байна.</p> <p style="text-align: center;">Хэрэгжиж байна 90%</p>
	<ul style="list-style-type: none"> • зэс хайлуулж, холбооны кабель утас, ороомог, машин, тоног төхөөрөмжийн эд анги, хийц үйлдвэрлэж экспортод гаргах. 	<p>“Эрдмин” ХХК нь 2008 онд төрөл бүрийн голчтой зэс утас үйлдвэрлэх цехийг ашиглалтанд оруулж 14 ажлын байр бий болгож улмаар үйлдвэрлэлээ өргөжүүлэн кабель утас, ороомог үйлдвэрлэж эхлээд байна. Молибдений баяжмал боловсруулах үйлдвэр нь гидрометаллургийн шинэ технологи ашиглан жилд 3600 тн молибдений баяжмал боловсруулан цэвэр исэл 1692 тн, нунтаг молибден 60 тн, молибден агуулсан тусгай эдлэл 40 тн, рени агуулсан бүтээгдэхүүн 1000 кг үйлдвэрлэх хүчин чадалтай юм. Үйлдвэрийн төслийг 2 үе шаттайгаар хэрэгжүүлж ашиглалтанд орууллаа. “Шимтехнолоджи” ХХК ний молибдений давхар исэл боловсруулах үйлдвэр нь сард 20-30 тн бүтээгдэхүүн үйлдвэрлэж Солонгос улсад импортолж байна.</p> <p>2010 онд 563.2 мян.тн зэсийн баяжмал, 4.5 мян.тн молибдений баяжмал, 2.8 мян.тн катодын зэс, экспортлож өнгөрсөн оны мөн үеэс экспортод гаргасан катодын зэс 21.7 хувиар өсч, зэсийн баяжмал 2.9 хувиар, молибдений баяжмал 22.4 хувиар буурсан байна. Эрдмин ХХК нь 1х1-1х17,5 диаметрийн голчтой 21 төрлийн 855254 метр кабель утас үйлдвэрлэсэн ба 1.930.4 метр кабель утсыг дотоодын зах зээлд нийлүүлсэн байна.</p> <p style="text-align: center;">Хэрэгжиж байна 90%</p>
<i>Стратегийн зорилт 2. Бүс нутгуудын хөгжлийн дотоод гадаад нөөц боломжтой оновчтой уялдуулан үйлдвэрлэл</i>		
	<ul style="list-style-type: none"> • бүсүүдийн тулгуур төв, зарим хотод үйлдвэрлэл, технологийн парк 	<p>Эрдэнэт Үйлдвэрлэл технологийн паркийн ашиглалтын өмнөх захиргаа нь “Эрдэнэт Үйлдвэрлэл технологийн парк байгуулж хөгжүүлэх техник эдийн</p>

байгуулж ажиллуулах;	<p>засгийн үндэслэл, зураг төслийг боловсруулж дууссан бөгөөд Үйлдвэр Худалдааны Яаманд хүлээлгэж өглөө. Уг төслийн хүрээнд төр засгийн бодлого, гадаад улс орнуудын туршлага, бодит байдлын судалгааны үр дүн, судлаачдын дэвшүүлсэн онол арга зүйн хандлага зэрэгт үндэслэн “Эрдэнэт” Үйлдвэрлэл, Технологийн Паркийг байгуулах хөгжүүлэх талаар дараах дүгнэлтэнд хүрч байна.</p> <p>Үүнд: 1. Хангайн бүсийн тулгуур төв Эрдэнэт хот нь тус бүсийн бусад аймгуудтай харьцуулахад дэд бүтэц илүү хөгжсөн, мэргэшсэн боловсон хүчний нөөц бүрдсэн, эрдэм шинжилгээ, үйлдвэрлэлийн материаллаг бааз суурь харьцангуй давуу байна. Мөн үүний зэрэгцээ уул уурхай, хөнгөн болон хүнсний үйлдвэрлэл харьцангуй сайн хөгжсөнтэй холбоотой энэ талын ажиллах боловсон хүчний нөөц, мэдлэг оюуны хуримтлал нэгэнт бүрэлдэн бий болжээ.</p> <p>2. “Эрдэнэт” Үйлдвэрлэл, Технологийн Паркийг байгуулан хөгжүүлснээр Эрдэнэт хотын цаашдын ирээдүйн хөгжлийн хандлага дан ганц уул уурхайн үйлдвэрээс хамаарах бус орчин үеийн нарийн технологид суурилсан үйлдвэрлэлийн цогцолбор болон хувирч, уулын үйлдвэрийн түүхий эдийн нөөц багасах үед Эрдэнэт хот биеэ даан цаашид хөгжих олон талын бололцоо нээгдэх юм.</p> <p>3. Паркийн үйл ажиллагаа нь дараах үндсэн чиглэлтэй байх бөгөөд бусад үйлдвэрлэлийн чиглэлийг дэмжинэ. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> • Уул уурхайн тоног төхөөрөмж, сэлбэг, технологийн материалын үйлдвэрлэл, • Экспортын мах, махан бүтээгдэхүүн үйлдвэрлэл, • Хөдөө аж ахуйн түүхий эдийг гүнзгий боловсруулах үйлдвэрлэл, • Мод модон бүтээгдэхүүн, барилгын материалын үйлдвэрлэл, • Оёдол, сүлжмэл бүтээгдэхүүн үйлдвэрлэл. <p>4. Үйлдвэрлэл, Технологийн Паркийн үйл ажиллагаа нь “Төр -Үйлдвэрлэл технологийн паркийн нэгжүүд – Эрдэм шинжилгээний байгууллага, их, дээд сургууль” –ийн зохистой шүтэлцээ, нягт хамтын ажиллагааны үр дүнд хэрэгжинэ. Үйлдвэрлэл технологийн парк нь Иновацийн төслүүд, нанотехнологийг үйлдвэрлэлд нэвтрүүлж эцсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэн гадаад зах зээл дээр гаргах зорилготой.</p> <p>Үйлдвэрлэл, технологийн паркийн үйл ажиллагаа эрхлэхэд дэмжлэг үзүүлэх, хяналт тавих журам Засгийн газраас батлагдаж гараагүй байгаа тул хүлээгдэж</p>
----------------------	--

		<p>байна. Үйлдвэр технологийн паркийн хилийн цэсийг ерөнхий байдлаар нь Говил багт тогтоож, “Эрдэнэт” Үйлдвэр техникийн паркийн ТЭЗҮндэслэл, мастер төлөвлөгөөг боловсруулан холбогдох яамдад хүргүүлснээр тус паркийн захиргааг ажлын байраар хангасан байна. Үйлдвэр, технологийн паркад орж ажиллах 34 аж, ахуйн нэгж байгууллагуудын хүсэлт, төслийг хүлээн аваад байна. Үйлдвэрлэл, технологийн паркийн эрх зүйн байдлын тухай хуульд заасны дагуу ҮТП-ийн үйл ажиллагаа эрхлэхэд дэмжлэг үзүүлэх, хяналт тавих журам Засгийн газраас батагдаж гармагц, тус паркийн үйл ажиллагааг эхлүүлэхэд орон нутгийн зүгээс хамаарах бэлтгэл ажлуудыг бүрэн хангаад байна.</p> <p style="text-align: right;">Хэрэгжиж байна. 70%</p>
	<p>• байгаль орчинд сөрөг нөлөөгүй, шинэ дэвшилтэт техник, технологи бүхий “Ямааны ноолуур, тэмээний ноос, хонины нарийн ноос боловсруулах” болон “Арьс ширний үйлдвэрлэлийг хөгжүүлэх” зэрэг бүс нутгийг хөгжүүлэхэд чиглэсэн хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэх.</p>	<p>Орхон аймагт жилд 960.8 мянган метр квадрат хивс үйлдвэрлэх хүчин чадалтай “Эрдэнэт хивс” ХК үйлдвэр, жилд 9000 ширхэг ноолууран сүлжмэл бүтээгдэхүүн үйлдвэрлэх хүчин чадалтай “Натураль альфа” үйлдвэр үйл ажиллагаа явуулж байна. Мөн жилд 80 тонн ноолуур боловсруулж, 1500 ширхэг сүлжмэл бүтээгдэхүүн үйлдвэрлэх хүчин чадалтай “Эрдэнэт ноолуур” ХХК-ны үйлдвэр эргэлтийн хөрөнгийн дутагдалтайгаас одоогоор үйл ажиллагаа нь зогссон байна. “Эрдэнэт хивс” компани нь 92–100 хувийн хонины ноосны агууламжтай хивсийг төрөл бүрийн зориулалтаар 6 нэр төрөл, 850 гаруй зураг дизайнаар үйлдвэрлэлт явуулж байгаа бөгөөд 2008-2009 онд 160 гаруй шинэ ба шинэчилсэн загварыг үйлдвэрлэлд нэвтрүүлж хэрэглэгчдэд хүргээд байна. Тус компани дотоод зах зээлийн хэрэгцээний 60 хувийг хангадаг төдийгүй Австрали, Япон, Итали, Англи, Казахстан, Герман, Сингапур, Унгар, Швед, Хятад, ОХУ зэрэг арав гаруй оронд хивсээ экспортолж байна. “Эрдэнэт хивс” ХК нь ISO 9001:2000, MNS ISO 9001:2001 Олон улсын чанарын удирдлагын стандартыг үйл ажиллагаандаа хэрэгжүүлсэн Монголын хоёр дахь байгууллага юм.</p> <p>2010 оны 01-р сарын 13-15-ны өдрүүдэд Орхон аймгийн ЗДТГ, ГТХАН-ийн Бүс нутгийн эдийн засгийг дэмжих хөтөлбөр хамтран “Орон нутагт ноосны үйлдвэрлэлийг хөгжүүлэх боломж” сэдэвт уулзалт, зөвлөгөөн, туршлага судлах аялал, үзэсгэлэн худалдааг зохион байгуулав.</p> <p>Малын эрүүл мэнд ба мал аж ахуйн маркетингийн европын холбооны төсөл, Мери кор MORE, Швейцарийн хөгжлийн агентлаг, Ноос, ноолуурын үйлдвэрлэлийг хөгжүүлэх сан, Ноос, ноолуурын холбоо, ТИС-ийн үйлдвэрлэлийн технологи, дизайны сургуулийн захирал, үйлдвэр, аж ахуйн нэгжийн төлөөлөгчид нийт 80 орчим төлөөлөгч оролцож ноосны салбарын</p>

		<p>өнөөгийн байдал, тулгамдаж буй асуудал, цаашид хэрэгжүүлэх асуудлын талаар санал бодлоо солилцож зөвлөмж гаргалаа. Орон нутагт ноосон сүлжмэл эдлэл ийн үйлдвэрлэл эрхэлж байгаа 13 цех , эсгий эдлэлийн жижиг үйлдвэрлэл эрхэлдэг 6 иргэн ажиллаж байна.</p> <p style="text-align: right;">Хэрэгжиж байна 90%</p>
<p>5.2.1.3. Жижиг, дунд үйлдвэрлэл, үйлчилгээний хөгжлийн бодлого:</p>		<p>Нэгдүгээр үе шат (2007-2015 он)</p>
<p><i>Стратегийн зорилт 1. Жижиг, дунд үйлдвэрлэлийн хөгжлийг дэмжих эрх зүйн таатай орчинг бүрдүүлнэ:</i></p>		
	<ul style="list-style-type: none"> • жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэгчдийг зээлийн үйлчилгээнд хамруулах; 	<p>ЖДҮ эрхлэгчдийн санхүүгийн чадавхийг дээшлүүлэх зорилгоор улсын болон орон нутгийн төсвийн хөрөнгөөр сан бүрдүүлж хөнгөлөлттэй зээл олгож байгаа боловч үйлдвэрлэл эрхлэгчид барьцааны хөрөнгө дутагдалтайгаас төслийн дагуу шаардлагатай зээлээ авч чадахгүй байгаа болон зээлийн баталгаа, батлан даалтын үйлчилгээг ЖДҮ эрхлэгчдэд төрөөс үзүүлэх зайлшгүй шаардлага байгаа талаар ХХААХҮЯам, ЗГХАгентлаг ЖДҮГазарт уламжлан санал өгсөн байна.</p> <p>Орон нутагт хэрэгжиж байгаа БНЭЗД хөтөлбөрийн хүрээнд Санхүүгийн үйлчилгээний шинэ хэлбэр болох зээлийн батлан даалтын үйлчилгээг бий болгосноор аймгийн ЖДҮ эрхлэгчид хүртэж эхэлсэн. Зээлийн Батлан Даалтын үйлчилгээг ХААН, ХАС, ХХБ, Голомт банкуудтай хамтран хэрэгжүүлж зээлийн Батлан Даалтын үйлчилгээнд нийт хамрагдахаар 60 гаруй иргэн, аж ахуйн нэгж хүсэлт гаргаснаас 40 аж ахуйн нэгж иргэний 638,5 сая төгрөгний зээлийг авахад нь 243,7 сая төгрөгний зээлийн батлан даалтыг гаргасан бөгөөд нийт зээлийн эрсдлийн 38,2 хувийг эзэлж байна. Зээлийн дээд хэмжээ 135 сая төгрөг, доод хэмжээ 500 мянган төгрөг, зээлийн дундаж хэмжээ 15,9 сая төгрөг, зээлийн эргэн төлөлт 98 хувьтай байна.</p> <p>Мөн орон нутгийн нөөц боломжийг ашиглах жижиг дунд үйлдвэрлэгчдэд үзүүлж буй санхүүгийн үйлчилгээний олон талт арга, хэлбэрийг таниулах, нэвтрүүлэх гарцыг хамтран эрэлхийлэх цаашид хамтран ажиллах боломжийг нээх зорилгоор “ЖДҮ-ийг дэмжих санхүүгийн альтернатив хувилбарууд” сэдэвт</p>

		<p>уулзалт хэлэлцүүлэгийг зохион байгууллаа. Уулзалт хэлэлцүүлэгт Төрийн болон төрийн бус 13-н байгууллага, банк, санхүүгийн 19 байгууллага, Олон улсын төсөл хөтөлбөрийн 2 байгууллагын төлөөллүүд болон ЖДҮ эрхлэгч 100 гаруй иргэд оролцлоо.</p> <p style="text-align: center;">Хэрэгжиж байна 90%</p>
	<p>• жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэгчдийг дэмжиж, бага оврын тоног төхөөрөмжийн лизингийн үйлчилгээг өргөжүүлэх.</p>	<p>Хүнс, хөдөө аж ахуй, Хөнгөн үйлдвэрий сайдын тушаалаар Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангаас тоног төхөөрөмжийг лизингээр олгох байгууллагатай хамтран ажиллах журам батлагдан гарснаар жижиг, дунд үйлдвэр эрхлэгчдэд тоног төхөөрөмжийг 4 жилийн хугацаатай, сарын 0.9 хувийн хүүтэйгээр лизингээр олгож эхэллээ. Журмыг сурталчлах ажлыг орон нутгийн ТВ-ээр 3 удаа ярилцлага өгч, 1 удаа зар өгч, 1 удаа 4 хоногийн турш реклам явуулж сонирхогчдод мэдээлэл хүргэлээ. Манай аймгийн "Баяжуулагч одод" ХХК Оросын Холбооны Улсаас сүү боловсруулах тоног төхөөрөмжийг лизингээр авахаар 77.0 сая төгрөгний санхүүжилт авлаа.</p> <p>Европын холбооны тусламж хөтөлбөрийн хүрээнд хэрэгжиж байгаа "Малын эрүүл мэнд, мал аж ахуйн зах зээл" төслийн хүрээнд хөнгөлтэй болон бага хүүтэй зээлийн нөхцлөөр аймгийн хэмжээнд дараахь нэр төрлийн тоног төхөөрөмжийг улсын болон хувийн хэвшлийн аж ахуйн нэгжүүдэд зах зээлийн үнийн 40-70 хүртэл хувийн хөнгөлөлт үзүүлэн нийлүүллээ. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> • "Дөмөг" ХХК мах худалдаалах хөргүүртэй лангуу 10 метр, 10.0 сая төгрөг • "Далх бүрэн" ХХК мах худалдаалах хөргүүртэй лангуу 5 метр, хөргөх камер-1 ширхэг 10.2 сая. төгрөг • "Эрдэнэт шанд" ХХК сүү, сүүн бүтээгдэхүүн хадгалах хөргөгч 3 ширхэг, Хөргөх агергат-1 нийт 6.8 сая. төгрөг • "Эрдэнэт прогресс" ХХК мах, махан бүтээгдэхүүн хадгалах хөргөх камер - 1 ширхэг, 5.2 сая. төгрөг • Жаргалант сумын "Зэст ус", "Сэлэнгэ ачуут" хувийн мал эмнэлгүүд тус бүр нэг компьютер 1.2 сая. төгрөг • "Идэр баялаг" ХХК хиамны тоног төхөөрөмж 15.6 сая төгрөг

		<ul style="list-style-type: none"> • “Сан-сэн” ХХК ноос пресслэгч 600,0 мян.төгрөг Нийт 273.1 сая.төгрөний 31 төрлийн тоног төхөөрөмжийг 40 хувийн хөнгөлөлттэй 3 хүртэл жилийн хугацаатай 1.2 хувийн хүүтэйгээр олгосон . • Мөн хувийн мал эмнэлгүүдэд нийт 80.0 сая. төгрөгийн лабораторийн болон бусад тоног төхөөрөмжийг 70 хүртэл хувийн хөнгөлөлттэй нөхцлөөр олголлоо. <p>Үйлдвэрийн аргаар боловсруулсан мах, махан бүтээгдэхүүний хангалтыг нэмэгдүүлэх зорилгоор мах, махан бүтээгдэхүүний чиглэлээр үйлдвэрлэл явуулдаг аж, ахуйн нэгжүүдийг орчин үеийн дэвшилтэт тоног төхөөрөмжөөр хангах үүднээс төсөл, хөтөлбөрт хамруулах арга хэмжээ авч “Малын эрүүл мэнд, мал аж ахуйн зах зээл” төсөлд хандан “Дөмөг” захын дэргэдэх мал нядалгааны цэгт мал нядалгааны тоног төхөөрөмж, “Идэр баялаг” ХХК хиамны тоног төхөөрөмжийг тус тус лизингээр авахаар шалгараад байна.</p> <p style="text-align: right;">Хэрэгжиж байна 90%</p>
<p><i>Стратегийн зорилт 2. Жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэгчдэд үзүүлдэг төрийн үйлчилгээг чирэгдэлгүй, түргэн шуурхай болгоно:</i></p>		
	<ul style="list-style-type: none"> • жижиг, дунд үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэх хүсэлтэй иргэдийг шаардлагатай мэдээ, мэдээллээр хангах, тэдэнд техник, технологийн сонголт хийхэд нь туслах, төсөл боловсруулах, шалгаруулах явцад нь зөвлөгөө өгөх, үйлчилгээ үзүүлэх үүрэг бүхий төвүүдийг аймаг, нийслэл, сум, дүүргүүдэд зохион байгуулж ажиллуулах; 	<p>Манай аймагт жижиг, дунд үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэх хүсэлтэй иргэдийг шаардлагатай мэдээ, мэдээллээр хангах, тэдэнд техник, технологийн сонголт хийхэд нь туслах, төсөл боловсруулах, шалгаруулах явцад нь зөвлөгөө өгөх, үйлчилгээ үзүүлэх үүрэг бүхий ЖДҮ-ийг дэмжих төв одоогоор байхгүй байгаа ба орон нутагт үйл ажиллагаа явуулж байгаа Орхон –Булган аймгийн ХАҮТ, Хоршооллын сургалт мэдээллийн төв, Бизнес ширээгээр дамжуулан мэдээллийг хүргэж байна.</p> <p>Бизнес эрхлэх үйл ажиллагааны талаархи мэдээллийг иргэдэд нэг цэгээс үзүүлэх зорилгоор НЦҮ-ний зааланд Бизнес ширээг ажиллуулах концепц, үзүүлэх үйлчилгээний зураглал,түүнтэй холбоотой мэдээлийн хуудсуудыг хамтран ажиллах байгууллагуудаас авч бэлтгэн “Бизнес ширээ”-нээс үзүүлэх журамыг боловсруулан гаргаж “Бизнесийн орчны шинэтгэлийн жил”-ийн ажлын хүрээнд “Бизнес ширээ” үйлчилгээг 2010 оны 5-р сарын 17-ний өдрөөс эхлэн НЦҮ-ний танхимд нээн ажиллууллаа. “Бизнес ширээ” үйлчилгээгээр дараах</p>

		<p>зуучлах үйлчилгээг үзүүлж байна.</p> <ol style="list-style-type: none"> 1.МХГ-ын “Улсын байцаагчийн ажлын байрны нэгдсэн дүгнэлт 2.БОАЖГ-ын “Байгаль орчинд үзүүлэх нөлөөллийн ерөнхий үнэлгээ” гаргах үйлчилгээ 3.ОБГ-ын “Ажлын байрны галын аюулгүй байдлын дүгнэлт” гаргах үйлчилгээ 4.АЗДТГ-аас олгодог “Согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх тусгай зөвшөөрлийн хүсэлт хүлээн авах үйлчилгээ 5.БӨСумын ЗДТГ-аас олгодог “Тамхи худалдах зөвшөөрөл”-ийн хүсэлт хүлээн авах үйлчилгээ 6.ХАҮТ-аас олгодог “Монгол улсад үйлдвэрлэснийг гэрчлэх гарал үүслийн гэрчилгээ” авах үйлчилгээ 7.ХАҮТ-аас олгодог “Бараа бүтээгдэхүүнд зураасан код олгох” үйлчилгээ <p>“Бизнес ширээ”-ний үйлчилгээний талаар шторк бэлтгэн орон нутгийн Номин ТВ-ээр тодорхой давтамжтайгаар цацаж, сурталчлах ажлыг хийж байгаа ба зааланд урсдаг самбар, гарын авлага, материалуудыг байрлуулан сурталчилгааны зорилгоор 600 ширхэг сонин, болон тараах материал хэвлүүлж үйлчилж байна. Мөн хэвлэл мэдээллийн хэрэгслэлээр үйлчилгээ үзүүлэх холбогдох байгууллагын удирдлагуудыг оролцуулан ярилцлага зохион байгуулсан. Одоо иргэд, төрийн болон ТББ, төсөл, хөтөлбөр, банк санхүүгийн байгууллагуудын үйл ажиллагааны болон бүтээгдэхүүний мэдээллийг цуглуулан мэдээллийн бааз бий болгох зорилттой ажиллаж байна. Одоогийн байдлаар “Бизнес ширээ”-нээс нь иргэн, ААН-үүдэд зуучлах болон мэдээллийн чиглэлээр зөвлөгөөг өгч байна. Бизнесийн мэдээллийн нэгдсэн файл үүсгэх зорилгоор АЗДТГ, банк санхүүгийн байгууллага, ТББ, бизнесийн зөвлөгөө үзүүлэгч байгууллагууд, төсөл хөтөлбөрүүдээс мэдээлэл цуглуулан программ хийж байна.</p> <p style="text-align: center;">Хэрэгжиж байна 90%</p>
	<ul style="list-style-type: none"> • жижиг, дунд үйлдвэрлэлийн бодлогын асуудалтай холбоо бүхий 	<p>2010 оныг Монгол улсын Засгын Газраас "Бизнесийн орчны шинэтгэлийн жил" болгон зарласантай холбогдуулан Төрийн бус байгууллагуудын хамтын</p>

<p>аливаа шийдвэрийг гаргахдаа тэдний ашиг сонирхолыг илэрхийлэгч мэргэжлийн холбоодын саналыг авч тусгаж байх;</p>		<p>ажиллагааг сайжруулах, хувийн хэвшилд тулгуурласан эдийн засгийн хөгжлийг хангах, төрийн зарим чиг үүргийг гэрээгээр хувийн хэвшлээр гүйцэтгүүлэх ажлын талаар гарсан саналуудыг холбогдох байгууллагуудад хүргэх зорилгоор ТВ хэлэлцүүлэг хийж хэлэлцүүлэгт төр, хувийн хэвшлийг төлөөлж 25 хүн оролцсон. Жижиг, дунд үйлдвэрлэлийн бодлогын асуудалтай холбоотой аливаа шийдвэрийг гаргахдаа тэдний ашиг сонирхолыг илэрхийлэгч мэргэжлийн холбоодын саналыг авч тусгах зорилгоор аймгийн хэмжээнд байгуулагдаж байгаа ажлын хэсэгт холбогдох ТББ-ын төлөөллийг орлцуулан ажиллаж байна. 2010 онд Орхон аймгийн Засаг Даргын захирамж, Татварын Ерөнхий Газрын даргын тушаалын дагуу дараах 5 ажлын хэсгийн бүрэлдэхүүнд орж ажиллаж байна. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> - Орон нутгийн эдийн засгийг хөгжүүлэхэд шаардлагатай зохицуулалт, бүтэц, зохион байгуулалтын орчинг сайжруулах санал боловсруулах ажлын хэсгийн бүрэлдэхүүнд - ЖДҮ-ийг дэмжих зорилгоор арилжааны банкаар дамжуулан зээл олгох төслийн сонгон шалгаруулах дэд комиссын бүрэлдэхүүнд - Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажил гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах Үнэлгээний хорооны бүрэлдэхүүнд - "Үйлдвэржүүлэлтийн бодлогын зөвлөлийн салбар зөвлөл"-ийн бүрэлдэхүүнд - Аймгийн Татварын хэлсийн дэргэдэх "Татварын маргаан таслах зөвлөл"-ийн бүрэлдэхүүнд гэх. мэт <p>Аймгийн Засаг дарга, ЗДТГ-аас Хэрэглэгчдийн эрх ашгийг хамгаалах нийгэмлэг, "Хангайн бүсийн бүтээмж хөгжлийн төв", Хоршоолын сургалт мэдээллийг төв, Орхон-Булган аймгийн ХАҮТ, Тогоочдын холбоо, Хүнсчдийн холбоо, АОЭХ-той хамтран сургалт, мэргэжлийн ур чадварын уралдаан тэмцээн, үзэсгэлэн яармаг зохион байгуулахад санхүүгийн дэмжлэг үзүүлж ажиллаа.</p> <p style="text-align: right;">Хэрэгжиж байна 90%</p>
	<ul style="list-style-type: none"> • бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалд нийцүүлэн жижиг, дунд үйлдвэрлэлийг дэмжиж, бизнес инкубатор 	<p>Аж ахуй эрхлэх, төслийн сургалтыг Эрдэнэт Бизнес инкубатор төвтэй 12 удаа зохион байгуулж 278 иргэнийг хамруулан аж ахуй эрхлэх төрөл бүрийн ур чадвар олгов. Үүнд:</p>

байгуулж ажиллуулах;		<ul style="list-style-type: none"> • Бизнесээ эхэл-бизнесээ хөгжүүл сургалтанд 4 удаа- 63 • Эдийн засгийн анхан шатны мэдлэг олгох сургалт-10 • Төсөл хөтөлбөр боловсруулах арга зүйн зөвлөгөө өгөх үйлчилгээнд жижиг зээлийн төсөл боловсруулах сургалтаар- 48 • Хоршооны сургалт-18 • Бүлгээр ажиллах чадварын сургалт-15 • Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн сургалт-32 • Шинэ эхлэл ажил хайх чиг баримжаа олгох сургалт-92 иргэн тус тус хамрагдсан байна. <p style="text-align: right;">Хэрэгжиж байна 90%</p>
5.2.1.4. Хөдөө аж ахуй, хүнсний үйлдвэрлэлийн хөгжлийн бодлого Нэгдүгээр үе шат (2007 – 2015 он)		
<i>Стратегийн зорилт 1. Бүс нутгийн онцлогыг харгалзан бэлчээрийн болон эрчимжсэн мал аж ахуйг хослуулан хөгжүүлж, халдварт өвчний гаралт, тархалтыг эрс бууруулан малыг эрүүлжүүлж, мал аж ахуйн бүтээгдэхүүний үйлдвэрлэл, боловсруулалт, экспортыг нэмэгдүүлнэ:</i>		
<ul style="list-style-type: none"> • малыг халдварт болон шимигчит өвчнөөс хамгаалах өндөр технологийг нэвтрүүлж эхлэх; 		<p>Дэлхийн банкны санхүүжилтээр хэрэгжиж буй “Шувууны томуу, хүний томуугийн цар тахалтай тэмцэх чадавхийг сайжруулах” төсөл, Европын холбооны “Малын эрүүл мэнд, мал аж ахуйн зах зээл” төслүүдээс 200,0 гаруй сая төгрөгийн тоног төхөөрөмжийн хөрөнгө оруулалт тус тус хийгдсэнээр оношлох, шинжлэх хурд мэдрэмж өндөр био аюулгүйн 2-р зэрэглэлийн лаборатори байгуулж итгэмжлэгдлээ.</p> <p>Ингэснээр шүлхий, хөх хэлтэх, шувууны томуу зэрэг гоц халдварт өвчнүүдээс гадна боом, галзуу, дуут хавдар, цусан халдварт, инан, бруцеллөз гэх мэт 20 гаруй халдварт өвчнийг орон нутагт оношлох боломж бүрдлээ.</p> <p style="text-align: right;">Хэрэгжиж байна 90%</p>
<ul style="list-style-type: none"> • Монгол малын тэсвэрт чанарыг бататган, цус ойртохоос урьдчилан сэргийлж, биологийн боломжийг бүрэн ашиглаж, байгалийн эрсдэл даах чадварыг нь бэхжүүлэх; 		<p>Махны чиглэлээр үхрийн чанар сайжруулах талаар ажиллаж байгаа 6 малчинд үржлийн үнээ 8, бух 2-ыг олж өгөхөд тусаллаа. Мөн “Баяжуулагч-Од” фермерийн аж ахуйд Улаанбаатар хотын Партизаны фермерүүдээс хар тарлан, алатау үхрийн эрлийз 9 үхэр, гунж авахад арга зүйн дэмжлэг үзүүллээ.</p> <p>Аймгийн хэмжээнд хээлтэгч, хээлтүүлэгчийн тохироог тооцсоноор шинээр тохиромжтой хэвшлийн мал бүхий сууриудаас 2 азарга, 100 хуц, 120 ухна, 18</p>

		бух шинээр сонгон тавьж хээлтүүлэгт ашиглахаар бэлтгэв. Хэрэгжиж байна 90%
	• малын чанар, үржлийн ажлыг сайжруулах;	Аймгийн хэмжээнд үржлийн малд ангилалт хийх ажлыг 2 суманд зохион байгуулж 33768 эм хонь, ямаа, 861 хуц ухна, бүгд 34629 бог мал хамруулж, 8.0 мянган үнээнд үржлийн үзлэг хийж, нийт 7.7 мянган малыг цөм сүрэгт хамрууллаа. Баян-Өндөр сумын “Мэргэн өгөөж” фермерийн аж ахуйд Оросын цагаан үүлдрийн 14 гахай олж өгөхөд зуучлан дэмжлэг үзүүлэв. Баян-Өндөр, Жаргалант сумын малчдын захиалгаар Сэлэнгэ, Төв аймгаас хар тарлан, алатау, симменталь үүлдрийн үнээ бух бүгд 32 толгойг авахад зуучилсан байна. Хэрэгжиж байна 90%
	• бэлчээрийг зохистой ашиглах, эзэмшүүлэх, сайжруулах, хамгаалах, талхлагдсан бэлчээрийг нөхөн сэргээх замаар багтаамж, даацыг нэмэгдүүлэн мал аж ахуйн эрсдэлийг бууруулах;	Хил залгаа Булган, Сэлэнгэ аймгийн 5 сумтай бэлчээр нутаг хамтран ашиглах талаар сумдын түвшинд хэлцэл хийж, 655 өрхийн 173.0 мянган толгой малыг өвөлжүүлж, хаваржуулах арга хэмжээ авч, бэлтгэлийг ханган бэлчээрийн даацыг зохицуулах арга хэмжээ авч хэрэгжүүлсэн байна. Орхон, Булган аймгийн удирдах ажилтны уулзалтыг Эрдэнэт хотод зохион байгуулж, аймгийн Засаг дарга нарын хамтран ажиллах гэрээ баталж, түүнд Орхон аймгийн малчдад Булган аймгийн нутаг дэвсгэрт нутаглах бэлчээрийг хуваарилах талаар тусган бэлчээрийг сэлгээтэй ашиглах арга зүйн зөвлөмжийг 680 гаруй малчин өрхүүдэд өгч ажилласан байна. Хэрэгжиж байна 90%
	• бэлчээрийн газрыг ашиглах, эзэмших харилцааны эрх зүйн зохицуулалтыг төгөлдөржүүлж, уламжлалт аргад тулгуурласан бэлчээрийн менежментийг боловсронгуй болгож, бэлчээрийн даацад зэрлэг амьтны бэлчээр, тэжээлийн хэрэгцээг оруулан тооцох зарчмыг баримтлах;	Орхон, Булган аймгийн удирдах ажилтны уулзалтыг Эрдэнэт хотод зохион байгуулж 2 аймгийн Засаг дарга нарын хамтран ажиллах гэрээний дагуу 2010 онд зохион байгуулах ажлын төлөвлөгөө баталж, уг төлөвлөгөөнд Орхон аймгийн малчдад Булган аймгийн нутаг дэвсгэрт нутаглах бэлчээрийг хуваарилах талаар тусган, бэлчээр нутгийг сэлгээтэй зөв ашиглах талаар 2 сумын 600 гаруй малчин өрхүүдэд хөдөө ажилласан ажлын хэсгийн бүрэлдэхүүнээр дамжуулан яриа таниулга хийж, зөвлөгөө зөвлөмжөөр хангах арга хэмжээ авч ажиллалаа. Малын тэжээлийн хангамжийг нэмэгдүүлэх хүрээнд “Тогтвортой амьжиргаа-2” төслийн санхүүжилтээр Баян-Өндөр суманд 5 га, Жаргалант суманд 8 га газар

		<p>царгас тариалж, 150 га хадлангийн талбайг хашиж хамгаалан малчдын бүлэгт эзэмшүүлж эхэллээ.</p> <p>Хэрэгжиж байна 90%</p>
	<ul style="list-style-type: none"> биотехнологийн ололтыг нэвтрүүлж, мал үржүүлгийн бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг өргөжүүлэх; 	<p>Саалийн үнээний 10-аад фермерийн үнээний 30 гаруй үнээнд амьдын жинг нэмэгдүүлэх, үржлийн чадавхийг сайжруулах Англи улсаас витаминт-эрдсийн хольцыг тусгай жороор төслийн мэргэжилтнүүдтэй хамтран хяналттайгаар олгож туршилт явуулсан байна..</p> <p>Улаанбаатар хотоос Малын удмын сангийн үндэсний төвтэй “Эрдэнэ-Хутагт” мал эмнэлэг, үржлийн үйлчилгээний нэгжийг хамтран ажиллах гэрээтэй ажиллуулж, цэвэр үүлдрийн бухны гүн хөлдөөсөн 4 төрлийн 200 тун үр авчирч 7 фермер, 13 малчны захиалгаар 85 үнээнд зохиомол хээлтүүлэг хийв.</p> <p>Хэрэгжиж байна 90%</p>
	<ul style="list-style-type: none"> малчдыг хөгжүүлэх, мал аж ахуйн үйлдвэрлэлд шинжлэх ухааны ололтыг нэвтрүүлэх болон мал аж ахуй эрхлэх арга ухааны чиглэлээр малчдын дунд албан бус сургалтын нэгдсэн тогтолцоог бүрдүүлж хэрэгжүүлэх. 	<p>Эрчимжсэн мал аж ахуй эрхэлж байгаа болон цаашид эрхлэхээр ажиллаж эхэлсэн 62 хүнд фермерийн аж ахуй эрхлэх, эрчимжсэн технологи нэвтрүүлэх, эзэмших арга зүйн зөвлөгөө, зөвлөмжийг өгч, кабинетын сургалтанд 140 хүн хамрууллаа.</p> <p>“Хөгжлийн шийдэл”, СНФ төрийн бус байгууллагуудтай хамтран тахианы аж ахуй эрхлэгч, сонирхогч 22 иргэнтэй ажлын уулзалт, ярилцлагыг 3 удаа хийсний дээр 16 цагийн технологийн сургалт, дадлагын ажилд хамруулж батламж олгов.</p> <p>“Гэр санаачлага” төслийн “Өртгийн гинжин холбоо” хөтөлбөртэй хамтран гахайн аж ахуй эрхлэгч 32, сонирхогч иргэн 14, мал аж ахуйн мэргэжилтэн 5, бүгд 51 хүнийг хамруулсан сургалт явуулж, АНУ-ын болон төслийн мэргэжилтнүүдээр зөвлөгөө өгүүлэв.</p> <p>Хэрэгжиж байна 90%</p>
	<p><i>Стратегийн зорилт 2. Газар ашиглалтыг сайжруулж, усалгаатай тариаланг хөгжүүлэн, биотехнологи нэвтрүүлэн газар тариалангийн бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг нэмэгдүүлнэ:</i></p>	
	<ul style="list-style-type: none"> услалтын оновчтой системийг бий болгон усалгаатай газар тариалангийн техник, тоног төхөөрөмжийг лизингээр олгох, усжуулалтын барилга 	<p>Усалгаатай талбайн хэмжээг нэмэгдүүлж газар тариалангийн эрсдэлийг багасгаж, тогтвортой ургац хураан авах, ургацын чанарыг сайжруулж дотоодын үйлдвэрлэлийг нэмэгдүүлэн хүн амын хэрэгцээт төмс, хүнсний ногоо, гурилаар дотоодын хэрэгцээг хангах үүднээс усалгаатай газар тариаланг хөгжүүлэн</p>

	байгууламжийн эзэмшилт, ашиглалтыг зах зээлийн зарчимд нийцүүлж сайжруулах;	<p>өөрийн орон нутагт тохирсон нэвчилтийн, дуслын, бороожуулах усалгааны тоног төхөөрөмжөөр хангах, зуучлах, мэдээ мэдээллээр хангах, мэргэжлийн арга зүйн туслалцааг тариаланч, механикжуулагчдад өгч ажиллаж байна. Цаашид тариаланг усалгаажуулахад гүний усыг ашиглаж “Алтан тошлой” 140 га, “ЁБЦЕ” ХХК 69 га, нийт 209 га-гийн услалтын системийг “Алтан тошлой” 80 сая, “ЁБЦЭ” 105 сая төгрөгийн улсын төсвийн хөрөнгө оруулалттайгаар барилгын ажил хийгдэж байна.</p> <p style="text-align: center;">Хэрэгжиж байна 90%</p>
	<ul style="list-style-type: none"> • өрхийн аж ахуйн үйл ажиллагааг хөнгөвчлөх орчин үеийн бага оврын техник, тоног төхөөрөмж, багаж хэрэгслийг импортолдог болон дотооддоо үйлдвэрлэж байгаа аж ахуйн нэгжийг дэмжих; 	<p>Уулын баяжуулах “Эрдэнэт” үйлдвэрийн засвар механикийн заводод өрхийн аж ахуйн үйл ажиллагааг хөнгөвчлөх, орчин үеийн бага оврын тракторыг ОХУ-аас оруулж ирж угсрах, эд анги, дагалдах тоног төхөөрөмж чиргүүл, дүүшин машиныг үйлдвэрлэх чиглэлээр ажиллаж, угсарсан бага оврын трактор чиргүүл, дүүжин машиныг үйлдвэрлэлд туршиж хэрэглэгчдэд нийлүүлж байна. Өрхийн тариалан эрхлэгчдэд хөдөлмөрөө хорших, техник, тоног төхөөрөмжөөр төлбөртэй үйлчилж, тариалалт, ургац хураалтын ажлыг технологийн хугацаанд чанартай хийлгэх ажлыг зохион байгуулж Жаргалант сумын иргэн Д. Дарьсүрэн Д.Хүрлээ, Б.Барс, Л.Батхуяг нар өрхийн тариалан эрхлэгчдэд төлбөртэйгээр техникээр үйлчилгээ үзүүлж байна. Өрхийн тариалан эрхлэгчдэд техникээр үйлчилгээ үзүүлэх нэгжийг шинээр зохион байгуулах тухай саналаа ХХААХҮЯаманд хүргүүлснээр Жаргалант суманд Беларус МТЗ-82 дугуйт трактор,ХТЗ-3510 маркын бага оврын тракторыг дагалдах тоног төхөөрөмж төмсний иж бүрдлийн хамт хөнгөлөлттэй нөхцөлөөр олгож өрхийн тариалан эрхлэгчдэд үйлчилгээ үзүүлж байна. Өрхийн болон жижиг үйлдвэрлэл эрхлэгчдийн үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнийг сурталчлах, зах зээлд таниулах, нутгийн бренд бүтээгдэхүүний чанарыг дээшлүүлж, нэр төрлийг нэмэгдүүлэх зорилгоор 7 дугаар сарын 2-3-ны өдрүүдэд “Өрхийн үйлдвэрлэл-2010” үзэсгэлэн худалдаа зохион байгууллаа. Тус арга хэмжээнд 80 орчим иргэн, аж ахуйн нэгж өөрийн үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнээр оролцсон бөгөөд 10 гаруй иргэний бүтээгдэхүүн, зохион байгуулалт сайтай оролцсон багийг шагнаж урамшуулан 15 иргэнийг “Хангайн бүсийн түншлэл Архангай-2010” үзэсгэлэн худалдаанд урилгаар оролцууллаа. Улаанбаатар хотод зохион байгуулагдсан “Жижиг, дунд үйлдвэр-хоршоо-2010” үзэсгэлэн худалдаанд манай аймгаас нийт 18 иргэн, аж ахуйн нэгж оролцож иргэн Э.Амартүвшингийн монгол шатар “Үндэсний онцлог, хэв шинжийг хадгалсан бренд бүтээгдэхүүн үйлдвэрлэгч” номинацийн шилдгээр</p>

		<p>шалгарч цол, өргөмжлөлөөр шагнагдлаа.</p> <p>“Өрхийн жижиг үйлдвэрлэлийг дэмжих зорилгоор арилжааны банкаар дамжуулан хөнгөлөлттэй зээл олгох төслийг сонгон шалгаруулах журам”-ыг боловсруулан аймгийн Засаг даргын 2010оны 96 дугаар захирамжаар батлав.Өрхийн жижиг үйлдвэрлэл эрхлэгчдэд зориулж улсын төсөв, банкны санхүүжилтээр 1.0 тэрбум төгрөгийн эх үүсвэрийг бий болгон нэг зээлдэгчид 5,0 хүртэлх сая.төгрөгний зээлийг 1 жилийн хугацаатай, сарын 1 хувийн хүүтэйгээр ХААНБанк, Төрийн банкаар дамжуулан 81 төсөлд 212,3 сая.төгрөгний зээлийг олголоо.</p> <p style="text-align: center;">Хэрэгжиж байна 90%</p>
	<ul style="list-style-type: none"> • жимс, жимсний мод үржүүлгийн газруудыг байгуулж, жимс, жимсгэний тариалалтыг өргөтгөх; 	<p>Жимс, жимсгэний мод бут тариалах сонирхолтой аж ахуйн нэгж, иргэдийг дэмжин мэргэжил, арга зүйн туслалцаа үзүүлэх, сургалт, үзэсгэлэн зохион байгуулан ажилласнаар жимс, жимсгэний мод, бут тариалах иргэн, аж ахуйн нэгж, албан байгууллага нэмэгдэж байна.</p> <p>“Хотын ногоон байгууламжийг нэмэгдүүлэх жил” –ийн хүрээнд иргэд, аж ахуйн нэгж, албан байгууллага орчныхоо цэцэрлэг болон мод, бут, сөөг зэрэг тарьж ургуулаад байна. ХХААХҮЯ-наас зарласан чацаргана тариалах тендерт “Элсэн буйр”ХХК шалгарч 25сая төгрөгийн зээлийг хөнгөлөлттэй нөхцлөөр авч төслөө хэрэгжүүлж байна. Чацаргана, жимс, жимсгэнэ тариалах талаар иргэн, аж ахуйн нэгжид мэдээлэл арга зүйн зөвлөгөө өгч ажиллаж байна.</p> <p>Хотын ногоон байгууламж нэмэгдүүлэх жилийн хүрээнд мод бут, жимс, жимсгэний суулгац, тарьцын үзэсгэлэн худалдаа зохион байгуулж, 20 гаруй аж ахуйн нэгжүүд оролцож, мод, бут, жимс, жимсгэний тарьц, суулгацыг борлуулсан байна.</p> <p>“Чацаргана” хөтөлбөрийн хүрээнд “Чацарганы суулгац зээлээр олгох” төсөлд 7иргэн аж ахуйн нэгжийг дэмжин оролцуулснаар “Оюут-Уул” ХХК 2050ш, “Тэгш-Олон” ХХК 3000ш, 3 иргэн 1500ш бүгд 6550ш чацарганын суулгац зээлээр олгож 4.5га талбайд чацаргана тариалаад байна. Энэ онд нийт 10.04га-д чацаргана, 0.12 га-д үхрийн нүд шинээр тариалсан байна.</p> <p>Улаанбаатар хотод зохион байгуулсан “Чацаргана сонирхогчдын сургалт”-нд 10 иргэнийг хамруулж чацаргана тариалах,арчлах ,хураах ,боловсруулах чиглэлээр танхимын болон талбайн сургалтыг 2 өдрийн хугацаатай хийж мэдээллээр хангасан байна.</p>

		Хэрэгжиж байна 90%
	<p>•таримал ургамлын өвчин, хортонтой тэмцэх, сорт, сорилтын чанарыг сайжруулж, хүлэмжийн аж ахуйг хөгжүүлэх;</p>	<p>Таримал ургамлын өвчин, хортонтой химийн аргаар тэмцэх талаар иргэн, аж ахуйн нэгж, өрхийн тариалан эрхлэгчдэд мэргэжил, арга зүйн зөвлөгөө өгөх, мэдээ мэдээллээр хангах, ургамал хамгааллын бодисын тун нормыг тогтоох хэрэглэх арга ,ажиллагааны талаар газар дээр нь зөвлөгөө өгч ажиллалаа.</p> <p>Манай улсад ашиглаж болох ургамал хамгааллын бодисын заавар, гарын авлагаар тариалан эрхлэгчдийг хангаж, Дархан-Уул аймгийн УГТСЭШХүрээлэнгийн эрдэмтдийг урьж сургалт явуулснаар сүүлийн үед шинээр гарсан манай улсад ашиглаж болох ургамал хамгааллын бодисын жагсаалтанд орсон олон төрлийн хор гербицидийг өргөн ашиглаж газар тариалангийн үйлдвэрлэлд химижүүлэлт нэмэгдсэнээр ургацын хэмжээ, чанар нэмэгдэж, хорогдол багасаж байна.</p> <p>Хамгаалагдсан хөрсний тариаланг нэмэгдүүлэх чиглэлээр үзүүлэх сургууль, сургалт зохион байгуулан ажилласнаар хүлэмжийн аж ахуй эрхлэх сонирхолтой иргэн, аж ахуйн нэгж нэмэгдэж 4500 м2 талбай бүхий шилэн болон нийлэг хальсан зуны хүлэмжинд хүнсний ногоо тариалж байна. Зоорь, хүлэмжийн аж ахуйг дэмжих журам боловсруулан аймгийн Засаг даргын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж, захирамж гаргуулан хэрэгжилтийг зохион байгуулан ажиллаж байна. 2010 онд Баян-Өндөр сум 300м/2 талбай бүхий 4 хүлэмж , Жаргалант сум 666м/2 талбай бүхий12 хүлэмжийг шинээр барьж ашиглалтанд оруулан хэмх лооль зэрэг хүнсний ногоо тариалж 30 гаруй тн ургац хураан авч орон нутгийн зах зээлд нийлүүлэхийн зэрэгцээ шинээр барьж ашиглалтанд оруулсан зоориудад 500 төмс хүнсний ногоо хадгалан иргэдийн хүнсний хэрэгцээнд нийлүүлж байна Шинээр зоорь хүлэмж барьж ашиглалтанд оруулан төмс хүнсний ногоо хадгалан борлуулж төмс нүнсний ногооны хангамжийг нэмэгдүүлэхэд тодорхой хувь нэмэр оруулсан иргэдэд “Зоорь хүлэмжийн аж ахуйг дэмжих журам”-ын дагуу шалгаруулалт явуулж,шалгарсан 9 иргэнд 3430.0 мянган төгрөгийн урамшуулал олгож дэмжлэг үзүүлэв.</p> <p>Зоорь барих хүсэлтэй иргэн, аж ахуйн нэгжид зоорь барих, зоорины зураг төслийг гаргаж өгөх зэргээр 60 гаруй иргэн, аж ахуйн нэгжид мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч, зоорины зураг, бусад гарын авлагаар хангав.</p> <p>Энэ онд ХХААХҮЯ-аасСолонгос улсын нийлэг хальсан хүлэмж 15 ширхэгийг татан авч Биргэн ,баж ахуйн нэгжид хуваарилан олголоо Зоорь, хүлэмжийг дэмжих зорилгоор иргэн, аж ахуйн нэгжид мэргэжил арга зүйн дэмжлэг үзүүлж,</p>

		<p>гарын авлага материалаар хангасан байна. Хүлэмжийн аж ахуйн чиглэлээр гадаад, дотоодын сургалтанд ногоочид, мэргэжилтнүүдийг хамруулан суралцуулсан байна. Хэрэгжиж байна 90%</p>
	<ul style="list-style-type: none"> • ганд тэсвэртэй үр, нутагшсан сортын үрийн талаар бодлого боловсруулж хэрэгжүүлэх. 	<p>Ганд тэсвэртэй, ургацын потенциал өндөртэй нутагшсан сортын үрийг сонгон тариалах талаар эрдэм шинжилгээний байгууллагуудтай хамтран ажиллаж байна. Эрдэм шинжилгээний байгууллага, үйлдвэрлэгчдийн уядлаа холбоог сайжруулах, хамтын ажиллагааг бэхжүүлэх бодлого баримтлан ажиллаж байна</p> <p>Манай улсад ашиглаж болох ургамал хамгааллын бодисын заавар, гарын авлагаар тариалан эрхлэгчдийг хангаж, Дархан-Уул аймгийн УГТСЭШХүрээлэнгийн эрдэмтдийг урьж сургалт явуулснаар сүүлийн үед шинээр гарсан манай улсад ашиглаж болох ургамал хамгааллын бодисын жагсаалтанд орсон олон төрлийн хор гербицидийг өргөн ашиглаж газар тариалангийн үйлдвэрлэлд химижүүлэлт нэмэгдсэнээр ургацын хэмжээ, чанар нэмэгдэж, хорогдол багасаж байна.</p> <p>Хэрэгжиж байна 90%</p>
<p><i>Стратегийн зорилт 3. Хүнсний үйлдвэрлэлд орчин үеийн дэвшилтэт технологийг нэвтрүүлж, бүтээгдэхүүний өрсөлдөх чадварыг сайжруулна:</i></p>		
	<ul style="list-style-type: none"> • экологийн цэвэр хүнсний бүтээгдэхүүний болон импортыг орлох хүнсний бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх; 	<p>Дотоодын хүнсний үйлдвэр эрхлэгчдийн үйл ажиллагааг дэмжиж хөгжүүлснээр импортыг орлох хүнсний бүтээгдэхүүний үйлдвэрлэл өсөн нэмэгдэх нөхцөл бүрдэх юм.</p> <p>Хүнсний салбарт энэ онд нийтдээ 901.4 сая төгрөгийн санхүүжилт хийгдэж, шинээр 3 үйлдвэр, цех байгуулагдаж, 9 аж ахуйн нэгжийн үйл ажиллагаа өргөжин үйлдвэрлэлийн хүчин чадал нэмэгдэж, бүтээгдэхүүний нэр төрөл, тоо хэмжээ нэмэгдлээ.</p> <p>Намрын ургац хураалтаар үр тариа 4102.0 га-аас 8491.2 тн, төмс 479.1 га-аас 5418.8 тн, хүнсний ногоо 367.7 га-аас 4518.9 тн-ийг хураан аваад байна. Нэг га талбайгаас үр тариа 20.7 цн, төмс 113.1 цн, хүнсний ногоо 122.9 цн-ыг хураан авсан нь өмнөх жилтэй харьцуулахад үр тарианых буурч, төмс, хүнсний ногооны</p>

		<p>га-гийн ургац нэмэгджээ.</p> <p>2010 оны байдлаар хүн амын хэрэгцээт улаан буудайн 88.2 хувь, төмсний 109 хувь, хүнсний ногооны 64 хувийг дотоодын үйлдвэрлэлээр хангаж байна. Жаргалант, Баян-Өндөр сумын хэмжээнд 5171 тн багтаамж бүхий 242 зоорийг ашиглан төмс, хүнсний ногооны 48 хувь хадгалан хэрэглэгчдэд хүргэж байна. Өрхийн тариалан эрхлэгчдэд энгийн уурхайн худаг 20, гүн өрмийн худаг 12, усан сан 12 /360 м²/-ыг төмс, хүнсний ногооны үйлдвэрлэлд ашиглаж байна. ХААХҮЯам, “Монгол төмс” хөтөлбөр, Хөдөө аж ахуйн үйлдвэрлэлд шинжлэх ухааны ололт нэвтрүүлэх төвтэй хамтран ажиллаж, 2 аж ахуйн нэгжийг “Монгол төмс” хөтөлбөрийн үр үйлдвэрлэгчээр сонгон ажиллуулж байна.</p> <p>“Ногоон хувьсгал” хөтөлбөрийн хүрээнд 2 тн төмсний үр, 7 төрлийн 28 кг хүнсний ногооний үр, хор шүршигч багаж зэргийг татан авч өрхийн тариалан эрхлэгчдэд олголоо. Аймгийн хэмжээнд хүнсний ногоо даршлан нөөшилдөг 3 цех тогтвортой ажиллагаа явуулж, жилд 65000 шил консервлосон хүнсний ногоог орон нутгийн болон Улаанбаатар, Булган аймгийн зах зээлд нийлүүлж байна.</p> <p>Мал аж ахуйн чиглэлээр сүүний үнээний нэг аж ахуйд ХХААХҮЯамны тендерээс 30.0 сая, ЖДҮ-ийг дэмжих сангаас гахайн нэг аж ахуйд 30.0 сая, тахианы нэг фермерт 15.0 сая, Зөгийчдийн бүлэгт ОХУ-аас зөгий авахад НҮБ-ын сангаас 14.5 сая, бүгд 89.5 сая төгрөгийн зээл олгож дэмжлэг үзүүллээ. Эдгээр арга хэмжээний үр дүнд саалийн үнээний 13, махны үхрийн 3, гахайн аж ахуйн 3, тахианы аж ахуйн 2, зөгийн аж ахуй 4, бүгд 25 фермерийн аж ахуй сүү, мах, өндөг, зөгийн балны үйлдвэрлэлийн чиглэлээр үйл ажиллагаа явуулж байна. Чацаргана хөтөлбөрийн хүрээнд зарлагдсан тендерээс 2 аж ахуйн нэгж, 3 иргэн нийт 6550 чацарганы суулгац авч тариалалтаа амжилттай хийгээд байна.</p> <p>Мөн ХХААХҮЯамнаас 14 хүлэмжийг хөнгөлөлттэй үнээр авч авч хүсэлт гаргасан иргэд, аж ахуйн нэгжүүдэд олгов.</p> <p style="text-align: right;">Хэрэгжиж байна 90%</p>
	<ul style="list-style-type: none"> • орчин үеийн техник, технологтой хүнсний үйлдвэрлэлийг хөгжүүлэн хүн амыг тэжээллэг, чанартай, аюулгүй хүнсээр жигд, хүртээмжтэй хангаж, гадаад зах зээлд нийлүүлж эхлэх; 	<p>2010 онд хүнсний салбарт ЖДҮДСан болон орон нутгийн дэд сангаас нийт 415.0 сая төгрөгийн 3 хүртэлх жилийн хугацаатай сарын 1 хувийн хүүтэй зээл, тоног төхөөрөмжийн лизингийн үйлчилгээнд 1 аж ахуйн нэгжийг хамруулан 77.0 сая төгрөгийн, орон нутгийн ЖДҮйлдвэрийг хөгжүүлэх сангаас хүнсний 4 цехэд 2 жилийн хугацаатай нийт 32.0 сая төгрөгийн, Европын холбооны Улсын санхүүжилтээр хэрэгжиж буй “Малын эрүүл мэнд, мал аж ахуйн зах зээл”</p>

		<p>төслөөс хөнгөлөлттэй нөхцлөөр хүнсний үйлдвэр, хүнсний зах, худалдааны төвүүдэд үйлдвэрлэлийн болон хүнсний бүтээгдэхүүн хөргөх, хадгалах, худалдааны зориулалтын нийт 327.4 сая төгрөгийн өртөг бүхий тоног төхөөрөмжүүдийг 40 хувийн хөнгөлөлттэй 3 хүртэл жилийн хугацаатай 1.2 хувийн хүүтэйгээр тус тус олгуулан, аж ахуйн нэгжүүд өөрийн хөрөнгөөр 50.0 сая төгрөгийн, нийтдээ 901.4 сая төгрөгийн санхүүжилт хийгдэж, шинээр 3 үйлдвэр, цех байгуулагдаж, 9 аж ахуйн нэгжийн үйл ажиллагаа өргөжин үйлдвэрлэлийн хүчин чадал нэмэгдэж, бүтээгдэхүүний нэр төрөл, тоо хэмжээ нэмэгдлээ. Үүний үр дүнд хагас боловсруулсан махан бүтээгдэхүүн, мах ангилан савлаж худалдаалах цехүүд шинээр байгуулагдаж байна. “Эрдэнэт Прогресс” мах боловсруулах үйлдвэр 600 тонны хөргүүртэй агуулах шинээр ашиглалтанд оруулж, хөргөлтийнхөө хүчин чадлыг 1100 тонны багтаамжтай болгон өргөтгөлөө. Мөн талх, нарийн боов, сүү боловсруулах үйлдвэрүүдэд техник, технологи, хөргөлтийн тоног төхөөрөмжийн шинэчлэл хийснээр бүтээгдэхүүний чанар сайжирч, нэр төрөл нэмэгдэх боломж бүрдлээ. Тухайлбал “Эрдэнэт өег” ХХК 50.0 сая төгрөгний хөнгөлөлттэй зээл авч, 8 төрлийн шинэ тоног төхөөрөмж нэмж, үйлдвэрлэлийн байраа 66 м2-аар өргөтгөснөөр бүтээгдэхүүний нэр төрлийг 5-аар нэмэгдүүлж нийт 22-24 нэр төрлийн бүтээгдэхүүн үйлдвэрлэн, үйлдвэрлэлийн хэмжээгээ 2 дахин нэмэгдүүллээ. Энэ онд “Монгема” ХХК адууны мах 883,5 тонн, хонины мах 28 тонн, “Эрдэнэт Прогресс” ХХК 1052.9 тонн адууны мах, 140 тонн үхрийн махыг үйлдвэрийн аргаар бэлтгэн гэрээт байгууллагаар дамжуулан экспортонд гаргасан байна.</p> <p style="text-align: right;">Хэрэгжиж байна 90%</p>
	<ul style="list-style-type: none"> • тохиромжтой бүс нутгуудад бөөний худалдааны төв, бирж байгуулж, хүнсний бүтээгдэхүүний борлуулалтын оновчтой сүлжээг бий болгох. 	<p>Манай аймагт сүүлийн жилүүдэд орчин үеийн хэрэгцээ, шаардлага хангасан Төгөл их дэлгүүр, Гурван од, Ачит, Идэр, Дэнж зэрэг 16 томоохон худалдаа, үйлчилгээний төвүүд ашиглалтанд орж худалдаа эрхлэгчид, үйлчлүүлэгчдийн ая тохитой байдлыг ханган, үйлчилгээний чанарыг сайжруулан ажиллаж байна. Мөн Дөмөг, Ан дөл зэрэг хүнсний бөөний худалдааны төвүүд үйл ажиллагаа явуулж байна. Дөмөг худалдааны төвд мал, малын гаралтай хүнсний бүтээгдэхүүн, түүхий эд, хүнсний ногоо, гурилын бөөний худалдааны цэг, салбарууд байнгын үйл ажиллагаа явуулж байна. 2011 онд мал, түүхий эдийн төрөлжсөн зах, хөдөө аж ахуйн гаралтай бүтээгдэхүүн борлуулах худалдааны төв шинээр байгуулахаар төлөвлөн ажиллаж байна.</p> <p style="text-align: right;">Хэрэгжиж байна 90%</p>

<p><i>Стратегийн зорилт 4. Газар тариалангийн болон бэлчээрийн усан хангамжийг сайжруулж, хөдөөгийн хүн амын ундны усны хэрэгцээ, шаардлагад тохирсон усны нөөцийг нэмэгдүүлнэ:</i></p>	
<ul style="list-style-type: none"> • ашиглагдахгүй байгаа бэлчээрийг худаг гаргаж, хурын ус хуримтлуулж, булаг шандны усыг нэмэгдүүлж, усжуулах; 	<p>Жаргалант суманд малчдын зөвлөгөөн зохион байгуулж, бэлчээрийг улиралын хуваарьтай сэлгэн ашиглах, худаг уст цэгийг ариг гамтай эзэмшиж, ашиглах талаар малчдад зөвлөмж, үүрэг чиглэл өгсний гадна худаг, уст цэгт сумтай хамтарсан үзлэг хийж, 10 худагт засвар хийх шаардлагатай байгаа талаар судалгаа санал гаргаж орон нутгийн 6.3 сая төгрөгийн санхүүжилтээр Баян-Өндөр сумын 4, Жаргалант сумын 2, аж ахуйн нэгж, иргэний 1, бүгд 7 худагт засвар хийж ашиглалтанд оруулсан байна.</p> <p>Хэрэгжиж байна 90%</p>
<p><i>Стратеги зорилт 5. Малын тэжээлийн үйлдвэрлэлийг сэргээн хөгжүүлж, тэжээлийн шимт чанар, тэжээллэг байдлыг сайжруулах, хангамж, хүртээмжийг нэмэгдүүлэх цогц арга хэмжээ авч хэрэгжүүлнэ:</i></p>	
<ul style="list-style-type: none"> • “Тэжээл” хөтөлбөр хэрэгжүүлж, малын тэжээл, усны хангамжийг сайжруулах; 	<p>Малын “Тэжээл” үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх төлөвлөгөөг аймгийн Засаг даргаар батлуулж, 10 гаруй арга хэмжээг төлөвлөн, сум багт хүргүүлж биелэлтэнд нь хяналт тавьж ажилласан байна.</p> <p>Аймгийн хэмжээнд 9650 тн өвс, 366 тн сүрэл, 189,2 тн ногоон тэжээл, 573,5 хүчит тэжээл, 44 тн гар тэжээл бэлтгэв.</p> <p>Хөтөлбөрийн хэрэгжилтийг зохион байгуулж 2010 онд хийсэн ажлын тайланг ХХААХҮЯ-нд холбогдох саналын хамт хүргүүлэх арга хэмжээ авсан байна.</p> <p>Хэрэгжиж байна 90%</p>
<ul style="list-style-type: none"> • шимт чанар сайтай, ургац ихтэй тэжээлийн шинэ төрлийн таримал нутагшуулах, үр үйлдвэрлэлийг дэмжиж, хувийн хэвшлийн аж ахуйн нэгж, фермерийн аж ахуйг тэжээлийн ургамлын үрээр хангах тогтолцоо бүрдүүлэх; 	<p>Хаврын тариалалтын хэрэгцээнд Баян-Өндөр сумын “Сүмийн нуга” хоршоогоор 7 га-д овьёосны, 4 га-д хөх тарианы, 1 га-д эрдэнэшишийн, 0.5 га-д судан өвсний, Жаргалант сумын “Орхон тариа” ХХК-иар 22 га-д овьёосны тариалалт тус тус хийлгэж, намрын ургац хураалтаар авсан ургацаар 78.1 тн ногоон тэжээл бэлтгүүлж, саалийн фермерийн аж ахуйнуудыг хангав.</p> <p>Хэрэгжиж байна 90%</p>
<ul style="list-style-type: none"> • бэлчээрийн мал аж ахуйн эрсдэл даах чадавхийг нэмэгдүүлэх зорилгоор жилийн тодорхой хугацаанд малаа 	<p>Аймгийн хэмжээнд малчдад төрийн үйлчилгээ хүргэх, төр засаг, орон нутгийн бодлого, шийдвэрийг сурталчилах, хүн, мал эмнэлгийн тусламж үзүүлэх, мал өвөлжүүлж, хаваржуулж, онд оруулах, хадлан тэжээл бэлтгэхэд дэмжлэг үзүүлэх</p>

	тэжээдэг малчдын арга ажиллагааг дэмжин хөгжүүлэх.	<p>чиглэлээр удирдах ажилтан 81 хүн оролцсон ажлын хэсгийг 12-р сараас 04 саруудад 2 суманд 4 удаа, 10 дугаар сард нэг удаа 10 гаруй хоногийн хугацаатай ажиллуулан, тэдгээр бүрэлдэхүүнээр дамжуулан мал аж ахуйн эрсдэл даах чадавхийг нэмэгдүүлэх, өвөл хаврын улиралд тэжээлийг ариг гамтай зарцуулж малыг технологийн дагуу оновчтой зөв тэжээх, малын арчилгаа, маллагаа, тэжээллэгийг уламжлалт аргатай зөв хослуулж хэрэглэх талаар нийт малчдын 87.9 хувийг мэдээллээр хангав.</p> <p style="text-align: right;">Хэрэгжиж байна 90%</p>
<i>Стратеги зорилт 6. Хөрсийг эвдрэлээс хамгаалах, үржил шимийг хадгалах, чийгийн ууршилтыг багасгахад чиглэсэн дэвшилтэт технологийг газар тариаланд нэвтрүүлнэ:</i>		
	<ul style="list-style-type: none"> • химийн аргаар боловсруулах уриншийн хэмжээг нэмэгдүүлэх; 	<p>Газар тариалангийн үйлдвэрлэлд цомхотгосон технологи, тэг элдэншүүлэлтийг нэвтрүүлэх чиглэлээр үр тарианы үйлдвэрлэл эрхэлдэг аж ахуйн нэгжүүдтэй хамтран ажиллаж зэргэлдээ аймаг, сумдын аж ахуйн нэгжүүдтэй туршлага судлан хамтран ажиллаж байна. Атрын 3 дахь аян тариалангийн хөгжлийн үндэсний хөтөлбөрийн хүрээнд СКП-2.1, СКП-2.1Д үрлүүрийг хаврын тариалалтанд ашиглаж, 2200 га талбайд хөрсний элэгдэлтэй тэмцэх техникээр тариалалт хийлээ.</p> <p>КПЭ-3.8-ийг лидер-4-өөр тоноглон, уриншийн боловсруулалт 4360 га талбайд хийж 1750 га талбайг химийн аргаар боловсруулав. Цомхотгосон технологийг нэвтрүүлж тариалангийн талбайд сүрлэн хучлаг үүсгэх зорилгоор ПУН-5 төхөөрөмж ашиглан 4100 га-д сүрлийг хэрчиж цацаж хучилт үүсгэлээ.</p> <p>Хөрсийг механик аргаар боловсруулах тоог цөөрүүлэн, химийн аргаар хог ургамалтай тэмцэх, цомхотгосон технологи нэвтрүүлэх чиглэлээр ажилласнаар 2010 онд 1750 га талбайд химийн аргаар уриншийн боловсруулалт хийсэн байна.</p> <p style="text-align: right;">Хэрэгжиж байна 90%</p>
	<ul style="list-style-type: none"> • ногоон бордуурт болон цомхотгосон технологиор уринш бэлтгэх арга ажиллагааг нэвтрүүлэх; 	<p>Хөрсийг салхи, усны элэгдэл, эвдрэлээс хамгаалж, шим тэжээлийн бодисын хангамжийг сайжруулж, чийгийн алдагдлыг багасгаж, гангийн нөлөөллийг бууруулж, ургацыг нэмэгдүүлэх зорилтын хүрээнд газар тариалангийн үйлдвэрлэлд цомхотгосон технологийг нэвтрүүлэх ажлыг зохион байгуулан ажиллаж байна.</p>

		<p>Цомхотгосон технологийг нэвтрүүлэхэд шаардагдах нэг явалтаар олон үйлдэл хийдэг багаж тоног төхөөрөмжийг худалдан авахад дэмжлэг үзүүлэн үр тарианы үрлэгч 9, сийрүүлэгч 4, хор цацагч 2-ыг хөнгөлөлттэй нөхцөлөөр олголоо. Мөн талбайд сүрлэн хучилт үүсгэх зориулалт бүхий сүрэл хэрчигч төхөөрөмжийг үнэгүй олгох зэргээр дэмжлэг үзүүллээ. 2010 онд 1750 га талбайд химийн аргаар уриншийн боловсруулалт хийлээ.</p> <p style="text-align: right;">Хэрэгжиж байна 90%</p>
	<ul style="list-style-type: none"> дэвшилтэт технологи нэвтрүүлэхэд шаардлагатай хөдөө аж ахуйн машин, техникийг худалдан авахад аж ахуйн нэгж, фермерүүдэд төрөөс дэмжлэг үзүүлэх; 	<p>Дэвшилтэт техник, технологи нэвтрүүлэх, техникийн шинэчлэл хийхэд дэмжлэг үзүүлж дунд оврын трактор 8, үр тарианы комбайн 3, ХАА-н чиргүүл, дүүжин машин 16, хор цацагч 2, будаа ачигч 2, будаа цэвэрлэгч 1-ийг 5 аж ахуйн нэгжид хөнгөлөлттэй нөхцөлөөр зээлээр олгож дэмжлэг үзүүллээ..</p> <p style="text-align: right;">Хэрэгжиж байна 90%</p>
	<ul style="list-style-type: none"> тариалангийн талбайг сүрлэн хучлагатай болгож хашаалан хамгаалах; 	<p>Тариалангийн талбайн хөрсийг салхины элэгдэлээс хамгаалах, чийгийн хангамжийг нэмэгдүүлэх зорилгоор талбайд сүрлэн хучилт үүсгэх сүрэл хэрчигч пун-5 тоног төхөөрөмжийг ХХААХҮЯ-ны ТЭДСангаас үр тарианы үйлдвэрлэл эрхэлдэг аж ахуйн нэгжүүдэд олголоо. Тариалангийн талбайг малаас хамгаалах сүрлэн хучилт бий болгох зорилгоор 2200 га талбайд байнгын болон зөөврийн хашаа барьж хашаажууллаа.</p> <p style="text-align: right;">Хэрэгжиж байна 90%</p>
5.2.1.5. Аялал жуулчлалын хөгжлийн бодлого Нэгдүгээр үе шат (2007 – 2015 он):		
<i>Стратегийн зорилт 2. Аялал жуулчлалын томоохон цогцолборуудыг барьж байгуулан, аялагч, жуулчдын сонирхлыг татсан аяллын төрлүүдийг бүс нутгаар төрөлжүүлэн хөгжүүлнэ.</i>		
	<ul style="list-style-type: none"> улирлын хамаарлыг багасгаж, бүтээгдэхүүн, үйлчилгээний нэр төрлийг олшруулах; 	<p>Бурхан багшийн сэрэг дүр цогцолборын барилга угсралтын ажилд “Эрдэнэт үйлдвэр” ХХК 2007-2009 онд 2 сая 300мян.ам доллар, 2010 онд 500 мян.ам доллар олгож нийт 2 сая 350 мян.ам доллар буюу 2919.3 сая төгрөг шилжүүлээд байна. Мөн орон нутгийн төсвөөс 100 сая төгрөг, иргэд байгууллагууд 23 сая төгрөг хандивлаж, нийт эх үүсвэр 3049.9 сая төгрөг зарцуулалт 3 тэрбум төгрөгт хүрээд байна.</p> <p style="text-align: right;">Бурхан багшийн сэрэг дүр цогцолборын барилга угсралтын ажлын 80 гаруй</p>

		<p>хувь, сэрэг дүр цутгуурын ажлын 75 хувь, сүншиг аравнайн эд зүйлсийн 85 хувь, цогцолборын нийт төсөвт ажлын 75 хувь тус тус хийгдээд байна.</p> <p>125.43га талбай бүхий “Их шүтээн цогцолбор” аялал жуулчлалын бүс, 250га талбай бүхий “Эрдэнэт цэнгэлдэх хүрээлэн” спорт, чөлөөт амралтын бүс байгуулах шийдвэрийг аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Тэргүүлэгчдийн хуралдаанаар хэлэлцүүлэн батлуулаад байна.</p> <p>“Эрдэнэт Цэнгэлдэх хүрээлэн” спорт, чөлөөт амралтын бүсийн хамгаалалтын 3.54км урт хайсыг хийж гүйцэтгээд байгаа бөгөөд цэнгэлдэх хүрээлэн барьж байгуулах ажлыг “Авзага трейд” ХХК гүйцэтгэж байна.</p> <p style="text-align: right;">Хэрэгжиж байна 90%</p>
5.3. Дэд бүтцийн хөгжлийн бодлого		
5.3.1. Зам, тээврийн хөгжлийн бодлого Нэгдүгээр үе шат (2007 – 2015 он):		
<i>Стратегийн зорилт 3. Авто замын салбарт дэвшилтэд техник технологи нэвтрүүлж, авто зам, замын байгууламжийн чанарыг дээшлүүлж, ашиглалт, үйлчилгээг сайжруулна:</i>		
<ul style="list-style-type: none"> • авто замын туршилт, сорилт судалгааны ажлыг сайжруулах. 		<p>“Эрдэнэт автозам-2020” төсөл боловсруулан батлуулсан. Төслийн хүрээнд 2010 онд Нийтийн тээврийн үйлчилгээний 6 автобусны буудлыг шинээр барьж тохижуулан, 9 автобусны зогсоолыг сэргээн засварлаж захын хорооллуудад байрлуулсан байна. Эрдэнэ, Дэнж багийн 3.55 км авто зам, Наран, Шанд багийн 3,2 км авто зам, Баянцагаан багийн 0.526 км зам, Эрээний гудамжны 1,68 км хатуу хучилттай замыг барьж ашиглалтад хүлээн авсан. Хүрэнбулаг багийн 4 хорооллын доторхи салбар замын өргөтгөлийн ажлыг гүйцэтгэж дууссан. Мөн аймгийн нийт авто замын хэмжилт судалгааг хийсэн. Мэдээллийг цахим хэлбэрт оруулсан. 2010 оны 12 сарын байдлаар аймагт улсын чанартай авто зам 51.3 км, орон нутгийн асфальтобетонон зам 58.7 км, сайжруулсан зам 52.1 км, төмөрбетон гүүр 3 буюу 96 м, нийтийн эзэмшлийн тохижуулсан талбай 25321 кв.м, автозогсоол 40722 кв.м байна.</p> <p style="text-align: right;">Хэрэгжиж байна 90%</p>
5.3.2. Эрчим хүчний салбарын хөгжлийн бодлого Нэгдүгээр үе шат (2007 – 2015 он):		
<i>Стратегийн зорилт 2. Сум, суурин газрын болон малчдын цахилгаан эрчим хүчний хангамжийг сайжруулна:</i>		

	<ul style="list-style-type: none"> • төвлөрсөн системд холбогдоогүй сум, суурин газруудыг цахилгаан дамжуулах агаарын шугамаар холбохын зэрэгцээ сэргээгдэх эрчим хүч болон бусад эх үүсвэрүүдийг ашиглан байнгын цахилгаанаар хангах; 	<p>Орхон аймгийн Баян-Өндөр , Жаргалант сумууд нь төвийн эрчим хүчний нэгдсэн сүлжээнд холбогдсон болно.</p> <p style="text-align: right;">Биелсэн 100%</p>
	<ul style="list-style-type: none"> • “Буман нарны гэр” хөтөлбөрийн хүрээнд бүх малчин айл өрхийг нар, салхины эрчим хүчний эх үүсвэртэй болгох; 	<p>. 2010 оны эцсийн байдлаар Баян-Өндөр сумын Малчин багийн 721 малчин өрхийн 90 хувь буюу 648 өрх, Жаргалант сумын Дулаан-Уул багийн 290 малчин өрхийн 203 өрх нь сэргээгдэх эрчим хүчээр хангагдан ашиглаж байна. Сэргээгдэх эрчим хүчний үндэсний төвтэй Агаарын суваг ХХК гэрээ байгуулснаар аймгийн хэмжээнд цахилгаан эх үүсвэрийг нийлүүлэхээр болсон бөгөөд Баян-Өндөр сумын Малчин баг, Жаргалант сумдаас захиалга аваад байна.</p> <p style="text-align: right;">Хэрэгжиж байна 90%</p>
<p>5.3.4. Мэдээлэл, харилцаа холбооны технологийн хөгжлийн бодлого Нэгдүгээр үе шат (2007 – 2015 он):</p>		
<p><i>Стратегийн зорилт 2. Мэдээлэл харилцааны технологийн ололтыг нийгэм, эдийн засгийн бүх салбарт өргөн нэвтрүүлнэ:</i></p>		
	<ul style="list-style-type: none"> • зайн эмчилгээ, зайн эмнэлгийн анхдагч тусламж, үйлчилгээг үзүүлдэг болгож, нарийн мэргэжлийн эмч нар зайнаас зөвлөгөө өгөх, мэргэжлийн тусламж үзүүлэх боломжийг бүрдүүлэх; 	<p>Люксембургийн Вант улсын буцалтгүй тусламжаар хэрэгжиж байгаа “Телемедицин ба Зүрх судасны өвчин МОН 003” төслийн хүрээнд алсын зайн холбооны тусламжтайгаар өндөр нарийн мэргэжлийн эмч нараас зүрхний хүнд өвчтэй 15 хүний талаар зөвлөгөө авч, 20 эмчилгээтэй нярайд телемедицины сүлжээгээр нарийн мэргэжлийн эмч нараас эмчилгээ оношлогооны зөвлөлгөө авч эмчилгээ хийгдсэн байна.</p> <p style="text-align: right;">Хэрэгжиж байна 90%</p>
	<ul style="list-style-type: none"> • зайн банкны үйлчилгээ, зайн төлбөр тооцоо, зайн худалдаа, арилжаа, бэлэн бус мөнгөний эргэлт, нийгмийн халамжийн зайн үйлчилгээг нэвтрүүлэх; 	<p>Манай аймагт ХХБ, ХААН, ХАС, Хадгаламж, Голомт, Төрийн банкуудын нийт 13 бэлэн мөнгөний АТМ ажиллаж байсан ба шинээр 4 АТМ машин нэмэгдэж нийт 17 машинтай болсон байна. ХХБ, ХАС, ХААН, Голомт банкууд POS машинаа нийт 96 аж ахуй нэгжид байршуулан иргэдэд үйлчилж байна. Мөн манай аймагт үйл ажиллагаа явуулж байгаа арилжааны банкны салбар болон тооцооны төвүүд нийт 157 POS терминал машинаар иргэдэд картнаас бэлэн мөнгө гаргах бэлэн бус төлбөр тооцоо хийн ажиллаж байна. Тухайлбал</p>

		Интернет банк, мобайл банк зэрэг үйлчилгээг идэвхжүүлж байгаа болно. Хэрэглэгчийн телефон утасны төлбөр төлөх системийг хялбарчлан Хас банкны АМАР үйлчилгээгээр дамжуулан хэрэглэгч төлбөрөө төлөх нөхцлийг бүрдүүлсэн байна. Хэрэгжиж байна 90%
	<ul style="list-style-type: none"> хөдөө орон нутагт утасгүй холбооны системийг эрчимтэй хөгжүүлж, 2015 он гэхэд үүрэн телефоны шинэ үеийн үйлчилгээг газрын суурь сүлжээг ашиглан хүн амын 60 хүртэл хувьд хүргэж, газар нутгийн 50 хүртэл хувийг зөвхөн газрын суурь сүлжээний тусламжтайгаар хамруулах. 	<p>Аймгийн төсвийн байгууллагуудын “Цахим Эрдэнэт” нэгдсэн сүлжээнд ажиллаж байгаа байгууллагууд компьютерийн дотоод сүлжээндээ болон интернэтэд холбогдон мэдээллийн технологийг ашиглан үйл ажиллагаа явуулахдаа мэдээллийн аюулгүй байдлыг хангах, нууцлалыг хадгалах, хамгаалах журмыг батлуулан ажиллаж байна.</p> <p>2009 оноос хойш Булган-Бугат-Эрдэнэтийн шилэн кабелийн системийг ашиглалтанд авч мэдээлэл холбооны сувгийн багтаамж 37 дахин нэмэгдээд байна</p> <p>2010 онд суурин телефон цэгийн тоо 7515д хүрч, F-zone үйлчилгээний хэрэглэгчийн тоо 2009 онд 2008 байсан бол энэ жил 2090, ADSL үйлчилгээний хэрэглэгч буюу интернет хэрэглэгчийн тоо өмнөх онд 765 байсан бол энэ жил 936 болж нэмэгдлээ. ADSL хэрэглэгчийн төхөөрөмжийн багтаамжийг 240 хэрэглэгчээр нэмж одоогийн байдлаар 1012 хэрэглэгчийн багтаамжтай байна. Мөн 1 E1 урсгал нэмсэн.</p> <p>Хэрэглэгчийн телефон утасны төлбөр төлөх системийг хялбарчлан Хас банкны АМАР үйлчилгээгээр дамжуулан хэрэглэгч төлбөрөө төлөх нөхцлийг бүрдүүлсэн байна.</p> <p>Хэрэгжиж байна 90%</p>
5.3.5 Хот байгуулалт, барилгын хөгжлийн бодлого Бүх үе шат (2007-2021 он):		
<i>Стратегийн зорилт 1. Хүн амын нутагшилт, суурьшлын зохистой тогтолцоог хөгжүүлж, хот, суурингийн оршин суугчдад таатай орчин бүрдүүлнэ:</i>		
	<ul style="list-style-type: none"> хүн амын нутагшилт, суурьшлын талаар төрөөс баримтлах бодлогыг боловсруулж, хэрэгжүүлэх, хот байгуулалтын эрх зүйн орчинг сайжруулж, хот төлөвлөлтийн норм, нормативыг боловсронгуй болгох; 	<p>Хүн амын нутагшилт, суурьшлын талаар төрөөс баримтлах бодлогыг боловсруулж, хэрэгжүүлэх, хот байгуулалтын эрх зүйн орчинг сайжруулах зорилгоор “Эрүүл хот” хөтөлбөр, “Эрдэнэт зам”, “Эрдэнэт гэрэлтүүлэг”, “Орхон аймгийг 2020 он хүртэл хөгжүүлэх цогц бодлого” зэрэг бодлогын баримт бичгийг боловсруулан, хэрэгжилтийг нь ханган ажиллаж байна. Хангайн бүсийн тулгуур төв болон хөгжиж буй Орхон аймаг 2010 оны байдлаар 88705 хүн амтай байна Үүнээс Баян-Өндөр суманд 85783, Жаргалант суманд 2922 хүн ам тус тус</p>

		<p>амьдарч байна. Хүн амын нягтаршил их байгаатай холбогдуулан 2011 онд орон сууцны 7, 11-р хорооллыг барьж эхлээд байна.</p> <p>Хэрэгжиж байна 90%</p>
	<ul style="list-style-type: none"> • бүсийн хөгжлийн тулгуур төвүүдийг эхний шатанд тус бүр 50 мянгаас доошгүй хүн ам, цаашид тус бүр 100 мянга орчим хүн амтай хотууд болгон хөгжүүлэх таатай орчинг бүрдүүлэх; 	<p>Хангайн бүсийн тулгуур төв болон хөгжиж байгаа Эрдэнэт хотын хүн ам 2010 оны жилийн эцсийн байдлаар 87869 байна. Хот тосгоны эрхзүйн тухай хуулид заасны дагуу Эрдэнэт хотыг улсын зэрэглэлтэй хот болгох талаар саналыг Засгийн газар УИХ –д өргөн бариад байна. Бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалын дагуу Орхон аймаг Хангайн бүсийн эдийн засгийн тулгуур төв хот болон хөгжиж байна. Тулгуур төв болсонтой холбогдуулан Орхон аймгийн 2009-2021 оны хөгжлийн стратегийг боловсруулж, аймгийн ИТХ-ын хуралдаанаар хэлэлцүүлэн батлуулаад мөрдөн ажиллаж байна.</p> <p>Хэрэгжиж байна 90%</p>
	<ul style="list-style-type: none"> • орон нутгийн хот суурин газруудын инженерийн дэд бүтэц, газар ашиглалтыг хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөний дагуу сайжруулах. 	<p>2004-2010 оны хооронд Инженерийн шугам сүлжээ бүхий хотын төв хэсэг 1-6 дугаар орон сууцны хорооллуудад хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөний дагуу барилгажсан байна.</p> <p>Эрдэнэт хотын Инженерийн шугам сүлжээнд холбогдох боломж бүхий Говил, Тосгон, Дэнж багуудад хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөний дагуу Тосгонд 200 айлын орон сууц, Эрчим хүчний хэмнэлттэй сүрлэн барилгын хотхоны, Говил багт 400 айлын орон сууцны хотхон, 100 айлын орон сууцны хотхон, Ус цэвэршүүлэх үйлдвэр болон бусад үйлдвэрлэлийн чиглэлээр, Дэнж багт Улсын хөрөнгө оруулалтаар 40 ортой эмнэлэгийн барилгын зориулалтаар барилгажилтын ажил хийгдэж Дэнж багийн эмнэлэг ашиглалтанд орсон байна. Тус багуудад барилгажилтыг явуулахад одоо байгаа шугам сүлжээ нь хуучирч ашиглах боломжгүй болоод байгаа бөгөөд шинэчлэх, өргөтгөл хийх шаардлагатай байна.</p> <p>Гэр хорооллын 2020 он хүртэл хөгжүүлэх бодлогын хүрээнд нийт 750 га талбайг хамруулж Баян-Өндөр сумын гэр хорооллын ерөнхий төлөвлөгөө хийгдэж, төлөвлөгөөний дагуу гэр хорооллын дунд иргэдийн хэрэгцээг хангаж үйлчлэх цогцолбор төвүүд үүсч байна. Мөн гэр хорооллын усан хангамж болон цэвэр бохир усны шугам сүлжээнд холбож, дэд бүтцийг сайжруулах МОН2301 төслийн ажил эхэлсэн болно.</p> <p>Хэрэгжиж байна 90%</p>

<p><i>Стратегийн зорилт 2. Орчин үеийн чанарын шаардлага бүхий барилга, шинэ нэр төрлийн барилгын материалын үйлдвэрлэл, нийтийн аж ахуйн салбарыг бий болгон хөгжүүлнэ:</i></p>	
<ul style="list-style-type: none"> • олон давхар орон сууц болон томоохон үйлдвэрийн барилга барих үндэсний чадамжийг сайжруулах; 	<p>Орон сууцны 2а, 7, 7а хорооллын барилгажилтын ажлыг батлагдсан ерөнхий төлөвлөгөөний дагуу 2011 оноос барилгажуулж эхлэхээр бэлтгэл ажил хийгдэж байна. Үүнд 2а хорооллын гадна шугам сүлжээний ажлын зургийг Зам тээвэр барилга хот байгуулалтын яамны захиалгаар ДНТ ХХК-нд боловсруулж дуусаад байна. Орон сууцны 2а, 7, 7а хорооллын барилгажилтын төсөл боловсуурлах шатандаа явагдаж байна.</p> <p>Хэрэгжиж байна 70%</p>
<ul style="list-style-type: none"> • орон нутгийн түүхий эдийн нөөцөд түшиглэсэн барилгын материалын үйлдвэрлэлийг түлхүү хөгжүүлэх. 	<p>Орон нутгийн түүхий эдэд тулгуурласан тоосгоны -2, бетон төмөр бетоны -5, силикат барилгын -1, цементны -1, зэс утасны -1, бетон блок хананы 8 үйлдвэр ажиллаж байна. 2011 онд хөнгөн блок үйлдвэр ашиглалтанд ороход бэлэн болж тоног төхөөрөмжөө суурилуулаад байна.</p> <p>Барилгын материалын шинэ нэр төрлийн бүтээгдэхүүний үйлдвэрлэл хөгжиж байна. Тухайлбал “Өргөө гоёл” ХХК сүүлийн үед хөгжилтэй орнуудад хэрэглээ нь нэмэгдэж байгаа барилгын гипсэн гоёл чимэглэлийг Солонгос тенологиор үйлдвэрлэж эхлээд байна. “Мөнх тэнгэрийн ташуур” ХХК хаягдал хуванцар ашиглан эрүүл, аюулгүйн шаардлага хангасан замын хавтан үйлдвэрлэж байна. Дээрхи үйлдвэрүүдийг Монголын үндэсний олон нийтийн ТВ-ээр сурталчилж үйл ажиллагааг нь дэмжлээ. “Соён өргөө” ХХК хаягдал хуванцар ашиглан дээврийн хавтан үйлдвэрлэж байна. “Номчи гүүр” ХХК барилгын чулуун материалын үйлдвэр байгуулж байна. “Домогт тайж” ХХК хөнгөн блок, “Олз сервис” ХХК угсармал бетонон хашаа үйлдвэрлэж байна.</p> <p>“Жижиг, дунд үйлдвэрийг дэмжих зорилгоор арилжааны банкаар дамжуулан хөнгөлөлттэй зээл олгох төслийг сонгон шалгаруулах дэд комиссын үйл ажиллагааны журам”-ын дагуу аймгийн Засаг даргаар ахлуулсан Худалдаа аж үйлдвэрийн танхим, Ажил олгогч эздийн холбооны төлөөллийг оруулсан 9 хүний бүрэлдэхүүнтэй Төсөл сонгон шалгаруулах дэд комисс байгуулан ажилласан ба ЖДҮ-ийг дэмжих сангаас зээл хүссэн нийт 5371.9 сая төгрөгний зээлийн санал</p>

		<p>бүхий 218 төсөл хүлээн авч аймгийн ТСШДКомиссын хурлаар хэлэлцэн 1602.5 сая төгрөгний зээлийн санал бүхий 53 төслийг дэмжин Хадгаламж банкинд 4-р сарын 29-нд шилжүүлсэн байна. Банк төслүүдийг судлан нийт 25 төсөлд 650.0 сая төгрөгний хөнгөлөлттэй зээл олголоо.</p> <p>Нийт ирүүлсэн төслийг салбараар нь ангилж үзвэл 15.1 хувь нь хүнсний, 16 хувь нь мал аж ахуйн, 16.5 хувь нь газар тариалангийн, 34.9 хувь нь хөнгөн үйлдвэрийн, 11 хувь нь барилгын материалын үйлдвэрлэлийн үлдсэн 6.5 хувь нь эмнэлэг, ахуйн болон бусад үйлчилгээний салбарын төслүүд байсан бөгөөд аль болох импортыг орлох, орон нутгийн зах зээлд шаардлагатай байгаа нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг эхний ээлжинд санхүү зээлийн бодлогоор дэмжих бодлого барьж ажилласан байна.</p> <p>Зээл авсан төслүүдийг ангилж үзвэл 50 хувь нь хөнгөн үйлдвэрлэлийн, 25 хувь нь хүнсний үйлдвэрлэлийн, үлдсэн хэсэг нь мал аж ахуй, газар тариалан, барилгын материалын үйлдвэрлэл, ахуй үйлчилгээний чиглэлийн төсөл байна.</p> <p style="text-align: right;">Хэрэгжиж байна 90%</p>
<p><i>Стратегийн зорилт 3. Хүн амын орон сууцны хангамжийг эрс сайжруулна. “Орон сууц” үндэсний хөтөлбөр хэрэгжүүлнэ:</i></p>		
	<ul style="list-style-type: none"> • орон сууц барих санхүүгийн эх үүсвэрийг нэмэгдүүлж, орон сууцны урт хугацаатай зээлийн анхдагч ба хоёрдогч зах зээлийн тогтолцоог бий болгон хөгжүүлэх, орон сууц барих сан байгуулж, орон сууцны гэрээт хадгаламжийн системийг нэвтрүүлэх; 	<p>“Орон сууцны санхүүжилт” корпорацийн санхүүжилтээр “Эрдкон”ХХК-ны барьж буй 50 айлын орон сууцны ажлын явц 80 хувийн гүйцэтгэлтэй байна</p> <p style="text-align: right;">Хэрэгжиж байна 90%</p>
	<ul style="list-style-type: none"> • гэр хорооллыг оршин суугчдынх нь оролцоотойгоор орон сууцны хороолол болгон хөгжүүлж, хүн амын худалдан авах чадварт тохирсон орон сууцны хангамжийг нэмэгдүүлэх; 	<p>Баян-Өндөр сумын Гэр хорооллыг инженерийн хангамж бүхий амины орон сууцны хороолол болгон хөгжүүлэх ерөнхий төлөвлөгөөг зураг төслийн Дий Энд Жийс ХХК-р гүйцэтгүүлэн 2010 оны 12-р сарын 27-нд болсон аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн ээлжит 13-р хуралдаанаар хэлэлцүүлэн баталуулсан байна.</p> <p>Мөн гэр хорооллыг олон нийтийн оролцоотой хөгжүүлэх Мон 9306 төсөл, гэр хорооллын усан хангамжыг сайжруулах Мон 2301 төсөл амжилттай хэрэгжиж</p>

		<p>байна.</p> <p>Бага орлоготой иргэдийг орон сууцжуулах хөтөлбөр Хабитат төслийн хүрээнд 2010 онд айлыг орон сууц барихад 9, засварт 30 айл өрхийг хамруулсан бөгөөд 2001 оноос хойш засварын ажилд 22 сая 500 мянга, шинэ байр барихад өссөн дүнгээр 782 сая 624 мянган төгрөгийг тус тус зарцуулаад байна. Дэлхийн банк, Олон улсын хотуудын холбооноос санхүүжүүлэн Эрдэнэт хотыг 2020 он хүртэл хөгжүүлэх стратеги төлөвлөгөөг АНУ-ын “Падко” компанитай хамтран боловсруулсан бөгөөд хэтийн зорилтоо: “Бүсийн хөгжлийг тэтгэдэг, тогтвортой байгаль орчинтой мэдээллийн технологи болон үйлдвэрлэл дээр тулгуурласан экспортын баримжаатай, хүчтэй эдийн засагтай, эрүүл, өндөр боловсролтой иргэдтэй загвар хот байна” гэж тодорхойлсон бөгөөд стратегийн зорилтоо 6 санаачилгад хувааж ач холбогдлоор нь дараалуулан тодорхойллоо. Хөгжлийн стратегийг Англи, Монгол хэлээр хэвлсэн бөгөөд вэб сайтад байршуулах ажил хийгдэж байна. “Эрдэнэт хотын 2020 он хүртэл хөгжүүлэх стратеги төлөвлөгөөг” Дэлхийн банкнаас дүгнэлт хийгдэж сайшаагдсан бөгөөд аймгийн ИТХ-ын ээлжит бус IX хурлын 01 тоот тогтоолоор баталлаа. Германы бүс нутгийн эдийн засгийг дэмжих хөтөлбөртэй хамтран ажлын хэсэг байгуулан Орхон аймгийн хөгжлийн цогц бодлогыг боловсруулсан. Мөн 2009-2013 онд хэрэгжүүлэх “Эрүүл хот” төслийг боловсруулж АИТХ-аар хэлэлцүүлж баталсан. Говил багийн Дэнж, Хонхорын хэсэгт амины орон сууцны зориулалтаар иргэдэд газар олгох асуудлыг шийдвэрлүүлэхээр барилгажилтын төлөвлөгөө боловсруулж, аймгийн ИТХ-аар хэлэлцүүлэн дэмжүүлсэн. Шинээр орон сууц барихыг хүссэн 17 иргэний хүсэлтийг Монгол Хабитат хүмүүнлэгийн байгууллагад уламжлан, төслийн шугамаар орон сууцтай болгосон.</p> <p style="text-align: center;">Хэрэгжиж байна 90%</p>
	<ul style="list-style-type: none"> • орон сууцны шинэ хотхон, хорооллын дэд бүтцийг байгуулахад хувийн хэвшлийн оролцоог дэмжих; 	<p>Шинэ хорооллуудыг барилгажуулах төсөл сонгон шалгаруулалтаар 2а хорооллыг Глобалсэблезейшн ХХК, 7-р хорооллыг БНХАУ-ын Бээжин консртакшн ХХК шалгарч барилгажилтын зураг төслийн ажил хийгдэж байна.</p>

		Говил багт 450 өрхийн орон сууц барихаар ОХУ-ын хөрөнгө оруулалттай Инаросс ХХК барилгажилтын ажлаа эхлээд байна Хэрэгжиж байна 90%
<i>Стратегийн зорилт 4. Хот суурингийн газар ашиглалтыг сайжруулж, эд хөрөнгийн бүртгэлийн тогтолцоо, үйл ажиллагааг боловсронгуй болгоно:</i>		
	• газрын шинэтгэлийг эрчимжүүлэх, газрыг иргэн бүрт үнэгүй өмчилж, эдийн засгийн эргэлтэнд оруулах эрх зүйн орчинг боловсронгуй болгох;	2008 онд Монгол улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хуулинд орсон нэмэлт өөрчлөлтөөр Монгол улсын иргэн бүр гэр бүлийн хэрэгцээний зориулалтаар нэг удаа газар үнэгүй өмчилж авах эрхтэй болсон. Иргэн бүр газар өмчлөх эрхтэй болсноор өмнө нь хамтран өмчлөгчөөр бүртгүүлсэн байсан 509 иргэний хамтран өмчлөх эрхийг хүчингүй болгож, шинээр газар өмчилж авах эрхийг нь сэргээгээд байна Хуульд нэмэлт өөрчлөлт орсноор газар өмчлөгчдийн тоо нэмэгдэж, иргэдийн дунд газрыг эдийн засгийн эргэлтэнд оруулах эрэлт, сонирхол нэмэгдэж байна. Хэрэгжиж байна 90%
	• газрын мэдээллийн үндэсний системийг бий болгон энэ талаархи мэдээллээр олон нийтэд шуурхай үйлчилдэг болгох;	ГХБГЗЗГ-аас Үндэсний газрын мэдээллийн системийг боловсруулж, ашиглаж эхлээд байна. Энэ ажлын хүрээнд аймгийн газрын кадастрын зургийг олон улсын стандартд нийцсэн тусгагт шилжүүлэх ажлыг зохион байгуулан ажиллаж байна. Мөн хиймэл дагуулаас газрын байрлал тодорхойлох байнгын ажиллагаатай “CORS” суурин станцтай болох саналыг Монголын Мянганы Сорилтын Сангийн Хөрөнгийн эрхийн төсөлд тавьж шийдвэрлүүлэн, станц суурилуулагдан сургалт дадлагын ажил зохион байгуулагдаж туршилт тохируулга хийгдэж байна. Хэрэгжиж байна 90%
	• газрын мониторингийн сүлжээ бий болгож, доройтолд орж эвдэрч талхлагдсан газрыг нөхөн сэргээж сайжруулах хөтөлбөр, төслүүдийг боловсруулан хэрэгжүүлэх	Тариалангийн газрын 200 га – д зурваслан тариалж, 120.0 га талбайг шим бордоогоор бордож, 280.2 га-д хортон шавьж, мэрэгчдийн хөнөөлтэй тэмцэх ажиллагаа хийсэн ба Бэлчээрийн 8.0 га газрыг тордон сайжруулах царгас тариалан, 60.0 га бэлчээрийн даацыг тохируулсан байна. Хот тосгоны эдэлбэр газарт 0.64 га–г хөрсжүүлэн зүлэгжүүлж, 0.01 га-д мод, бут, сөөг тарьж, Хүрэн булаг багийн 11-р хороолол, Шанд багийн нутаг дэвсгэрт байсан 0.08 га нүх, гуу жалга бүхий эвдэрсэн газарт үерийн далан хийж, үйлдвэрийн болон ахуйн хог хаягдлаас 135.7 га газрыг цэвэрлэх ажил хийлээ. Ойн сан бүхий газарт 5425.0 га -д өвчин хортонтой тэмцэн хор цацаж, 72 га-д ойн цэвэрлэгээ хийж, усны сан

		<p>бүхий газарт Жаргалант сумын Хонгор морьт, Дарст зэрэг 1.2 га газарт усны эх булаг эрэг орчмыг хамгаалалтанд авч тохижилтын ажлыг хийсэн байна. Уурхайн эдэлбэрийн газарт Уулын баяжуулах “Эрдэнэт” үйлдвэр, “Зунрун” ХХК -ийн овоолгын талбайд техникийн нөхөн сэргээлтийг 13.6 га талбайд хийж, 0.2 га газрыг хөрсжүүлсэн байна.</p> <p style="text-align: right;">Хэрэгжиж байна 90%</p>
	<ul style="list-style-type: none"> • үл хөдлөх эд хөрөнгийг эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлд бүрэн хамруулж, өмчийн бүртгэлийн системийг боловсронгуй болгон бэхжүүлэх. 	<p>Нийт 12586 иргэн эзэмшиж буй газраа өмчилж авсан бөгөөд эдгээрийн иргэдийн 70,8 хувь буюу 8907 иргэн эд хөрөнгө өмчлөх эрхийн улсын бүртгэлд газраа бүртгүүлэн өөрийн өмчийн газрыг эдийн засгийн эргэлтэнд оруулах эрхтэй болжээ.</p> <p style="text-align: right;">Хэрэгжиж байна 70%</p>
5.4. Бүс нутаг, хөдөөгийн хөгжлийн бодлого Нэгдүгээр үе шат (2007-2015 он):		
<i>Стратегийн зорилт 1. Бүсчилсэн хөгжлийн төлөвлөлт, удирдлагыг боловсронгуй болгож, бүс нутгийн хөгжлийг түргэсгэнэ:</i>		
	<ul style="list-style-type: none"> • Баруун, Хангайн, Төвийн, Зүүн, Улаанбаатарын бүсийн 2015 он хүртэлх хөгжлийн хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэх; 	<p>Хангайн бүсийн хөгжлийн хөтөлбөрийн хүрээнд Гадаадын хөрөнгө оруулагчид болон хандивлагчдын чуулга уулзалтыг Эрдэнэт хотод 2010 оны 6-р сарын 24-25 ны хооронд зохион байгуулсан. Уг чуулга уулзалтад гадаад дотоодын аж ахуйн нэгжийн төлөөлөл болон ЗГ, яам агентлагын удирдлагаас гадна 3 элчин сайдын яам оролцсон. Уг арга хэмжээг Хангайн бүсийн 3 тэргүүлэх салбар: Уул уурхай, олборлолт, Хүнс хөдөө аж ахуйн үйлдвэрлэл буюу дахин боловсруулалт, Аялал жуулчлалын гэсэн 3 бүлгээр хурал зөвлөгөөнийг зохион байгуулж Хангайн бүсийн хөгжлийн давуу сул тал, цаашдын хөгжлийн талаар илтгэл танилцуулга хийж зөвлөмж гаргаж ажилласан байна.</p> <p>Мөн манай улсын томоохон үйлдвэрлэгч Дархан нэхий, Дархан савхи компани, Номин холдинг, Алтай кашимер, Техник импорт, Эрдэнэт хивс компаниуд энэ арга хэмжээнд идэвхтэй оролцсон юм. Үүнээс гадна Дархан, Сэлэнгэ, Төв аймгаас төлөөлөл ирж оролцлоо.</p> <p style="text-align: right;">Хэрэгжиж байна 90%</p>
	<ul style="list-style-type: none"> • бүсийн тулгуур төв болох Ховд, Улиастай, Эрдэнэт, Хархорин, Дархан, Зуунмод, Өндөрхаан, Чойбалсан хотуудын болон аймаг, бичил бүсийн хөгжлийн хөтөлбөрүүд, суурин газруудын ерөнхий төлөвлөгөөг боловсруулж хэрэгжүүлэх; 	
6. БАЙГАЛЬ ОРЧНЫ БОДЛОГО Бүх үе шат (2007-2021он):		
<i>Стратегийн зорилт 1. Байгаль орчны бохирдол, доройтлыг хязгаарлан зогсооно:</i>		
	<ul style="list-style-type: none"> • Улаанбаатар болон томоохон хот суурин газрын орчны бохирдлыг багасгах 	<p>Аймгийн хэмжээнд орчны бохирдлыг бууруулах зорилгоор “Эрүүл хот хөтөлбөр”, “Хог хаягдлын менежментийг боловсронгуй болгох хөтөлбөр”, зэрэг</p>

<p>эрх зүй, эдийн засаг, удирдлага, зохион байгуулалтын нэгдсэн арга хэмжээг хэрэгжүүлэх;</p>		<p>орон нутгийн хөтөлбөрүүд хэрэгжиж байгаагаас гадна Монгол улсын Засгийн газар болон Бүгд Найрамдах Франц улсын Засгийн газрын хоорондын Санхүүгийн протокол, Монгол улсын Сангийн Яам, Франц улсын Натиксис банкны зээлийн хэлэлцээрийн үндсэн дээр Орхон аймаг нь Франц улсын Дегремент компани, Эжис БСЕОМ Интернэйшнл компаниудтай “Эрдэнэт хотын цэвэрлэх байгууламжийн өргөтгөл”-ийн төслийг хэрэгжүүлэхээр ажиллаж байна. Эрдэнэт Үйлдвэрийн ээлжит зөвлөлийн хурлаас цэвэрлэх байгууламжийн өргөтгөлийн санхүүжилтэнд зориулан 1 сая еврогийн хөрөнгө шийдвэрлэж өгсөн бөгөөд энэхүү хөрөнгийг зураг төсөл барилга угсралт болон хайгуул судалгааны ажилд зориулан зарцуулж байна. Өнөөдрийн байдлаар Дегремент компани болон Инженерийн зураг төслийн хэлтэст зураг төсөл боловсруулах ажил дуусах шатандаа явж байна. 2011 онд тендерийг зарлах юм байна</p> <p style="text-align: center;">Хэрэгжиж байна 90%</p>
	<ul style="list-style-type: none"> • Улаанбаатар болон томоохон хотуудын агаарын бохирдлыг бууруулах асуудлаар хөтөлбөр, төлөвлөгөө боловсруулж хэрэгжүүлэх; 	<p>Гэр хорооллоос үүсэх агаарын бохирдолтыг бууруулах богино хугацааны хөтөлбөр боловсруулж, хэрэгжүүлэх ажлын хэсгийг аймгийн Засаг даргын 2010 оны 02 дугаар захирамжаар байгуулсан. Ажлын хэсэг нь 2010-2012 онд хэрэгжүүлэх богино хугацааны хөтөлбөр болон хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөний төслийг боловсруулан Засаг даргын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж, аймгийн ИТХ-ын 2010 оны 42 дугаар тогтоолоор батлуулав.</p> <p>Хөтөлбөр, төлөвлөгөөг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах ажлын хэсгийг аймгийн Засаг даргын 2010 оны 240 дүгээр захирамжаар Хотын захирагчийн албаны даргаар ахлуулсан 13 хүний бүрэлдэхүүнтэй байгуулсан бөгөөд ажлын хэсэг нь төлөвлөгөөнд тусгагдсан ажлуудыг хэрэгжүүлж эхлээд байна.</p> <p>Үүнд: Түлш болон халаалтын сүүлийн үеийн дэвшилтэт техник технологиудын талаар интернет ашиглан судалгаа хийж, орон нутагт нэвтрүүлэх боломжтой технологиудыг харьцуулан судалсны дүнд Улаанбаатарт үйл ажиллагаагаа явуулдаг “Дашваанжил” ХХК-ны худалдаалж байгаа “DAEWOO” гаазбойлер болон хананы цахилгаан халаагуурыг иргэдэд сурталчилж байна.</p> <p>Баян-Өндөр сумын гэр хорооллын багийн захиргааны байруудад Герман технологиор хийгдсэн цахилгаан халаагуурыг “Изо Хаус” ХХК-аас суурилуулсан бөгөөд уг халаалтын системийг Баянбулаг багийн нэр бүхий 3 иргэн хувийн</p>

		<p>байшиндаа суурилуулахаар захиалгаа өгөөд байна.</p> <p>“Хамтын илч” ХХК нь бүрэн шаталттай түлшний үйлдвэр байгуулах зорилгоор Герман улсад үйлдвэрлэсэн, өдөрт 1200 кг түлш үйлдвэрлэх хүчин чадалтай “SPANEX” технологийг нэвтрүүлж, 3645 ккал илчлэг бүхий утаа багатай шахмал түлшийг гарган иргэдийн хэрэгцээнд нийлүүлж эхлээд байна.</p> <p>Агаар бохирдуулагч хөдөлгөөнт эх үүсвэрүүдийн яндангийн утаанд СО-ийн хэмжээг тогтоох хэмжилтийн ажлыг аймгийн МХГ, ЦГ, УЦУОШАлбатай хамтран 2010 оны 03 дугаар сарын 20-ны өдөр нийтийн тээвэрт явдаг болон замын хөдөлгөөнд оролцож байгаа бензин хөдөлгүүртэй 100 автомашинд Япон улсын “ALTASS” маркийн багажаар хийсэн.</p> <p>Хэмжилтийн дүнгээс үзэхэд нийт хамрагдсан тээврийн хэрэгслийн 47.5% буюу 48 автомашин MNS 5013:2003 стандарт (1987 он хүртэлх 2.0-2.5 %, 1988-1990 он хүртэл 2.0 %, 1991-1995 он хүртэл 1.0-1.5 %, 1995 оноос хойш 0.5-1.0 %) -д заасан бензин хөдөлгүүртэй автомашины яндангийн утааны найрлаган дахь СО-ийн зөвшөөрөгдөх дээд агууламжаас давсан нь тогтоогдсон бөгөөд уг хэмжилт судалгааны дүнд мэргэжилтний дүгнэлт, цаашид авах арга хэмжээний саналыг гаргаад байна.</p> <p>Хотын төвд байрлалтай агаар бохирдуулагч суурин эх үүсвэрүүдийн тооллогоор 103 эх үүсвэр бүртгэгдсэнээс Зэст багт 6, Оюут багт 60, Уурхайчин багт 4, Хүрэн булаг багт 22, Бүрэнбүст, Уртбулаг багт 6, Согоот багт 5 байгаа бөгөөд Оюут, Хүрэн булаг багийн нутаг дэвсгэрт манаач, сахиул нэрээр буусан нийт 74 өрхөд байгаль орчны хяналтын Улсын байцаагчийн албан шаардлага хүргүүлж, нүүлгэн шилжүүлэх ажлыг аймгийн МХГ, Баян-Өндөр сумын ЗДТГ, хэсгийн цагдаа нартай хамтран зохион байгуулж, Оюут багаас 5, Хүрэнбулаг багаас 2 айлыг нүүлгэн шилжүүлсэн.</p> <p>Хотын агаарын бохирдолтыг бууруулах, хүн амын эрүүл мэндийг хамгаалах, идэвхитэй хөдөлгөөнийг дэмжих зорилгоор хотын төвд сар бүрийн эхний 7 хоногийн ням гарагийг “Автомашингүй өдөр” болгох аймгийн Засаг даргын 2010 оны 452 дугаар захирамж гаран хэрэгжилтэнд хяналтанд тавин ажиллаж байна.</p> <p style="text-align: right;">Хэрэгжиж байна 90%</p>
	<ul style="list-style-type: none"> хот, суурин газрын хатуу хог хаягдлыг цуглуулах, тээвэрлэх, хадгалах, ялган ангилах, дахин боловсруулах, 	<p>ХТГазар нь 2010 онд нийт 69550м³ ахуйн болон үйлдвэрлэлийн хуурай хог хаягдлыг дараах ангиллаар хүлээн аван түрж, дарж устгасан байна. Үүнд: ААН, байгууллагаас- 5180м³</p>

<p>эргүүлж ашиглах, байгальд халгүй аргаар устгахад шинэ технологи, менежментийн цогц бодлого хэрэгжүүлж, ажлын байр шинээр бий болгох;</p>	<p>Гэр хорооллоос-6936м³ Орон сууцны хорооллоос-29952м³ Эзэнгүй дүүргээс- 4960м³ Үйлчилгээний газруудаас-5998м³ Замын цэвэрлэгээнээс-1248м³ Өөрийн тээврээр хогийн цэг дээр буулгасан хогны хэмжээ-15276м³ тус тус байна. Аймгийн МХГ-тай хамтран зохион байгуулсан “Ахуйн болон үйлдвэрлэлийн хог хаягдлын тухай хууль”-ийн хэрэгжилтийн шалгалтанд хамрагдсан үйлдвэр, ААН-үүдэд хог хаягдлыг төрөлжүүлж, гарах хэмжээг тооцон бүртгэл хөтөлж байх шаардлага тавин ажилласан. Одоогийн байдлаар томоохон үйлдвэрүүд гарч байгаа нийт хаягдлаа ахуйн болон үйлдвэрлэлийн хог хаягдал гэж ангилан хотын төв хогийн цэгт тээвэрлэн хаяж байна. Аймгийн Засаг даргын 2009 оны 125 дугаар захирамжаар томилогдсон ажлын хэсэг хог хаягдлын менежментийг боловсронгуй болгох хөтөлбөр боловсруулж, аймгийн Засаг даргын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж, хөтөлбөрийн үйл ажиллагааны төлөвлөгөөг ИТХ-ын Тэргүүлэгчдийн хурлаар батлуулсан бөгөөд 2010 оноос судалгаа шинжилгээ болон зохион байгуулалтын ажлуудыг хэрэгжүүлж эхлээд байна. Хог хаягдлын менежментийг сайжруулах хөтөлбөрт хог хаягдлыг булшлах “Ландфиль”-ийн аргыг 2012 онд хэрэгжүүлэхээр төлөвлөн байнгын ажиллагаатай диспетчерийн байршлийг өөрчлөн нүүлгэж, өвлийн байртай болгон тохижуулснаас гадна бульдозерийн гараж шинээр барьж ашиглалтанд оруулсан байна. Хог хаягдлын нэгдсэн цэгийн эргэн тойрны хаягдлыг 1.5-2 км-ийн радиуст цэвэрлэж дотогш нь хумиж цэвэрлэсэн. Хогийн цэгийн дотор талд болон орчинд нь байгаа хуучин карьерийн нүхийг хог хаягдлыг дарж устгахад ашиглах зорилгоор тойруулан талбай гаргаж байна. Хэрэгжиж байна 90%</p>
	<p><i>Стратегийн зорилт 3. Усны нөөцийг бохирдол, хомсдолоос хамгаалах, зохистой ашиглах, хүн амыг эрүүл ахуйн шаардлагад нийцсэн усаар хангах нөхцөлийг бүрдүүлнэ. “Ус” үндэсний хөтөлбөр хэрэгжүүлнэ:</i></p>
<p>• усны нөөцийг хамгаалах, зохистой ашиглах харилцааг зохицуулах эрх зүйн</p>	<p>Аймгийн ЗДТГазрын даргын 95 дугаар тушаалаар үнийн харьцуулалтаар сонгон шалгаруулах комисс Жаргалант сумын ЗДТГазрын Байгаль орчны</p>

	<p>орчинг боловсронгуй болгож, ус хэмнэх усны нөөцийн менежмент, бүтэц, зохион байгуулалтыг сайжруулах;</p>	<p>хэсгийг шалгаруулан гэрээ байгуулж, БОАЖЯамаар баталгаажуулж, Жаргалант сум дахь Хонгор морьт, Даршт I, II булгуудыг чулуун суурьтай модон хашлагаар хамгаалж тохижууллаа.</p> <p>2010 онд “Цэвэр орчин бүрдүүлэх” жилийн хүрээнд БОАЖГазраас тавьсан саналын дагуу Хүрэнбулагийн рашааныг “Эрдмин” ХХК хамгаалж тохижуулан Баян-Өндөр суманд хүлээлгэн өгсөн.</p> <p>Баянцагаан багийн нутаг дэвсгэрт орших Далиу булгийн эхийг хамгаалахаар 775 м² талбайд төмөр хайс хашлагыг Баян-Өндөр сумын Байгаль орчныг хамгаалах зөвлөл хийж, шинэс, улиас, бургас зэрэг 850ш мод, бургасыг тарьж ургуулаад байна..</p> <p style="text-align: center;">Хэрэгжиж байна 90%</p>
	<p>• гадаргын усны тодорхой хэсгийг аж ахуйн эргэлтэнд оруулан арвижуулах замаар хүн ам, үйлдвэрлэлийн усан хангамжийг шийдвэрлэх;</p>	<p>Гадаргын усны тооллогыг 9 дүгээр сард зохион байгуулсан бөгөөд тооллогоор гол горхи-4, булаг-19, рашаан-3, нуур тойром-4, нийт 30 цэг тооллогот хамрагдаж, бүртгэл судалгааг шинэчилсэн байна. Гадаргын усны ашиглалтыг сайжруулах зорилгоор Жаргалант сумын Хавчиг, Урд булаг, Урт зэрэг газруудад газар тариалангийн зориулалтаар хөв цөөрөм барих саналаа БОАЖЯаманд хүргүүлсэн.</p> <p>Аймгийн ИТХ-ын 26 дугаар тогтоол, аймгийн Засаг даргын 140 дугаар захирамжаар батлагдсан “Хүн амын ус хангамжийн одоогийн байдал, түүний нөөц эх үүсвэрүүд, тэжээмжийн байдал” удирдамжийн дагуу ажлын хэсэг 5 дугаар сарын 3-наас 10-ны хооронд “Эрдэнэт Үйлдвэр” ХХК-ний Баяжуулах фабрик, эрчим хүчний цехийн ус татах насосууд, “Эрдэнэт-Ус ДТСүлжээ” ОНӨХК, “Эрдэнэт-Амьдрал” ОНӨХК, хотын усан сангууд, аймгийн цэвэрлэх байгууламжууд, гэр хорооллын ус түгээх байруудын үйл ажиллагаанд хяналт шалгалт хийсэн байна. Шалгалтын үр дүнг аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2010 оны 10 дугаар сарын 06-ны өдрийн хурлаар хэлэлцүүлэн хүн амын усан хангамжийн талаар авах арга хэмжээний тухай 100 дугаар тогтоолыг батлуулаад байна</p> <p style="text-align: center;">Хэрэгжиж байна 90%</p>
	<p>• хотуудыг болон уул уурхайн</p>	<p>2010 онд гүний ус ашиглах 12 иргэн, 12 аж ахуйн нэгж, байгууллагатай гэрээ</p>

<p>үйлдвэрлэлийг хэрэгцээт усаар хангах усны нөөцийг нэмэгдүүлэх.</p>	<p>байгуулсан бөгөөд усны төлбөрт нийтдээ 2717.5 мян.төгрөгийг орон нутгийн төсөвт, “Эрдэнэт үйлдвэр” ХХК нь Булган аймагт 1844.5 мян.төгрөгийг тус тус төвлөрүүлээд байна.</p> <p>“Эрдэнэт үйлдвэр” ХХК Сэлэнгэ-Эрдэнэтийн ус дамжуулах байгууламжийн 2, 3, 4 дүгээр өргөх станц дээр Япон улсын Эбара маркийн насос тус бүр 3-ыг суурилуулж станцуудын хэвийн ажиллагааг хангаж, ус дамжуулах байгууламжийн усны эх үүсвэрийг нэмэгдүүлэх зорилгоор 4ш гүний худгийн өрөмдлөгийн ажлыг хийж дуусган, барилгын ажлыг хийж байна.</p> <p style="text-align: center;">Хэрэгжиж байна 90%</p>
<p><i>Стратегийн зорилт 4. Ойн нөөцийг тогтвортой ашиглаж, ой хамгаалах, нөхөн сэргээх, экологийн тэнцвэрийг хадгалах нөхцөлийг хангана:</i></p>	
<p>• ойн санд сансрын мэдээ ашиглаж, зайнаас тандан судлах аргаар хайгуул, судалгаа хийж, тархалт, бүтэц, бүрэлдэхүүнийг тогтоон ойн зураглал, ойн тогтвортой менежментийн хөтөлбөр боловсруулж, газар зүйн мэдээллийн тогтолцоонд суурилсан ойн мэдээллийн сан байгуулах;</p>	<p>2009 онд аймаг болон сумдын ойн сангийн менежментийн төлөвлөгөөг 5 жилийн хугацаагаар боловсруулж Байгаль орчин, аялал жуулчлалын сайд, улсын Ойн газрын даргаар тус тус батлуулан ажиллаж байна.</p> <p>Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Ойн газраас зарласан Орхон аймгийн Баян-Өндөр, Жаргалант сумдын ойн санд ой зохион байгуулалтын ажил хийх ОГ-2010.ОЗБ-6/21-3 тендерт “Гурван сээр” ХХК оролцон шалгарч, ойн сангийн талбай, нөөц, таксацын үндсэн үзүүлэлтүүд тэдгээрийн өөрчлөлтийг судлан тогтоож ойн нөөцийг хамгаалах, зохистой ашиглах, нөхөн сэргээх үндэслэлийг тогтоох зорилгоор 2010 онд тус аймгийн ойн санд ой зохион байгуулалтын ажлыг хийж гүйцэтгэсэн байна.</p> <p style="text-align: center;">Хэрэгжиж байна 90%</p>
<p>• стратегийн дунд хугацааны зорилтын хүрээнд уур амьсгалыг зөөлрүүлж, цөлжилт, хөрсний эвдрэл, түйрэн, элсний нүүдэлтэй тэмцэх зорилгоор ойг нөхөн сэргээх, говь, хээрийн бүсэд мод тариалж ногоон зурвас байгуулах;</p>	<p>Улсын төвлөрсөн төсвийн хөрөнгөөр 2010 онд Жаргалант сумын нутаг “Хойт булаг”-ийн аманд 25 га-д 62.5 мян.ш шинэсний 2 настай тарьцаар, “Хонгор морьт”-ийн аманд 5 га-д хайлаасны 12.5 мян.ш тарьцаар тус тус ойжуулалтын ажлыг гүйцэтгэж, Сархиа ууланд 2500 ш 4 төрлийн өсвөр мод шилжүүлэн суулгаж ургуулаад байна.</p> <p style="text-align: center;">Хэрэгжиж байна 90%</p>

	<ul style="list-style-type: none"> • ой хамгаалах ажилд дэвшилтэт менежментийн арга хэлбэрийг нэвтрүүлж, ойн сангийн 20 хүртэлх хувийг нутгийн иргэд, нөхөрлөлд гэрээгээр эзэмшүүлэн ойг хамгаалах, нөхөн сэргээх, зохистой ашиглах хариуцлагын тогтолцоо бүрдүүлэх. 	<p>Аймгийн хэмжээнд Засгийн газрын 227 дугаар тогтоолоор батлагдсан журмын дагуу ойн санг 8 иргэдийн нөхөрлөл, 2 ААН-д гэрээгээр эзэмшүүлэх ажлыг зохион байгуулаад байна. Аймгийн нийт ойн сангийн 34.6 хувь буюу 6160 га талбай бүхий ойн санг дээрхи иргэдийн нөхөрлөл, ААН-д гэрээгээр эзэмшүүлснээр ойн сан эзэндээ ойртож хамгаалалт нь сайжирсан байна.</p> <p>Хэрэгжиж байна 90%</p>
ДОЛОО. ЭРХ ЗҮЙ, ТӨРИЙН БАЙГУУЛАЛЫН ХӨГЖЛИЙН БОДЛОГО		
7.1 Эрх зүйн шинэтгэл Бүх үе шат (2007-2021 он):		
<i>Стратегийн зорилт 1. Төрийн институцүүдийг чадавхжуулж, төрийн үйлчилгээг ил тод, хүртээмжтэй болгох эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгоно:</i>		
	<ul style="list-style-type: none"> • төрийн үйлчилгээг хүртээмжтэй, ил тод болгох; 	<p>Монгол улсын Ерөнхийлөгчийн “Нээлттэй хаалганы өдөр”-ийг зохион байгуулж байх тухай 2007 оны 97 дугаар зарлиг, Монгол улсын Засгийн газрын 2007 оны 190 дүгээр тогтоол, 13 дугаар албан даалгаварын мөрөөр төрийн бодлого боловсруулах, шийдвэр гаргахад аймгийн хэмжээнд иргэдийн санал, хүсэлтийг сонсож, бодлого шийдвэрт тусгах, хэрэгжүүлэх, төрийн байгууллагаас хийж буй ажлыг сурталчлах, төрийн үйлчилгээг иргэдэд шуурхай хүргэх зорилгоор төрийн байгууллагуудад “Нээлттэй хаалганы өдөр”-ийг зохион байгуулах журам, хуваарийг батлан хэрэгжилтэнд хяналт тавин ажиллаж байна. “Нээлттэй хаалганы өдөр”-ийн арга хэмжээний үеэр аймгийн хэмжээнд давхардсан тоогоор нийт 4120 иргэнээс санал хүсэлт хүлээн авч 3985 иргэний хүсэлтийг нь шийдвэрлэн хариу өгсөн ба 135 иргэний санал хүсэлтийг төв болон орон нутгийн байгууллагуудад уламжилж цаашид төр засгийн бодлого, үйл ажиллагаандаа тусган хэрэгжүүлэхээр ажиллаж байна.</p> <ul style="list-style-type: none"> - Хөдөлмөр, нийгмийн халамжийн чиглэлээр – 1862 - Иргэний бүртгэл мэдээллийн чиглэлээр - 828 - Хууль, хяналтын чиглэлээр - 119 - Татвартай холбогдолтой асуудлаар - 94 - Эрүүл мэндийн чиглэлээр - 148 - Нийгмийн даатгалын чиглэлээр - 72

		<ul style="list-style-type: none"> - Боловсролын салбарын чиглэлээр - 163 - Хөдөө аж ахуй, байгаль орчны асуудлаар - 64 - Үйлдвэрлэл, үйлчилгээ, дэд бүтцийн чиглэлээр – 286 - Газрын асуудлаар – 182 - Нийтийн тээврийн чиглэлээр - 70 - Бусад асуудлаар - 232 <p>Мөн нийтийн тээврийн чиглэлээр иргэдээс гарсан санал шүүмжлэлийн мөрөөр ахмадын унааг Жаргалант суманд 7 хоногт 2 удаа, Эрдэнэ багт 1 буудал сунган, нийтийн тээврийн унааг Дэнж, Говил, Баянцагаан багт маршрутыг уртасгаж, Хабитат, Зээлийн чиглэлд шинээр нээн явуулах арга хэмжээ авч, гэрийн хорооллын нийтийн тээврийн унааны эцсийн буудалд өглөө, орой зорчигч урсгал их үед диспетчер ажиллуулж байна.</p> <p>Аймаг, сумдын Засаг даргын Тамгын газрын “Иргэд хүлээн авах байр”-ыг ажиллах журмын дагуу тогтмол ажиллуулан тус байран дахь хууль эрх зүйн санд байнга баяжилт хийж иргэдийг цаг үеийн болон хууль эрх зүйн мэдээлэл авах, санал хүсэлтээ биечлэн ирж болон Иргэд хүлээн авах байрны утсаар илэрхийлэх боломжоор ханган өргөдөл, хүсэлтийг шуурхай шийдвэрлэж байна. Тайлангийн хугацаанд аймгийн ЗДТГ-ын Иргэд хүлээн авах байраар нийт 512 иргэн үйлчлүүлснээс аймгийн удирдлагууд нийт 149 иргэнийг биечлэн хүлээн авч уулзан өргөдөл, санал, хүсэлтийг нь хүлээн авч, шийдвэрлэж хариу өгөв. Мөн аймгийн ЗДТГ-ын дэргэдэх Нэг цонхны үйлчилгээний төвөөр хөдөлмөр халамж, газрын харилцаа, нийгмийн даатгал, банк, нотариат болон бизнес эрхлэгчдэд мэдээлэл, зуучлалын үйлчилгээг үзүүлж иргэдийн санал хүсэлтийг хүлээн авч шийдвэрлэж ирсэн ба тайлангийн хугацаанд давхардсан тоогоор нийт 45442 иргэн үйлчлүүлээд байна.</p> <p>Тайлангийн хугацаанд аймаг, сумдын Засаг даргын Тамгын газар болон хэлтэс, албадууд, төрийн чиг үүрэг бүхий байгууллага, ажилтанд нийт 14121 өргөдөл, гомдол ирсний 2808 нь шийдвэрлэх хугацаа болоогүй, 11313 буюу 80,1 хувь нь хуулинд заагдсан хугацаанд шийдвэрлэгдсэн байна.</p>
--	--	---

		<p>Дээрх өргөдөл, гомдлын 270 нь гомдол, 13851 нь өргөдөл, хүсэлт байна. Ирсэн гомдлын ихэнх хувь нь худалдаа үйлчилгээ, газрын маргаан, цахилгаан эрчим хүч, хувийн хэвшлийн байгууллагууд цалин хөлсийг дутуу олгодог ба олгодоггүй, орон сууцны дээврээс ус гоожиж байгаа болон дээд давхрын айлаас ус алдсан, тухай гомдол байна.</p> <p>Шийдвэрлэх хугацаа болоогүй хүлээгдэж байгаа өргөдлүүдийн ихэнх нь шинээр газар олгож өгөхийг хүссэн өргөдлүүд эзэлж байна. Баян-Өндөр суманд шинээр олгох газар байхгүй тул тус онд шинээр газар олгож өгөхийг хүссэн иргэдэд энэ тухай тайлбарлаж өргөдлийг нь бүртгэн дараалалд авлаа. Цаашид хашааны газрын асуудлыг шийдвэрлэх талаар Булган аймагтай хамтран ажиллах төлөвлөгөөнд тусган ажиллаж байна.</p> <p>Нийт ирсэн өргөдөл гомдлыг өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 2179 өргөдлөөр буюу 18,2 хувиар өссөн байна. Ирсэн өргөдөл гомдлыг агуулга тус бүрээр нь шинжлэн үзэхэд иргэний бүртгэл мэдээлэлтэй холбогдолтой өргөдөл 2 дахин өссөн байна. Энэ нь улсын хэмжээнд иргэний шинэчилсэн бүртгэл явагдаж байгаатай холбогдон иргэд шилжилт хөдөлгөөн хийлгэх, бичиг баримтын зөрчлөө арилгах зэрэг арга хэмжээ авч байгаатай холбоотой гэж үзэж байна. Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлын шийдвэрлэлтэнд хяналт шинжилгээ үнэлгээ хийж дүнг аймгийн Засаг даргын дэргэдэх зөвлөлийн хуралд хэлэлцүүлэн хуралдаанаас өгөгдсөн холбогдох үүрэг даалгаварын хэрэгжилтэнд хяналт тавин ажиллаж байна.</p> <p style="text-align: center;">Хэрэгжиж байна 90%</p>
	<ul style="list-style-type: none"> • төрийн захиргааны байгууллагаас гаргах эрх зүйн актын боловсруулалтыг шинжилгээ судалгааны үндэстэй, системтэй болгох; 	<p>Төрийн захиргааны байгууллагаас гаргах эрх зүйн актын боловсруулалтыг шинжилгээ судалгааны үндэстэй, системтэй болгох ажлын хүрээнд, Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 866 тогтоол, Засаг даргын 5847 захирамжийг гар болон цахим сандаа бүртгэн авч, “Эрх зүйн мэдээллийн нэгдсэн систем” болон, “Төрийн мэдээлэл”, “Хууль зүйн мэдээлэл” сэтгүүл, гар санг ашиглан мэдээлэл, лавлагаагаар үйлчилж байна. Хууль тогтоомжийн бүртгэл-лавламжийн сангаас 91 байгууллага, аж ахуйн нэгж, 1011 иргэнд анхан шатны зөвлөгөө, лавлагаа өгч, Хэлтэс, агентлагуудын үйл ажиллагаанд мөрдөж байгаа аймгийн ИТХ, ИТХТ</p>

		<p>болон Засаг даргын захирамжаар батлагдсан 8 дүрэм, журмуудын төслийн хууль зүйн үндэслэлийг хянан, аймгийн Засаг даргаас 2010 онд гаргасан 549 захирамжийг төслийн шатанд нь хууль тогтоомжид нийцэж байгаа эсэхийг хянаж, захирамжийн төсөлд санал дүгнэлт өгч, хууль тогтоомжид нийцүүлсэний дээр Баян-Өндөр, Жаргалант сумдын Засаг дарга нарын 1400 захирамжийг хянаж, 10 захирамжийг хуульд заасан бүрэн эрхийн хүрээнд хуульд нийцүүлэн гаргуулсан. Лавламжийн сангийн хадгалалт хамгаалалтыг сайжруулах зорилгоор Эрх зүйн туслалцааны танхимын дэргэд жижиг өрөөг тохижуулж, үйл ажиллагаа нь жигдэрсэн, санд тухай бүр тодотгол, нэмэлт өөрчлөлтүүдийг хийн ажиллаж байна.</p> <p style="text-align: center;">Хэрэгжиж байна 90%</p>
	<p><i>Стратегийн зорилт 2. Хүний эрхийг баталгаатай хангана:</i></p>	
	<ul style="list-style-type: none"> • хүний эрх, эрх чөлөөг хангахад шууд үйлчилдэг тогтолцоог төрийн эрх мэдлийн хуваарилалтыг тэнцвэржүүлэн төгөлдөржүүлэх замаар боловсронгуй болгоно; 	<p>Төрийн байгууллагуудад, “Иргэд хүлээн авах байр”-г журмын дагуу ажиллуулж иргэдэд цаг үеийн болон хууль эрхзүйн мэдээлэл авах, санал хүсэлтээ чөлөөтэй илэрхийлэх, иргэдтэй харьцах харилцаанд хүний эрхийг зөрчихгүй байх өргөдөл, гомдол, санал хүсэлтэд хуулийн хугацаанд хариу өгөх зэрэг ажлууд тогтмолжиж байна.</p> <p>Хэлтэс, газар, албадууд төрийн үйлчилгээг ард иргэдэд хүртээмжтэй хүргэхэд өөрсдийн чиг үүргийн хүрээнд ТББ-тай хамтран ажиллаж байна “Хүний эрхийг хангах үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд ТББ н оролцоо” сэдэвт чуулга уулзалтанд оролцогчдоос гаргасан санал, хүсэлтийг нэгтгэсэн зөвлөмжийн хүрээнд хэрэгжүүлж хийсэн ажлын тайланг хүргүүлсэн. Сургалт сурталчилгаа, мэдээлэл судалгааны “Машид гэрэлтэх нийгэмлэг” ТББ-тай хамтран ЕБС-н төгсөх ангийн сурагчдад хүүхдийн эрхийн тухай, олон улсын конвенц, үндэсний хууль тогтоомжууд, хүүхдээс гэмт хэрэг зөрчилд холбогдож шийтгүүлсэн талаарх мэдээлэл, уулзалт ярилцлагыг зохион байгуулж, харилцан санал солилцсон бөгөөд, уг арга хэмжээнд 890 гаруй хүүхэд оролцсон үр дүнтэй ажил болсон бөгөөд 150,0 мянган төгрөгийн хөрөнгийг зарцуулсан байна.</p> <p>Дэлхийн зөн олон улсын байгууллагатай, хүүхдийн эрхийг хамгаалах чиглэлээр хамтран ажиллаж байна. Энэ ажлын хүрээнд насанд хүрээгүй хүмүүсээс</p>

	<p>байцаалт авах, санал бодлыг нь сонсох, эрхзүйн туслалцаа үзүүлэх, зориулалт бүхий өрөө тасалгаа байгуулж, уг өрөөнд насанд хүрээгүй 5 хохирогчид таниулга хийлгэж, нийт 85 хүүхэд тэдний эцэг эх, асран хамгаалагчид сэтгэл зүйн болон эрх зүйн зөвөлгөөг өгч ажилласан. Хүүхдийн эрхийн тухай НҮБ-н конвенцийг хэрэгжүүлэх, хүүхдийн эрхийг хамгаалах тухай Монгол Улсын хууль тогтоомж, шийдвэрийг хэрэгжүүлэх зорилгоор Аймгийн хууль хяналтын байгууллагуудтай хамтран ажиллаж байна.</p> <p>Аймгийн Засаг даргын захирамжаар төрийн захиргааны, байгууллагуудад, хууль тогтоомж, засгийн газрын шийдвэрийн хэрэгжилтийн байдалд, хяналт шинжилгээ үнэлгээг хийсэн. Хяналт шалгалтын явцад Хууль зүйн хэлтсээс тусгай удирдамжийн дагуу, Эрх зүйн ажлын төлөвлөгөө, түүний биелэлтийн байдал, Хүний эрх, Авлигын эсрэг хууль, хөтөлбөрийн хэрэгжилтийн хүрээнд шударга ёс, ил тод шалгуур үзүүлэлтийг хангах төлөвлөгөөний дагуу зохион байгуулж хийсэн ажил, удирдлагаас гарч буй эрх зүйн актын хууль зүйн үндэслэл зэрэгтэй танилцан зөвлөмж зөвөлгөө өгч ажиллалаа. Хяналт шалгалтанд төрийн 23 байгууллага хамрагдав.</p> <p>Мөн аймгийн Эрхзүйн туслалцааны төв, ХТХ, Цагдаагийн газар, Шүүх, Хуульч эмэгтэйчүүдийн холбоо” ТББ-тай хамтран хүн худалдаалах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр 3 удаагийн сургалт, ярилцлага, хэлэлцүүлгийг хуульчид болон иргэдийн дунд зохион байгуулж, энэ ажлын хүрээнд өсвөр насны охидыг садар самуунд уруу татагдах, бэлгийн хүчирхийлэлд өртөхөөс урьдчилан сэргийлэх, тэдний хууль эрхзүйн мэдлэгийг дээшлүүлэх зорилгоор ЕБС –н 8-11-р ангийн сурагч охидын дунд “Би охин нас, нэр, биеэрээ гоёх дуртай” сэдэвт нээлттэй хэлэлцүүлэгийг зохион байгуулж, хууль хяналтын байгууллагуудын эмэгтэй ажилтнуудыг урьж, тэдэнд зөвлөмж зөвөлгөөг өгч, ЕБС –н төлөөлөл 500 гаруй охид хамрагдав.</p> <p>”Хүүхэд насаа хайрлая” сэдэвт 4-р зөвлөгөөнөөс гаргасан шийдвэрийг орон нутагт хэрэгжүүлэх зорилгоор Аймгийн хэмжээнд “Насанд хүрээгүй хүмүүсийг гэмт хэрэг хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, хэрэгт холбогдсон, гэмт</p>
--	---

	<p>хүчирхийллийн улмаас хохирсон хүүхдийг нийгэмшүүлэхэд тулгамдсан асуудал” сэдэвт зөвөлгөөнийг 2010 оны 05-р сарын 04-ний өдөр зохион байгуулж, хурал, төр захиргааны байгууллагын дарга, ГХУСАЗЗ н дарга, болон холбогдох хууль хяналтын байгууллагын удирдлагууд, хэлтэс, агентлаг, албад, төсвийн байгууллагын удирдлагууд болон ажилтан албан хаагчид, нийт 150 гаруй хүн оролцож, энэ талаархи хийж буй ажлын тухай болон цаашид төлөвлөн хийж, хэрэгжүүлэх үйл ажиллагааны талаар холбогдох илтгэлүүд хэлэлцүүлэв.Тус зөвөлгөөнөөс зөвлөмж гарган төрийн захиргааны байгууллагуудад хүргүүлэн чиглэл тус бүрээр ажил зохион байгуулахаар боллоо. Уг арга хэмжээнд 700,0 мянган төгрөгийн хөрөнгийг зарцуулсан байна. Хүний эрхийг хангах үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах ажлын чиглэлээр төрийн болон төрийн бус байгууллагатай хамтран 15 удаагийн уулзалт ярилцлага, сургалт зөвөлгөөнийг зохион байгуулж, гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх талаар тус байранд хүмүүжигч 170 хүнд 4 удаа яриа таниулга хийсэн байна. Аймгийн Хүүхдийн төлөө хэлтэс, Шүүх, Цагдаагийн газар, Аймаг дахь эмэгтэйчүүдийн эрхийг хамгаалах байгууллага, хамтран Охид эмэгтэйчүүдийн эрх, тэднийг бэлгийн мөлжлөгөөс хамгаалах талаар Баян-Өндөр сумын нийт 19 багийн хэсгийн ахлагч, төрийн ухуулагч нарын дунд нээлттэй хэлэлцүүлэг, ярилцлагыг зохион байгуулж 80 гаруй хүн хамрагдаж харилцан санал солилцов.</p> <p>Өнгөрсөн онд “Хүний эрх”-ийн өдрийг угтаж 12 дугаар сарын 01-ны өдөр хууль хяналтын байгууллагуудын удирдах ажилтнууд иргэдтэй уулзалт, ярилцлага зохион байгуулж, Өмгөөлөгч үнэ төлбөргүй зөвлөгөө, туслалцаа үзүүлсэн бөгөөд хүний эрхийг хангах үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажилд идэвхи, санаачлага гарган ажилласан нэр бүхий 6 хүнийг шагнаж, урамшуулахад салбар хорооны төсвөөс 487.0 мянган төгрөг зарцуулав. 2010 оны 09-р сард Өмгөөлөгчид эрхзүйн туслалцааны танхимаар үнэ төлбөргүй хуульзүйн зөвлөгөөг 2 өдрийн турш зохион байгуулж 40 гаруй иргэн хамрагдсан байна. “Архидалт мансуурлын эсрэг ассоциацтай хамтран эрүүлжүүлэн баривчлах байранд хүмүүжигсдийн эрх зөрчигдөж байгаад хяналт тавьж, 35 хүнд хүний эрх,</p>
--	--

		<p>хүчирхийллэл, ухаархуй сэдвээр сургалт зохион байгуулж, 140ш гарын авлага, материалыг тарааж ашиглуулсан байна.</p> <p>Хүний эрхийн өдрийг угтан хүний эрхийн чиглэлээр зохион байгуулан хийж байгаа ажлын талаар "Хууль зүйн мэдээ" сонины нэг дугаарыг эрхлэн гаргаж, 1500ш-г хэвлүүлж сурталчлах ажлыг зохион байгуулав.</p> <p>Хөдөлмөрийн харилцаа-Хүний эрх" сэдэвт богино хэмжээний киног Хуулийн цаг нэвтрүүлгээр гаргаж, Хөдөлмөрийн хуулийг сурталчилж байна. Кино бүтээхэд өнгөрсөн онд Хүний эрхийг хангах салбар хорооны зардлаас 205.0 мянган төгрөг тус тус зарцуулсан юм.</p> <p>Эрүүлжүүлэх, баривчлах байранд хүмүүжигсдийн эрх зөрчигдөж байгаад хяналт тавих ажлын хүрээнд хүмүүжиж буй 158 хүнд хүний эрхийн талаар, архины хор хөнөөл болон гэр бүлийн хүчирхийлэл, бэлгийн мөлжлөгөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр яриа хийн сургалт явуулсан байна. Эрүүлжүүлэх байрны эрүүл ахуйн нөхцлийг сайжруулах, эрүүлжүүлэх баривчлах байрны засварын зардалд зориулан Засаг даргын 2009 оны 07 дугаар сарын 09-ны өдрийн 250 дугаар захирамжаар 2.5 сая төгрөгийг орон нутгийн бусад зардлаас гаргасан. Эрүүлжүүлэн баривчлах байранд хяналтын камер суурилуулан ажиллаж байна. Эрүүлжүүлэн баривчлах байрыг шинээр барих ажлыг Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрт тусган уг ажилд одоогоор 200,0 сая төгрөг зарцуулсан ба цаашид үргэлжлүүлэн барих төсөв хөрөнгийг 2011 оны төсөвт тусгуулсан.</p> <p style="text-align: center;">Хэрэгжиж байна 90%</p>
	<ul style="list-style-type: none"> • бусдын хууль бусаар учруулсан хохирлыг нөхөн төлүүлэх эрх зүйн орчинг бүрдүүлэх; 	<p>Хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын шатанд хохирол нөхөн төлүүлэх ажиллагааг эрчимжүүлж, хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагчын ажлыг дүгнэх гол үзүүлэлт болгон ажилласан. Гэмт хэргийн улмаас нийт учирсан хохирол 988.3 сая төгрөг, үүнээс иргэдэд учруулсан хохирол 798.3 сая төгрөг, нөхөн төлүүлсэн хохирол 477.5 сая төгрөг, байгаа бөгөөд хохирол нөхөн төлүүлэлтийн хувь 48,3 хувьтай байна.</p> <p>Энэ онд Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн шатанд үлдэгдэл 1706 төлбөр,</p>

		<p>тэтгэлэгийн гүйцэтгэх баримт бичгийн 1458721,7 мянган төгрөгийн төлбөр, тэтгэлэг дээр шинээр 4823375,3 мян төгрөгийн үнийн дүнтэй 865 гүйцэтгэх баримт бичгийг хүлээн авч нийт 2484 гүйцэтгэх баримт бичгийн 15901161,3 мян төгрөгийн материалд шийдвэр гүйцэтгэх ажиллагаа явуулсан байна. Жилийн эцсийн байдлаар 2596800.4 мянган төгрөгийн үнийн дүнтэй 677 гүйцэтгэх баримт бичгийг дуусгавар болгон хааж, гүйцэтгэх баримт бичгийн бодит биелэлт 27 хувьтай, мөнгөн дүнгийн бодит биелэлт 44.0 хувьтай байна. Төлбөрийн гүйцэтгэх хуудсыг өмнөх оны мөн үетэй харьцуулахад гүйцэтгэх баримт бичгийн бодит биелэлт 3 хувиар өсч, мөнгөн дүнгийн биелэлт 19 хувиар өссөн үзүүлэлттэй гарсан. Шийдвэр гүйцэтгэгчийн буруутай үйл ажиллагааны улмаас үүссэн хохирол төлбөрийг буруутай албан тушаалтнаас нөхөн гаргуулж, урамшууллаас суутгах, шүүхэд нэхэмжлэл гаргах ажлын хэсгийг албаны даргын 2010 оны 06-р сарын 11 ны өдрийн А/32 тоот тушаалаар 4 хүний бүрэлдэхүүнтэйгээр томилон ажиллаж, анхны хурлаар шийдвэр гүйцэтгэгчийн буруутай ажиллагааны улмаас иргэн О.Намжилийн нэхэмжлэлийн дагуу шүүхийн шийдвэрээр төлсөн 11700.0 мян төгрөгийг буцаан төлүүлэх асуудлыг хэлэлцэж, тухайн үед ажиллаж байсан холбогдох албан тушаалтнуудын хаягийг олж тогтоох, биечлэн уулзах чиглэлээр ажлын хэсгийн гишүүдэд үүрэг өгч ажиллаж байна.</p> <p>Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн шатанд биелүүлбэл зохих 2381094627 төгрөгийн үнийн дүнтэй 1632 гүйцэтгэх баримт бичгийн материалаас 995043010 төгрөгийн үнийн дүнтэй 696 гүйцэтгэх баримт бичгийн 1386051617 төгрөгийн үлдэгдэлтэй байна. Төлбөрийн бодит биелэлт 42 хувьтай, гүйцэтгэх баримт бичгийн бодит биелэлт 43 хувьтай байна.</p> <p style="text-align: center;">Хэрэгжиж байна 90%</p>
	<ul style="list-style-type: none"> • хүний эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхийг хангах; 	<p>Иргэдийн эрүүл, аюулгүй орчинд ая тухтай амьдрах эрхийг хангах ажлын хүрээнд Гэр хорооллын орчныг сайжруулах, хөрсний бохирдлыг багасгах, хог</p>

		<p>хаягдлын менежментийг боловсронгуй болгох чиглэлээр дараах ажлууд хийгдсэн байна. Үүнд:</p> <p>Хөрсний бохирдолт хүн амын нягтрал суурьшил ихтэй газруудад их байгаа чир 2010 оныг “Цэвэр орчин бүрдүүлэх жил” болгон энэ ажлын хүрээнд хотын ногоон байгууламжийг нэмэгдүүлж, АЗДТГ, “Хамтдаа инээмсэглэл” ТББайгууллага, Солонгосын эмч нарын багтай хамтран хүнсний зах, худалдааны төв, мах боловсруулах үйлдвэрүүдийн хөрсны ариутгал халдваргүйтгэл, бүх нийтийн их цэвэрлэгээ тогтмол хийж ирлээ. Хотын төвд нийтийн бие засах газрыг нэмэх шаардлагатай ба гэр хорооллын жорлон, муу усны нүхны авгалдай устгал хангалттай хийгдэж чадахгүй байна. Хотын ойр орчимд хүн амын ундны усны эх үүсвэрийн хайгуул хийж худаг барих зорилгоор Чех улсаас хэрэгжүүлж буй төслийн хүрээнд 23 ш гүний худаг гаргаж, 8 худгийн хайгуулын ажлыг хийж гүйцэтгэсэн. 2010 онд орон нутгийн төсвийн хөрөнгөөр Эрдэнэ багт /Шинэ Хабитат/- 1ш ус түгээх цэгийн байрыг “Тод жаргал” ХХК гүйцэтгэсэн.</p> <p>2010 оны бүх нийтээр мод тарих ажлын хүрээнд гэр хороололд хашаандаа мод, бут тарьсан иргэдийн судалгааг албан ёсоор гаргуулан авч, БОАЖГ, МХГ, ХТГ, Баян-Өндөр сумын холбогдох мэргэжилтнүүдийн бүрэлдэхүүнтэй ажлын хэсэг багийн дарга нарыг нь байлцуулан шалгаруулалт хийж, урамшуулалд хамруулах 200 гаруй иргэдийн жагсаалтыг гарган “Ногоон байгууламжийг нэмэгдүүлэх ажлыг зохион байгуулах төв комисс”-т танилцуулсны эцэст газар дээр нь шалгаж шалгаруулах 4 хүний бүрэлдэхүүнтэй ажлын хэсэг томилогдсон. Ажлын хэсэг нь өрхүүдээр явж шалгасны үндсэн дээр 44 өрх айлыг шалгаруулан 1716.0 мян.төгрөгөөр шагнаж урамшуулан нийтэд сурталчилснаар иргэдийн хашаандаа мод тарих идэвхи санаачилга нэмэгдэж байна.</p> <p>АХБанкны санхүүжилтээр хэрэгжүүлж буй МОН-2301 төслийн хүрээнд гэр хорооллын усан хангамжийг сайжруулах шугам барих, усан сантай болгох ажлын зураг хийгдэж гүйцэтгэгчийг шалгаруулсан барилгажилтын ажил 2011 онд явагдахаар төлөвлөгдсөн ба уг төслийн хүрээнд Цагаанчулуут, Шанд Рашаант, Наран, Их залуу багууд бүрэн, Эрдэнэ, булаг багуудын айл өрхийн тодорхой</p>
--	--	---

		<p>хэсэг цэвэр усны шугаманд бүрэн холбогдох боломжтой юм. Монгол улс Чех улсын засгийн газар хоорондын хэлэлцээрийн дагуу Орхон аймгийн гэр хороолол ба түүний ойр орчмын ундны усан хангамжийг сайжруулах бэлчээр усжуулалтын зориулалтай хийгдэж буй төслийн хүрээнд Уртын голд 2ш, Их залууд 2ш, Шандад 1ш гүний худаг гарган багуудаар дамжуулан хувь хүмүүсээр ажиллуулан иргэдийг ундны усаар хангаж байна.</p> <p>Гэр хорооллыг олон нийтийн оролцоотой хөгжүүлэх төслийн хүрээнд жорлон болон ахуйн нөхцлөө сайжруулах төсөлд зөвлөгөө өгч өмнөх хэрэгжсэн төслийн туршлага судлуулан санхүүгийн туслалцаа үзүүлж, Сумын Засаг даргын 157 дугаар захирамжаар нутаг дэвсгэрийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж байгаа ариутгал халдваргүйжилтийн 5 компанитай гэрээ байгуулан гүйцэтгэлд хяналт тавин ажиллан,энэ ажлын хүрээнд 6306 айл өрх, үүнээс бие засах газар 961, бохирын цооног 775, хог хаягдлын цэг 931 нийт 800789м² талбайд ариутгал халдваргүйжилтийн ажлыг хийж гүйцэтгэсэн. Дээрх төслөөс нарийн гудамж засварлах, зарим эвдэрсэн гуу жалгын гарцыг сайжруулахаар Наран, Булаг, Баянцагаан, Баянбулаг, Цагаанчулуут багийн 8 бүлэг 8 гудамж талбайн замыг сайжруулж, 14 гудамж замын дагуу гэрэлтүүлэг хийгдсэн.</p> <p>засварласан. Малчин багийн арцатын давааны замыг засварлах ажлыг тогтвортой амьжиргаа төслийн 4,964,000 төгрөгийн санхүүжилтээр барьж хүлээлгэн өгсөн.</p> <p>Гэрэлтүүлэг хөтөлбөрийн хүрээнд Дөмөг зах руу явсан автозамын дагуух гэрэлтүүлэг, Баянцагаан болон Жаргалант сумын гэр хорооллын хойд хэсгийн явган хүний гэрэлтүүлэг барих ажлуудыг гүйцэтгэж ашиглалтанд оруулсан. Гэр хорооллын Наран, Шанд, Их залуу багийн 3.2км авто замын дагуух гэрэлтүүлэг барих ажлыг авто замыг ашиглалтанд авсны дараа барихаар шийдвэрлэсэн. Иргэд оршин суугчдыг хог хаягдлаа ялгаж сургах чиглэлээр багуудтай хамтарсан ухуулга сурталчилгаа, яриа таниулга жил бүр хийснээр гэр хорооллын айл өрхийн хог хаягдлаас орох орлого нэмэгдэж, эзэнгүй дүүргийн хог хаягдал 60-70 хувиар буурсан. 2010 оны орон нутгийн төсвийн тодотголоор</p>
--	--	--

		<p>280 сая төгрөгийг хог, тээврийн авто машин нийлүүлэх тендер зарлагдсан. Хот тохижуулах газраас эзэнгүй хог хаягдлыг бууруулах чиглэлээр гэр хорооллын айл өрхийн ачилт тээвэрлэлтийг нэмэгдүүлж, мөн гудамж, талбай, гуу жалганд ил задгай хаясан хогийг тогтмол ул мөргүй цэвэрлэн ачиж тээвэрлэснээр уг хог хаягдал буурсан.</p> <p>Хот тохижуулах газраас 6 хүний бүрэлдэхүүнтэй комисс томилон хог хаягдлын бүтцийн судалгааг гаргаж, дахин ашиглаж болох хоёрдогч түүхий эдийн нийт хэмжээг тодорхойлох ажлыг зохион байгуулсан. Хог хаягдлыг дахин боловсруулах, ашиглах зорилгоор нэр бүхий иргэд хог хаягдлыг хоёрдогч түүхий эдийн зориулалтаар түүх, ашиглах, худалдан авах иргэдийн нөхөрлөл байгуулсныг дэмжиж, Хот тохижуулах газар агуулахаар хангаж, хог хаягдлыг дахин боловсруулах үйлдвэрийг “Тэнгэрийн Аураг” ХХК Жаргалант суманд байгуулж жилдээ 10 тн хоёрдогч түүхий эд цуглуулан боловсруулж хайс, хашлага, сандал зэрэг бүтээгдэхүүн үйлдвэрлэж байна. Мөн “Дүнгээ хайрхан” ХХК бүх төрлийн хаягдал гялгар уут, хуванцар савыг худалдан авч, хагас боловсруулан экспортлож, иргэн Ц.Ганзориг нь хаягдал ясыг дахин боловсруулж био бордоо үйлдвэрлэхээр барилгын ажлаа тус тус эхлээд байна. Ахуйн болон үйлдвэрлэлийн хог хаягдлын менежментийг боловсронгуй болгох дэд хөтөлбөр боловсруулагдан аймгийн Засаг даргын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн дэмжигдэж, ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2009 оны 112 дугаар тогтоолоор батлуулан хэрэгжүүлж эхлээд байна.</p> <p style="text-align: right;">Хэрэгжиж байна 70%</p>
	<ul style="list-style-type: none"> • хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрхийг тусгайлан хангах; 	<p>Хөгжлийн бэрхшээлтэй болон төлбөрийн чадваргүй иргэдэд үзүүлэх өмгөөллийн ажлын хүртээмжийг дээшлүүлж, эрх зүйн туслалцааны төвийг Хууль зүйн хэлтсийн дэргэд 2008 оны 08 сарын 01-ны өдрөөс эхлэн байгуулж шаардлагатай тоног төхөөрөмжөөр ханган ажилласнаар Нийт төлбөрийн чадваргүй болон хөгжлийн бэрхшээлтэй 91 иргэний үүний дотор 6 хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн өмгөөллийн туслалцаа хүссэн өргөдөл ирсэнээс 7 хэргээс татгалзаж, 84 хүнд холбогдох 71 эрүүгийн хэргийг хүлээн авч, 64 хүнд</p>

		<p>холбогдох 55 хэргийг шүүхээр шийдвэрлүүлсэн байна. Төвд хандсан 446 иргэнд эрүү, иргэн, хөдөлмөр, захиргааны болон бусад хуулиар анхан шатны зөвлөгөөг утсаар болон биечлэн өгч , баримт бичиг /өргөдөл, гомдол, хүсэлт/ боловсруулахад нь туслав. Иргэдэд мэдээлэл, зөвлөгөө өгөх ажлын хуваарийг улирлаар гарган бүрэн хэрэгжүүлж ажиллалаа. Мэргэжлийн багш нарын туслалцаатайгаар хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй ажилладаг эцэг, эх асран хамгаалагчдад 2 удаагийн сургалт явуулж 45 хүнийг хамрууллаа. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд олноор суралцдаг 7-р сургуулийн 3 багшийг ижил төстэй сургуулиудаар туршлага судлуулах ажил зохион байгууллаа. Улаанбаатар хотын 25-р тусгай сургуулийн согог зүйч 2 багшийг авчирч сургалт явуулж 18 багш, 50 хүүхэд, 30 эцэг эхийг хамрууллаа. Аймгийн нийт цэцэрлэгүүдэд 56 хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд хүмүүжиж байна. Дэлхийн зөн ОУБ-ын дэмжлэгтэйгээр хөгжлийн бэрхшээлтэй иргэдтэй зүй зохистой харьцах чиглэлээрхи сургалтуудыг багш, нийгмийн ажилтан, эцэг эхчүүдэд тогтмол явуулж байна.</p> <p>2010 онд хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэх боломжийг судлан мэргэжлийн сургалтанд 47 хүнийг хамруулсан. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> ○ Тогооч -2 ○ Оёдолчин -1 ○ Гэр ахуйн цахилгаан хэрэгсэлийн засварчин – 1 ○ Цахилгаанчин -2 ○ Гагнуурчин -1 ○ Үсчин – 2 ○ Шүрэн урлал – 4 ○ Гар утасны засварчин -2 ○ Бизнесээ эхэл, хөгжүүл – 32 хөгжлийн бэрхшээлтэй иргэд сургалтыг төгсөөд байнгын ажлын байртай болоод үйл ажиллагаа явагдаж байна. <p>Хөдөлмөр эрхлэлтийн дэмжих сангаас 47 иргэний сургалтанд 1,145,000 төгрөг зарцуулагдсан. Хүүхдэд тохиолдох хөгжлийн бэрхшээл ба түүнийг засан</p>
--	--	--

		<p>сайжруулах чиглэлийн ном, гарын авлага, лекцийн эмхтгэл болон бусад холбогдох ном сурах бичгээр хангагдсан. Мөн дээрхи төслөөс 7-р сургуульд зөөврийн компьютер, LCD проектор, дэлгэц, зөөврийн тэргэнцэр, цахим хичээл бүхий 2190.0\$-ийн өртөгтэй иж бүрэн зөөврийн кабинет нийлүүлсэн. Дэлхийн зөн ОУ-ын байгууллагаас 7-р сургуульд 6 иж бүрдэл компьютер өглөө.</p> <p>Аймгийн номын төв дээр хараагүй иргэдэд зориулсан брайл үсэг бүхий номын сантай болох ажлыг Хараагүйчүүдийн холбооны Орхон аймгийн зөвлөл орон нутгийн төсвөөс 1.0 сая төгрөгний санхүүжилт авч хийж гүйцэтгэсэн. “Боломж” төв дээр хичээллэж байгаа сонсголын бэрхшээлтэй хүүхдүүдийг Орхон аймгийн “Эрхэст оргил” эмнэлэгт үзүүлж аппарат шаардлагатай 6 хүүхдэд 11 ш аппарат тавиулж, тохируулж өглөө. ХБХЭЭХ-ны 5-н жилийн ойн хүрээнд тус холбоонд эцэг эхчүүд болон хандивлагч байгуулагуудаас хамтран ЛСД дэлгэцтэй компьютер иж бүрдлээр нь өнгөт канон, принтерийн хамт хандивлалаа.</p> <p>Шинээр баригдаж байгаа барилга байгууламжинд хөгжлийн бэрхшээлтэй иргэд чөлөөтэй зорчих нөхцөл бүрдүүлэх дэд бүтцийг бий болгох ажлын хүрээнд Дэнж багийн 40 ортой эмнэлэг, 120 хүүхдийн цэцэрлэг, Ахмадын сувилал зэрэг байгууллагуудад хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн тэргэнцэр явах зам гаргаж явган замд хараагүй иргэдийн зорчих хавтанг суулгаж байна. АЗДТГ-ын төв хаалганы гадна талын шатанд тэргэнцэрийн зам тавьсан. Цаашид баригдаж байгаа барилга байгууламж, зам талбайд энэ чиглэлээр хяналт тавин ажиллаж байна.</p> <p style="text-align: center;">Хэрэгжиж байна 90%</p>
	<ul style="list-style-type: none"> • хүүхдийн эрхийг хангах эрх зүйн орчинг сайжруулах. 	<p>Насанд хүрээгүй хүмүүсээс үйлдэгдсэн гэмт хэрэг захиргааны зөрчил, гэмт хэрэг зөрчлийн улмаас хохирсон насанд хүрээгүй хүмүүсийн нөхцөл байдалд үнэлэлт дүгнэлт хийж холбогдох байгууллага албан тушаалтнуудад танилцуулж, хамгийн олон хүүхэд гэмт хэрэгт холбогдсон багийн Засаг дарга, сургуулийн холбогдох удирдлагууд, эцэг эхийн зөвлөлийн уулзалт ярилцлагыг хийж, шалтгаан нөхцлийг харилцан ярилцаж цаашид хамтарч хийх ажил</p>

		<p>шийдвэрлүүлэх саналыг холбогдох газруудад хүргүүлэн ажилласаны дагуу тоглоомын газар, биллиард, интернэтийн цагийн хуваарийг шинэчлүүлж, холбогдох хууль хяналтын байгууллагуудтай хамтран 2 удаа шалгалт хийж, удаа дараа зөрчил гаргасан 2 тоглоомын газрын үйл ажиллагааг зогсоох арга хэмжээ авсан. Аймгийн хэмжээнд 2009 онд 53 РС тоглоомын газар үйл ажиллагаа явуулж байсан бол хэсэгчилсэн болон нэгдсэн арга хэмжээ, хяналт шалгалтыг тогтмол зохион байгуулж хийснээр хууль зөрчин үйл ажиллагаа явуулсан тоглоомын газрын үйл ажиллагааг зогсоож, 2010 оны эцэст 21 тоглоомын газар болж цөөрсөн ба цаашид тавих хяналтыг тогтмолжуулан ажиллаж байна.</p> <p>Хүүхдийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр аймгийн ЗДТГ, Боловсрол соёлын газар, Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх салбар зөвлөл, Хүүхдийн төлөө хэлтэс, Хүний хөгжлийн төв, зэрэг төрийн болон төрийн бус байгууллагууд уулзалт ярилцлагыг 3 удаа зохион байгуулууж, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээ, хамтран ажиллах талаар санал солилцов. 2010-2011 оны хичээлийн жилд хүүхдийн ГХУС ажлыг хамтран хийх гурвалсан гэрээг Цагдаагийн газрын дарга, Хууль зүйн хэлтсийн дарга, ЕБС-ийн захирлуудтай байгуулж хамтарч ажиллав. Хүнс, барааны барааны захуудад байнга байдаг хараа хяналтгүй 66 хүүхдийг Цагдаагийн газар дээр цуглуулж, хүүхдийн эсрэг хүчирхийлэл, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх сургалтанд хамруулж, эрүүл мэндийн үзлэг хийлгэв. Төөрсөн тэнэсэн 15 хүүхдийг олж хаяг тогтоон эцэг эх асран хамгаалагчид нь хүлээлгэн өгөв. амьдралын түвшин доогуур орлоготой 2 хүүхдийг дэлхийн зөн ОУ-н байгууллагын байнгын дэмжлэгт хамрууллаа. Аймгийн хэмжээнд нийт 261 бүтэн өнчин хүүхэд байгаагаас 119 хүүхэд зуны улиралд хөдөлмөр эрхэлдэг судалгаа байна. Хүнд нөхцөлд байгаа хүүхдийн талаар мэдээллийн сан байгуулж, нийгмийн үйлчилгээнд хамруулах ажил хийлээ. Үүнд : Бүтэн өнчин 261 хүүхдээс 63 хүүхдийг төсөл, хөтөлбөрт хамруулсан байна. 10 охиныг сургалтанд хамруулж, амьдрах ухаан, зөв дадал, зуршилтай болгох ажлыг зохион байгуулсан. Улаанбаатар хотод оршин сууж</p>
--	--	---

		<p>байсан Эрдэнэ багийн харьяат 3 охиныг ээжийнх нь хүсэлтээр гэрт нь авчруулсан. Эцэг, эх асран хамгаалагчдын хараа хяналт сул, 12 хүүхдийн гэр ороноор нь орж, асран хамгаалагчтай нь уулзан зөвөлгөө өгч, дахин тэнэхгүй тэнүүлэхгүй байх талаар баталгаа гаргуулан авч хяналт тавин ажиллаж байна. Аймгийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж байгаа асрамж, халамжийн төвүүдэд нэгдсэн шалгалтыг зохион байгуулж, илэрсэн зөрчил, дутагдлыг арилгууллах арга хэмжээ авав. Баян-Өндөр сумын Засаг дарга хүсэлт гаргаж бүтэн болон хагас өнчин 6 хүүхдийг “Эрдэнэт үйлдвэр” ХХК-ны харьяа Энэрэл хүүхэд асрамжийн төвд хүргүүлсэн. Хүүхдийн хүнд хөдөлмөр эрхлэх явдал 11-ээр буурсан үзүүлэлттэй байна.</p> <p>Гэмт хэрэг зөрчил, хүчирхийллээс хүүхдийг хамгаалах ажлын хүрээнд “Хүүхэд насаа хайрлая” сэдэвт 4-р зөвлөгөөнийг зохион байгуулж, түүнээс гаргасан шийдвэрийг орон нутагт хэрэгжүүлэх зорилгоор Аймгийн хэмжээнд “Насанд хүрээгүй хүмүүсийг гэмт хэрэг хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, хэрэгт холбогдсон, гэмт хүчирхийллийн улмаас хохирсон хүүхдийг нийгэмшүүлэхэд тулгамдсан асуудал” сэдэвт зөвлөгөөнийг 2010,05,04 ний өдөр зохион байгуулж, ИТХ-н дарга ГХУСА33 н дарга, Аймгийн засаг дарга, болон холбогдох хууль хяналтын байгууллагын удирдлагууд, хэлтэс, агентлаг, албад, төсвийн байгууллагын удирдлагууд болон ажилтан албан хаагч нар, нийт 150 гаруй хүн оролцож, энэ талаархи хийж буй ажлын тухай болон цаашид төлөвлөн хийж, хэрэгжүүлэх үйл ажиллагааны талаар холбогдох илтгэлүүд хэлэлцүүлэв.</p> <p>Тус зөвлөгөөнөөс төрийн болон төрийн бус байгууллагуудад хандаж албан даалгавар гаргасан бөгөөд тус тусынхаа чиглэлийн дагуу тодорхой ажлуудыг зохион байгуулан хийх юм. Уг арга хэмжээнд 700,0 мянган төгрөгийг зарцуулсан байна. Хүүхдийн эрхийн тухай НҮБ-н конвенцийг хэрэгжүүлэх, хүүхдийн эрхийг хамгаалах тухай МУ-н хууль тогтоомж, шийдвэрийг хэрэгжүүлэх зорилгоор Аймгийн шүүх, Прокурор, Өмгөөлөгчдийн зөвлөл, Цагдаагийн газар зэрэг байгууллагуудтай хамтран Хүүхдийг худалдах, хүчирхийлэлд өртөхөөс урьдчилан сэргийлэх биеэ үнэлэх, садар самуунд уруу татагдахаас урьдчилан</p>
--	--	---

		<p>сэргийлэх, гэмт хэргийг илрүүлэх талаар Цагдаагийн газрын Хүүхдийн алба, Хүүхдийн төлөө хэлтэстэй хамтран ЕБС дын суралцагсдын дунд гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх, яриа таниулга, сургалт, зөвлөмж, зөвөлгөөг тогтмол өгч ажилласан.</p> <p>Хөдөлгөөний аюулгүй байдлын эсрэг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, замын хөдөлгөөнд соёлтой оролцоход суралцах эрхзүйн мэдлэг олгох чиглэлээр ЕБС-н бага ангийн хүүхдүүдийн дунд “Ногоон гэрэл-цагаан шугам” тэмцээнийг анх удаа зохион байгуулж орон нутгийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр сурталчилсан бөгөөд энэ арга хэмжээнд 12 сургуулийн 144 хүүхэд хамрагдаж, эцэг, эх, багш нар оролцсон нийт 1000 гаруй иргэд оролцов.</p> <p>Тэмцээнийг угтсан нэг сарын аянг зохион байгуулж, ерөнхий боловсролын 6 сургуульд, жолооны курсын багш, замын цагдаагийн зохицуулагч нараар замын хөдөлгөөний хичээл заалгаж, зам тээврийн осол гэмтлээс урьдчилан сэргийлэх яриа таниулга хийсэн зэрэг арга хэмжээг зохион байгуулсан бөгөөд цаашид энэ арга хэмжээг уламжлал болгон зохион байгуулж байх саналыг эцэг, эх, багш сурган хүмүүжүүлэгч нараас гаргасаныг холбогдох төр захиргааны байгууллагуудад уламжилсан. Хүүхдийг зам тээврийн осол, хэргээс урьдчилан сэргийлэх ажлын хүрээнд, ЕБС-дын хичээл цуглах тарах үеэр багш, нийгмийн ажилтан нар, явган зорчигч, сурагчдын хөдөлгөөнийг зохицуулж ажиллахад шаардагдах, хувцас хэрэглэлийг шийдвэрлүүлэх болсон. “Хүүхэд - замын хөдөлгөөн” сэдэвт арга хэмжээг зохион байгуулав. Хүүхдэд багаас нь замын хөдөлгөөнд оролцох дадлага эзэмшүүлэхэд, эцэг, эх, багш сурган хүмүүжүүлэгчдийн үүрэг хариуцлагыг өндөржүүлэх зорилгоор 19,21,10-р цэцэрлэгүүд 2,4-р сургуулиудын суралцагсдын эцэг эх, багш нарт “Гэр, сургуулийн хооронд хүүхдүүдийг аюулгүй, зорчуулах” сэдвээр уулзалтыг зохион байгуулав.</p> <p>Зам тээврийн осолд өртөж хохирсон 7 хүүхдийг харъяа сургуульд нь зөвлөмж өгч, хөдөлгөөний аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэг, ослоос урьдчилан сэргийлэх чиглэлээр мэргэжлийн байгууллагаас зөвөлгөө авч ажил зохион</p>
--	--	--

		<p>байгуулах тухай зааварчилга өгсөн. Замын хөдөлгөөнд соёлтой оролцох дүрмийн мэдлэгийг дээшлүүлэх зорилгоор ТВ-10 телевизтэй хамтран 14 хоногт 1 удаа “Аюулгүйн тойрог” нэвтрүүлэг, бусад мэдээллийн талаар санамж, зөвлөмж, сэрэмжлүүлэг, зэргийг тогтмол явуулж, 24 удаагийн сургалт, ТВ-р 110 удаа, Радиогоор 15 удаа, сонин хэвлэлээр 8 удаа, 8 төрлийн 3000ш санмж сэрэмжлүүлэгийг хөдөлгөөнд оролцогчдод тарааж сурталчилсан байна. Ерөнхий боловсролын 25 сургуульд хүүхдийн өөрөө удирдах байгууллагын дэргэд хууль сурталчлах, хүүхдийн эрхийг хамгаалах танхим байгуулж үйл ажиллагаа явуулж байна. Хүний эрхийн өдрийг угтан хүний эрхийн болон хүүхдийн эрхийн талаар самбар гарган хүүхдийн эрхийн талаар сурталчлах ажил зохион байгуулсан байна.</p> <p style="text-align: center;">Хэрэгжиж байна 90%</p>
7.2. Монгол Улсын төрийн байгуулал, төрийн удирдлагын хөгжил Бүх үе шат (2007-2021 он):		
	<i>Стратегийн зорилт 2. Төрийн удирдлагын шийдвэр гаргах үйл явцын ил тод байдал, түүнд иргэд оролцох боломжийг хангана:</i>	
<ul style="list-style-type: none"> • төрийн зарим чиг үүргийг хувийн хэвшил, болон төрийн бус байгууллагаар гүйцэтгүүлэх чиглэл баримтлах 	<p>2010 оны 2-р сард аймгийн хэмжээнд идэвхитэй үйл ажиллагаа явуулж буй иргэний нийгмийн байгууллага болон төрийн захиргааны байгууллагын төлөөллийг оролцуулсан “Хурал, захиргааны болон төрийн бус байгууллагуудын харилцаа, хамтын ажиллагаа” сэдэвт нээлттэй хэлэлцүүлгийг зохион байгуулж, хамтын ажиллагааны өнөөгийн байдал болон цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаар санал солилцов.</p> <p>1997 оноос мөрдөгдөж байгаа Төрийн бус байгууллагын тухай хуулийн 9-р зүйлийн 3-т “Төрийн байгууллага төрийн бус байгууллагын үйл ажиллагаанд санхүүгийн болон бусад хэлбэрийн дэмжлэг үзүүлж болно” гэж заасны дагуу аймгийн Засаг дарга, ЗДТГ-аас гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, хүүхэд, оюутан, залуучуудыг идэвхижүүлэх, гэр бүлийн асуудлыг дэмжих, ахмадуудын</p>	

		<p>эрх ашгийг хамгаалах, ахмад настан болон хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрх ашгийг хамгаалах, үзэсгэлэн яармаг зохион байгуулах, хэрэглэгчдийн эрх ашгийг хамгаалах зэрэг чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг 16 төрийн бус байгууллагуудад 2010 онд 27.0 гаруй сая төгрөгийн санхүүгийн дэмжлэг үзүүлж хамтран ажиллалаа.</p> <p>Үүнээс заримыг дурьдвал: Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн эцэг эхийн холбооны Орхон аймаг дахь салбар зөвлөлтэй хамтран “Гэрээр айлчлах” төсөлд 50 хүүхдийг хамруулж 9,0 сая төгрөгийн, мөн тус холбоотой гэрээ байгуулан олон нийтийг хамарсан үйл ажиллагаанд зарцуулахаар 337,0 мянган төгрөгийн санхүүжилтийг гэрээгээр олголоо.</p> <p>Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн төлөөлөл “Үндэсний чуулган”-д оролцох,” Хүртээмжтэй орчин” сэдэвт хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн нэгдсэн арга хэмжээнд оролцох замын зардалд орон нутгийн төсвөөс 100,0 мянган төгрөг, Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас 53,0 мянган төгрөг зарцуулсан байна.</p> <p>Залуучуудын холбооноос хамтран ажиллах гэрээг аймгийн Засаг даргатай байгуулж “Аймгийн залуучуудын хөгжлийн 2009-2012 он хүртэлх дунд хугацааны хөтөлбөр”-ийг боловсруулж, хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг гарган ажиллаж байгаа ба Хангайн бүсийн их, дээд сургуулиудын дунд ерөнхий эрдмийн олимпиад, “Summer sun” залуучуудын аялал, Хэрэглэгчдийн эрх ашгийг хамгаалах нийгэмлэгтэй хамтарч “Соёлтой үйлчилгээ-боловсон харилцаа” сарын аян, Хангайн бүсийн бүтээмж хөгжлийн төвтэй хамтарч нутгийн захиргааны байгууллагуудын дунд сэтгэл ханамжийн судалгаа, сургалт зохион байгуулах, “Гал голомт” Үндэсний холбооны аймгийн салбар хүрээтэй хамтарч гэр бүлийн өдрийг тэмдэглэн өнгөрүүлэх зэрэг арга хэмжээнүүдийг зохион байгууллаа.</p> <p>Ахмадын хорооноос ирүүлсэн хүсэлтийн дагуу 4.0 сая төгрөгний санхүүжилт олгож өндөр настны саам эмчилгээний үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэв.</p> <p style="text-align: right;">Хэрэгжиж байна 90%</p>
	<p><i>Стратегийн зорилт 4. Засаг захиргаа, нутаг дэвсгэрийг эдийн засгийн чадамж, хүн амын нөөцөд тулгуурлан томсгоно:</i></p>	
<ul style="list-style-type: none"> • баг, хороог төрийн үйлчилгээг иргэдэд хүргэдэг төрийн захиргааны хамгийн анхан 	<p>Багуудын ажиллах нөхцлийг сайжруулах, багийн хөгжлийг дэмжих замаар төрийн үйлчилгээг иргэдэд ойртуулах, шуурхай чанартай болгох, багийн үйл</p>	

<p>шатны нэгжийнх нь хувьд бэхжүүлэх;</p>	<p>ажиллагааны чадавхийг бэхжүүлэх зорилгоор аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн хурлаар “Багийн хөгжлийг дэмжих” аймгийн дэд хөтөлбөрийг батлан 2008-2015 он хүртэл 2 үе шаттайгаар хэрэгжүүлэн ажиллаж байна.</p> <p>“Багийн хөгжлийг дэмжих” аймгийн дэд хөтөлбөрийг хэрэгжүүлэхээр 4 зорилтын хүрээнд 2009 онд 18, 2010 онд 21 арга хэмжээ төлөвлөн хэрэгжүүлсэн ба хөтөлбөрийн хэрэгжилт 2009-2010 онд 97.6 хувьтай байна.</p> <p>2008-2010 онд Баян-Өндөр сумын Уурхайчин, Шанд, Согоот, Цагаанчулуут, Их залуу, Бүрэнбүст, Жаргалант сумын Улаантолгой багийн жишиг баг болгон тохижуулсан ба 2011 онд Баян-Өндөр сумын Эрдэнэ, Говил багийн жишиг баг болгох зорилт тавин ажиллаж байна. Мөн 2008-2010 онд Баян-Өндөр сумын Эрдэнэ, Их залуу, Баянбулаг, Булаг, Шанд, Бүрэнбүст багийн ажлын байрыг шинээр барьж, Жаргалант сумын Дулаан-Уул, Жаргалант, Баян-Өндөр сумын Согоот, Хүрэнбулаг багийн ажлын байрны ажиллах нөхцлийг сайжруулах арга хэмжээ авлаа.</p> <p>Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын ээлжит XII хуралдааны 2010 оны 07 дугаар тогтоолын дагуу Баян-Өндөр сумын 19 баг тус бүрт нийгмийн ажилтан ажиллуулж байна.</p> <p>2008-2009 онд Баян-Өндөр сумын Цагаанчулуут, Шанд, Их залуу багийн Засаг дарга нар Удирдлагын академид бакалавр болон менежерийн сургалтанд суралцаж төгслөө.</p> <p>Багуудын боловсон хүчний чадавхи, мэдлэг чадварыг дээшлүүлэх зорилгоор Удирдлагын академийн зайны сургалтын төвийг түшиглэн Германы техник хамтын ажиллагааны Нийгэмлэгийн “Бүс нутгийн эдийн засгийг дэмжих хөтөлбөр”, “Дэлхийн зөн” олон улсын байгууллагын Эрдэнэт дахь Хөгжлийн хөтөлбөрийн байгууллагуудтай хамтран 22 багийн Засаг дарга, зохион байгуулагчдад төрийн удирдлагын болон хууль эрх зүйн чиглэлээр “Хүний нөөцийн хөгжил, манлайлал”, “Төрийн удирдлага”, “Төрийн албан хаагчийн ёс зүй”, “Үйлчилдэг удирдлага”, “Орон нутгийг хөгжүүлэхэд иргэдийн оролцоо”, “Нийгмийн даатгалын багц хууль”, “Архив, албан хэрэг хөтлөлт”, “Захиргааны эрх зүй” зэрэг сургалтуудыг 15-20 удаа зохион байгуулж 22 багийн Засаг дарга, зохион байгуулагч, хэсгийн ахлагчдыг хамруулав.</p> <p>2010 онд Баян-Өндөр, Жаргалант сумдын 22 багийн Засаг дарга, зохион байгуулагчдад “Тогтвортой амьжиргаа-II”, Мянганы хөгжлийн сангийн хөрөнгийн</p>
---	---

		<p>эрхийн төсөл, бусад олон улсын байгууллага болон Удирдлагын академитай хамтран төрийн удирдлага, хууль эрх зүй, менежментийн чиглэлээр “Бизнес төлөвлөгөө боловсруулах”, “Өрхийн аж ахуй эрхлэх тухай”, “Төрийн албан хаагчдын өнөөгийн байдал”, “Захиргааны эрх зүй, захиргааны акт”, “Харилцааны соёл, ёс зүй”, “Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх”, “Агаарын бохирдол”, “Эрүүл мэндийн салбарын өнөөгийн байдал”, Нийгмийн хамгааллын тухай болон Эрүүл мэндийн даатгалын тухай хууль зэрэг 24 сэдвээр сургалтууд зохион байгууллаа. Дээрх сургалтуудад багийн Засаг дарга нар 13 удаа, зохион байгуулагчид 11 удаа, хэсгийн ахлагч нар 5 удаа тус тус хамрагдсан байна.</p> <p>Багийн Засаг даргын бүрэн эрхээ хэрэгжүүлэх, үйл ажиллагааг нь дэмжихэд санхүүгийн дэмжлэг үзүүлэх зорилгоор 2007 оноос эхлэн баг хөгжүүлэх сан байгуулж жил бүр 22 баг тус бүрт 1.0 сая төгрөгийг орон нутгийн төсөвт тусган, хагас, бүтэн жилээр багийн ИНХ, сумын Засаг даргад багууд сангийн зарцуулалтаа тайлагнан ажиллаж байгаа ба ажлын байранд шаардлагатай зарим эд хогшил худалдан авах, мэдээлэл сурталчилгааны материал бэлтгэх, тэмдэглэлт ой, баяр ёслол, үйл явдлыг дэмжих, багийн ажлыг сурталчлах өдөрлөг зохион байгуулах, аж ахуйн нэгж, байгууллага, иргэдийг шагнаж урамшуулах зэрэгт зарцуулсан байна.</p> <p>Мөн орон нутгийн төсвөөр багуудын нутаг дэвсгэрт гудамж талбайн тохижилт, авто замын засвар, гэрлэн дохио, авто зогсоол гаргах, гудамжны хайс, орон сууцны байруудын дээврийн засвар зэрэг ажлууд, багуудын бичиг хэрэг, ном хэвлэл, тээврийн шатахуун, шуудан холбоо, урсгал зардал зэрэгт тодорхой хэмжээний хөрөнгө тусгаж хэрэгжүүлэн ажиллав.</p> <p>Төрийн үйлчилгээг хөдөөгийн иргэдэд түргэн шуурхай хүргэж байх зайлшгүй шаардлагын улмаас хөдөөгийн багийн Засаг дарга нарын унааны асуудлыг шийдвэрлэж Баян-Өндөр сумын Малчин, Их залуу багийг авто машин, Жаргалант сумын Дулаан-Уул багийг мотоцикльтой болгов.</p> <p>2008-2010 онд Баян-Өндөр, Жаргалант сумдын нийт 22 багийн албан хэрэгцээнд зургийн аппарат, проектор дэлгэц зэрэг сурталчилгааны тоног төхөөрөмж, ширээ, сандал, номын шүүгээ, сейф, скайнер, канон зэргийг шийдвэрлэх, улирал бүр “Төрийн мэдээлэл” сэтгүүл, хууль эрх зүйн болон сурталчилгааны бусад гарын авлага материалаар хангахад 185.6 сая, бичиг хэргийн зардалд 26.6 сая төгрөгийг тус тус зарцуулсан байна.</p> <p>Багийн иргэдэд төр засгийн бодлого, нутгийн хурал, захиргааны байгууллагаас</p>
--	--	---

		<p>гаргасан шийдвэр, бусад мэдээллийг хүргэх зорилгоор 158 хэсгийн ахлагчдыг Баян-Өндөр сумын 19 багт ажиллуулж тэдний урамшууллыг шийдвэрлэн ажиллаж байгаа ба гэр хорооллын багуудын дэргэд шуудан холбооны цэгийг нээсэн байна. Жаргалант сумын Дулаан-Уул баг малчдын дунд мэдээллийг хүргэх явуулын номын сан, самбар ажиллуулж хэвшсэн ба Баян-Өндөр сумын гэр хорооллын багууд “Иргэдээ сонсоё”, “Сурталчилгааны хайрцаг”, “Хууль тогтоомжийн мэдээллийн дэвтэр”, “Харилцах дэвтэр” хэлбэрээр иргэдийн санал хүсэлтийг хүлээн авч шийдвэрлэж байна.</p> <p style="text-align: right;">Хэрэгжиж байна 90%</p>
<p><i>Стратегийн зорилт 5. Төрийн бүртгэл, мэдээллийн тогтолцоог шинэтгэж, бодитой, үнэмшилтэй цахим мэдээллийн тогтолцоо, сан байгуулна:</i></p>		
	<ul style="list-style-type: none"> • төрийн бүртгэлийг цахим хэлбэрт бүрэн шилжүүлж, төрийн бүртгэлд бүртгүүлснийг батлах баримт бичгийг компьютерт уншигдахаар болгон, бусад төрлийн цахим баримт бичигтэй хоршин хэрэглэдэг болгох; 	<p>Монгол улсад бүртгэлийн нэгдсэн тогтолцоо бий болгох хөтөлбөрийн хүрээнд Орхон аймгийн Улсын бүртгэлийн хэлтэс нь иргэний бүртгэл, эд хөрөнгийн эрхийн бүртгэл, хуулийн этгээдийн бүртгэлийг цахим хэлбэрт оруулан, УБЕГ-тай online сүлжээнд бүрэн холбогдон мэдээллийн сангаас иргэн, аж ахуйн нэгж, байгууллагуудад шаардлагатай лавлагаа, мэдээллээр түргэн шуурхай хангаж байна.</p> <p>2010 онд иргэний гэр бүлийн байдлын бүртгэлийн 3735, шилжилт хөдөлгөөний бүртгэлийн 18042, иргэний үнэмлэхний бүртгэлийн 12629, ХААТР маягтуудыг мэдээллийн санд оруулаад байна. Иргэний бүртгэлийн чиглэлээр нийт 34406 бүртгэл мэдээллийн санд шинээр орсон.</p> <p>Эд хөрөнгийн эрхийн бүртгэлийн чиглэлээр үл хөдлөх эд хөрөнгийн 15133 бүртгэл, газрын бүртгэл 8867 мэдээллийн санд орууллаа. Нийт 24000 буюу хадаглагдаж буюу нийт хувийн хэргийг цахим санд оруулаад байна.</p> <p>Хуулийн этгээдийн бүртгэлийн чиглэлээр шинээр үүсч байгуулагдсан 331 аж ахуйн нэгжийг шинээр бүртгэн 48 аж ахуйн нэгжийг бүртгэлээс хасч, шилжин ирсэн 6, хэлбэрээ өөрчилсөн 9 аж ахуйн нэгжид цахим санд бүртгэл хийлээ.</p> <p>Аймгийн Засаг даргын 2010 оны 243 дугаар захирамж гарч Иргэний шинэчилсэн бүртгэл явуулах ажлын хэсгийг 13 хүний бүрэлдэхүүнтэй байгуулан ажиллаж байна. Иргэний шинэчилсэн бүртгэл явуулах 6 тоног төхөөрөмж ирснийг сумдад хуваарилаж, тоног төхөөрөмжийг байруулах хуваарийг баталж тодорхой заавар зөвлөлгөө, гарын авлага материалыг сумдын Засаг дарга нарт</p>

		өгөөд байна. Иргэний шинэчилсэн бүртгэл явуулах ажлын зохион байгуулалтын талаарх ажлыг ажлын хэсгийн зүгээс хангаж ажилласан байна. Хэрэгжиж байна 90%
7.3. Монгол Улсын төрийн захиргаа, төрийн албаны шинэтгэлийн бодлого Бүх үе шат (2007-2021 он):		
<i>Стратегийн зорилт 1. Төрийн албаны стратегийн төлөвлөлт, гүйцэтгэлийн удирдлагын чадамжийг хөгжүүлнэ:</i>		
• төрийн албаны, ялангуяа ерөнхий менежерийн стратегийн төлөвлөлтийн чадамжийг бэхжүүлэх;		“Төсвийн байгууллагын стратеги төлөвлөлт”, “Гүйцэтгэлийн удирдлага” сэдвээр Төрийн албаны зөвлөл, Дэлхий зөн ОУБ зэрэг байгууллагатай хамтран 2 удаагийн сургалт зохион байгуулан төсвийн байгууллагын Ерөнхий менежерүүдийг бүрэн хамруулав. Хэрэгжиж байна 90%
• төрийн албаны гүйцэтгэлд үндэслэсэн удирдах чадавхийг бэхжүүлэх.		Монгол улсын Төрийн албаны зөвлөлөөс Шведийн төрийн захиргааны олон улсын институт /СИПУ/-тэй хамтран хэрэгжүүлж буй “Суралцагч байгууллагын хөгжүүлэх манлайлал” сургалтын хөтөлбөрийн хүрээнд төрийн албаны удирдах ажилтнуудын манлайлах ур чадварыг хөгжүүлэх 9 өдрийн сургалтыг 6 удаа зохион байгуулан 120 ерөнхий менежерийг хамруулан сургалаа. Мөн энэхүү төслийн хүрээнд манлайлалын мастер сургагч багшаар 3 ажилтныг бэлтгэн орон нутагт сургалтыг зохион байгуулж байна. Хэрэгжиж байна 90%
<i>Стратегийн зорилт 2. Төрийн албаны бодлого, дүн шинжилгээний болон төрийн албан хаагчийн манлайллын чадамжийг шинэ түвшинд хүргэнэ:</i>		
• төрийн албаны бодлогын мэдээлэл, дүн шинжилгээ, хяналт, шинжилгээ, үнэлгээ хийх чадавхийг хөгжүүлэх;		Аймгийн ЗДТГ-ын хяналт шинжилгээ, үнэлгээний тасгийн ажилтнуудыг 3-р сард “Хяналт-шинжилгээ, үнэлгээний арга зүй сургалтанд, мөн 07-р сард Хяналт шинжилгээ, үнэлгээний тасгийн дарга Үр дүнд чиглэгдсэн Хяналт шинжилгээ үнэлгээний онол, арга зүйн түвшинг дээшлүүлэх сургалтанд тус тус хамруулав. Хэрэгжиж байна 90%
• төрийн албаны удирдах албан тушаалтан, ялангуяа ерөнхий менежерийг нээлттэй өрсөлдөөний зарчмаар сонгон шалгаруулах.		УИХ-ын 2002 оны 13 дугаар тогтоолоор баталсан “Төрийн жинхэнэ албаны удирдах албан тушаалд томилогдох ажилтныг сонгон шалгаруулах журам”-ын дагуу аймгийн Засаг даргын дэргэдэх хэрэгжүүлэгч агентлаг ХХААЖДҮГ, Тээвэр, авто замын газар, Нийгмийн даатгалын хэлтэс, Биеийн тамир спортын газар, ГХБХБГазар, Хүүхдийн төлөө хэлтэс, Хотын Захирагчийн албаны дарга, Гэр бүлийн ордон ОНӨҮГ-ын захирал, Номын төвийн захирал, Баян-Өндөр сумын

		<p>Хүүхэд залуучуудын төвийн эрхлэгч, Жаргалант сумын ИТХ-ын нарийн бичгийн дарга, ЗДТГ-ын дарга, Хүн эмнэлгийн эрхлэгч, Соёл мэдээллийн төвийн эрхлэгч зэрэг 14 төсвийн ерөнхий менежерийн үүрэг гүйцэтгэх удирдах ажилтан болон БТСГ-ын албаны даргыг нээлттэй өрсөлдөөний зарчмаар сонгон шалгаруулж томилсон бөгөөд 2010 онд төрийн албаны удирдах албан тушаалтан, ялангуяа ерөнхий менежерийг нээлттэй өрсөлдөөний зарчмаар сонгон шалгаруулах ажил нэмэгдэж хийгдээгүй болно.</p> <p style="text-align: right;">Хэрэгжиж байна 90%</p>
<i>Стратегийн зорилт 3. Байгууллагын болон хүний нөөцийн хөгжлийг хангана:</i>		
	<ul style="list-style-type: none"> • дотоод шийдвэр нь ил тод, ажлын гүйцэтгэлд чиглэсэн суралцагч байгууллагыг хөгжүүлэх; 	<p>Аймгийн Засаг даргын Тамгын газрын үйл ажиллагааны хэтийн төлөвлөгөөнд “Байгууллагаа суралцагч байгууллага болгон хөгжүүлэх” зорилт тавин энэхүү зорилтын хүрээнд “Орхон аймгийн Засаг даргын Тамгын газрын хүний нөөцийн хөтөлбөр”-ийг боловсруулан энэ оны эхнээс мөрдөн хэрэгжилтийг зохион байгуулан ажиллаж эхлээд байна.</p> <p style="text-align: right;">Хэрэгжиж байна 90%</p>
	<ul style="list-style-type: none"> • төрийн албан хаагч бүрт хүний нөөцийн удирдлагын ур чадварыг эзэмшүүлэх. 	<p>Удирдлагын академитай хамтран ажлын байрны шинжилгээ хийх, ажлын байрны тодорхойлолт боловсруулах арга зүй сургалтыг зохион байгуулахаар бэлтгэл ажил хийгдээд байна.</p> <p style="text-align: right;">Хэрэгжиж байна 90%</p>
<i>Стратегийн зорилт 5. Төрийн албаны оновчтой хэмжээг хангаж, төрийн үйлчилгээний чанар, хүртээмжийг дээшлүүлнэ</i>		
	<ul style="list-style-type: none"> • төрийн захиргааны төв болон нутгийн захиргааны бүх шатны байгууллагын чиг үүргийн шинжилгээ хийх замаар төрийн албыг үе шаттайгаар цомхон чадварлаг болгож, зохистой хэмжээнд хүргэх; 	<p>Эрдэнэт хотын Захирагчийн алба, Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газрын барилгын салбарын ажлын чиг үүрэгт шинжилгээ хийн ажлын давхардал, хийдэгдэлийг арилгах ажлын хэсэг томилон асуудлыг шийдвэрлэв.</p> <p style="text-align: right;">Биелсэн 100%</p>
	<ul style="list-style-type: none"> • төрийн суурь үйлчилгээний чанар, хүртээмжийн талаархи нийгмийн аудитын арга зүйг нэвтрүүлэх; 	<p>Судалгааны ажил хийгдэж байна.</p> <p style="text-align: right;">Хугацаа болоогүй</p>
	<ul style="list-style-type: none"> • төрийн жинхэнэ болон үйлчилгээний албан хаагчдыг намын 	<p>Аймгийн хэмжээнд 2009 оны 1 сарын 5-ны байдлаар улс төрийн намын гишүүний харьяалалтай 652 төрийн албан хаагч ажиллаж байсан ба Төрийн</p>

	<p>гишүүнчлэлгүй болгож, Төрийн албаны зөвлөлийн эрх хэмжээг нэмэгдүүлж, төрийн албыг тогтворжуулж, төрийн албаны боловсон хүчний нөөцийг бүрдүүлдэг системийг бий болгож, төрийн албыг чанаржуулах.</p>	<p>албаны тухай хуулийн дагуу 651 төрийн албан хаагч намын гишүүнчлэлээс татгалзаж 1 төрийн албан хаагч төрийн албанаас чөлөөлөгдсөн. Энэ хугацаанаас хойш шинээр төрийн албанд орж буй иргэд намын гишүүнчлэлээс татгалзаж, татгалзсаныг нотлох баримтаа томилох эрх бүхий албан тушаалтанд ирүүлж хэвшээд байна.</p> <p>2011 оны 2-р сарын 8-ны байдлаар төрийн жинхэнэ албан тушаалд анх орох иргэний нөөцөд 145 иргэн бүртгэгдээд байгаа ба үүнээс 65 нь байнгын ажлын байраар хангагдаад байна</p> <p style="text-align: right;">Хэрэгжиж байна 90%</p>
7.5. Гадаад бодлого Бүх үе шат (2007-2021 он):		
<i>Стратегийн зорилт 1. Энхийг эрхэмлэсэн, идэвхтэй гадаад улс төрийн бодлогыг хэрэгжүүлнэ:</i>		
	<ul style="list-style-type: none"> • хөрш хоёр оронтойгоо харилцан ашигтай, тэнцвэртэй харилцахад тэргүүлэх ач холбогдол өгөх, эдгээр орны зах зээлд хөгжиж буй болон далайд гарцгүй улс орнуудын эдлэх хөнгөлөлтөөр дамжиж орох бодлогыг хэрэгжүүлэх; 	<p>Манай улсын гадаад бодлогын үзэл баримтлалын үндсэн 6 чиглэлийн тэргүүлэх чиглэл болох хөрш хоёр орныхоо муж, хотуудтай идэвхтэй хамтран ажиллаж ирлээ.</p> <p>2010 оны 5-р сарын 10-12-ны өдрүүдэд БНХАУ-ын Эрээн хотод аймгийн Засаг дарга тэргүүтэй төлөөлөгчид ажлын айлчлал хийж, хоёр хотын найрсаг хамтын ажиллагааны хэлэлцээрийг шинэчлэн, Баян-Өндөр сум, Эрээн хотын Зүүн хот дүүрэгтэй хамтын ажиллагааны санамж бичиг үйлдсэн ба мөн оны 6-аар сард Эрээн хотын төлөөлөгчид манай аймагт айлчлан томоохон үйлдвэр, аж ахуйн нэгжүүдийн үйл ажиллагаатай танилцаж, аймгийн удирдлагуудтай уулзалт хийв.</p> <p>2010 оны 10-р сарын 17-18-ны өдрүүдэд Эрээн хотын “Эх газрын эдийн засгийг хөгжүүлж, хамтын ажиллагааны коридорыг байгуулах Эрээн хотын эдийн засаг худалдааны форум” –д ЗДТГ-ын төлөөлөл оролцсон байна.</p> <p>Хамтын ажиллагаат БНХАУ-ын Бугат хотын урилгаар 2010 оны 10 дугаар сарын 18-наас 22-ны хооронд аймгийн төр захиргааны төлөөлөгчид болон 30 гаруй уран бүтээлчид “Эрдэнэт” хотын соёлын өдрүүдийг Бугат хотод зохион байгуулж, хотын дарга нарын уулзалт болж цаашид хамтран ажиллах асуудлаа ярилцсан байна.</p> <p>ОХУ-ын Улаан-Үд хотын Дуурь бүжгийн эрдмийн театрын балетын бүрэлдэхүүн /50 уран бүтээлчид/ 2010 оны 3-р сард ирж “Хунт нуур”, “Буратино” бүжгэн жүжгүүд, балетийн цоморлиг тоглолтыг иргэдэд толилуулав. Баян-Өндөр цогцолборын хөгжмийн гүнзгийрүүлсэн сургалттай сургуулийн “Цуурай” хамтлаг</p>

		<p>аугаа Ялалтын 65 жилийн ойд зориулж Улаан-Үд хотноо зохиогдсон найрал дууны уралдаанд оролцож 2-р байр эзэлсэн байна.</p> <p>Верхнеудинской Думын 115 жил болон Улаан-Үд хотын зөвлөл байгуулагдсаны 15 жилийн ойг тохиолдуулан Улаан-Үд хотын 8-р сургуулийн соёл урлагын арга хэмжээнд Баян-Өндөр цогцолбор сургуулийн багш, сурагчид оролцлоо.</p> <p>Хэрэгжиж байна 90%</p>
	<p>• Америкийн Нэгдсэн Улс, Япон Улс болон Европын холбоотой иж бүрэн түншлэлийн түвшинд харилцах бодлого баримтлах;</p>	<p>“Эгч дүү хотууд” болох Аляск мужийн Файрбанк хоттой байгуулсан гэрээний дагуу манай аймаг дахь ШУТИС-ийн харьяа Ш.Отгонбилэгийн нэрэмжит Технологийн сургуулийн 2 оюутан хөнгөлөлттэй /40.000 ам.долларын төлбөрөөс чөлөөлөх/ нөхцөлөөр Аляскийн их сургуулийн Файрбанк хотын салбар сургуульд 2009 оны 1-р сараас суралцаж эхэлсэн ба Аляскийн Их сургуульд 2009 оноос жил бүр 2 оюутныг Аляск мужийн өөрийнх нь оюутны адилаар хөнгөлөлттэй нөхцөлөөр /60%/ сургахаар тохирсны дагуу 2009 оны 8-р сард манай аймгийн 2 оюутан суралцаж байна. Тус хотын Аляска Их сургуулийн “Зайны сургалтын төв”-ийн захирал Curt Madison тэргүүтэй төлөөлөгчид Орхон аймагт 2010 оны 11 дүгээр сард айлчлан ирж, тус аймгийн эрүүл мэндийн байгууллагуудын үйл ажиллагаатай танилцсан бөгөөд Орхон аймгийн эмч, эмнэлгийн мэргэжилтнүүдийг зайны сургалтанд хамруулах талаар хамтран ажиллаж байгаа болно.</p> <p>Аймгийн ЗДТГ-аас хойд Америкийн “Эгч дүү хотууд”-ийн холбоонд хандан АНУ-ын Аляск мужийн Файрбанк хоттой “Ах дүү хотууд”-ын харилцаатай тухайгаа болон дахин АНУ-ын өөр нэг хоттой холбоо тогтоох тухай хүсэлтээ явуулан, www.sister-sities.org цахим хуудсанд аймгийнхаа танилцуулга болон холбоо барих хаягийг байршууллаа.</p> <p>Хэрэгжиж байна 90%</p>
	<p>• уламжлалт харилцаатай Дорнод Европын орнуудтай тогтоосон хамтын ажиллагаагаа идэвхжүүлж өргөтгөх чиглэл</p>	<p>БНТУ-ын Эдремит хотын дарга Тунжай Киличийн урилгаар 2010 оны 11-дүгээр сард аймгийн Засаг дарга Д.Оюунбат Турк Улсад айлчлан, хоёр талын найрсаг харилцаа, хамтын ажиллагааг хөгжүүлэх, эдийн засгийн салбарт</p>

	баримтлах;	<p>харилцан дэмжиж, хамтран ажиллах чиглэлээр найрсаг хамтын ажиллагааны гэрээг санал нэгтгэйгээр байгуулан ах дүү хот болохыг хүлээн зөвшөөрөлцөв.</p> <p>БНТУ-д болсон Олон Улсын хот байгуулалтын чиглэлийн сургалтанд Хотын захирагчийн албаны дарга Х.Олзбаатар 2010 оны 10 дугаар сард оролцсон байна.</p> <p>Орхон аймаг Эрдэнэт хот нь Кувейт улсын Эль-Кувейт хотын Эль-Фарваниях мужийн хооронд хоёр талын найрсаг харилцаа, хамтын ажиллагааг хөгжүүлэх, эдийн засгийн салбарт харилцан дэмжиж, хамтран ажиллах чиглэлээр найрсаг хамтын ажиллагааны хэлэлцээрт хамтран ажиллахаар болсон байна.</p> <p>Европын холбооны улсуудын кино өдөрлөгийг 2010 онд Эрдэнэт хотод 3 өдрийн турш амжилттай зохион байгуулсан байна.</p> <p>Чех улс, Монгол улсын хооронд дипломат харилцаа тогтоосны 60 жилийн ойд зориулсан фото зургийн үзэсгэлэнг Элчин сайдын яамтай хамтран Эрдэнэт хотод зохион байгуулсан болно.</p> <p style="text-align: right;">Хэрэгжиж байна 90%</p>
	<ul style="list-style-type: none"> • Зүүн Хойд Ази, Зүүн Азийн харилцан уялдаа бүхий хамтын ажиллагааны үйл явцыг урагшлуулах яриа хэлэлцээрт нэгдэхийг эрхэмлэж, тус бүс нутагт байр сууриа бэхжүүлэх. 	<p>Манай аймаг нь 2006 онд БНСУ-ын Пухан хотноо болсон ОХУ, БНХАУ, Япон, БНСУ, БНАСАУ, Монгол улсуудын 69 муж , хязгаар, аймгуудыг эгнээндээ нэгтгэдэг Зүүн Хойд Азийн орнуудын бүс нутгийн Засаг захиргаадын холбооны /NEAR / 6-р чуулганаар энэ холбооны гишүүнээр нь элссэнээс хойш идэвхтэй хамтран ажиллаж байгаа бөгөөд 2010 онд Кёнги мужийн Гуян хот, Кенсабуг мужийн Кёнжү хотуудад 2010 оны 10 дугаар сарын 25-аас 30-ны өдрүүдэд Зүүн хойд Азийн бүс нутгийн Засаг захиргаадын холбооны 8 дахь удаагийн Бүгд хурал болон эдийн засгийн форумд аймгийн ЗДТГ-ын дарга Х.Ганболд , аймгийн ЗДТГ-ын Нийгмийн хөгжлийн хэлтсийн дарга Г.Батбаатар нар оролцсон байна.</p> <p>БНАЛАУ-ын Луангпрабанг мужаас шууд харилцаа, хамтын ажиллагаа тогтоох тухай санал хүлээн авч, уг асуудлыг судалж байна.</p> <p style="text-align: right;">Хэрэгжиж байна 90%</p>
7.6. Батлан хамгаалах салбарын бодлого Бүх үе шат (2007-2021 он):		
<i>Стратеги зорилт 1. Орон нутгийн хамгаалалтад тулгуурласан батлан хамгаалах нэгдмэл тогтолцоог бүрдүүлэн бэхжүүлнэ</i>		
	<ul style="list-style-type: none"> • улс орны үндэсний аюулгүй байдал, хөгжил дэвшил, иргэдийн амгалан 	<p>Аймгийн тогтвортой хөгжил, эдийн засгийн хурдацтай өсөлтийг бүх талаар хангах, иргэдэд эх оронч үзэл, хүмүүжлийг төлөвшүүлэх, нийгмийн тогтвортой</p>

	тайван амьдралын баталгааг найдвартай хангахад төрийн батлан хамгаалах бодлого чиглэгдэх;	байдал, иргэдийн амгалан тайван аж төрөх нөхцлийг хангахад батлан хамгаалах бодлого зорилтыг чиглүүлэн ажиллаж байна. Хэрэгжиж байна 90%
	<ul style="list-style-type: none"> Монгол Улсын эдийн засаг, нийгмийг хөгжүүлэхдээ улс орны батлан хамгаалах ашиг сонирхлын дагуу улсын дайчилгааны зохих нөөцийг бүрдүүлэх; 	<p>Аймгийн дайчилгааны төлөвлөгөөг тодотгож, сумдын дайчилгааны даалгаврыг тогтоож, дайчилгааны даалгавраар тогтоогдсон материал, хэрэгслийн нөөцийг бүрдүүлэх, түүнийг шинэчлэх, нөхөн сэлбэх ажлын төлөвлөгөөг гарган ажиллаж байна.</p> <p>Аймгийн нутаг дэвсгэртээ дайчилгааны зарлан мэдээлэл явуулах журмыг тодотгож, цугларах, шилжүүлэх байруудын томилгоот бүрэлдэхүүнтэй сургалт, дадлагыг зохион байгуулж явуулж байна.</p> <p>Хэрэгжиж байна 90%</p>
	<ul style="list-style-type: none"> эх оронч үзлийг улс орноо хөгжүүлэх эрхэм хүсэл тэмүүлэлтэй холбон утга агуулга, зорилгыг нь оновчтой тогтоож, хүн бүрт хамаатай үзэл болгохыг зорих; 	<p>Төсвийн ерөнхийлөн захирагч Батлан хамгаалахын сайдаас аймгийн Засаг даргатай бүтээгдэхүүн нийлүүлэлт, санхүүжилтийн талаар байгуулсан гэрээний дагуу 2010 оны цэргийн шинэчилсэн тоо бүртгэлийг зохион байгуулах ажлын хүрээнд Батлан хамгаалах бодлого үйл ажиллагаа, батлан хамгаалах хууль тогтоомж, Зэвсэгт хүчний шинэчлэл, өнөөгийн гүйцэтгэж буй үүргийг сурталчлах ажлыг амжилттай зохион байгуулж явуулсан байна.</p> <p>Батлан хамгаалах асуудал эрхэлсэн Төрийн захиргааны төв байгууллага байгуулагдасны 99 жилийн ой, Зэвсэгт хүчин үүсч хөгжсөний 89 жилийн ойг тэмдэглэн өнгөрүүлэх ажлын хүрээнд цэрэгжсэн байгууллагуудын дунд марш тактикийн болон буудлагын тэмцээн, “Би чадна”, “Дэвжээ” зэрэг тэмцээнүүд, үндэсний бөхийн барилдаан, шагайн харваа болон уулзалт ярилцлагыг зохион байгуулж, аймаг, орон нутгийн хэвлэл, мэдээллийн хэрэгслээр нэвтрүүлж, сурталчиллаа.</p> <p>Түүнчлэн бага, өсвөр үеийн болон цэргийн насны залуучуудад цэрэг-эх оронч үзэл, хүмүүжлийг төлөвшүүлэх, орон нутагт цэрэг-иргэний харилцааг бэхжүүлэх зорилгоор “Цэргийн дууг хэн сайн дуулах вэ” уралдаан, “Эх орны цэрэг яруу найргийн наадам” зэрэг урлаг соёлын арга хэмжээ, уулзалт ярилцлага, гэрээт цэргийн албыг сурталчлах өдөрлөгийг тус тус зохион байгуулж Зэвсэгт хүчний 186 дугаар ангитай хамтран жагсаал, гардан тулалдааны үзүүлэх тоглолтыг иргэдэд сонирхуулсан нь орон нутгийн иргэд, залуучуудын талархлыг хүлээсэн үйл ажиллагаа боллоо.</p> <p>1945 оны чөлөөлөх дайны түүхт 65 жилийн ойг тэмдэглэн өнгөрүүлэх</p>

		<p>ажлын хүрээнд ойг угтан түүхэн ялалтын үнэ цэнэ, цэрэг эрсийнхээ байгуулсан гавъяаг судлах,сурталчлах,аймагтаа оршин суугаа дайнд оролцсон ахмад дайчиддаа хүндэтгэл үзүүлэх,тэдний эх оронч сэтгэл,зүтгэлийг залуу үед өвлүүлэх арга хэмжээг зохион байгуулснаас гадна Монгол-Орос цэрэг эрсийн байгуулсан гавъяаг алдаршуулах дурсгалыг нь мөнхжүүлэх хоёр ард түмний найрамдалт харилцаа хамтын ажиллагааг шинэ нөхцөлд баяжуулан хөгжүүлэх арга хэмжээг орон нутгийнхаа онцлогтой уялдуулан зохион байгуулж мөн 1945 оны чөлөөлөх дайнд оролцсон боловч энэ үйл хэргийн төлөө өмнө нь төрийн одон,медалиар шагнагдаагүй зарим ахмад дайчдыг шагнуулах ажлыг зохион байгуулж явууллаа.</p> <p style="text-align: right;">Хэрэгжиж байна 90%</p>
	<ul style="list-style-type: none"> • залуу үеийг эрүүлжүүлэх, өндөр боловсрол, мэдлэг, чадвар олгох, зэвсэгт хүчний байнгын болон дайчилгааны нөөц бие бүрэлдэхүүний чанарыг сайжруулах, нийт иргэдийн цэрэг, зэвсэгт хүчнээрээ бахархах сэтгэлгээг төлөвшүүлэх; 	<p>Цэргийн мэргэжлийн удирдлагын дээд байгууллагаас тогтоосон хяналтын тоонд багтаан 2010 онд Цэргийн жинхэнэ албанд татагдагчдын эрүүл мэнд, мэдлэг боловсрол, бие бялдар, ёс зүйн шаардлага хангасан иргэдээр Зэвсэгт хүчин бусад цэргийг нөхөн хангасан. Цэргийн жинхэнэ албанд татагдагсадын боловсролын түвшинг урьд оныхтой харьцуулахад дээд боловсролтой иргэдийн тоо 1.1, бүрэн дунд боловсролтой иргэдийн тоо 6.8, бүрэн бус дунд боловсролтой иргэдийн тоо 0.5 хувиар тус тус өссөн.</p> <p>2010 оны I,II ээлжээр эрүүл мэндээр чөлөөлөгдсөн 718 иргэний нэрсийг ЭМГ, Баян-Өндөр сумтай хамтран өрхийн эмнэлгийн хяналтанд авч картжуулан эрүүлжүүлэх ажил явагдаж байна. Цэргийн насны залуучуудын боловсролын түвшинг дээшлүүлэх ажлын хүрээнд Аймгийн боловсрол соёлын газартай хамтран албан бус сургалтанд 15 иргэнийг хамруулах ажил зохион байгуулсан байна.</p> <p style="text-align: right;">Хэрэгжиж байна 90%</p>

БИЕЛЭЛТТЭЙ ТАНИЛЦСАН: АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН

ТАМГЫН ГАЗРЫН ДАРГА

Х. ГАНБОЛД

БИЕЛЭЛТ ГАРГАСАН: АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН

ТЗУХ-ИЙН ХШҮ-НИЙ ТАСГИЙН ДАРГА

М.ЖАНБОЛАТ

**МЯНГАНЫ ХӨГЖЛИЙН ЗОРИЛТОД СУУРИЛСАН ҮНДЭСНИЙ
ХӨГЖЛИЙН ЦОГЦ БОДЛОГЫН ХЭРЭГЖИЛТИЙН ҮНЭЛГЭЭ**

2011.02.18

Эрдэнэт

№	Бодлого	Зорилт	Хяналтанд авсан заалтын тоо	Хэрэгжилтийн дундаж үнэлгээ
1	Ядуурал, ажилгүйдлийг бууруулах бодлого Нэгдүгээр үе шат (2007-2015 он):	Стратегийн зорилт 1. Ядууст чиглэсэн, харьцангуй чинээлэг дунд давхаргыг төлөвшүүлэх эдийн засгийн бодлого хэрэгжүүлж, орлогын өсөлтийг хангах замаар ядуурлыг хоёр дахин бууруулна.	4	90%
2	4.2. Жендэрийн тэгш байдлыг хангах бодлого Бүх үе шат (2007-2021 он):	Стратегийн зорилт 1. Жендэрийн тэгш байдлын үзэл баримтлалыг үндэсний соёлын дэвшилтэт уламжлал, хүн төрөлхтөний соёл иргэншлийн ололттой хослуулан төлөвшүүлнэ.	3	83.3%
3	4.3. Гэр бүлийн хөгжил, хүн ам зүйн бодлого – Бүх үе шат (2007-2021 он):	Стратегийн зорилт 1. Гэр бүлийг хүний аж төрөх таатай орчин болгоход чиглэсэн цогц бодлого хэрэгжүүлнэ	5	82%
		Стратегийн зорилт 2. Хүн амын эмзэг бүлгийн хөгжлийг дэмжих хүний эрхэд суурилсан гэр бүл төвтэй төрийн цогц бодлого хэрэгжүүлнэ:	4	90%
		Стратегийн зорилт 3. Эцэг, эх үр хүүхдээ эрүүл, саруул өсгөн бойжуулж, боловсрол хүмүүжлийн зөв төлөвшилтэй болгон хөгжүүлэхэд чиглэсэн гэр бүлийн таатай орчныг бүрдүүлэхийг төрөөс дэмжинэ. Төрөлтийг дэмжих замаар хүн амын жилийн дундаж өсөлтийг нэмэгдүүлж, улмаар хүн амаа өсгөх бодлого баримтална:	4 3 заалтын хугацаа болоогүй дээд шатнаас шийдвэр гаргаагүй болно.	90%
		Стратегийн зорилт 4. Хүүхэд эхээс төрсөн цагаасаа зургаан нас хүртэл гэр бүл, эсхүл түүнтэй дүйцэх орчинд өсөж торних, зөв хүмүүжил, ёс суртахуунтай болох, сургуулийн өмнөх боловсрол олгоход төрөөс онцгой анхаарна:	3 1 заалтын хугацаа болоогүй дээд шатнаас шийдвэр гаргаагүй болно	90%
4	4.4. Боловсролын хөгжлийн бодлого Нэгдүгээр үе шат (2007-2015 он):	Стратегийн зорилт 1. Суралцагчдад хүртээмжтэй, чанартай, хэрэгцээнд нь нийцсэн боловсрол эзэмших тэгш боломж бүрдүүлнэ:	9	87.7%
		Стратегийн зорилт 2. Боловсролын бүх түвшний стандарт	8 1 заалтын хугацаа	78.5%

		сургалтын хөтөлбөрийг тухайн үеийн суралцагчийн хэрэгцээ, нийгмийн шаардлагад нийцүүлэн боловсронгуй болгон	болоогүй дээд шатнаас шийдвэр гаргаагүй болно	
		Стратегийн зорилт 3. Багшийн мэргэжил, арга зүйн хөгжил болон цалин хөлс, урамшуулал, нийгмийн асуудлыг цогцоор нь шийдвэрлэж, энэ чиглэлд хөрөнгө оруулалтыг эрс нэмэгдүүлнэ	4	90%
5	4.5. Эрүүл мэндийн хөгжлийн бодлого Нэгдүгээр үе шат (2007-2015 он):	Стратегийн зорилт 1. Сум, өрхийн эмнэлгийн анхан шатны тусламж хүргэх, шинжилгээ, оношилгоо, эмчилгээ, дархлаажуулалт хийх, шүдний өвчин эмчлэх, бэлгийн замаар дамжих халдвар, хүний дархлал хомсдолын вирус, дархлалын олдмол хомсдол, сүрьеэгээс сэргийлэх, эх, нялхсын эрүүл мэндийг хамгаалах чадамжийг цогц байдлаар хөгжүүлнэ:	4	90%
		Стратегийн зорилт 2. Аймаг, дүүргийн болон улсын клиникийн нэгдсэн эмнэлэг, мэргэжлийн төвүүдийн үйл ажиллагааны чадамжийг хөгжүүлнэ:	4	85%
		Стратегийн зорилт 3. Эрүүл мэндийн байгууллагыг мэргэжлийн өндөр мэдлэг, ур чадвартай боловсон хүчнээр хангана:	3	83.3%
		Стратегийн зорилт 4. Хүн амын өвчлөл, цаг бусын нас баралтыг бууруулж, дундаж наслалтыг ахиулна. Эрүүл аж төрөх хэв маяг, эрүүл мэндээ хамгаалах зөв зан үйлийг төлөвшүүлнэ:	10	90%
6	4.6.Соёл, урлагийн хөгжлийн бодлого Бүх үе шат (2007-2021 он):	Стратегийн зорилт 1. Үндэсний соёлыг эрчимтэй хөгжүүлэх эдийн засаг, зохион байгуулалтын тааламжтай орчинг бүрдүүлнэ:	2	90%
		Стратегийн зорилт 2. Хүн амд соёл, урлагийн үйлчилгээг хүртээмжтэй, чанартай хүргэж,иргэдийн оюуны хэрэгцээг хангах талаар дорвитой ахиц гаргана:	5 1 заалтын хугацаа болоогүй дээд шатнаас шийдвэр гаргаагүй	90%
7	4.8.Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн бодлого Бүх үе шат (2007-2021 он):	Стратегийн зорилт 1.Гэр бүл, нийгэм, хамт олонд тулгуурласан халамжийн тогтолцоог төлөвшүүлж, халамжийн үйлчилгээг олон улсын жишигт хүргэж хөгжүүлнэ:	2	90%
		Стратегийн зорилт 2. Иргэний хөдөлмөрлөх эрхийг	5	90%

	он):	хамгаалах, бүтээмж, ур чадварыг хөгжүүлэх үндсэн дээр цалин хөлсийг нэмэгдүүлэх, бизнесийн орчин, ажлын байрны тогтвортой байдлыг дэмжих, нийгмийн түншлэлийг төлөвшүүлэхэд чиглэсэн хөдөлмөр эрхлэлтийн бодлогоор дамжуулан хөдөлмөрийн зах зээлийн зохицуулалтыг оновчтой, үр ашигтай болгож, иргэдийн амьдралын түвшинг дээшлүүлэхэд дэмжлэг үзүүлнэ:		
		Стратегийн зорилт 3. Хүн амын бүлгүүдийн зохистой хөдөлмөр эрхлэлт, түүний дотор нийгмийн эмзэг бүлгийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих бодлого, хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлнэ:	5	74%
8	5.1.1. Улсын төсвийн бодлого –Бүх үе шат (2007-2021 он):	Стратегийн зорилт 1. Төсвийн төлөвлөлтийг Монгол Улсын Мянганы хөгжлийн зорилтод суурилсан Үндэсний хөгжлийн цогц бодлогыг хэрэгжүүлэхэд нийцүүлэн боловсронгуй болгоно:	3	90%
		Стратегийн зорилт 2. Төсвийн хөрөнгө оруулалтыг Мянганы хөгжлийн зорилтуудтай оновчтой уялдуулан нэмэгдүүлж, урт, дунд хугацааны хөгжлийн хөтөлбөр, төслүүдэд суурилан хэрэгжүүлнэ:	2	90%
9	5.1.2. Татварын бодлого Бүх үе шат (2007-2021 он)	Стратегийн зорилт 2. Экологийн татварыг бий болгож, татварын суурийг өргөтгөн татвар хураалтыг сайжруулж, төсвийн орлогыг зохистой нэмэгдүүлнэ:	1	90%
10	5.1.6. Гадаад худалдааны бодлогын стратегийн зорилтууд Бүх үе шат (2007-2021 он):	Стратегийн зорилт 1. Экспортын бүтээгдэхүүний нэр төрөл, хэмжээг зохистой өсгөнө:	1	90%
		Стратегийн зорилт 2. Импортын бүтээгдэхүүний нэр төрөл, хэмжээг эдийн засгийн хөгжлийн хэтийн чиг хандлагатай оновчтой уялдуулан сайжруулна:	1	90%
11	5.1.7. Хувийн хэвшлийн хөгжил Бүх үе шат	Стратегийн зорилт 2. Бизнесийн үйл ажиллагааны эрх зүйн орчинг боловсронгуй болгож, хувийн хэвшлийн үйл	2	70%

	(2007-2021 он):	ажиллагаанд оролцох Засгийн газрын оролцоог зохистой түвшинд хүртэл хязгаарлана:		
12	5.2.1.1. Геологи, уул уурхай, эрдэс баялаг, хүнд үйлдвэрийн хөгжлийн бодлого Нэгдүгээр үе шат (2007-2015 он):	Стратегийн зорилт 1. Стратегийн орд газруудыг ашиглана. Улсын зардлаар геологийн хайгуул хийж, нөөцийг нь тогтоосон стратегийн орд газруудад төрийн мэдлийн хувийг 51-ээс дээш байлгах бодлогыг баримтална:	2	90%
		Стратегийн зорилт 2. Уул уурхайн салбарт байгаль орчныг хамгаалж, экологийн тэнцвэрт байдлыг хадгална:	3	90%
13	5.2.1.2. Боловсруулах аж үйлдвэрийн хөгжлийн бодлого Нэгдүгээр үе шат (2007-2015 он):	Стратегийн зорилт 1. Гадаад зах зээлд өрсөлдөх чадвартай эцсийн бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг нэмэгдүүлнэ:	2	90%
		Стратегийн зорилт 2. Бүс нутгуудын хөгжлийн дотоод, гадаад нөөц боломжтой оновчтой уялдуулан үйлдвэрлэл, технологийн паркуудыг байгуулж хөгжүүлнэ:	2	80%
14	5.2.1.3. Жижиг, дунд үйлдвэрлэл, үйлчилгээний хөгжлийн бодлого: Нэгдүгээр үе шат (2007-2015 он):	Стратегийн зорилт 1. Жижиг, дунд үйлдвэрлэлийн хөгжлийг дэмжих эрх зүйн таатай орчинг бүрдүүлнэ:	2	90%
		Стратегийн зорилт 2. Жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэгчдэд үзүүлдэг төрийн үйлчилгээг чирэгдэлгүй, түргэн шуурхай болгоно:	3	90%
15	5.2.1.4. Хөдөө аж ахуй, хүнсний үйлдвэрлэлийн хөгжлийн бодлого Нэгдүгээр үе шат (2007 – 2015 он):	Стратегийн зорилт 1. Бүс нутгийн онцлогыг харгалзан бэлчээрийн болон эрчимжсэн мал аж ахуйг хослуулан хөгжүүлж, халдварт өвчний гаралт, тархалтыг эрс бууруулан малыг эрүүлжүүлж, мал аж ахуйн бүтээгдэхүүний үйлдвэрлэл, боловсруулалт, экспортыг нэмэгдүүлнэ:	7	90%
		Стратегийн зорилт 2. Газар ашиглалтыг сайжруулж, усалгаатай тариаланг хөгжүүлэн, биотехнологи нэвтрүүлэн газар тариалангийн бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг нэмэгдүүлнэ:	5	90%

		Стратегийн зорилт 3. Хүнсний үйлдвэрлэлд орчин үеийн дэвшилтэт технологийг нэвтрүүлж, бүтээгдэхүүний өрсөлдөх чадварыг сайжруулна:	3	90%
		Стратегийн зорилт 4. Газар тариалангийн болон бэлчээрийн усан хангамжийг сайжруулж, хөдөөгийн хүн амын ундны усны хэрэгцээ, шаардлагад тохирсон усны нөөцийг нэмэгдүүлнэ:	1	90%
		Стратеги зорилт 5. Малын тэжээлийн үйлдвэрлэлийг сэргээн хөгжүүлж, тэжээлийн шимт чанар, тэжээллэг байдлыг сайжруулах, хангамж, хүртээмжийг нэмэгдүүлэх цогц арга хэмжээ авч хэрэгжүүлнэ:	3	90%
		Стратеги зорилт 6. Хөрсийг эвдрэлээс хамгаалах, үржил шимийг хадгалах, чийгийн ууршилтыг багасгахад чиглэсэн дэвшилтэт технологийг газар тариаланд нэвтрүүлнэ:	4	90%
16	5.2.1.5. Аялал жуулчлалын хөгжлийн бодлого Нэгдүгээр үе шат (2007 – 2015 он):	Стратегийн зорилт 2. Аялал жуулчлалын томоохон цогцолборуудыг барьж байгуулан, аялагч, жуулчдын сонирхлыг татсан аяллын төрлүүдийг бүс нутгаар төрөлжүүлэн хөгжүүлнэ.	1	90%
17	5.3.1. Зам, тээврийн хөгжлийн бодлого Нэгдүгээр үе шат (2007 – 2015 он):	Стратегийн зорилт 3. Авто замын салбарт дэвшилтэд техник технологи нэвтрүүлж, авто зам, замын байгууламжийн чанарыг дээшлүүлж, ашиглалт, үйлчилгээг сайжруулна:	1	70%
18	5.3.2. Эрчим хүчний салбарын хөгжлийн бодлого Нэгдүгээр үе шат (2007 – 2015 он):	Стратегийн зорилт 2. Сум, суурин газрын болон малчдын цахилгаан эрчим хүчний хангамжийг сайжруулна:	2	95%
19	5.3.4. Мэдээлэл,	Стратегийн зорилт 2. Мэдээлэл харилцааны технологийн	3	90%

	харилцаа холбооны технологийн хөгжлийн бодлого Нэгдүгээр үе шат (2007 – 2015 он):	ололтыг нийгэм, эдийн засгийн бүх салбарт өргөн нэвтрүүлнэ:		
20	5.3.5 Хот байгуулалт, барилгын хөгжлийн бодлого Бүх үе шат (2007-2021 он):	Стратегийн зорилт 1. Хүн амын нутагшилт, суурьшлын зохистой тогтолцоог хөгжүүлж, хот, суурингийн оршин суугчдад таатай орчин бүрдүүлнэ:	3	90%
		Стратегийн зорилт 2. Орчин үеийн чанарын шаардлага бүхий барилга, шинэ нэр төрлийн барилгын материалын үйлдвэрлэл, нийтийн аж ахуйн салбарыг бий болгон хөгжүүлнэ:	2	80%
		Стратегийн зорилт 3. Хүн амын орон сууцны хангамжийг эрс сайжруулна. “Орон сууц” үндэсний хөтөлбөр хэрэгжүүлнэ:	3	90%
		Стратегийн зорилт 4. Хот суурингийн газар ашиглалтыг сайжруулж, эд хөрөнгийн бүртгэлийн тогтолцоо, үйл ажиллагааг боловсронгуй болгоно:	4	85%
21	5.4. Бүс нутаг, хөдөөгийн хөгжлийн бодлого Нэгдүгээр үе шат (2007-2015 он):	Стратегийн зорилт 1. Бүсчилсэн хөгжлийн төлөвлөлт, удирдлагыг боловсронгуй болгож, бүс нутгийн хөгжлийг түргэсгэнэ:	2	90%
22	6. Байгаль орчны бодлого Бүх үе шат (2007-2021 он):	Стратегийн зорилт 1. Байгаль орчны бохирдол, доройтлыг хязгаарлан зогсооно:	3	90%
		Стратегийн зорилт 3. Усны нөөцийг бохирдол, хомсдолоос хамгаалах, зохистой ашиглах, хүн амыг эрүүл ахуйн шаардлагад нийцсэн усаар хангах нөхцөлийг бүрдүүлнэ. “Ус” үндэсний хөтөлбөр хэрэгжүүлнэ:	3	90%
		Стратегийн зорилт 4. Ойн нөөцийг тогтвортой ашиглаж, ой хамгаалах, нөхөн сэргээх, экологийн тэнцвэрийг хадгалах нөхцөлийг хангана:	3	90%
23	7.1 Эрх зүйн шинэтгэл Бүх үе шат (2007-2021 он):	Стратегийн зорилт 1. Төрийн институцүүдийг чадавхжуулж, төрийн үйлчилгээг ил тод, хүртээмжтэй болгох эрх зүйн	2	90%

	он):	зохицуулалтыг боловсронгуй болгоно:		
		Стратегийн зорилт 2. Хүний эрхийг баталгаатай хангана:	5	86%
24	7.2. Монгол Улсын төрийн байгуулал, төрийн удирдлагын хөгжил Бүх үе шат (2007-2021 он):	Стратегийн зорилт 2. Төрийн удирдлагын шийдвэр гаргах үйл явцын ил тод байдал, түүнд иргэд оролцох боломжийг хангана:	1	90%
		Стратегийн зорилт 4. Засаг захиргаа, нутаг дэвсгэрийг эдийн засгийн чадамж, хүн амын нөөцөд тулгуурлан томсгоно	1	90%
		Стратегийн зорилт 5. Төрийн бүртгэл, мэдээллийн тогтолцоог шинэтгэж, бодитой, үнэмшилтэй цахим мэдээллийн тогтолцоо, сан байгуулна:	1	90%
25	7.3. Монгол Улсын төрийн захиргаа, төрийн албаны шинэтгэлийн бодлого Бүх үе шат (2007-2021 он):	Стратегийн зорилт 1. Төрийн албаны стратегийн төлөвлөлт, гүйцэтгэлийн удирдлагын чадамжийг хөгжүүлнэ:	2	90%
		Стратегийн зорилт 2. Төрийн албаны бодлого, дүн шинжилгээний болон төрийн албан хаагчийн манлайллын чадамжийг шинэ түвшинд хүргэнэ:	2	90%
		Стратегийн зорилт 3. Байгууллагын болон хүний нөөцийн хөгжлийг хангана:	2	90%
		Стратегийн зорилт 5. Төрийн албаны оновчтой хэмжээг хангаж, төрийн үйлчилгээний чанар, хүртээмжийг дээшлүүлнэ	3 1 заалтын хугацаа болоогүй	95%
26	7.5. Гадаад бодлого Бүх үе шат (2007-2021 он):	Стратегийн зорилт 1. Энхийг эрхэмлэсэн, идэвхтэй гадаад улс төрийн бодлогыг хэрэгжүүлнэ:	4	90%
27	7.6. Батлан хамгаалах салбарын бодлого Бүх үе шат (2007-2021 он):	Стратеги зорилт 1. Орон нутгийн хамгаалалтад тулгуурласан батлан хамгаалах нэгдмэл тогтолцоог бүрдүүлэн бэхжүүлнэ	4	90%
	Дундаж үзүүлэлт			88.0%

ҮНЭЛГЭЭТЭЙ ТАНИЛЦСАН: АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН

ТАМГЫН ГАЗРЫН ДАРГА

Х. ГАНБОЛД

ҮНЭЛГЭЭГ ГАРГАСАН: АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН

ТЗУХ-ИЙН ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ ҮНЭЛГЭЭНИЙ

ТАСГИЙН ДАРГА

М. ЖАНБОЛАТ